

**БУРХАН БАГШИЙН
СУРГААЛ**

DDC
294.342
Б-777

**БУРХАН БАГШИЙН СУРГААЛ
ЕРТӨНЦИЙН АМГАЛАН ХУТГИЙГ ОЛОХ
ХҮМҮҮНИЙ ЭРЭЛ**

Орчуулагч: М.Шагдарсүрэн
Ерөнхий редактор: До.Цэнджав
Редактор: Г.Мэнд-Ооёо
Дизайнер: Х.Амартүвшин
Хэвлэлийн эх бэлтгэсэн: П.Бадамханд
Хэвлэлийн хуудас: 17.5 х.х

“СЭЛЭНГЭПРЕСС” ХХК-д хэвлэв.
Утас (976) 11 459790

ISBN 978-99962-0-195-0

Printed and donated for free distribution by
The Corporate Body of the Buddha Educational Foundation
11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.
Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415
Email: overseas@budaedu.org
Website: <http://www.budaedu.org>

This book is strictly for free distribution, it is not for sale.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО



М.ШАГДАРСҮРЭНГИЙН ОРЧУУЛГА



- **БУРХАН БАГШИЙН
СУРГААЛ**
- **ЕРТӨНЦИЙН АМГАЛАН
ХУТГИЙГ ОЛОХ
ХҮМҮҮНИЙ ЭРЭЛ**

Улаанбаатар хот 2012 он

НОМЫН ОРОНД ӨРГӨХ ТАХИЛ

*Номын садан, дуун хөрвүүлэгч,
Эрхэм анд М.Шагдарсүрэндээ*

Огторгуйд түгэгч од бүхэн өөрийн шалтгаан лугаа тохиоюу
Оюунт хүмүүний гэгээн номын мөр одод лугаа зохилдую
Орчлонгийн харанхуйд ном эрдмийн мөнх зул бадраах нь
Очир эрдэнэсийн хүү сангийн алтан хуурцаг нээх лугаа буюу
Мэргэн ухааны сувдыг хязгааргүй далайгаас хэн шүүрдэх
Мэдэхгүйн харанхуй цөлд биндэрьяан гэрэл хэн асаах
Биндэр ятгын алтан аялгууг Янжинлхамтай хэн сонсох
Билиг ухааны их тэнгист хэлний сэлүүрээр хэн аялах?
Аглагийн орон руу Бурхан багшийн гэгээрлийн мөрөөр хэн бэдрэх
Андууг арилгагч XIV Дээрхийн гэгээнтний ариуслын оронд хэн очих
Далай лам Цаянжамцын янагийн дууллын нууцыг хэн сонсох
Далайн чанад арлын Японы адармаатай ханзыг хэн тайлах?
Эртний Персийн эрэн захаар Омар Хайямтай хэн алхах
Энэтхэг дахины хөлгөн Дармапада-гийн оронд хэн зочлох
Сарны доор Ли байгийн гүцтэй сархадаас хэн амсах
Сац бас Нангиадын мэргэн үгийн сувдыг хэн хэлэх?
Бийр барьж шөнө туж нойроо мартаж хэн суух
Бэхэсийн мөр үгсийн оньсоор цагийн чинадад хэн зорчих?
Арван боть номын хөлгөн асарт тэр хүн заларч буй
Алжаал, цөхрөл, аврал, итгэл, ялалт цөм тэнд буй.

Г.МЭНД-ООЁО. 2007.Х.29



Долоо дахь удаагийн хэвлэл





Wang Wensheng



ЕРӨНХИЙ РЕДАКТОРААС ӨГҮҮЛЭХИЙН УЧИР

Уншигч Таны өмнө гэгээрэл, оюуны хур шим оргилж буцалсан ном эрдмийн нэгэн гайхалтай ертөнцийг нээж байгаадаа өчүүхэн миний сэтгэл тун баяр хөөртэй байна. Энэ эрхмийг манай үеийнхэн одоо нэгэнт таньдаг, мэддэг, биширдэг болсон тул элдэв долоон үгийн нэмэр бараг илүүц ч гэлээ гол мөрний ус эргэж өөдөө урсдаггүйн учир, үеэс үед дамжсаар үнэ цэнээ алдахааргүй суварган их бүтээл туурвисны хувьд, хожмынхонд энэ нь шинэ үг болж улбаачлагдахын учир цөөнийг мөрлөв. Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор “элэгний” хэмээн ард олондоо нэр хүнд олсон мэс засалч, гарамгай дуун хөрвүүлэгч Маналжавын Шагдарсүрэн бага залуугаасаа ертөнцийн цаг хормыг ер бишээр хуваарилан, ном эрдэмд цэцгийн бал руу тэмүүлэх зөгий мэт шунаж, нэг хэлээс нөгөө рүү, нөгөөгөөс цаашаа гүнзгийрүүлэн суралцаж эдүгээ өрнийн болоод дорнын хэд хэдэн чухал гол хэл, хэлбичгийг

ороо морийг уургалан барьж номхоруулахын анзаанд сурчээ. Бие сэтгэл могож няцаж байсан ч хатамжлан, бэрхэд хүслэн гэгчийг бэхлэхийг түрүү болгосноор амьдралаа учир утгатай болгоод зогсоогүй, амжиж бүтээхийн туурвилзүйдээ асар хурц гэрлийг асааж чадсан ховор билгүүн авьяаст, оюут гэгээнтэн эрхтгүй мөн.

Эрдэм чадал илт дорой буурай ч гэсэн эрхэм номун нөхрийн итгэж миний гарт бариулсан 20 боть сүмбэнг нэг бүрчилэн уншиж, илүү дутуу үг, арай дутмаг мөчид хальтирсан зүйл байна уу? хэмээн үг өгүүлбэрийг эрхийвчилэн торгоож хянамгайлахыг хичээсэн боловч нүдэнд өртөх, үзгийн үзүүрт баригдах зүйл тун багахаан тааралдав. М.Шагдарсүрэнгийн эл ботиудын хуудас бүрээс гэгээрэл, ариусахуй, танихуйн ертөнц тэр чигээрээ дэлгэгдэж оюуны ид хав амтагдаж, сэтгэлийг илбэдэн баясгаж байх юм.

Заримдаа “Амьдрал” гэдэг яасан ч хуурамчхан, хүн гэдэг ямар ч гүехэн, эрх мэдэл хөөцөлдөх гэдэг ямар ч мулгуу, алдар нэр гэдэг яасан ч хоосон юм бэ? дээ гэж шоолж инээмээр, гутармаар, бас баясмаар ер бусын саруул гүн ухаан гэрэлтэхийг уншигч Та мэдэрч намайг хүлцэн зөвшөөрөх бизээ. Ертөнц дахины буурал мэргэдийн эрт эдүгээгээс хураасан эрдмийн хамгийн шимтэй амттай, гэхдээ үгүйлэгдэн шохоорогдох, танин мэдэх, ухаарч гэгээрэх тэрхүү орон зай руу шурган орж, эрдэнэсийн эрдэнэсийг сонгож авна гэдэг бол хэр наад захын эрдэмт хүмүүн хөл алдаж, басчиг самгардан зарим заримдаа зориг могож болохоор чөмөг дундрам ажил ажээ. Үүний тул М.Шагдарсүрэн яахын аргагүй өнөө цагийн гайхалтай соён гэгээрүүлэгч гэхэд оюут мэргэд энэхүү суварган бүтээлийн үр шимийг хүртсэний хойно хэн ч эргэлзэн гайхахааргүйг нотолно.

Нэрт орчуулагч М.Цэдэндоржийн “Орчуулагч хүн гэдэг бол зохиолчоос нь илүү хийх хэрэгтэй” гэж ам дүүрэн хэлсэн үг үлджээ. Үнэндээ Расул Гамзатовын “Миний Дагестаныг” хөрвүүлсэн нь уг бүтээлээс хэтрүү давж гарсныг нэг бус бичгийн хүн үнэлж байхыг сонссон билээ. Шагдарсүрэн угийн аядуу даруу хичээнгүй нэгэн болохоор ингэж хэлж чадахгүй ч ингэж бодогдохоор бүтээдэгийг цухас тэмдэглэх нь зүй буйзаа.

Монголчууд, нэн ялангуяа эрдэмт лам хутагтууд бүр эртнээс буюу тавдугаар зууны орчмоос согд, уйгар хэлээс орчуулан хөрвүүлэх эш онол, эрдмийг зохион бичих туурвихаасаа ч илүүтэйгээр эзэмшсэн байх юм. Тэр бүү хэл орчуулгын онолыг боловсруулаад үүнийг дуун ухааны хөрвүүлгэнд “хууль” мэт сахиж баримтална гээд өдүгээгийн бидний хэлэх дуртай зарчимыг гаргаад тавьчихжээ. Үүнийгээ “Мэргэд гарахын орон” гэж нэрийдэж “Ганжуур”, “Данжуурыг” хөрвүүлэхдээ бичгийн сайдууд хулсан бийр хазайлгалгүй, худал хуудамгайг илчлэн, эндүүрэл илүүг элдэв ташаалгүй барьж байсан домог шиг яриа уламжлагдан үлджээ. Зөрчвөөс хулсан бийрийн үзүүрт хуудам явдал, худал олтгой зүйл байх учиргүйг мэдрүүлж зэгсэн баалчихдаг, оволзсоныг мохоон олбогт нь сөхрүүлдэг, мохоо сулбууг ирмэглэж хурцалдаг, олон ном судартай харьцуулан нийцүүлэх чанга дэг жаягтай байсан нь номун жудаг, цэдэг гэдэг ямархан ариун дагшин байжив хэмээн гайхмаар, бас биширмээр.

Эл судар бичигт “Урнаар найруулах”, “сайтар тохиолдуулах”, “утгын найрыг дагах”, “яруу найр зохисоор шүлэглэх” гэсэн гоц баримтлах түлхүүр үгс цөөнгүй тааралдана. Мөн гүн ухааны баталсан сөхөөсөн үгсийг “хурц бөгөөд мэдэхүйеэ амар үгсээр” орчуулах гэхчилэн сургаалжээ. Эртний судар номун хөрвүүлгэндээ М.Шагдарсүрэн “Мэргэд гарахын орон”, Дандины

“Зохист аялгуу”-ны зарчим сургаалыг даган баясаж монгол хэлнийхээ ухахуйяа гүн гүнзгий, сонсохуйяа эерүү уянгалаг, танихуйяа олон утгат цэц мэргэн, бясалгахуйяа бурхан шидлэг, нээхүйеэ ер бусыг ёстой л чихүнү чимэг болсон гайхамшигт илэрхийллийг мөр бүрнээ гэрэлтүүлж чадсан байна. Үгийн гэрэлд судрын хуудас сүлэгдэж харагддаг бус уу. Тэр аливааг эх хэлнээ буулгахдаа ер зөөлөн зүдэх зүйлгүйг үл сонгон аль л болох адармаатай хэцүү бэрх, утга гишүүн далдалсан энгүй бэрхийг зориуд барьдаг нь харваач цэцэд сумаа тавихдаа цэцгийн шилбэ таслалгүй онохын агаар нэгэн ажээ. Ийм уран чадвар, билэгт үгийн чанад чадварыг шингээн ариун дээд адис ерөөлт “Бурхан багшийн сургаалийг” хэрхэн орчуулснаас олж цөхөх юмгүй. Үгийг чимэглэн өнгөлж чаддаг, бүдгийг дүрэлзүүлэн асааж чаддаг, хэт хурцыг будунгуйд орхиж бүдгэрүүлж мэддэг, хэт чахарганыг эгшиглүүлэн уясаж, хахирган хатууг яргуйн дэлбээ мэт булбарай ахуйд шингээж чадсан бичиг бийрийн эрдэмт хөвүүний эзэмшвээс зохих лавтай наадын таван эрдэм ухаан тэгширч бүрэлдсэнийг мэдэрч бахадлаа.

Олон жилийн туршид бичиг цаас нухаж одоо ч учрыг олохгүй манан буданд төөрөлдөж яваа манийн хувьд өөртөө нээсэн. “Үгэнд хөлийн таширгүй, үгэнд мэлмийн ташир буй, үгэнд тэргүүн ташир буй. Эл гурван ташрыг нэгэн үзүүрт нийтгэвээс бийрийн торгон үзүүрээс ухааны сувдан эрдэнэс алтан эрвээхэй шиг нисэлдэн унамой” гэсэн үгийн маань эзэн болох хүнтэй өнөөдөр учрав. Тэр гэнэн бядгүйн ухаан илааршиж, элдвийг үзэж эрхбиш буй болоод буй биш зүйлийг нэвт эргэцүүлэхтэйгээ болсон ид исгэлэн цоцмог үедээ барьж авсан “Бурхан багшийн сургаал” хэмээх гайхамшигт ботиос мэргэн уншигч Та ихийг олж, энэ эрхмийн номун билгүүнд найр тавин даган баясах бизээ. Хатуу бэрх үгийн мэлмийг зүйтэй нээвээс мянган бурхад гийгүүлэн баясах нь тодорхой. Үг энгийнээс



энгийн болоод гүнзгийгээс гүнзгий тусмаа сэтгэлд төдөх юмгүй буудгийн жишээг энэхүү сургаалийн хуудас бүрээс хүртэн мэдэрч болно. “Сургаал сонсолгүй зуун жил амьдарснаас сургаалийг мэдэж нэгэн өдөр амьдарсан нь дээр. Хүн өөрийгөө жинхэнэ ёсоор хайрлаж чадвал хорт нүглээс хамгаалж чадна. Хүн амьдрах хугацаандаа ядаж нэг удаа ч гэсэн залуу, идэр, ахимаг насны алинд боловч итгэл үйлдэх хэрэгтэй. Энэ ертөнц бол шунал, уур, мунхагийн галаар мөнхөд шатаж байна. Хүн энэ аюулаас аль болох хурдан зайлсхийх хэрэгтэй. Энэ ертөнц бол аалзны тор шиг хөөс хир дүүрэн тортой адил байна” гэх буюу өөрөөр бас “Цэвэр ариун бадамлянхуа цэцэг намгийн шавраас ургадаг шиг ертөнцийн хүслийн буртагаас Бурханы ариун Гэгээрэл үүсдэг” гэхчилэн юутай гэрэлт бурханлаг ид шидийн бадаг мөрүүд жасаалан оршсоныг тааж ядах юун билээ. Яаж бүхнийг тоочих...

“Японы хайку”-г баргийн мэргэд лавтай гүнзгий барин ядан явсаар Шагдарсүрэнгийн гар дээр иржээ. Гэхдээ Б.Явуухулан, Ж.Лхагва нар орос хэлнээс дамжуулан мэргэн ончтой орчуулсныг үнэлэх нь зүй. Харин Шагдарсүрэн шууд эх хэл дээр нь буюу японы жинхэнэ эхийг барьж авснаараа “монгол хайкучуудын” дотор тун дээгүүр олбогийг засаад авав бололтой. Манай “Ертөнцийн гурав” дэндүү гайхамшигтай боловч бүх талаараа хайкутай зэрэгцүүлэн дүйцүүлэхийн аргагүй өөр л дөө. “Ертөнцийн гурав”-т холбоо хэлхээ учир шалтгаалцлын орон зайд маргаж мэтгэлцэхийн завдал өгөхгүй тасхийтэл тархины орой руу гартал хэлдэг. Дорнын мэргэд “Гуравтын гүн ухаан”-ыг хүн төрөлхтний оюун ухааны далайд нэгэн гол мөрөн болгон урсган шингээж чадсан, гагц үүгээр бахархахад л үлэмжхэн зүйлийг сануулж чадна. Японы хайку үнэндээ мань мэтэд заримдаа юу ч биш юм шиг ухаж торгоход алинаар нь ч буумаар санагддаг. Ийм тусмаа хайкуны гайхамшиг оршдог байна. Үүнийг үгээр

буулгахаасаа илүүтэй гүн ухаан, далд дам ухааныг төлгөчилөн буулгана гэдэг орон орны дуун хөрвүүлэгч хэний ч аавын хүүгийн чөмгийг дундалсаар иржээ. Хайку шүлгийн санаа бол хушганы яс доторхи үрт идээ мэт үзэгдэж харагдахгүй нуугдмал зүйл шүү дээ. Түүнийг зургаа дахь мэдрэхүй буюу илбэ жилбийн гэмээр мэдрэхүйгээр илчлэн гаргана уу гэхээс энгийн ухаанаар бол оньсыг тайлахын аргагүй бэрх зүйл юм.

Хортой загаснаас хордоогүй би
 Хонгор бүсгүйн аалинд
 Хордсон шиг хордлоо
 ...Гадаа бороо орсоор л...
 Хөрш маань гэрлээ асаахад
 Манайх бас гэрэлтэй болов...
 ...Тэртээ уулын цэцгэн дор
 Хичнээн хүн нойрсож буйг
 Хэн мэдэх ажаам...
 Оргүй хоосонд би одоод
 Огторгуй тэнгэрээс унжих
 Сакура болох байхаа...

Японоороо ямар байгааг мэдэхгүй, монголоор бол үг болоод утга санаа нь толины хэлтэрхийд буусан шумуулын дүрс шиг тод томруун өнгө өнгөөрөө дурайтал буужээ.

Японы хайку, эртний Персийн рубай, Энэтхэг хиндийн гүн ухаант эгшиглэл уужим Дармапада, Хятадын сонгодог яруу дуурсалт шүлгүүд, Төвдийн сүншигт гүн шүлэглэл, Буриад түмний сургаалт ариун бадаглал зэргийг орчуулсан нь дорнын их яруу найраг, оюун сэтгэлгээний “газрын зураглалд” хөл тавиагүй газар үгүй мэт байна. Дэмий үгийг хэлж дэвэргэхийн тулд биш юмаа, дэнслэн байж дэн дун хагасыг хэлтэлж байгаа минь энэ юм шүү, эрхэм уншигчид минь, эрх биш та нар маань эдгээр ботиудыг



уншаад харин тэр нөхөр чухал далдыг нээгээгүй байна” гэж зэмлэж магад.

Түүний орчуулсан Омар Хаямын рубайг уншихад бүдэг бүхэн гэрэлтэж, далд бүхэн ил гарч, утгагүй юмс утгатай болж, утгатай юмс утгагүй болж би ерөөс өөрөө хаанаа байгаагаа ч сэхээрэхээ хэсэг болив. Өчүүхэн мань мэт нь хэний төлөө, юун төлөө явав гэж санааширч, амьдралын туршид хөгийн гэмээр ёс зүй, жудаг, журам сахиусыг баримтлан шүтэж даруу буурай явсандаа гундасхийж ёстой нөгөө дураараа цалгилагч Омарын үг тархи сэтгэлийг мансууруулах шиг болсон нь чухамдаа орчуулагчийн үгийн урлагийн ид шид юм. Манай өмнөө барьдаг сайхан найрагчид, орчуулагчид Омар Хаямын рубайг жар далаад оноос л цухалзуулж эхэлсэн. Б.Явуухулан, М.Цэдэндорж, Х.Цэвээн, Л.Дашням, Д.Цоодол гээд аваргачуул өөр өөрийн ертөнцөөр тольдож рубайг буулгажээ. Эд оюуны мэлмийд юутай гэрэл гэгээ болсныг тэмдэглэх нь зүй. Омар Хаям гэдэг бол арван том орчуулагч нийлээд ч барахааргүй, цаана нь өдий төдийгөөр нь үлдэх аварга том ертөнц юм. Орчуулга гэдэг нэгэн бүтээлийг хэчнээн ч талаас нь ч нээж болох боломжтой байдгаараа өвөрмөц содон эрдэм юм.

Харин Шагдарсүрэнгийн орчуулга бол арабын эртний амьдрал үгийн утгазүйн өнгийг олж харсан. Тэр найрагчийн зан араншинг олж харсан. Хэт жимбийрдэх биш, зарим газар зөнгөөрөө туйлын хайнга юм шиг сулхийгээд гаргачихсныг тэр хэвээр нь буулгасан. Өвгөн Хаян зориуд ингэж адармаалахаа мэдэлгүй яахав. Бурханы өмнөөс ч элдвийг сөргүүлдэг хүн шүү дээ. Зохиогчоо эхлээд танина гэдэг орчуулагчийн уран нүд юм. Тэрхүү араб, перс, лалын ертөнцийн будангуй болоод өнгө гэрэлгүй ч юм шиг, солонго мэт өнгө гэрэлтэй болоод зэрэглээ мэт хуурамч ч юм шиг амьдрал ахуй нь

харагдмаар, урт буурал сахалтай, битүү ороолтон чалма малгайтай өвгөн найрагчийн өвөр дээрх гоо бүсгүйн судасны цохилт мэдрэгдэж, амьсгалах нь ч, аальгүйгэх нь, тас тас инээлдэх нь ч сонстох шиг хөрвүүлэн буй лалын бийрэн оройт сүм, хавь орчин сонин ховор сэтгэлгээг хам цуг зурж чаджээ.

Хүн намайг архичин гэвэл, үнэндээ яг тийм

Хүний мөсгүй үймүүлэгч гэвэл, үнэндээ яг тийм

Би бол би, юу хүссэнээрээ, дураараа чалчицгаа

Би Хаямаараа л үлдэнэ, үнэндээ яг тийм. Билэг танхай, биедээ ааг омог тээнэ гэж энэ бизээ.

Бас нэгэн боть болж орсон Буриадын их гэгээнтэн Эрдэни Хайбзун Галшиевийн “Мэлмий нээхүйн мянган бадаг” ном бол эрдэнийн “Субашид” шиг цулаараа алт ажээ. Хэлэх ёстойг хэлчихсэн, ойлгоогүйг ойн тойнд оруулчихсан үнэхээр л ширээн дээрээ байлгаж өдөр бүр ядаж нэг бадгийг тогтоон уншиж бодож бясалгаад байвал ертөнцийн бүх явдал гарын алган дээр буух шиг болно. Энэ бол бас л дуун хөрвүүлэгчийн ид шид. Энэ бүхнийг яаж тоочиж барахав.

Өрнө, дорно ерөөс эх дэлхийн сод ухааныг нэгэн ай савд шингээн багтаана гэдэг хэд хэдэн хүн нийлж хийгээд барахааргүй зүйлийг амжуулсанд М.Шагдарсүрэнгийн хамаг гайхамшиг оршино. Хурд, самбаа гэдэг бол түүний хувьд зүрхний лугшилт шиг амсхийдэггүй агшин гэсэн үг юм билээ. Хятадын сонгодог найрагч Дү-Фүгийн “Сарны дор ганцаараа сархад хүртэхүй” шүлэгт,

Цэцэгсийн дунд гүц дүүрэн архиа тавиад

Цэмцийн зогсож ганцаараа хүртэхүй дор

Гэгээн саранд сэржим өргөн ёсорхож

Гэрэл сүүдэр нийлээд гурвуулаа согтовоо. Үүнийг тайлах гэж оролдохын хэрэг юусан.



Ертөнцийн гоо сайхан, ер бусын шидэт билбүүрдлийн өмнө жирийн хүн байтугай бурхдын хүслэн сэтгэл гээч цангасан, цанхаалсан морьд лугаа адилхан юм бус уу? Зургадугаар Далай лам Цаянжамцын “Хайрын дуулал” боть шүлгийг уншиж байхад эрхтгүй ингэж төрнө. Түүний бичгийн бурханы яруу догдлолт зовлон гунигийн замаар бэдрэн явж шүлгийн хагасаас уншваас,

...Дорно уулын орой дээгүүр
 Мөнгөн саран шагайгаад
 Дотно охины гэрэлт царай
 Миний сэтгэлд ургаад байнам
 Өнгөрсөн оны нялх нахиа
 Өнөө жил цоор болов
 Өнгөтэй залуу нас өнгөрөхөд
 Өмнө зүгийн нумнаас илүү бөхийв
 Золоор учирсан анхилам үнэрт амраг минь
 Зоргоороо явсаар чамаасаа хагацвал
 Цагаан гэрэлт оюун эрдэнийг олоод
 Цалгих давалгаанд оргүй алдсан мэт...
 ...Эмнэг адуу ууланд хулживч
 Цалам бугуйлаар барьж болно.
 Зангаа эвдэж хэрүүлч болсон амраг минь
 Засарч номхролгүй бурханд ч дийлдэхээ болино...
 ...Тэр бүсгүй эхээс төрөөгүй
 Тоорын модноос ургасан гэж үү?
 Эр хүнээс уйдах сэтгэл нь
 Тоорын цэцэг унахаас хурдан юм...
 Хөгшин шар банхар минь
 Хүнээс дутуугүй ухаант амьтан минь
 Үдшээр оргоод явдагийг минь
 Үүрээр буцаад ирдэгийг минь дурсаарай...
 ...Бэхээр бичсэн мянган үгийг
 Бороон дусал төдийхнөөр ч арилгаж болно

Сэтгэлийн гүн дэх бичигдээгүй санааг

Хэчнээн хүслээ ч арилгаж эс чадна. Жинхэнэ яруу эгшиглэнгийн охийг бусдаас түрүүлэн амсаж, түүнээ бусдад хүртээхээр оюун бодлыг чилээж, олдсон биеэ оломгүй ихээр зовоож, ороо хурц, яруу үгс эгшгийг бийр бэхний үзүүрт торгоон бэхлэж, билэг номун хуудсанд үлдээнэ гэдэг энэ мөнөөсөө мөн дөө.

Энэхүү 20 боть тус бүрдээ өөрийн онцлогтой, өөрийн шидэт ертөнцтэй. Ертөнцийн тайлагдашгүй оюун ухаан, сэтгэлгээ, гүн ухаан, яруусахуйн ухаан, аж байдал гээд гайхамшигт бүхэн, ховор чухаг эрдэнэсээс охь нь ёроолдоо тунгаагдан үлджээ. Зөвхөн “Монголын эзэнт гүрний арми” гэдэгт л их эзэн хаан Чингис хаан болоод түүний эрэлхэг жанждын сэтгэхүй, цэргээ удирддаг урлаг, хосгүй жанжны дүр төрх, монгол цэргийн тулааны нууц зэрэг нь аяндаа тодорч хүний санаанд оршгүй зүйлсийг гаргасан маш сонирхолтой содон төрх байдал, алдар цууг шимтэн уншиж мэдэж авна.

“Анагаах ухааны англи-монгол толь”, “Анагаах ухааны монгол-англи толь”, “Япон-англи-орос-монгол идэвхтэй үгсийн толь” “Монгол охь үгийн толь” “Ургамлын толь”, “Төвд-монгол дөрвөн үндэсний толь” “Төвд-монгол анагаах ухааны толь” бол оюуны мунхаг харанхуйг арилгагч мянган мэлмийг нээх мөнхийн зул гэдгийг харуулж чаджээ. Тоймгүй олон залуус түүний зузаан зузаан толь бичгийг эргүүлж чухам юунд хүрэхийг өнөөдөр тааж хэлэхэд хэцүү байна. Та юуны ч өмнө сөхөрч мэхийхгүй омголон бардам байж болноо. Гэвч агуу их эрдэмлиг оюун билэг, төгс гэгээрэл, ариусахуйн хутаг, мэргэн ухаан агуу их ном шастирын өмнө мэхийхээс аргагүй ээ. За ингээд яруу найраг, монголынхоо эх түүх, ёс заншил, билгэ зүй, гүн ухаан, шашин, анагаахуй ухаан, толь бичиг гээд номун бүхий л гоо сайхны үзэмжит тансаг



цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлт ховор ертөнц таны өмнө хөшгөө нээхэд бэлэн боллоо.

Номун эрхэм садан М.Шагдарсүрэн маань элэг нэгтэн монголчууд, хүүхэд залуучуудад юу сурсан мэдсэнээ зориулах гэж яаж мэрийн мэтгэж зүтгэж байсныг хажуугаас нь харж, хар цай оочлон хамтдаа хэдэн сар, өдрийн шөнийн од анивчихыг үзэвээ. Оюуны хөдөлмөр гэдэг бол биеийн хөдөлмөрийн хажууд хэдэн мянга дахин хүнд нүсэр, хэцүү бэрх шүү дээ. Үүнийг үзэж туулсан хүмүүс л мэднэ, ойлгоно. Нүдэнд илхэн арван давхар сүрлэг байшин нэгэн цагт ойчино. Харин оюуны гэрэлт бүтээл тэр бүр нүдэнд ил харагддаггүй. Жишээлэхэд, дээр дурдсан Омар Хаямын рубай хэдэн зууныг гайхшруулан туулж Араб ертөнцийн алдарт сүм харшаас илүү амьдарч, тэр танишгүй этгээд ертөнцийг дуурсгасаар байна.

“Ээ дээ алдав” гэж эргэн эргэн үзэж, эрдэмт номун мэргэдээс лавлан асууж, “Өвгөөн нэг шүүгээд өгөхгүй юү?” гэж далд утга томъёолол болгоныг зөв зүйтэй буулгах гэж их хотын гудамжинд нохой ч хуцахаа больсон түнэр харанхуй цагаар ширээний гэрэлтүүлэгчийн дор халимаг үсээ ч самначих завгүй сууж, нэг хэлээс эс ойлгогдохыг нөгөө хэлээс олж шүүрдэн үзэхийн гэрчлэгч нь яах аргагүй би юмаа. “Хаявал яасан юм бэ? дээ” гэхэд “За байз хө, энд нэг хараадахъя. Тэр хаашаа бултав гэж...” хэмээн инээмсэглэн хэлээд түүнээ төдөлгүй олоод, “хүүхэдтэй болжээ” гэсэн үгийг анх сонссон энэг шиг баярлана, хөөрнө. Ерөөс Шаагаа “Нэг хэлний ороо мориог нөгөө хэлний хулжсан мориор уургална” гэж ярих дуртай. Ийм учир Та бид ч азтай. Гэгээвчээр өглөөний тунгалаг эрүүл цэнгэг агаар орж ирэхийн адил оюуны хүчирхэг агаарыг нэгэн биед шингээхийн төлөө жинхэнэ эрдэмтэн хүн шиг, жинхэнэ урлахуйн инжаан дархан шиг, жинхэнэ соён гэгээрүүлэгч шиг зүтгэн зүтгэн, чармайн чармайн



хөлс хүчээ цутган байж бүтээсэн (энэхүү) дүнжгэр, үнэнхүү бядлаг чанартай, үнэнхүү даацтай, үнэнхүү сод бүтээлүүд түүний оргилж буцалсан их мэдлэг авъяасаар тордогдон хэзээ ч баларч хуучрахгүй үеийн үед сүндэрлэн байх номын гэрэлт хөшөө дурсгал мөнөөсөө мөн.

Номын ариун цагаан буян дор мөргөмүй. Ном шастир, судрын бууршгүй их туяа Та нарын минь ариуссан сэтгэлийн гүнд гэрэлтсээр байх болтугай.

Монголын Уран Зохиолын Академийн
Ерөнхийлөгч, МУИС-ийн доктор,
профессор ДОЛГОРЫН ЦЭНДЖАВ

2010.04.27, 28. Улаанбаатар



ӨМНӨТГӨЛ

Бүх нийтийн оюун санаа, ёс суртахууны ариусал, гэгээрлийн тухай ярихгүйгээр хүн төрөлхтний хөгжлийн гэрэлт ирээдүйг сайн сайхнаар төсөөлөх аргагүй. Өөрөөр хэлбэл, хээнцэр тансаг орд харш, цахим машин, онгоц, пуужин, атомын эрчим түгээгч аль нь ч ирээдүйн оршин тогтнохын баталгаа бус, харин хүн төрөлхтний оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахууныг ариусган, гэгээрлийн шид хутаг оюуныг олох явдал л хөгжил мөн бөгөөд амьдрал мөнхийн баталгаа тэр мөн болой. Иймд ард түмний оюун санааны гэгээрэл ариуслын үйлсэд сэтгэл, бүтээлээ зориулагчийн хийсэн сайн бүхэн нь дээд буян болох учиртай. Миний эрхэм анд, хүний их эмч, доктор М.Шагдарсүрэн арав шахам жилийн өмнө арлын Японд суралцаж ирээд надад нэгэн сайхан номын орчуулгын гар бичмэлээ уншуулсан нь эдүгээ уншигч таны өмнө байгаа “Бурхан багшийн сургаал” хэмээх ном бөлгөө. Би тэр даруйд уг номыг амтархан уншиж бас чиг нөхөрт хэрэг болуужин хэмээн зарим нэг үгийн тайлбар, уламжлалт орчуулга хэллэг зэргийг санал болгож Соёлын

сангаасаа эрхлэн хэвлүүлсэн маань 1995 он билээ. “Бурхан багшийн сургаал” хэмээх алдарт номыг ийнхүү анх зориглон орчуулж хэвлүүлсэн М.Шагдарсүрэн бол эдүгээ Монгол улсын нэртэй эмч “элэгний” хэмээх тодотголтойгоор олны дунд ихэд алдаршсан ачтан билээ. М.Шагдарсүрэн хэдэн жилийн өмнө Монгол, англи, япон, орос ховор үгийн толь бичиг хийж хэвлүүлсэн хийгээд “Бурхан багшийн сургаал” номыг англи, япон хэлнээс харьцуулан орчуулсан зэргээс үзвэл эрдмээр ч, хэл соёлоороо ч манай урдаа барих сэхээтний нэг юм.

Тэрбээр Чой.Лувсанжав багшийн итгэлтэй шавь нарын нэг байлаа. М.Шагдарсүрэн маань 1995 онд “Бурхан багшийн сургаал” номоо ээжийнхээ ач буяныг санах хүүгийн сэтгэлээ шингээн хэвлүүлж үнэгүй тараачихаад Америк тивд суралцахаар одсон юм. Тэндээс АНУ-ын Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн, академич цолтой ирсэн нөхөр маань өөрийнхөө нэртэй эмнэлэг байгуулж, одоо түүнийг мэдэхгүй хүн монголд байхгүй болжээ. М.Шагдарсүрэн маань энэхүү үнэ цэнтэй номынхоо орчуулгыг дахин нягтлан үзэж нэгэнт олдохуйяа бэрх болсны учир гурав дахь удаагаа хэвлүүлж байгаа нь энэ болой.

“Бурхан багшийн сургаал” номыг анх 1925 онд японд хэвлэсэн бөгөөд буддын гүн ухааны олон эрдэмтний таван жилийн хөдөлмөрийн үр дүнд нийтийн хүртээл болжээ. 2500 жилийн тэртээ Бурхан багшийн айлдсан 5000 орчим боть номноос хураангуйлан орчин цагийн уншигчдад ойлгомжтойгоор хялбаршуулан тайлж орчуулсан энэ ном эдүгээ дэлхийн соёлт улс болгоны хилийг алхжээ. Бурхан багшийн сургаалыг орчуулах ажлыг 1925 онд удирдсан Шүүгакү Ямабэ, Чизэн Аканума профессорууд болон анх хэвлүүлж дэлгэрүүлсэн Муан Кизу болон 1934 онд англиар хэвлүүлэхэд тусалсан Д.Годдарт нарын нэрийг хэвлэн нийтлүүлэгчид дурддаг ёстой ажээ.



Ингэснээр Нуматагийн хөрөнгөөр “Бурхан багшийн сургаал”-ыг англиар хэвлэж 1960-аад онд даян дэлхийд түгээн дэлгэрүүлж эхэлсэн бөгөөд соёлт улс орны зочид буудалд буухад зочны өрөөнд заавал байдаг ном болсон билээ.

Энэ удаа М.Шагдарсүрэнгийн орчуулгын гурав дахь хэвлэл хэвлэгдэн нийтийн хүртээл болж байгаад анх нягтлан үзэж байсны хувьд дахин баясаж Мэгжид жанрайсиг их шүтээний шүншигт энэхүү номын хэвлэлийн эхийг залсан түүхийг нэхэн дурсаж, нэн бүтээлч, их хөдөлмөрч анд нөхөртөө сайны ерөөл талбису.

Бурханы сургаал өнө үүрд дэлгэрч, судар номын нь цагаан буян аривжих болтугай.

2002.12.05

Дэлхийн Урлаг Соёлын Академийн
Утга зохиолын доктор,
яруу найрагч Г.Мэнд-Ооёо

УНШИГЧ ТАНАА ӨРГӨН БАРИХУЙ

Мэргэн уншигч танаа толилуулж буй энэ номтой азтай нэгэн учирлаар анх тохиосон газар бол Японы Кобе хотын нэгэн зочид буудал болой. “Бурханы сургаал” хэмээн алтан үсгээр хавтсан дээрээ бичсэн номын хуудсыг сөхөн үзвээс, “Хүн бүхэнд бурханлиг чанар заяагдсан буй. Гагцхүү тэр чанарыг орчлонгийн шунал мунхагийн тоос шороон доороос сэргээж чадах аваас хүн бүр бурхан болох замтай” хэмээсэн мөрүүд сэтгэлд нэн ойлгомжтойгоор бурханы сургаалыг өгүүлсэн энэ номыг орчуулан монгол уншигчиддаа хүргэх юмсан гэх санаа бодол намайг эзэмдсэн билээ.

Амралтаараа эх Монгол нутаг руугаа зорин Номхон далайн хөлгүй цэнхэр мандал дээгүүр нисч явахдаа энэ номыг өвөр дээрээ тавьж, ачит эх Долгорсүрэнгийнхээ буянт ачийг дурсан, алс холын Жагарын орноо эрдэм сурахаар



одсон хайрт хөвгүүн Түвшинтөгсөө санан судрын гэрэлт мөрүүдийг сэтгэлдээ асаан монголчилж эхэлснээс хойш хэдэн жил өнгөрч нэг л мэдэхэд зөвхөн өөртөө гэх энэ хувь монгол орчуулгатай болсон юм.

“Бурханы сургаал” гэдэг ном бүр 1925 онд анх Японд доктор Шүүгакү Ямабэ, Чизэн Аканума нарын болон олон тооны Буддын гүн ухааны эрдэмтэдтэй хамтран бараг таван жил орчмын хугацаа зарж, 2500 жилийн тэртээ Бурхан багшийн айлдсан 5000 боть номноос хураангуйлан орчин үеийн уншигчидад хялбаршуулан орчуулжээ. Түүнээс хойш олон номч, мэргэн орчуулагч нар улам улам боловсронгуй болгон олон удаа хэвлүүлсээр дэлхийн соёлт уншигчийн номын санд эрдэнэсийн гайхамшиг болон байраа эзэлсэн юм.

1981 онд уг номыг Америк, Японы дээд сургуулийн оюутнуудаар судлуулан санал асуулга явуулж, улмаар нэмэлт засвар оруулан англи, япон хэлээр хэвлүүлсэн нь энэхүү номын орчуулгын эх болой.

Ийнхүү дэлхий нийтийн уншигчдад бурханы сургаалын мөн чанарыг энгийн хүүрнэн тайлсан энэхүү гайхамшигт номыг бурхан шашныг дээдлэгч монгол уншигчиддаа хүргэх чин санаа өвөрлөн англи, япон хэлнээс утга дүйлгэн харьцуулж орчууллаа.

Гар бичмэлийг үзэж зөвлөгөө өгсөн орчуулагч С.Загдсүрэн, Гандантэгчинлэн хийдийн лам Ч.Энхболд, орчуулгыг хянан тохиолдуулсан яруу найрагч Г.Мэнд-Ооёо нарт талархахын ялдамд “Бурхан багшийн сургаал” номын анхдугаар хэвлэл хэвлэгдэн гарч монгол уншигч түмнийхээ гар дээр нь очсон номын авшига оршсон аргын тооллын 1995 он байсан билээ.

Тэр цагаас хойш хэдэн он улирахын зуур энэ ном олдохуйяа бэрх болсныг үзэж, бурхан номын үйлс ариун




байдгийг санагалзан дахин хянан хэвлүүлж уншигч таны өлмийд өргөн барьж байна.

Бурханы сургаал үүрд дэлгэрч, номын буян хурах болтугай.

М.Шагдарсүрэн

БУДДА



ШАГЖАМУНИ БУРХАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



1. БУДДАГИЙН НАМТАР

1. Гималайн нурууны өмнө бэлээр урсах Роохины голын эрэгт Шакья буюу Шагж овгийнхон амьдарч байжээ. Омгийн тэргүүн Суддана* хаан өөрийн гүрний нийслэл Капилавастүг байгуулан, сүрлэг их хэрэм цайзаа бариулан, төр улсаа мэргэнээр жолоодон, түмэн албатынхаа хайр хүндэтгэлийг хүлээн амьдардаг юмсанж.

Буддагийн эх Маяа хатан Шагж овгийн хөрш орны хааны гүнж бөлгөө. Хаан хатан хоёр дэр нэгдээд хорин жил өнгөрсөн авч хүүхэд төрүүлсэнгүй. Нэгэн шөнө хатан “Баруун хавирганы завсраар цагаан заан орж хэвлийд шингэв” хэмээн хачин сонин зүүд зүүдэлснээс хойш бие шалтгаантай болов. Хаан, түшмэл, харц олон агь төрөхийг хоног тоолон хүлээж байлаа. Тэр нутгийн заншлаар хатан төрхөмдөө очиж амаржих ёстой болж морилох замдаа



Лүмбиний цэцэрлэгт саатан амарчээ.

Эргэн тойрноо үзэсгэлэнтэй дэлгэрсэн Ашог* (Бодь модны) модны сүүдэрт тухлахдаа хатан баруун гараа сунгаж мөчирт хүрэхээр өндиймөгц агь хөвгүүн мэндэлжээ.

Их хатан хүү төрүүлсэнийг сонссон бүхэн тэсгэлгүй ихээр баясч, аз жаргалын дуугаа өргөв гэнэ.

Энэ мартагдашгүй өдөр бол 4-р сарын 8* байлаа.

Хааны баярласныг үгээр илэрхийлэхэд бэрх агаад хүүдээ Сиддарга (Сэдэдраднаа) хэмээх “Хүсэл бүхний биелэл” гэсэн утгатай нэр хайрлажээ.

2. Гэвч хааны ордонд энэ их баяр удаан үргэлжилсэнгүй. Хэдхэн хоногийн дараа эелдэг сайхан Маяа хатан гэнэт нас нөгчсөнд хатны дүү (Маха) Пражапата нь хаан хүүгийн өрлөг эх болж, хайрлан энэрч өсгөн хүмүүжүүлэв.

Тэдний омгоос холгүй ууланд оршин амьдрагч Асита хэмээх мэргэн даяанч хааны харшийн зүгээс их гэрэл цацрахыг нэгэн удаа үзжээ. Даяанч үүнийг нэгэн сайн үйлийн совин буйзаа хэмээн биширч уулнаасаа бууж ирэхүй дор хүүг түүнд үзүүлжээ. Тэрээр “Хаан хүү өөрийн ордонд өсөж торнивол ертөнцийг дагуулагч их хаан болно.

* Монголчууд судар шастиртаа Ариун идээт хаан хэмээн бичиж заншжээ.

* Монгол төвд судар шастирт Бодь мод хэмээн гардаг. Харин Ашог модыг монголчууд Гаслан үгүй мод хэмээн нэрлэдэг.

* Монгол төвд судар шастирт Буддагийн эхийн хэвлээс мэндэлсэн өдрийг хаврын тэргүүн сарын шинийн арван таванд хэмээн тэмдэглэжээ.

Харин ордныг орхин үнэний эрэлд даяан хийж, шашны мөр дагаваас ертөнц даяарыг аврагч Бурхан болно” хэмээн айлдав.

Хаан эцэг мэргэн даяанчийн үгийг сонсоод эхэндээ баярласан авч цорын ганц хүү нь гэр орноо орхин даяанчлан тэнүүчлэх вий гэхээс санаа нь зовних болов. Хаан хүү долоон наснаасаа эхлэн цэргийн урлаг болон утга соёл, зан заншил, ёс суртахуун, бүхий л эрдэмд суралцах хичээл заалгаж эзэмшсэн авч, бодол сэтгэл нь өөр зүйлийг эрэлхийлж байлаа.

Хаврын нэгэн өдөр хаан хүү эцгийн хамт зугаацахаар хэрмийн гадна гарахдаа нэгэн тариачин эр анжисаар газар хагалж байгаатай тааралдав. Нойтон шороотой хамт ил гарсан өт хорхойг шувуу шүүрэн авч идэхийг хараад сэтгэл шаналж “Ай халаг, амьтан гэдэг бие биеэ залгиж хөнөөж байх учиртай байх нь ээ” хэмээн халаглав.

Төрөөд удалгүй эхээсээ хагацсан хан хүү маань тэр жижиг амьтдын энэхүү эмгэнэлт явдлыг үзэж сэтгэл нь ихэд шаналав. Түүний сэтгэлийн энэ шарх зулзган модон дээрх сорви лугаа өсөж торних тутам нь өдрөөс өдөрт улам гүнзгийрч, хүний ертөнцийн аж төрөх зовлон түүнийг туйлын их шаналгаж байв.

Хаан эцэг нь даяанчийн зөгнөн хэлсэн үгийг эргэн санаад улам их шаналж, хаан хүүг зугаатай байлгаж, бодол санааг нь өөр зүгт чиглүүлэхэд чадах бүхнээ зориулж байлаа.

Хаан эцэг нь хүүгээ Дэвадаха цайзын тэргүүн Супрабуддагийн охин Яшодхара гүнжтэй 19 настайд нь гэрлүүлэв.

3. Арван жилийн турш тансаг харш шилтгээндээ дуу хуур, найр наадмын дунд байсан боловч хан хүүгийн

бодол санаа нь зовлон гэж чухам юу болох тухай, хүний амьдралын үнэн утга учрыг олж мэдэхийг хичээж байлаа. “Нэг л өдөр бид өвдөж, хөгширнө. Үхлээс зайлах арга үгүй. Амьдрал, эрүүл мэнд, залуу насны утга учир чухам юунд орших вэ? Амьдралын төлөө тэмцэж байгаа хүн мэдээж ямар нэг үнэ цэнтэй юмыг эрж байна гэсэн үг. Хүн амьдарч тэмцэж байна гэдэг бол эцэстээ ямар нэгэн юмыг эрж байгаа хэрэг. Гэвч нэг хэсэг нь зөв замыг нөгөө хэсэг нь буруу замыг эрж байна. Өвдөж, өтлөж, үхэх нь зайлшгүй атал хувиршгүй залуу нас, үхэшгүй мөнхийг хүсэх нь төөрөгдөл.

Хэрэв зөв замыг эрж байгаа бол өвчин, өтлөх, үхэхийн үнэн чанарыг таньж, хүний бүхий л зовлон хувирамтгай гэдгийг ойлгоно. Тансаг хангалуун энэ амьдралд би буруу замыг бэдэрч явах шиг байна “ гэж боджээ.

4. Сэтгэлийн энэхүү зовлон үргэлжилж, өдөр хоног урсан өнгөрсөөр, хаан хүү 29 нас хүрч байхад Рахүла хүү төрлөө. Өдрийн бодол шөнийн зүүд болсон сэтгэлийн зовлон нь эцэстээ гэр орноо орхин даяанчлах амьдралыг сонгоход хүргэжээ. Тэр нэгэн шөнө хайртай ганц цасан цагаан хүлэг Кантакатаа унан, үнэнч хөтөч Чандактайгаа хамт ордныг орхин оджээ.

Энэ үед шулмасууд түүнд “Чи ордондоо эргэж очих нь зөв, удахгүй бүх ертөнц чинийх болно” хэмээн ятгаж байлаа. Тэр хариуд нь “Надад энэ ертөнцөд юу ч хэрэггүй” хэмээн үсээ хусаж тойн болоод, бадар аягаа бариад, өмнө зүгийг зорин оджээ.

Хан хүү эхлээд Багава даяанчийнд хүрч, хатуужил хийхийг нь үзэж мэдлээ. Дараа нь Арада Калама бас Удрака Рамапутра нарын бясалгалаар нирваанд хүрэх аргыг сурахаар одлоо. Тэрээр хатуужлыг хэрхэн хийж буйг өөрийн

биеэр туршиж үзсэн боловч энэхүү арга гэгээрэх замд хүргэж чадахгүй гэдэгт үнэмшжээ. Эцэст нь тэр Магада оронд очиж Гаяа цайзын орчим урсах Найронжана голын эрэг дээрх Үрүвилвагийн ойд бясалгал үйлдэхээр оджээ.

5. Энэ нь үнэхээр сонсоод итгэхийн аргагүй бэрх зовлон, хатуу чанга, бясалгал даяанчлал байлаа. “Миний туулсан тэр хатуужил даяан нь урьд хэзээ ч болж байгаагүй, одоо ч байхгүй, хойшид ч тохиолдохгүй тийм бэрх хатуу даяанчлал байлаа” гэж тэрээр хожим нь хэлж байжээ.

Хэдийвээр тийм хатуужил даяаныг давсан боловч хан хүүгийн зорилго биелсэнгүй. Ойд зургаан жил хатуужил үйлдсэний дараа махбодын энэ зовлонг зогсоож, голд очин угаалга үйлджээ. Зэргэлдээх тосгонд амьдарч байсан залуу бүсгүй Сүжатагийн гараас аяга сүү ууж зовсон биеэ торджээ. Хаан хүүтэй хамт зургаан жилийн турш хатуужил даяаныг хийж байсан таван нөхөр нь бүсгүйн гараас сүү авах болсонд нь машид гайхаж, даяаныг тэсвэрлэж чадсангүй хэмээн үзээд орхин одоцгоожээ. Хаан хүү цор ганцаар үлдэв. Түүний бие нь туйлын дорой, амиа алдахын ирмэгт очсон боловч тэрбээр “Цус ширгэж, мах хатаж, яс үйрвэл үйрэг. Харин би Гэгээрэх замыг олтлоо энэ газрыг хэзээ ч орхихгүй” хэмээн өөртөө тангараглаж бясалгалын бас нэг шатанд орлоо. Энэ нь туйлын хэцүү, зүйрлэхийн аргагүй тэмцэл байлаа. Хорт муу шулмасын хорлол хөнөөлөөр ухаан санааг нь аймшигт хар сүүдэр нөмөрч, үй түмэн ээдрээ бодолд самууран, тэрээр галзуурах шахаж байв. Тэрбээр нягт нямбай, хүлээц тэсвэртэй, нухацтай цэгнэн тэмцсэний эцэст тэр бүхнийг ялж чадсан байна. Энэ бол яс үйрч, мах шуугдаж, цус ширгэсэн үнэнхүү хэцүү тэмцэл байлаа.

Харин тэнгэрийн зүүн хаяанаа үүрийн цолмон гарч ирэхэд хаан хүүгийн тэмцэл ялалтаар дуусч, ухаан нь гэгээн



өдөр шиг цэлмэг саруул болж ирлээ.

Ингэж тэр эцэст нь гэгээрч Бурхан боллоо. Энэ нь 12 дугаар сарын 8*-ны өглөө бөгөөд хаан хүү яг 35 настай байлаа.

6. Энэ цагаас хойш хан хүү Бурхан багш Будда, ялж төгс нөхцсөн, Татхагата, зарим хүмүүс Шакьямүни, Шагж омгийн мэргэн, зарим нь ертөнцийн их мэргэн зэргээр алдаршуулав.

Тэрээр эхлээд Варанасийн Мригадава руу урд түүнтэй хамт зургаан жил бясалгал хийж байсан таван даяанч дээр очлоо. Эхлээд тэд түүнээс дөлсхийж байснаа сургаалыг нь сонссоны эцэст биширч түүний сургаалын анх дагагчид боллоо. Тэгээд түүний урдын нөхөр байсан Бимби Сара хааныг Ража Гриха цайзад очин үнэмшүүлэн дагуулжээ. Эндээс цааш орон даяар аялан явж, өглөгийн хишгээр амьдран, өөрийн сургаалаа айлдсаар явлаа.

Цангаж өлссөн хүмүүс хоол унданд тэмүүлэхийн адил олон түмэн түүний сургаалыг хүлээн авч байлаа. Шарибудра, Маудгалиаяна (Шаарийбуу, Монголжийбуу) хэмээх хоёр их багш, хоёр мянган шавь нартайгаа Бурхан Будда дээр ирж шавь орлоо. Бурхан багшийн эцэг Суддана хаан хүүгээ орон гэрээ орхиод явсанд эхлээд дотроо ихэд шаналж байсан авч дараа нь түүний итгэлтэй шавь боллоо.

* /Бурхан багшийн арван хоёр зохионгуй/ зэрэг судар шастирт зуны тэргүүн сарын 15-нд 35-ны сүүдэртээ бурхан болохын ёсыг үзүүлсэн бөгөөд Бурхан багшийн эхийн хэвлийд заларсан, нирваан болсон дээрх гурван үйл явдал нэг өдөр давхацсан тул жил бүрийн зуны тэргүүн сарын 15-ныг Бурхан багшийн дүйцэн (их ёсолгооны) өдөр хэмээн тэмдэглэдэг.

Хойд эх (Маха) Пражапати, гэргий Яшодара гүнж болон Шагж гүрний бүх хүмүүс ирж Бурханы номлолыг дагалаа.

7. Дөчин таван жилийн турш Бурхан багш орон даяар хэрэн хэсч, өөрийн туулж Гэгээрсэн амьдралын замаа мөрдөх аргыг заан сургаж, сургаал номоо айлдаж явлаа. Гэвч наян насандаа Ражагараас Шравасти орох замдаа Вайсали балгасанд бие нь чилээрхэх үед, гурван сарын дараа нирвааны дүрийг үзүүлнэ хэмээн өөрөө айлджээ. Тэрээр Пава хүртэл заларсан бөгөөд, төмрийн дархан Чундагийн өгсөн хоолноос зооглосноор бие нь улам чилээрхжээ. Эцэст нь түүний бие нь улам дордон өвчин нь хүндэрч байсан ч Гүшинагарийн ойролцоох их ойд заларч очлоо. Хоёр том Сала модны хооронд амсхийн хэвтэх зуур сургаалаа эцсийн мөч хүртэл айлдсаар байжээ. Ертөнцийн агуу их багш болж төгс сургаалаа айлдсаныхаа эцэст ийнхүү нирвааны дүрийг үзүүлэв.

8. Бурхан багшийн хайртай шавь Анандын зарлигаар түүний цогцосыг Гүшинагарад чандарлажээ.

Ажатаватрү тэргүүтэй зэргэлдээх долоон гүрний их хаад чандарыг хувааж хүртээхийг шаарджээ. Гүшинагарийн хаан эсэргүүцэж, эцэстээ дайтахад хүрэв. Гэвч Дрона хэмээх мэргэний зөвлөснөөр чандарыг найман гүрэнд хуваан залуулжээ. Мөн цогцос чандарласан газрын үнс, шороог бас өөр олон гүрний хаадад дурсгал болгон хүргүүлэв. Бурхан багшийн чандар дурсгалыг тахихаар агуу том арван суварга сүндэрлүүлэв.



2. БУРХАН БАГШИЙН СҮҮЛЧИЙН СУРГААЛ

1. Бурхан багш Гүшинагарын Сала модны доор шавь нартаа сүүлчийн сургаалыг айлджээ.

“Өөрийгөө гэгээрүүл. Зөвхөн өөрийнхөө хүчинд түшиглэ. Хэнд ч бүү найд. Миний сургаал та нарын гэрэл гэгээ, түшиг тулгуур болог. Бусад номлолыг бүү дага, өөрсдийн бие махбодийг ариун бус хэмээн бодогтун.

Жаргал зовлон хоёр нь хоёулаа адилхан зовлонгийн шалтгаан болдог гэдгийг мэдэгтүн. Жаргал цэнгэлд бүү ташуур. Сэтгэлээ шинжээд “би” гэдэг юм үгүй болохыг мэдэгтүн. Өөрсдийн санасанд бүү төөрөгд.

Тэгвэл зовлонгоос зайлж чадна. Хэрвээ та нар эдгээр сургаалыг үнэнчээр дагаж чадах юм бол намайг энэ ертөнцөөс явсны дараа ч миний жинхэнэ шавь нар хэвээрээ

байх болно.

2. Шавь нар минь. Та нар миний хэлсэн сургаалыг хэзээ ч бүү орхиж мартагтун. Эдгээр сургаалыг үргэлж сонсож, бодож, бясалгаж, биелүүлж явагтун.

Хэрвээ та нар эдгээр сургаалыг мөрдвөл үргэлжийн аз жаргалтай байх болно.

Сургаалын гол утга нь оюун сэтгэлээ удирдахад оршино. Ухаанаа атаа шуналаас холдуулан зөв явж чадвал ухаан чинь цэвэр саруул, үг чинь шударга үнэн байх болно. Амьдрал мөнх биш, үргэлж хувирдгийг санан уур хилэн, атаа хорсол, мунхаг авираа хязгаарлах чадвартай бай. Тэгвэл бүхий л нүглээс зайлж чадах болно.

Хэрвээ ухаан санаа чинь тогтворгүй болж атаа жөтөө хөдөлвөл түүнийг хянаж хязгаарлах ёстой.

Ухаан сэтгэлдээ эзэн бай. Хүний ухаан өөрийг чинь бурхан, эсвэл адгуус болгоно. Эндүүрч төөрвөл буг чөтгөр ч болгоно. Ингэхээр оюун ухаанаа удирдан зөв замаас бүү хазайлга.

3. Та нар миний сургаалыг дагаж бие биеэ хайрлах ёстой. Та нар тос ус хоёр шиг нийцэхгүй марган тэмцэхээс зайлсхий. Ус сүү хоёр шиг сүлэлдэн найрч бай.

Та нар миний сургаалыг хамтдаа сурч судлан хэрэгжүүлэгтүн. Хайран оюун ухаан, цагаа үр ашиггүй дэмий балай, санаачилга самбаагүй сүйтгэж бүү үр. Зөв замын үр жимсийг тариалж, гэгээрэхүйн цэцэгсийг үржүүлэгтүн.

Та нарт хэлж буй энэ сургаалаа би өөрийн биеэр тэмцэж олж ирсэн билээ. Та нар энэ сургаалыг чанад мөрдөн



цагийн байдал бүрт тохируулагтун. Хэрэв та нар эдгээрийг цалгардуулбал надтай дахиад хэзээ ч учрахгүй гэсэн үг. Хэрэв мөрдөж чадах аваас бие тань хол авч сэтгэл тань надад туйлын ойр байна гэсэн үг.

4. Шавь нар минь. Миний сүүлчийн мөч ойртлоо. Бид хагацаж буй боловч бүү гашуудагтун. Амьдрал бол мөнхийн хувирал. Энэ бие задарч үгүй болохоос юу ч зайлуулж чадахгүй. Миний бие одоо хэнд ч хэрэггүй хэмхэрсэн тэрэг мэт боллоо. Үүнийг би одоо өөрийн биеэр үзүүлэх гэж байна. Дэмий бүү гашуудагтун.

Харин хувиршгүй мөнх юм байдаггүй гэдгийг, хүний амьдралын хоосон чанарыг үүнээс мэдэж авагтун. Хувирч өөрчлөгдөх юмыг хувиршгүй мэт санах нь бүтэхгүй хүсэл.

Ертөнцийн хүслийн шулам нь хүний ухааныг самууруулах чөлөө боломж эрэлхийлж байдаг. Хэрэв гэрт чинь могой байх юм бол зайлуулж гаргахгүйгээр тайван унтаж чадахгүй биз дээ. Та нар юуны өмнө өөрсдийн хүсэл шуналын хүлээсийг дээрх могойг зайлуулахтай адил тайлах хэрэгтэй.

5. Та нар өөрийн оюун ухааныг зөв хамгаалах хэрэгтэй. Үхэл гэдэг бол энэ бие махбодийн л төгсгөл гэдгийг бүү мартагтун. Бие махбод бол эцэг эхээс төрж, хоол ундаар тэжээгддэг болохоор өвчин болоод үхэл зайлшгүй хэрэг.

“Гэвч Бурхан бол хүний бие бус”. Энэ бол Гэгээрэл мөн. Хүмүүний бие үхэх нь жам ёсоо. Гэгээрлийн мэргэн ухаан номын үйл мөнхөд орших болно. Зөвхөн миний биеийг үзэж байгаа хүн бол үнэндээ намайг харж байгаа хүн биш. Харин миний сургаалыг авч байгаа хүн бол намайг харж байгаа хэрэг мөн билээ.

Намайг нөгцсөний дараа миний сургаал ном /Дхарма/ та нарын багш болог. Миний номын дагуу явбаас та бүхэн надад үнэнч байх болно. Би амьдралынхаа сүүлийн дөчин таван жилийн турш сургаалаасаа ер гажаагүй.

Энэ сургаал бол нууц биш. Ямар нэгэн далд утга ч үгүй, юм бүхэн ил тодорхой бөлгөө. Миний эрхэм шавь нараа, ингээд салах цаг боллоо. Энэ агшинд би нирвааны дүрийг үзүүлэх болно. Энэ бол миний сүүлчийн сургаал болой.



МӨНХИЙН БУДДА ХОЁРДУГААР БҮЛЭГ



1. БУРХНЫ НИГҮҮЛСЭЛ БА САХИЛ

1. Бурханы сэтгэл гэдэг нь агуу их энэрэн хайрлах, нигүүлсэхүйн сэтгэл юм. Агуу их энэрэн хайрлах сэтгэл бол амьтан бүхнийг ямарч үнээр хамаагүй аврах сэтгэл болой. Бурханы нигүүлсэл сэтгэл бол хүмүүсийг өвдвөл адилхан өвдөх, зовбол адилхан зовох чин хүсэл юм.

“Чиний зовлон миний зовлон, чиний жаргал миний жаргал” хэмээн Бурхан багш айлджээ. Бурханы энэ сэтгэл нь үрээ элбэрэх эхийн хайр шиг нэгээхэн хором ч зовлонт хүнийг мартаж үл чадна. Үүнд л энэрэн хайрлах Бурханы чанар оршино.

Бурханы энэрэн хайрлах сэтгэл нь хүний тусын тулд үүсэн гарчээ. Энэ нь эх хүн үрээ хайрласны ачаар хүүхэд нь аюулгүй амар тайван өсдөгийн адилаар Бурханы нигүүлсэнгүй сэтгэлийн хариуд хүний итгэсэн сүсэг бишрэл

өөрийг нь Гэгээрэлд хүргэдэг болно. Гэвч хүмүүс Бурханы энэ сэтгэлийг ойлгохгүйгээсээ болж, тэнэг мунхаг сэтгэлээс үүдэх ертөнцийн шуналын урхинд ойчиж, хүсэлдээ хүлэгдэн зовсоор л байна. Тэд ертөнцийн шуналаар хуримтлагдсан үйлийн үрээр нүгэлт үйлийнхээ хүнд ачааг үүрэн эндүүрэл төөрөгдлийн манан дунд бэдчин туйлдсаар л байна.

2. Бурханы энэрэн нигүүлсэх сэтгэл гэдэг зөвхөн энэ ертөнцийн амьдралаас хязгаарлагдана гэж бүү бодогтун. Энэ агуу их сэтгэл маш эрт цагаас хүмүүс төрж үхэх, эндүүрэх, зовлонгийн хүрдэнд эргэлдэх тэр цагаас эхлэн одоог хүртэл үргэлжлэн буй билээ. Энэрэн хайрлах сэтгэл бол мөнх бөгөөд, хэмжээ хязгаар гэж үгүй.

Бурхан, хүний өмнө хамгийн ойр дотных нь дүрд шингэн түүнд хамгийн мэргэн бөгөөд хялбар аргаар ач тусаа хүргээдэг.

Шагжмуни Бурхан Шагж овогт хан хүү болж төрөн, Даяанчийн амьдрал хөөхөөр тансаг ордноо орхин одож, хатуужил бясалгал үйлдсэнээр Гэгээрэлд хүрч хүмүүст ном сургаал айлдаж, эцэст нь өөрөө нирваан дүрийг үзүүлж хүмүүст үхлийн мөн чанарыг ухааруулсан. Хүний ертөнцийн төөрөгдөл арилахгүй цагт Бурхан багшийн сургаал номлол хүмүүст хэрэгтэй хэвээр байх болно. Хүний нүгэл ёроолгүйтэй адил Бурханы нигүүлсэнгүй сэтгэл нь хязгааргүй юм.

Бурхан ертөнцийн амьдралаас тасрахаар шийдэж дөрвөн их тангаргийг тавьжээ.

1. Бүх хүмүүсийг аврах,
2. Ертөнцийн бүх эндүүрэл төөрөгдлийг арилгах,
3. Бүх сургаалыг судлах,
4. Төгс Гэгээрэлд хүрэх.



Эдгээр тангараг (сахил) бол Бурханы мөн чанарын үндэс болсон агуу их нигүүлсэн энэрэхүйн илрэл юм.

3. Бурхан эхлээд юуны өмнө аливаа амь таслах нүглийг тэвчихийг сургаж, бүх хүмүүс урт наслаж, удаан жаргахын ерөөл тавьсан билээ.

Бурхан хулгай хийх нүглээс ангижран бүх хүмүүс хэрэгцээтэй бүх зүйлээрээ үл дутагдах хангалуун амьдралыг хүсэн залбирсан.

Бурхан хүсэл тачаалаас зайлж чадсан бөгөөд бүх хүмүүс хүсэл шуналд зовохгүйгээр цэвэр ариун сэтгэлийн аз жаргалыг эдлээсэй гэж залбирсан.

Бурхан дээрх зорилгодоо хүрэхдээ хууран мэхлэхээс зайлсхийж, бүх хүмүүс шударга, амгалан байх болтугай гэж хүссэн.

Бурхан зөрүүд мугуйд зангаас зайлж, бүх хүмүүс эв найртай нөхөрлөж хамтдаа жаргахыг залбирсан.

Бурхан аливаа хов живээс зайлж бүх хүмүүс бие биедээ тустай амьдрах, ухаан тогтуун, сэтгэл зөөлөн байгаасай хэмээн залбирсан.

Бурхан дэмий юм чалчихаас зайлж бусад хүмүүсийг бие биеэ ойлгон найрсаг байхыг залбирсан.

Бурхан ховдог шунахай сэтгэлээс зайлж бусад бүх хүмүүс чөлөөтэй амгалан тайван байж шуналаас ангид амьдрахыг залбирсан.

Бурхан мунхаг ба харанхуйг мэдэхийг тэвчиж, бүх хүмүүс үйлийн үрийг марталгүй үргэлж бодож бясалгаж явахыг залбирсан.

Тийнхүү Бурхан багшийн энэрэн нигүүлсэхүйн сэтгэл нь бүх хүмүүсийн аз жаргал, амар амгалангийн төлөө

зориулагдсан болой.

Бурхан багш эцэг эх нь хүүхдээ хайрладгийн адил хүмүүст хамгийн их аз жаргалыг хүсэж, тэдгээрт эндүүрэл зовлонгийн далайг эсэн мэнд гатлан туулахыг номлон залбирч байдаг.





2. БУРХАНЫ ТУС, АВРАЛ

1. Эндүүрлийн далайд живж байгаа хүмүүсийн зүрх чихэнд Гэгээрлийн гэрэлт эргээс Бурханы дуу хоолой сонсогдохгүй байлаа. Иймд Бурхан өөрөө эндүүрлийн далайд буун ирж тэднийг аврах аргыг зааж айлджээ. “Одоо би та нарт нэг үлгэр сонсоё” хэмээгээд:

“Урьд нэг баян хүн байжээ. Түүнийг гадагш яваад ирэхэд гэр нь шатаж байгааг хүүхдүүд нь мэдэхгүй улайран тоглосоор байлаа. Түргэн гарцгаагаарай, Наана чинь гэр чинь шатаж байна гэж эцэг нь сандран хашгирсан боловч хүүхдүүд нь анзаарсангүй. Сандарсан эцэг нь ухаан сийлж,

– Хүүхдүүдээ! Би та нарт хачин гоё тоглоом авчирлаа. Түргэн гараад ирцгээ” гэхэд тэд сая сонсож шатаж буй гэрээсээ гүйлдэн гарч ирж түймрээс аврагджээ.

Энэ ертөнц дэх бидний амьдрал дээрх шатаж буй гэртэй адил юм. Гэвч хүмүүс гэр нь шатаж буйг анзаарахгүйгээс аюул нүүрлэсэн гэртээ амьдарсаар л байна.

Иймээс Бурхан агуу их энэрэн нигүүлсэнгүй сэтгэлээр хүмүүсийг аврахын тулд үлэмжийн ач тусгаа хүртээж байна.

2. Бурхан багш бас нэг үлгэр айлдсан нь:

– “Эрт цагт нэг баян айлын ганц хүү гэрээ орхин ертөнцийг үзэхээр одсон боловч түүнд гай тохиолдож тэрээр гуйлгачин болжээ.

Эцэг нь хүүгийн эрэлд гарч дэвэн дэлхийг тойрсон боловч хүүгээ олсонгүй. Ингээд маш олон жил өнгөрсний дараа гуйлгачин хүү нь баян эцгийн амьдарч буй хотод санамсаргүйгээр тэнүүчлэн орж иржээ. Эцэг нь хүүгээ төвөггүй таньж түүнийг авчруулахаар зарц нараа илгээв. Хүү нь ордны сүр жавхлант хүмүүсийг хараад өөрийг нь хуурч байна гээд явсангүй.

Баян эцэг нь түүнийг гэртээ хөлсний ажил хийлгүүлэхээр зарц нараараа мөнгө илгээжээ. Хүү нь мөнгийг авч тэдэнтэй хамт эцгийн гэрт ирж зарц болжээ. Харин эцэг нь өөрийгөө огт танихгүй байгаа хүүдээ аажим аажмаар чухал итгэмжит ажил даалган, улмаар түүнийг бүхий л өмч хөрөнгө болоод эрдэнэсийн сангийн түлхүүрийг мэдэх хүртэл дэвшүүлжээ.

Эцэг нь хүүгээ үнэнч шударга, хөдөлмөрч хүн болсонд туйлын их баярлаж, өөрийнхөө амьдрах хугацаа нэгэнт ахархан болсныг мэдээд өөрийн төрөл төрөгсөд, найз нөхөд, ойр дотны хүмүүсээ цуглуулж хэлсэн нь:

– За энэ хүү бол миний олон жил эрсэн ганц хүү минь билээ. Энэ мөчөөс эхлэн миний бүх л эд хөрөнгө, эрдэнэс энэ хүний өмч болно гэв.

Хүү эцгийн гэрээслэлд гайхан баясаж: Юутай их аз завшаан билээ. Би эцгээ олсон төдийгүй энэ их хөрөнгө зoorь минийх боллоо” гэв.



Энэ үлгэрт гарч буй баян хүн нь Бурхан багш, тэнүүлч хүү нь бүх хүмүүс юм. Бурханы өрөвдөн хайрлах нигүүлсэнгүйн сэтгэл нь өөрийн ганц хүүгээ хайрлах эцгийн адил болой.

Бурхан бүх хүмүүсийг зөв замд хөтлөхдөө тэдэнд Гэгээрлийн эрдэнийг хайрласнаар ухааныг нь баяжуулдаг билээ.

3. Тэнгэрийн хур газарт алаггүй буухад хөрс ургамал ижилгүй шим авдгийн адил Бурхан нигүүлсэнгүйн сэтгэлээ хүн бүхэнд ав адилхан хайрласаар атал хүмүүс түүнээс харилцан адилгүй хүртдэг билээ.

4. Эцэг эх нь үр хүүхдээ бүгдийг хайрлах боловч өвчтэй хүүхдээ онцгой энхрийлнэ. Бурханы нигүүлсэнгүй сэтгэл бүх хүмүүст адил хандах боловч мунхаг болон зовж зүдэрсэн, нүглийн хүнд ачаа үүрэгсдэд онцгой туслана.

Нар дорно зүгээс мандаж харанхуйг хөөхдөө газар дэлхийг алаггүй гийгүүлдэгийн адил Бурханы нигүүлсэнгүй сэтгэл бүх л хүмүүсийг алагчлахгүй ивээж, нүглийг арилгаж, буяныг тэтгэж, ухааны гэрлээр гийгүүлэн, мунхаг, үл мэдэхийн сүүдрийг зайлуулан хүмүүсийг гэгээрэх замд хөтөлдөг билээ.

Бурхан энэрэн нигүүлсэх сэтгэлээр эцэг хүн шиг, өрөвдөн хайрлах сэтгэлээр эх хүн шиг билээ. Бурхан энэрэн нигүүлсэхүйн сэтгэлээр энэ дэлхийн бүх хүний сайн сайхны төлөө ханддаг билээ.

Бурханы энэрэн нигүүлсэхүйн сэтгэл үгүйгээр хүмүүс аврагдаж чадахгүй юм. Бүх хүмүүс түүний үр хүүхэд адил Бурханы авралыг хүртэх ёстой.



3. МӨНХИЙН БУДДА

1. Хүмүүс Бурханыг хан хүү болон төрж, даяан хийхээр ордноо орхин одож, бясалгал үйлдэж Гэгээрлийг олсон тэр хүнээр боддог. Гэвч Бурхан бол эхлэл, төгсгөл үгүй энэ ертөнцөд мөнх оршдог билээ.

Мөнх залрах Бурхан багш хүн болгоныг мэддэг бөгөөд тэднийг бүхий л аргаар авардаг. Бурханы номлосон мөнхийн ном Дхармад хуурмаг үгүй билээ. Бурхан энэ ертөнц дээрх бүх юмыг яг байгаагаар нь мэдэж түүнийгээ хүмүүст сургаж буй билээ.

Үнэндээ ертөнц дээр байгаа юмыг байгаагаар нь мэдэх шиг хэцүү юм үгүй билээ. Яагаад гэвэл: Зөв санагдсан юм буруу байдаг, буруу санагдсан юм зөв болдог. Ухаангүй хүмүүс ертөнцийн үнэнийг ойлгож чадахгүй.

Ганцхан Бурхан л ертөнцийг байгаагаар нь төгс үнэнээр ойлгож мэдсэн. Иймээс Бурхан энэ зөв, эсвэл буруу, эсвэл



үнэн, энэ худлаа, эсвэл сайн, муу гэж хэлдэггүй. Энэ ертөнцийг байгаагаар нь л дүрсэлдэг. Хүн бүхэн зан үйл, итгэл сүжгийнхээ хэрээр буяны үрийг тарьж байх ёстой хэмээн Бурхан сургажээ.

2. Бурхан, сургаал номлолоор төдийгүй үйл ажлаар сургаж илт үзүүлдэг билээ. Бурханы амьдралд эхлэл, төгсгөл гэж үгүй боловч шунал хүсэлт хүмүүсийн нүдийг нээхийн тулд ертөнцийн мөнх бусыг үзүүлдэг. Ингэснээр хүн төрөөд эцэст нь үхдэг гэдгийг үзүүлж буй хэрэг.

“Нэг эмч гэрээсээ гараад ирэх хооронд хүүхдүүд нь самсаргүйгээр хор уучихжээ. Эмч эргэж ирмэгц хүүхдүүдээ хордсоныг мэдээд яарч сандран, хорын эсрэг анагаах эм бэлдэж өгчээ. Хөнгөн хордсон нэг нь эмийг ууж эдгэсэн боловч, гүн хордсон зарим нь эм уухаас татгалзжээ. Эцэг нь хүүхдээ хурдан эдгээхийн тулд арга зохион:

“Би урт холын аянд явах хэрэгтэй боллоо. Миний нас өндөр болж, хэзээ үхэхийг мэдэхгүй. Би та нартай хамт байсан бол өчүүхэн боловч тус болох магад. Гэтэл алс замд явахаас аргагүй боллоо. Хэрэв та нар энэ эмийг уухгүй бол үхлийн аюулд учирч болно шүү. Намайг өөд болсныг сонсвол энэ эмээ шалавхан ууж түргэн эдгэхийг бодоорой” гэж захиад алсын аянд гарчээ. Удалгүй эмч насан өөд болсон гэсэн мэдээг элчээрээ хүргүүлжээ.

Хүүхдүүд нь сонсоод туйлын их гашуудаж: Эцэг минь нэгэнт үгүй боллоо. Одоо биднийг хэн хамгаалах билээ хэмээгээд эцгийн захисан сүүлчийн үгийг санаж, үлдээсэн эмийг нь ууж даруй эдгэрчээ.

Энд эмч эшгийг мэхэллээ хэмээн буруутгах аргагүй. Бурхан багш яг энэ эмч эцэгтэй адил билээ. Бурхан хүсэл шуналын хүлээсэнд орж юм харахаа больчихсон хүмүүсийг аврахын тулд энэ ертөнцийн үхэл, амьдралын тухай үлгэр домгийг зохиож ухааруулдаг юм.

БУРХАНЫ ДҮР БОЛООД БУЯН ГУРАВДУГААР БҮЛЭГ



1. БУРХАНЫ ДҮРИЙН ГУРВАН ТАЛ

1. Бурханыг хэлбэр болон шинжээр нь таних гэж оролдсоны хэрэггүй. Хэлбэр дүрс жинхэнэ Бурханд байдаггүй. Үнэн Бурхан гэдэг бол Гэгээрэл мөн. Бурханыг таних үнэн зам бол Гэгээрэлд хүрэх явдал юм.

Хэрвээ хэн нэгэн Бурханы гайхамшигт зургийг хараад Бурханыг үзлээ хэмээн бодвол Гэгээрээгүй нүдний эндүүрэл болно. Жинхэнэ Бурхан бол энгийн хүний нүдэнд үл харагдмой. Бурханыг хэлбэр дүрсээр нь хэзээ ч таньж чадахгүй. Мөн Бурханыг ямарч будгаар зурах боломжгүй. Бас Бурханы шинжийг хүний хэлээр тодорхойлон бичих аргагүй билээ. Бид Бурханы дүрийн тухай ярьдаг боловч мөнхийн Бурхан бол хэлбэр дүрс үгүй. Гэвч Бурхан ямар нэг сайхан дүрээр илрэн гарч ирж болно. Хэрвээ хэн нэг нь Бурханыг хэлбэр дүрсгүйгээр тод харж чадсан бол үнэнхүү



Бурханыг олж үзэх чадварыг эзэмшлээ гэсэн үг.

2. Бурханы бие гэдэг бол тэр чигээрээ Гэгээрэл мөн. Хэлбэр үгүй, мөн чанар үгүй, хэзээ ч эвдэрч устахгүй, мөнхийн Гэгээрэл мөн. Хоолоор тэжээгддэг бие махбод бус, мөн чанар нь мэргэн ухаан болсон мөнхийн Гэгээрэл билээ. Ийнхүү Бурхан өөрчлөгдөшгүй мөнх оршино.

Ингэхлээр Бурхан Гэгээрэл байсан цагт хэзээ ч алга болохгүй. Гэгээрэл бол мэргэн ухааны гэрэл болон цацарч, хүмүүсийг гийгүүлэн Бурханы оронд хөтөлнө. Энэхүү үнэнийг ухаарч буй хүн бол Бурханы шавь болж, сургаалыг нь хүртэл дагаж, хойч үедээ дамжуулна. Бурханы хүчнээс илүү гайхамшиг гэж юу ч үгүй.

3. Бурхан гурван үндсэн талтай. Үндсэн тал буюу Бурханы яг мөн чанар Дармакаая, хүч чадварын тал буюу Самбогакаая, Нирманакаая буюу хэлбэр дүрсээр илрэх бие гэж буй.

Дармакаая нь номын мөн чанар. Үнэний өөрийнх нь мөн чанар болно. Мөн чанарын талд Бурханд ямар нэгэн дүрс юмуу өнгө үгүй билээ. Бурхан хаанаас ч ирээгүй, хаашаа ч явахгүй. Яг хөх тэнгэр шиг бүхний дээр оршном. Бурхан залардаггүй газар гэж хаа ч байхгүй.

Бурханыг хүн бодсоноор гарч ирдэггүй, мартсанаар алга болдоггүй. Бурхан хүмүүсийг баяртай үед нь гарч ирдэггүй, гунигтай үед нь алга болдоггүй.

Хүмүүс бодсон ч, бодоогүй ч, хаа ч, хэзээ ч байсаар л байна. Бурханы бие нь энэ ертөнцийн бүх л өнцөг буланг дүүргэж, хүмүүс Бурханд итгэнэ үү, эргэлзэнэ үү огт хамаарахгүйгээр мөнхөд оршмуй.

4. Самбогакаяа гэдэг нь Бурханы өөрийн байгалийн чанарыг үзүүлж, нигүүлсэнгүй сэтгэл, мэргэн ухаан хоёрыг нийлүүлсэн, ямар нэгэн дүрсгүй, сахил сахих, үхэх төрөхийн бэлэгдлийг илэрхийлж, бүх хүнийг аврахын тулд оршино.

Нигүүлсэнгүй бол Бурханы энэ талын мөн чанар нь бөгөөд зовлонгоос ангижирахыг хүсэгч хүн бүхнийг аврахад тусална. Тосоо дуустал асах бамбарын адил Бурханы нигүүлсэнгүйн чанар нь ертөнцийн зовлон шавхагдтал хэзээ ч унтрахгүй. Салхи тоосыг үлээж зайлуулдаг шиг Бурханы нигүүлсэнгүй чанар нь хүний зовлонгийн тоосыг хийсгэн арилгана.

Нирманакаяа гэдэг нь Бурхан хүмүүсийг аврахын тулд түүний өмнө ямар хүн байна гэдгээс шалтгаалж, тэдний зан чанар, чадварт нь тохируулж, ертөнц дээр гарч ирж хүмүүст үзэгдэх Бурханы нэг хэлбэр юм. Бурхан хүмүүсийг зөв замд хөтлөхийн тулд энэ биеэрээ ертөнцийн хүмүүний дүрд шингэн төрж, ертөнцийг орхиж, мөн Гэгээрэлд хүрэх зэрэг бүхий л аргыг хэрэглэдэг юм. Бурханы жинхэнэ дүр нь Дармакаяа боловч хүний зан ааш өөр өөр байдгаас Бурхан ч янз янзын дүрээр гарч ирдэг юм. Бурханы дүр нь хүмүүсийн хүсэл, сэтгэл, чадвараас хамаарч тэдэнд өөр өөр дүрээр харагдах боловч үнэндээ тэр чигээрээ номын үнэн Гэгээрэл билээ. Хэдийвээр Бурхан гурван дүртэй боловч хүмүүсийг аврах ганц зорилготой.

Бурхан энэ ертөнцөд газар сайгүй өөрийн чанараа илэрхийлдэг боловч энэ илэрхийлэл нь өөрийн нь бие биш билээ. Учир нь Бурхан бол хэлбэр дүрс, биегүй юм. Бурханы бие гэдэг бол энэ ертөнцийг дүүргэж байдаг Гэгээрэл юм. Гэвч Бурхан зөвхөн үнэний мөн чанарыг олж мэдсэн тэр хүнд л мөн дүрээр үзэгдэнэ.



2. БУРХАН ҮЗЭГДЭХ

1. Энэ ертөнцөд Бурхан үзэгдэх нь ховор юм. Одоо Бурхан энэ ертөнц дэх хүмүүсийн эргэлзэх сэтгэлийн хүлээ баглааг урж, хорт сэтгэлийн үндсийг таслахын тулд Гэгээрлийн номыг айлдаж, хаа сайгүй төгс чөлөөтэй заларч байна. Бурханыг хүндлэхээс илүү сайн үйл гэж үгүй.

Бурхан зовлонт хүмүүсийг орхих сэтгэлгүй учир эндүүрэл төөрөгдлийн энэ ертөнцөд гарч ирдэг билээ. Бурханы ганц зорилго бол хүн бүхэнд номыг айлдаж, үнэнхүү аз жаргалыг хүртээхэд оршдог билээ.

Хүмүүс нь шуналын далайд живж, биеийн болоод сэтгэл санааны хувьд доройтсон, шударга бус байдал ноёлсон энэ нийгэмд номыг айлдана гэдэг бэрх юм.

2. Бурхан энэ ертөнцийн бүх хүний хамгийн сайн нөхөр агаад ертөнцийн шуналын хүнд ачаанд зовж буй нэгнийг харвал ачааг нь үүрэлцэнэ. Эндүүрэлд төөрсөн хүнтэй учирваас мэргэн ухааныхаа ариун гэрлээр түүнийг Гэгээрүүлнэ. Бурхан бол энэ ертөнцийн жинхэнэ үнэнч багш болой. Тугал эхээсээ холдож чаддаггүйтэй адил Бурханы сургаал нь үргэлж аз жаргал авчирдаг учир сургаалыг нь хүртэгчид нь Бурханаас салж чаддаггүй. Учир нь түүний сургаал туйлын үнэн байдаг.

3. Сар харагдахгүй болоход бид сар шингэлээ гэж ярьдаг. Сар гарч ирэхэд сар мандлаа гэдэг билээ. Гэвч сар тэнгэртээ л мөнх оршино. Үнэндээ сар шингэдэг ч үгүй, алга болдог ч үгүй. Бурхан яг сартай адил гарч ирдэг ч үгүй, алга болдог ч үгүй. Гагцхүү хүмүүсийн нүдэнд үнэнийг нээж өгөхийн тулд төрж байгаа юм шиг, үхэж байгаа юм шиг харагдана.

Хүмүүс сарыг хэлбэрээр нь дугариг сар, хавирган сар гэж нэрлэх боловч сар нь үнэндээ хотгор ч бус, гүдгэр ч бус яг дув дугираг. Бурхан бас сартай яг адил. Хүмүүсийн нүдэнд Бурхан дүрээрээ янз янз үзэгдэх боловч үнэндээ Бурханы мөн чанар өөрчлөгддөггүй.

Сарны туяа, хүн багширсан их хотын дээгүүр, зэлүүд тосгон, уул усны дээгүүр ч хааяагүй л тусна. Мөн цөөрмийн гүнд, аягатай цайнд тэрч атугай навчинд тогтсон шүүдрийн дусал дээр ч тусна. Хүн зуу зуун бээр явсан чиг сар түүнтэй хамт байна.

Харахад сар өөрчлөгдөж байгаа юм шиг боловч үнэндээ нэг л хэвэндээ тэнгэр огторгуйдаа заларсаар л байдаг. Бурхан сартай яг адил, энэ ертөнцийн хүмүүсийн орчин өөрчлөгдөж байгаатай уялдан янз бүрийн хэлбэрээр илэрхийлэгдэх боловч түүний мөн чанар нь хэзээ ч өөрчлөгдөхгүй.



4. Бурхан гарч ирэх, алга болох нь шалтгаан нөхцлийн хуулиар тайлбарлагдана. Тухайлбал, шалтгаан нөхцөл тохирсон үед Бурхан гарч ирж, мөн шалтгаан нөхцөл тохиороогүй үед Бурхан үзэгдэхгүй болно.

Бурхан гарч ирсэн ч, үзэгдэхгүй болсон ч Бурханы чанар тэр хэвээрээ л байна. Бурхан өөрийнхөө илрэлээр төрж байгаа юм шиг, үхэж ч байгаа юм шиг харагдавч үнэн хэрэгтээ Бурхан төрдөг ч үгүй, үхдэг ч үгүй. Энэхүү үнэнийг олж мэдээд ертөнцийн нөхцөл байдал, хүрээлэн байгаа орчны байнгын өөрчлөлт болон Бурханы дүрийн хувиралд сэтгэлээ эзэмдүүлэлгүй төгс ухааныг олж Гэгээрлийн замд хүрэх хэрэгтэй.

Бурхан бол бие махбод бус Гэгээрлийн биелэл билээ. Биеийг ямар нэгэн агуулах сав гэж бодоод түүнийг Гэгээрлээр бүрэн дүүргэвэл түүнийг Бурхан гэж нэрлэж болно. Тэгэхээр зөвхөн Бурханы биед нь татагдсан хүн дүрийг нь алга болоход гашуудаж байгаагаараа жинхэнэ Бурханыг харах чадваргүй байна гэсэн үг юм. Үнэн хэрэгтээ бүх юмсын жинхэнэ чанар нь хоосон, аливаа юмсын хооронд ялгаа гэж огт үгүй. Байна байхгүй, ирэх очих, сайн муу хоёрын хооронд ч ялгаа гэж байхгүй. Бүх юмс бол мөн чанарын ялгаа байхгүй төгс хоосон чанартай.

Аливаа юмсын ялгаа гэдэг бол хүн, үзэгдэл, юмсыг эндүү ташаа ухаарснаас үүсдэг билээ. Бурханы үнэн дүр бол алга болдог ч үгүй, гарч ирдэг ч үгүй мөнх орших чанар юм.

3. БҮРХАНЫ БУЯН

1. Бурхан багш дараахи таван буянаар ертөнцийн хүндлэлийг хүлээжээ. Үүнд; Зөв явдал, зөв үзэл, төгс ухаан, төгс чадвар, зөв замд хүмүүсийг хөтлөх гайхамшигт хүч эдгээр болой.

Үүнээс гадна найман агуу их чадварыг эзэмшжээ.

- ② Хүмүүст аз жаргал сайн сайхны баялгийг бэлэглэдэг.
- ② Бурханы сургаал энэ ертөнц дээр их ач тусыг хүргэсээр байна.
- ② Үнэн худал, сайн муугийн ялгааг сургаж байна.
- ② Зөв замд сургаж, Гэгээрэх замд хөтөлж байна.
- ② Бүхнийг нэгэн зорилгод чиглүүлж байна.
- ② Бурхан бардамнах, онгирах явдлаас ангижруулна.



- ② Үгэндээ үнэнч бөгөөд хэлснээ үйл болгож, ямагт биелүүлнэ.
- ② Сахил тангаргаа заавал биелүүлнэ.

Бурхан бясалгалаар энх амгалангийн сэтгэлийг олж хүн бүхэнд энэрэн хайрлах, нигүүлсэнгүй гэрлийг цацруулж байна. Бурхан шунал, хиртсэн сэтгэлээс бүрэн чөлөөлөгдөж, зөвхөн ариун сэтгэлтэй хүн эдлэх дээд аз жаргалыг хүртсэн билээ.

2. Бурхан энэ ертөнцийн хүмүүсийн эцэг нь ч, эх нь ч билээ. Хүүхдийг төрөөд арван зургаан сар болтол эцэг эх нь хүүхдийн хэлээр ярина. Тэгээд алгуурхан том хүний яриагаар харилцана. Бурхан бас өөрийг нь таньж чадах дүрээр хүмүүсийн өмнө гарч ирж, хүмүүсийн хэлээр сургаалаа айлдаж, амар амгалангийн ертөнцөд дагуулан удирдана.

Бурхан сургаалаа нэг хэлээр айлдах боловч хүмүүс зөвхөн өөрт нь хандсан мэтээр өөр өөрийнхөө хэлээр хүлээж авна. Бурханы сэтгэл нь төөрөгдсөн хүнд ухаарахын арга үгүй, үгээр илэрхийлэх боломжгүй, гагцхүү үлгэрлэн тайлбарлахаас л өөр аргагүй юм.

Их мөрнийг заан, адуу мал, загас, яст мэлхий зэрэг амьтад үргэлж булингартуулах боловч ямагт цэвэршин урсдаг билээ. Бурхан бас энэ их мөрний адил болой. Загас, жараахай урсгал сөрж хичнээн сэллээ ч нэмэргүй, их мөрөн урссаар байх амуй. Үүн лүгээ адил Бурханы ариун сургаал ч цэврээрээ хиртэлгүй оршиж бидний үед хүрч ирмүй.

3. Бурханы мэдлэг нь төгс Гэгээрэл тул үгээр илэрхийлэх аргагүй. Бурхан аливаа туйлшралаас зайлсхийж, ямагт голч (дундач буюу төв) замыг баримталдаг билээ.

Бурхан ялж төгс Гэгээрсэн тул энэ ертөнцийн бүх явдал, хүний бодол сэтгэлийг нэгэн агшны дотор мэдэх чадвартай.

Тэнгэрийн одод тэнгэрт тусдаг шиг бүх хүний бодол санаа Бурханы гэгээн мэлмийд ил тодорхой. Иймээс Бурханыг Ялж Төгс Гэгээрсэн хэмээмүй.

Бурханы мэргэн ухаан нь хүний хөшүүн ухааныг задалж Гэгээрүүлж, амьдралын утга учир дунд орших үйлийн үрийг ухааруулж байна. Түүнчлэн үхэх төрөх, шалтгаан үр, үнэнийг харах нүдийг нээж өгч байна.

4. Бурхан дүрээрээ хүмүүст үргэлж харагддаггүй. Заримдаа чөтгөр шиг эсвэл бүсгүй хүн шиг, ноён шиг, төрийн зүтгэлтэн шиг, тэрч байтугай мөрийтэй тоглоомчин шиг явах нь бий.

Тахал дэгдэхэд эмч болж, эм барьж, сургаал айлдана. Дайн болоход хүмүүсийг гай зовлонгоос ангижруулна. Аливаад дан ганц талыг баримтлах хүмүүст энэ ертөнцөд хувиршгүй юм юу ч үгүй гэдгийг сургана. Бардам зан болоод хувиа хичээгч хүмүүст даруу зан, амь биеийг үл хайрлах чанарын гайхамшигийг сургана. Ертөнцийн жаргал цэнгэлд халгиж яваа хүмүүст гай зовлон гэж байдгийг үзүүлж ухааруулж байна.

Амьдралын бүх тохиолдолд илэрч байдаг Бурханы бүхий л үйл нь Дармакаяагаас (Бурханы жинхэнэ мөн чанар) үндэслэлтэй.

Бурханы өрөвдөн хайрлах, энэрэн нигүүлсэхүй сэтгэл нь хязгааргүй. Гэрэлт Дармакаяагаас үүсэн гарч хүн төрөлхтөнд авралыг авчирж байна.



5. Энэ ертөнцийн амьдрал нь шатаж сүйдсэн гэр дахин цогцлоод, мөн эргээд шатаж нурам болдогтой адил ажээ. Хүмүүс мунхагийн харанхуйгаасаа болж будилж, уур хилэнцээсээ болж ухаанаа гэж, бие биедээ атаархан, гомдон тэмцэлдэж ертөнцийн шуналд эзлэгдэж байна. Нялх хүүхдэд эхийн хайр хэрэгтэйн адил Бурханы энэрэн нигүүлсэхүй хүн бүхэнд хэрэгтэй.

Бурхан энэ ертөнцийн агуу их багш агаад хүн төрөлхтөн түүний шавь нар юм. Бурхан бол ариунаас ариун билээ. Энэ ертөнц зовлонгоор дүүрэн үхэх, өвдөх, өтлөхийн зовлон газар сайгүй. Гэтэл хүмүүс зөвхөн жаргалыг л эрж, зовлонг урьдаас мэдрэх ухаанаа гэж байна.

Бурхан эндүүрлийн харанхуй ертөнцийн шатаж буй гэрийг тольдон, нам гүм сэлүүн ойд суун, энх амгалангийн орон болгохыг зорьж, “Эндүүрлийн зовлонг энэ ертөнц надад ч бас хамаатай. Түүнд амьдарч буй хүн бүхэн миний шавь нар. Тэднийг эндүүрэл төөрөгдлийн зовлонгоос ганцхан би л аварч чадна” хэмээжээ.

Бурхан номын үнэнхүү агуу хаан билээ. Бурханы сургаал хүн бүхэнд хүртээмжтэй. Бурхан энэ ертөнцөд Номыг айлдаж хүнийг зовлонгоос аврахын тулд залрах боловч энэ ертөнцийн хүмүүс шуналаасаа болж чих нь бөглөрөөд олж сонсож чадахгүй байна.

Гэвч сургаалыг сонсогч хүмүүс нь ертөнцийн эндүүрэл төөрөгдлөөс чөлөөлөгдөж бүрэн чадна. “Миний сургаалыг өөрсдийн ухаанаар бус, Бурханд итгэх сүсэг бишрэлээрээ хүртэнэ” хэмээн Бурхан айлджээ. Иймээс бид Бурханы сургаалыг бишрэн сонсч дагах ёстой.

ДАРМА



ШАЛТГААН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



1. ДӨРВӨН ҮНЭН

1. Хүмүүний энэ ертөнц зовлонгоор дүүрэн. Төрөх, үхэх, өтлөх, өвдөхийн зовлон буй.

Үзэн яддаг хүнтэйгээ уулзах зовлон, хайртай хүнээсээ хагацах зовлон, үл биелэх хүслээ биелүүлэх гэж үр дүнгүй тэмцэх бас зовлон. Үнэндээ хүсэл тачаалаас ангижраагүй амьдрал бол бас л зовлон. Хүний зовлонгийн шалтгаан бол шунал тачаалын хүчит эргүүлэг билээ.

Энэ бол зовлонгийн үнэн мөн болой. Хэрэв хүсэл тачаалын хүч чадлын үндсийг ухан, мөн чанарыг нээвэл сайн муу үйлийн нэгэнд хүрнэ.

Муу үйл шуналт сэтгэл нь үхлийг илгээх эрлэгийн элч адил хүчтэйгээс зовлонгийн шалтгаан тэр буюу.

Бүх л хүний хүсэл тачаал, шуналын үндэсийн мууг зайлуулах юм бол хүний зовлон арилах билээ. Энэ бол

хүний зовлонг арилгаж болох номлол юм. Зовлонгийн шалтгаан бүхнийг ялахын тулд найман замыг дагах ёстой,

Тэр юу вэ? гэвэл:

1. Зөв үзэл
2. Зөв эрмэлзлэл
3. Зөв үг
4. Зөв үйл
5. Зөв амьдрал
6. Зөв зүтгэл
7. Зөв дурдтгал
8. Зөв бясалгал

Үүнийг зовлонгийн шалтгааныг зогсоох, Гэгээрэхийн найман замын үнэн хэмээн нэрлэдэг болой. Хүмүүс энэ үнэнийг тархиндаа маш тодорхой хадгалах хэрэгтэй. Зовлонгоор дүүрсэн энэ ертөнцөд зовлонгоос зайлахыг хүсвэл зовлонгийн цорын ганц шалтгаан муу хүсэл, мугуйд тачаалын зангилааг ойлгох хэрэгтэй. Ертөнцийн муу хүсэл мугуйд, тачаалаас ангид амьдрах замыг Гэгээрсний хүчээр олно. Гэгээрэлд хүрэх зөв замын өгөөж энэ буюу.

2. Гэгээрэхийг эрж буй хүн бүхэн найман зөв замыг ойлгох хэрэгтэй. Үүнийг ойлгохгүй бол амьдралын манан будилаанд орооцолдоно. Энэ найман Гэгээн үнэнийг ойлгосон хүнийг “Билгийн нүд нь нээгдсэн” хэмээн нэрлэмүй. Тэгэхээр Бурханы сургаалыг мэдэхийг хүсч байгаа хүн ухаандаа дөрвөн үнэн, түүний утгыг маш хүчтэй төвлөрүүлэх хэрэгтэй. Ямарч үед өөртөө шингээж, бусдад сургаж байвал зохино.

Хүн дөрвөн үнэн, найман замыг сайтар ойлгосон байхад ертөнцийн шуналаас ангижирна. Хэрэв тэр шуналаас




ангигирсан бол маргахгүй, амьтан алахгүй, хулгай хийхгүй, буруу хурьцал үйлдэхгүй, ширүүн хатуу үг хэлэхгүй, хуурч мэхлэхгүй, бялдуучлан зусардахгүй, зангаа хувиргахгүй, амьдралын хуурамчийг мартахагүй, шударга бус загнахгүй, атаа жөтөө гаргахгүй, буяны мөрөөр амьдрах болно.

3. Гэгээрлийн зөв замыг дагавал харанхуй өрөөнд гэрэл орсонтой адил бөгөөд гэрэл харанхуйг арилгадаг билээ.

Гэгээн үнэний утгыг ойлгосон, зөв замыг дагаж баримтлагч хүн бол мунхагийнхаа харанхуйг сарниулж, билгийнхээ нүдийг нээж буй хэрэг.

Бурхан хүнд дөрвөн үнэнийг зааж өгсөн. Түүнийг төгс сайн ойлгосон хүн л Гэгээрнэ. Тэд хорвоод будилан эндүүрэгч хүнийг аварч халамжлах хүчийг олно. Итгэлийн үнэт баялаг эрдэм чадал болно.

Дөрвөн үнэнийг төгс ойлгосон байхад ертөнцийн шуналын бүх үндэс ёзоороороо булгарна. Энэ дөрвөн үнэнээр Бурханы шавь нар нь бусад бүхий л нандин үнэнд хүрч бүх утгыг ойлгон Гэгээрч, нэвтэрхий мэргэн ухааныг олж энэ ертөнцийн бүх хүнд буяны сургаалыг номлох харьж бууршгүй эрчмийг эзэмшинэ.



2. ШАЛТГААН

1. Хүний бүхий л зовлонд шалтгаан байна. Бас тэр шалтгааныг арилгах арга байна. Учир нь энэ ертөнцийн бүх л юм шалтгаан, нөхцөл байдал хоёрын нийлбэр үр дүн юм. Тэр шалтгаан үр дагавар хоёр өөрчлөгдөн өнгөрөхөд бүх юм үгүй болно. Бороо орж, салхи салхилж, ургамал ургаж, навч унах нь эргэх хорвоогийн жам билээ. Энэ бүх үзэгдлийн шалтгаан, үр дагавар харилцан нягт холбоотой. Шалтгаан нь нөхцөл байдал өөрчлөгдөхөд үгүй болно. Хүн эцэг эхээс шалтгаалан төрнө. Түүний бие махбод нь хоолоор тэжээгдэн бойжино. Харин ухаан нь сургаал, номлол, туршлага, мэдлэгээс шалтгаалж төлөвшинө. Ингэхлээр бие махбод, оюун санаа хоёр бол нөхцөл байдалд хамаарагдах бөгөөд тэр нөхцөл байдал өөрчлөгдөхөд дагаад өөрчлөгдөх зүйл байдаг. Тор гэхэд олон тооны зангилаанаас бүтнэ. Энэ ертөнц дээрх бүх юм зангилаануудын давтамжаар



холбогдсон байдаг. Хэрэв торны сүлжээ зангилаа тусгаар юм гэж ойлговол их эндүүрч буй хэрэг. Тэр сүлжилдсэн зангилаануудаас бүтэж буй учир тор гэж нэрлэж байгаа хэрэг. Бас сүлжээ бүр нь бусадтайгаа харилцаатай, өөрийн байрлалтай, үүрэгтэй байна.

2. Мод цэцэглэх ч тухайн цаг нөхцлөөс хамаардаг. Навч бас тухайн цаг нөхцөлд унадаг. Ингэж юм бүр ирж очиж, ээлжлэн солигдож байдаг. Ямарч юм юунаас ч хамаарахгүйгээр өөрчлөгдөхгүй байж чадахгүй. Бүх юм үйлийн үрийн шалтгаанаар бүтдэг. Үйлийн үр нь жам ёс билээ. Бүх юм өөрчлөгдөнө. Юу ч мөнх тэр чигээрээ үлдэхгүй.



3. ХАРИЛЦАН ХОЛБОО

1. Хүний зовлон, шаналгаа, амь тэмцэх шалтгаан хаанаас гарна вэ? Энэ нь ерөнхийдөө хүний хүсэлд л оршино. Хүмүүс баяжих дон, алхайн алмайрахыг жаргалд үзэх зөн, алдар нэр хөөцөлдөх, алдас шунал, атаа жөтөөнд хөтлөгдөн өөрийгөө хуурах нь хүний зовлонгийн үр үндэс гэдгийг мэдэхгүй байдаг. Эхнээсээ аваад энэ ертөнц гай гамшигаар дүүрэн байв. Түүний дээр өвчин, өтлөлт, үхэл нүүрлэх жамтай. Гэвч хүн энэ бүх байдлыг сайтар тунгаан бодож үзвэл бүх зовлонгийн угт муу хүсэл, шунал л оршиж байна гэдгийг мэдэх ёстой. Хэрэв энэ ховдог шуналаас зайлж чадвал хүний зовлон эцэслэх юм. Мунхаг гэгч нь оюуныг хордуулж шуналаар илэрнэ. Энэ нь хүн аливаа юмсыг залгамжлан үргэлжлүүлэх үнэн шалтгааныг мэдэхгүйн улмаас гардаг. Мунхаг,

шунал хоёроос буруу хүсэл төрж түүнийг биелүүлэхийн тулд зүтгэж явж хүн зовлонд унадаг. Мунхаг, шунал хоёрыг хүн ялгаатай хэмээн боддогч үнэндээ ялгаагүй юм. Мунхагаас болж бүх хүмүүс буруу бодол тээж явна. Зөв үзлээ хаяж аминч үзлээ урьтал болгон буруу бусармаг үйлийг хийж байна. Үүний үр дүнд хийсвэр юманд татагдаж байна. Үйл явдлаа аминч үзлийн талбар болгож ухаанаа мунхагаар манантуулан, шуналын бордоогоор бордож хувиа хичээж, эндүүрч явдаг.


Тэгэхээр хүмүүсийн өөрийнх нь үйлдэл санаа зовлон, уй гашуу, шаналалын шалтгааныг үүсгэж байна. Эндүүрлийн бүх гай гамшиг нь сэтгэлээс үүсэх сүүдэр юм. Чухамдаа өөр юу ч биш. Мөн яг тэр сэтгэлээс Гэгээрэл гарч ирдэг.

2. Энэ ертөнцөд гурван буруу үзэл байна. Энэ ертөнц дэх бүх юмс үнэн бус гэж дээр нэгэнт өгүүлсэн.
 - ☉ Бүх хүний үйл хувь заяанд үндэслэгдэнэ гэжээ
 - ☉ Бүх юмыг Бурхан бүтээсэн. Бүх юм түүний зоргоор удирдагдана
 - ☉ Ямарч шалтгаан нөхцөлгүйгээр бүх юм санамсаргүйгээр үүссэн гэжээ.

Энэ бол худлаа.

Хэрэв юм бүхэн хувь заяагаар шийдэгддэг юм бол нүгэл буян урьдчилан тодорхойлогдчихсон байхсан. Тэгээд ч аз жаргал, гаслан зовлон бас урьдаар оноогдчихсон байхсан. Тийм юм бол хүний бүх л чармайлт санаа бодол талаар болж хүн төрөлхтөнд найдах юм гэж ганц ч үгүй болно. Бусад үйлийн үнэн нь бас л адилхан. Хэрэв бүх юм үл мэдэгдэх Бурханы гарт байдаг бол эсвэл сохор азанд оршдог юм бол хүн төрөлхтөн чухам юуг дагах хэрэг вэ?

Ийм замыг шилэн сонгогчид муу үйлээс зайлж, ухаалаг хандах итгэлээ алдах нь зайлшгүй. Үнэндээ дээрх гурван үзэл бол бүгд буруу үзэл юм. Бүх юм шалтгаан нөхцлийн хуримтлал болсон эх үүсвэрийн илэрлийн үргэлжлэл залгамж болж байдаг билээ.



СЭТГЭЛИЙН ОНОЛ, ЮМСЫН МӨН ЧАНАР ХОЁРДУГААРБҮЛЭГ



1. ХУВИРАХ ЮМСАД БОДИТ БИЕ ҮГҮЙ

1. Бие сэтгэл хоёр нөхцөл бүрэлдсэнээс үүсэх ба жинхэнэ “би” гэх биегүй. Бие махбодиос тогтох бүтэц болохоор мөнх бус.

Хэрэв энэ бие өөрийн гэх бодитой байсан бол хүссэнээрээ оршиж болох байсан.

Хаан хүн гүрэн улсаа юу хүссэнээ гүйцээж чадна. Магтаж, зэмлэж, шийтгэж, гэсгээж чадна. Харин өөрт нь зайлахгүй ирэх, өтлөх, үхэхийн зовлонг хорьж үл чадмой.

Хүн өвдөх, өтлөхийг хүсэхгүй боловч заавал ирдэг нь жам билээ.

Хүний сэтгэл гэдэг бие үгүй, мөнхөд өөрчлөгдөж байх шалтгаан нөхцөлийн цогц юм. Хэрвээ сэтгэл бодитой байсансан бол хүссэн буянаа ч хийдэг, хүсээгүй муу үйлээс ч

зайлсхийж чаддаг байх байлаа. Гэвч үнэн хэрэгтээ хүсэхгүй авч мунхаг санааг агуулж, сайн үйлээс зугатаж, нэг юмыг ч гэсэн өөрийн бодсон зоргоор хийхгүй байна.

2. Хэрвээ бие тань үргэлжийн хувиршгүй юу? гэж асуувал хэн ч өөрчлөгдөнө гэж хариулах нь мэдээж. Хоромхон зуурын энэ амьдрал жаргал уу? зовлон уу? гэж асууваас энэ ертөнцөд төрж, өтлөх, үхэхийн зовлонг мэдэх хэн нь ч гэсэн зовлон гэж хариулна.

Ийнхүү үргэлж хувиран өөрчлөгдөх мөнх бус зовлонг бодитой юм, миний юм гэж бодох нь эндүүрэл болно. Хүний сэтгэл бас мөнх бус, үргэлжийн хувирамтгай зовлон бөгөөд миний гэх юм юу ч үгүй билээ.

Тухайн хүний амьдралыг үүсгэж байгаа бидний бие сэтгэл, түүнийг хүрээлэн байгаа гадаад ертөнц “би”, “минийх” гэх ойлголтонд огт хамаагүй.

“Би”, “минийх” гэх ойлголт бол мунхаг сэтгэлийн эндүүрэл юм. Бие, түүний эргэн тойрны орчин шалтгаан нөхцөлийн харилцаанаас үүсдэг учир эцэс төгсгөлгүй өөрчлөгдөн хэзээ ч тэр хэвээрээ байна гэж үгүй.

Үргэлж хувьсаж байдаг хүний сэтгэл түр зуур ч зогсохгүй голын урсгал шиг, үргэлж дүүлж байдаг сармагчин шиг, эсвэл шатаж буй дэн шиг болой. Ухаант хүн үүнийг онож мэдээд бие сэтгэлд хорогдохоос зайлсхийж Гэгээрэхийг зорьдог.

3. Энэ ертөнцөд хэн ч зогсоож үл чадах таван зүйл байна.

- 1) Өтөлж хөгшрөх
- 2) Эдгэшгүй өвчин
- 3) Үхэх




- 4) Зовлон зүдрэл
- 5) Мөхөл

Энэ ертөнцийн бүх хүн дээрх тавыг амсах нь зайлшгүй, Харин Бурханы сургаалыг ухаарсан хүн дээрх зовлон зайлшгүй ирнэ гэдгийг мэдэж байдаг учраас төдийлөн эмзэглэж шаналалгүй түүнээс ангижирдаг билээ.

Энэ ертөнцөд дөрвөн үнэн байдаг.

1. Бүх амьд амьтан мунхагийн харанхуйгаас үүсдэг.
2. Шунаж хүсэж байгаа бүх юм хувиран үргэлж зовлон болдог.
3. Бүх амьд юмс бас хувиран өөрчлөгдөж зовлон болдог.
4. ”Би”, “Минийх” гэх юм энэ ертөнцөд огт үгүй билээ. Бүх юм батгүй хувьсана. “Би” гэх бодит бие үгүй гэсэн гарцаагүй үнэн бол энэ ертөнцөд Бурхан байсан байгаагүйтэй ч холбоогүй юм.

Бурхан энэхүү үнэнийг олж ертөнцийн хүмүүст үнэний сургаал номыг айлдаж буй билээ.



2. СЭТГЭЛИЙН ОНОЛ

1. Эндүүрэл Гэгээрэл хоёулаа сэтгэлээс гарна. Энэ ертөнц дээрх бүх юмс, үзэгдэл сэтгэлийн үйлээс гарна. Яг илбэчний ханцуйнаас янз бүрийн юм гарч байгаатай адил. Сэтгэлийн хувирал төгсгөлгүй. Түүний боломж хязгааргүй.

Бохирдсон сэтгэл бохир орчныг, ариун сэтгэл цэвэр ертөнцийг бүрдүүлж байдаг. Тийнхүү гадаад орчин сэтгэлээс шалтгаалан өөрчлөгдөх нь хязгааргүй.

Зургийг зураач хүн бүтээнэ. Гадаад орчныг сэтгэл зурж бүтээнэ. Бурхан багшийн бүтээсэн орчин бол ямар нэг согоггүй, ертөнцийн шуналаас ангид цэвэр ариун билээ. Тэгвэл хүмүүсийн бүтээсэн ертөнц нь хүсэл шуналаар дүүрэн булингартсан байна. Сэтгэл нь уран зураач шиг янз янзын ертөнцийг зурж чадна. Энэ ертөнцөд сэтгэлээр бүтээгдээгүй юм гэж юу ч үгүй.



Бурхан бүх юмыг мөнх бусын сэтгэлээр харж зөв ойлгосон. Иймээс энэ ертөнцөд бүх юм сэтгэлээс үүссэн гэдгийг ойлгож чадах хүн жинхэнэ Бурханыг харах чадвартай болж байна гэсэн үг. Ийнхүү ертөнцийг бүтээхэд сэтгэл, Бурхан, хүн гурав ялгаагүй.

2. Гэвч сэтгэл нь үргэлж айж, зовж, шаналж байдаг. Болж өнгөрсөн юмнаас айж, шаналдаг. Болох юмнаас ч айж шанална. Энэ нь сэтгэлд мунхагийн харанхуй, зовлонт дур хүсэл шатсанаас үүсч буй билээ. Мунхаг сэтгэл, шуналаас эндүүрэл төөрөгдлийн ертөнц үүсч байдаг.

Эндүүрэл, төөрөгдлийн бүх шалтгаан гагцхүү сэтгэлд өөрт нь оршиж буй. Хэрвээ үхэл амьдралын тухай эндүү ташаа ойлголтыг төрүүлэгч сэтгэл үгүй бол түүнтэй хамт эндүү ташаа ойлголт ч бас үгүй болно.

Эндүүрэл төөрөгдлийн ертөнц сэтгэлээс гарна. Ертөнцийг төөрсөн сэтгэлийн нүдээр харвал ертөнц төөрөгдлөөр дүүрэн харагдана. Хэрвээ хүн сэтгэлдээ эндүүрлийн ертөнц байх ёсгүй гэж ойлгож чадвал бохирдлоос чөлөөлөгдөж Гэгээрэх замд орж чадна. Ийнхүү энэ ертөнц сэтгэлээр үүсч, сэтгэлээр удирдагдаж байна. Сэтгэл бол бүх нөхцөл байдлын эзэн болж байна. Сэтгэл төөрч эндүүрвэл энэ ертөнц зовлон зүдгүүрээр дүүрэн байх болно.

3. Ийнхүү бүх юм сэтгэлээс үүсч, сэтгэлээр удирдагдаж, сэтгэлээр зохицуулагдаж байдаг.

Ариун бус сэтгэлээр үйлдэн буй хүн ачаатай тэргэнд зүтгүүлсэн шартай адил зовно.

Саруул ухаанаар үйлээ явуулж буй хүнийг аз заяа үргэлж дагана. Нүгэл үйлдсэн хүн “Би буруу юм хийлээ” гэсэн ой

бодол нь хойт төрөлд нь зайлшгүй дамжиж үйлийнх нь үр илэрнэ. Буян үйлдсэн хүн “Би сайн үйлийг хийлээ” гэж бодож чадсанаар энэ төрөлдөө ч үргэлж сайн явж, буяныхаа үрээр хойт төрөлдөө ч жаргах болно.

Сэтгэл хиртэй болвоос бартаатай хэцүү замд олонтаа бүдрэн ихэд зовох болно. Хэрэв сэтгэл тунгалаг аваас зам шулуун, аян өлзийтэй байх болно.

Бие сэтгэлээр ариун хүн нүгэлт шунал, бузар бодол, аминч үзлийн торыг эвдэж Бурханы замаар сэтгэл ханамжтай өгсөх болно. Сэтгэлийг номхруулж чадсан хүн өдөр шөнөгүй улам хичээнгүйлэн улам чадвартай болж амгаланд хүрч чадна.





3. ЮМСЫН ҮНЭН БАЙДАЛ

1. Энэ ертөнц дэх бүх юмс шалтгаан нөхцөлөөр үүссэн болохоор тэдгээрийн дунд үндсэн ялгаа байхгүй. Харагдаж байгаа ялгаа нь хүмүүсийн хийсвэр ялгаатай бодлоос шалтгаалж байгаа хэрэг.

Тэнгэрт баруун, зүүн зүг гэсэн зааг байхгүй. Гэтэл хүмүүс өөрсдийн санаагаар зүг зохиож, тийм байдаг хэмээн итгэж байна.

Ганцаас эхлээд хязгааргүйд үргэлжлэх тоо ч гэсэн чанарын ялгаагүй хэрэг. Гэтэл хүмүүс өөрсдийн таалалд тохируулан их бага хэмээн ялгаа гарган хувааж байна. Амьдрах, үхэх явц ч ялгаагүй. Гэтэл хүмүүс нэгийг амьдрал нөгөөг үхэл хэмээн ялгаж байна. Түүнчлэн зөв буруу хоёрын хооронд ч ялгаа байхгүй. Гэтэл хүмүүс нэгийг нь сайн, нөгөөг нь буруу хэмээн ялган үзэж байна. Бурхан аливаа ялгаанаас татгалзаж, энэ ертөнцийг нүүж байгаа үүл мэт

оноосон. Бурханд тодорхой юм бүхэн эндүүрэл. Сэтгэлийн хүсч байгаа юм, хүсээгүй юм хоёр адилхан хоосон чанартай гэж үздэг. Бурхан сэтгэлийн ямар ч хүслээс ангид оршино.

2. Аятай тохитой амьдрах сэтгэлийнхээ хүслээр хүмүүс энэ ертөнцийн бүх юманд дурлан татагдаж байна. Эд баялагт шунаж, алдар нэр, эрх тушаал, амьдралдаа дурлаж байна.

Байгаа, байхгүй, сайн муу, зөв буруу бүх юманд дурлаж, түүнээсээ эндүүрэн зовж байна.

Эрт цагт холын аянд явж байсан нэг хүн их голын эрэг дээр иржээ. Тэр хүн: “Голын эргийн энэ хэсэгт нь аюултай байна, тэр хэсэг нь аюулгүй байна.” гэж бодоод сал холбон голыг аюулгүй гаталж, нөгөө эрэгт хүрээд: “Энэ сал намайг голын нөгөө эрэгт мэнд гаргаж, маш их тус боллоо. Иймд үүнийг хаялгүй үүрч явъя” гэж шийджээ. Энэ хүн ухаантан мөн үү?

Зөв хэрэгтэй юманд ч татагдаж дурлахгүй, түүнээс татгалзаж сурах хэрэгтэй. Тэр тусмаа буруу юмнаас бол шууд татгалзах хэрэгтэй гэдгийг энэ ёгт үлгэрт сургаж байна.

3. Энэ ертөнцөд биднийг хүрээлэн буй бүх юм бий болдоггүй, алга болдоггүй, хаашаа ч явдаггүй, хаанаас ч ирдэггүй. Ингэхлээр хүн аливаа юмыг олж авдаггүй, хаяж гээдэггүй.

Юмс орших, эс орших хооронд байх учир, юм буй болдог ч үгүй, алга болдог ч үгүй гэж Бурхан сургажээ.

Энэ нь бүх юм өөрийн гэх биегүй шалтгаан нөхцөлөөр үүсдэг учир юм оршиж байна гэж хэлэх боломжгүй. Бас юмс шалтгаан нөхцөлөөр үүсдэг учраас “оршихгүй байна”



гэж хэлж бас болохгүй.

Юмны дүрсийг үзээд түүнийг оршиж байна гэж бодох нь эндүүрлийн шалтгаан. Хэрэв дүрсийг үзээд түүнд татагдахгүй, сэтгэлд хүсэл төрөхгүй бол энэхүү хуурамч дүрслэл эндүүрэл арилах юм. Гэгээрэл бол үнэнийг олж сэтгэлийн хүслээс ангижрах үзэгдэл юм.

Ертөнц бол үнэндээ зүүд юм. Түүний баялаг эрдэнэс нь шуналыг татагч хоосон зэрэглээ юм.

4. Юмс тоо тоймшгүй шалтгаануудаас үүсч мөнхөд оршино гэдэгт итгэх нь том эндүүрэл бөгөөд үүнийг Мөнх оршихын онол гэнэ. Нөгөө талаар юмс үгүй болдог гэж үзвэл мөн эндүүрэл бөгөөд үүнийг Эс оршихын онол гэнэ. Байна, байхгүй, үхэл, амьдрал гэсэн энэ мөнхийн категорууд бол хүний эндүүрсэн нүдэнд тусан үзэгдэнэ. Энэ нь хүнд зөвхөн тэдгээрт татагдсанаас үүсэх явдал юм.


Юмс бол өөрийн гэх биегүй учир үргэлжид мөнх орших боломжгүй юм. Ертөнц дээрх бүх юм нөхцөл бүрдсэнээр үүсч бүгд өөрчлөгдөж байдаг. Юмс бол зүүд зэрэглээ шиг цаг үргэлжид хувьсч, өөрчлөгдөж байна. Энэ утгаар нь авч үзвэл юмс мөнхийн өөрчлөлтөнд оршино.

Голын ус хүнд голын ус шиг харагддаг бол өлссөн бирдэд гол нь ус биш гал шиг харагдана. Ингэхлээр бирдэд гол байна, хүнд гол байхгүй гэж хэлж болохгүй. Үүнтэй адил бүх юм зүүд зэрэглээ адил учир ямар ч юмыг байгаа, байхгүй гэж хэлж болохгүй.

Цаашилбал энэ зэрэглээ мэт ертөнцөөс гадна бодит мөнх ертөнц байна гэж хэлж болохгүй. Түүнчлэн энэ ертөнц болзож томъёолсон цаг зуурын гэж бас хэлж болохгүй. Энэ ертөнц бодит гэж хэлж болохгүй, Алдаа эндэгдлийн

шалтгаан энэ ертөнцөд оршино гэж хүмүүс бодож байгаа. Тэгвэл энэ ертөнц хоосон зэрэглээ юм бол хүний сэтгэлийн хүслийг үүсгэж алдаанд хөтлөж чадахгүй.

Хүмүүс энэ үнэнийг мэдэхгүй энэ ертөнц болзолт томъёолсон юмуу, цаг зуурын, эсвэл бодит гэж үздэгээс алдаанд ойчиж байна. Ухаант хүн энэ үнэнийг олж, зэрэглээг зэрэглээ гэж онож, ийм алдаанд ойчихгүй зовлонгоос ангижирч чадна.





4. ДУНДАЧ ҮЗЭЛ

1. Гэгээрэлд хүрэх замыг сонгож буй хэн боловч амьдралын хоёр туйлшралаас зайлсхийх хэрэгтэй.

- ☉ Биеийн хүсэлд автагдан туйлшрах.
- ☉ Энэ ертөнцийг тэвчихийн тулд бие, сэтгэлийг шалтгаангүйгээр тарчлаан зовоох.

Амьдралын энэ хоёр туйлшралаас зайлсхийж, сэтгэл оюунаа номхруулан саруул ухаанаар Гэгээрэлд хүрэх Дундач үзэл гэж буй. Дундач үзэл гэж юу вэ? Энэ нь найман зөв замыг хэлдэг юм. Үүнд зөв үзэл, зөв бодол, зөв яриа, зөв явдал, зөв амьдрал, зөв чармайлт, зөв ухаан, зөв төвлөрөлт болой.

Энэ ертөнц дээрх бүх юм шалтгаан нөхцөл бүрэлдсэнээр үүсэн үгүй болж байна. Юмыг байна, байхгүй гэж хэлж болохгүй. Зарим мулгуу хүмүүс юмыг байна гэж үзнэ. Нөгөө хэсэг нь байхгүй гэж үзнэ. Харин саруул ухаантай

хүн бол юмсыг байна, байхгүй хоёрын дунд хоёуланг нь агуулж чадах чанартайг олж хардаг. Энэ бол Дундач үзэл мөн. Юмыг зөвөөр таних нь Дундач үзлийн арга юм.

2. Модны зомгол голын усанд хөвжээ гэж бодъё. Хэрэв тэр живэхгүй, баруун зүүн эрэгтээ тээглэхгүй, усны эргүүлэгт унахгүй, дотроосоо ялзрахгүй, хүн гаргаж хаяхгүй бол эцэстээ далайд очно. Амьдрал бол их голд хөвж буй энэхүү зомголтой адилхан.

Бурханы сургаалыг дагаж буй хүн зөв буруу, байна байхгүй, гадна дотно юманд татагдахгүй, аливаа төөрөгдлөөс зайлж, муу үйлэнд халтирахгүй, сайн үйлээрээ бардахгүй, Гэгээрэх замд эндүүрэхгүй аваас ийм хүн Дундач замаар замнаж чадна.

Бурханы сургаалыг дагаж байгаа хүн бол амьдралдаа туйлшрах үзлээс ямагт зайлсхийж, Дундач замыг үргэлж барьдаг. Юунд ч татагдаж бүү дурла. Энэ ертөнц дээрх бүх юмс үүсдэггүй, алга болдоггүй, тодорхой шинж чанаргүйг мэдэх хэрэгтэй. Юмс бол байдаг ч биш, байдаггүй ч биш бүх юмны шинж нь зүүд зэрэглээтэй адил гэдгийг мэдэх хэрэгтэй.

Өөрийн үйлдсэн сайн үйлийн төлөө ч сайрхалгүй, ер нь юунд ч бүү татагд. Хүн хүслийн урсгалд эзлэгдэхээс зайлсхийхийн тулд юуны өмнө шунах, шохоорхох сэтгэлийг таслах хэрэгтэй. Байгаа байхгүй, гадна дотно, сайн муу, зөв буруу аливаа юманд татагдахгүй байх ёстой. Хэрэв хүн юманд татагдан автаж эхэлбэл яг тэр мөчөөс эндүүрлийн ертөнц эхэлдэг.

Бурханы сургаалаар явж буй хүн үхлээс айхгүй, амьдралыг гуйхгүй алив юманд дурлаж шохоорхохгүй, ямарваа үйл ирэхэд тайван ухаанаар угтана.



3. Гэгээрэл бол ямар нэг тодорхой хэлбэр үгүй, илэрхийлэгдэх шинж үгүй. Ийм учраас Гэгээрэлд өөрт нь Гэгээрэх юм гэж үгүй.

Мунхаг эндүүрэл байдаг учраас Гэгээрэл байна. Мунхаг эндүүрэл байхгүй бол Гэгээрэл байхгүй болно. Гэгээрлээс ангид эндүүрэл гэж үгүй.

Харанхуй байгаа учраас гэрэлтүүлэх хэрэгтэй. Харанхуйгүй бол гэрэлтүүлэх хэрэггүй. Тэгвэл гэрэл ч байхгүй, гэрэлтүүлэх юм ч байхгүй болно.

Үнэндээ Бурханы сургаалаар явж байгаа хүн Гэгээрээд, Гэгээрэл дээрээ зогсдоггүй. Яагаад гэвэл Гэгээрэл байна гэдэг бол төөрөгдөл байна гэсэн үг. Ийм байдалд хүрсэн цагт бүх юм төөрөгдлөөс Гэгээрч, харанхуй юм гэрэлтэй болно гэсэн үг. Ертөнцийн бүх шуналт сэтгэлийг Гэгээртэл гэрэлтүүлэх хэрэгтэй.

4. Юмсын үндсэн чанар нь ямар нэг ялгарах шинж үгүй, адилхан гэж үздэг Шунъята буюу хоосон чанарын онол гэж байдаг. Юмс бол өөрийн гэх биегүй, шинж чанаргүй, үүсдэггүй, алга болдоггүй. Юмс Хоосон чанартай учир үгээр илэрхийлэх боломжгүй, ертөнц дээрх бүх юм харилцан холбоотой. Харилцан бие биенээсээ хамаарна. Дангаараа бие дааж салангид оршино гэж үгүй. Бүх юм шалтгаан нөхцөлийн улмаас гарч ирдэг, алга болдог.

Яг л гэрэл сүүдэр, урт богино, хар цагаан гэдэг ойлголттой адил юм. Үүнтэй адил юмсын өөрийн гэх шинж чанар дангаараа байдаггүй тул хоосон чанартай юм. Үүнтэй адил шалтгаанаар мунхагаас ангид Гэгээрэл гэж үгүй. Гэгээрэлээс ангид мунхаг гэж үгүй. Юмс үндсэн чанараараа ялгагдахгүй учир эсрэг шинжтэй. Хоёр дахь чанар гэж үгүй.

5. Хүнд аливаа юмс үүсч байгаа юм шиг, үгүй болж байгаа юм шиг санагддаг. Гэтэл үнэндээ аливаа юмс үүсдэггүй, алга болдоггүй. Юмны үнэн учрыг олж чадсан хүн гэдэг бол юм үүсдэггүй, алга болдоггүй гэдгийн үнэнийг олж мэдэхэд энэ бол ялгаатай ойлголт биш гэдгийг олж ухаарна.

Хүмүүс ариун, ариун бус гэж ялгаж буй боловч юмсынхаа шинж чанарын хувьд бол сэтгэлийн хуурмаг хийсвэр дүрслэлээс гарч байгаагаас бус тийм ялгаа гэж байхгүй. Дээрхийн адил сайн муу хоёрын хооронд ялгаа гаргаж байгаа боловч үнэндээ сайн муу хоёр салангид оршдоггүй билээ.

Гэгээрлийн замаар явж байгаа хүн бол үнэнд хүрч сайн муу гэдэг бол ялгаатай ойлголт биш гэдгийг ухаарч, сайныг магтахгүй, мууг зэмлэхгүй. Энэхүү хоёрдмол бус чанарыг мэдэж авна. Хүн гай зовлонгоос айж аз жаргалыг хүсдэг. Гэвч жинхэнэ саруул ухаанаар ялгааг сайтар судалбал гай зовлон нь аз жаргал болж, аз жаргал нь гай зовлон болох нь ч цөөнгүй.

Саруул ухаантай хүн амьдралын өөрчлөгдөн байгаа нөхцөл байдалд тайван сэтгэлээр хандан амжилтанд ташуурдаггүй, таагүй юманд гутардаггүй, Ингэж хоёрдмол бус чанарын үнэнийг ойлгодог. Ингэхээр хоёрдмол харьцааг илэрхийлж байна байхгүй, ертөнцийн төөрөгдөл, үнэн мэдлэг, ариун, ариун бус, сайн муу гэх эсрэг утгатай зөвхөн хүний сэтгэл дэх энэ нэр томъёонуудыг үнэн байдлаар мэдэх болно. Сэтгэлийн буруу үзлээсээ чөлөөлөгдөх хэрэгтэй. Дээрх нэр томъёо сэтгэлийн төсөөллөөс чөлөөлөгдөж чадвал жинхэнэ хоосон чанарын утгыг ойлгож чадна.

6. Цэвэр ариун Бадамлянхуа цэцэг намгийн шавраас ургадаг шиг ертөнцийн хүслийн буртагаас Бурханы ариун Гэгээрэл үүсдэг. Тэрсүүдийн алдаатай үзэл,



ертөнцийн шунал эндүүрлийн балчигаас ч Бурханы ариун Гэгээрэл үүсч болно, Шүр сувд олохоор далайн ёроол уруу шумбагч хүн матар, аварга загасны аюулаас айхын адил Гэгээрлийн эрдмийн сувд хайх хүн ертөнцийн хүслийн их аюултай тэмцэх ёстой. Гэгээрэлд хүрэх замыг олохоос өмнө юуны урд аминч үзэл, хувиа хичээхийн аюулаас салах хэрэгтэй.

Биеэ хайрлах үзэл уулын чинээ их боловч Бурханы номоор замнахаар шийдсэн бол Гэгээрэлд хүрэх нь дамжиггүй. Эрт цагт үнэн замыг олох чин хүсэлдээ хөтлөгдсөн даяанч хүн жадны үзүүр шиг уулан дээгүүр гарч, галд орсон боловч итгэлээрээ тэсвэрлэсээр гарч ирсэн домог байдаг. Бурханы сургаалаар замнагч хүн ч гэсэн алдар хүнд, нэр төрийн хурц хадан хясаан дээгүүр авирч, үзэн ядахын дүрэлзсэн гал дундуур орлоо ч Гэгээрлийн сэрүүн салхи сэвэлзэхийг мэдэх болно.

7. Бурханы сургаалыг мөрдөгч хүн үнэнийг олж, эсрэг утгатай ойлголт бол эсрэг юм биш гэдгийг ухаарна. Хэрэв эсрэг утгатай ойлголтоос нэгийг нь шилж аваад, түүндээ бат итгэж зууралдвал зөв, сайн юм байлаа ч алдаа гарна.

Хэрэв хүн энэ ертөнц дээрх бүх юм хоосон, өөрчлөгддөг гэж зүтгэвэл бүх юм бодитой өөрчлөгддөггүй гэдэгтэй адил том алдаа болно. Хэрэв хүн “би” гэх сэтгэлдээ хатуу итгэвэл бас л алдаа болж, өөрийгөө аврах чадваргүй болно. “Би” гэдэг байхгүй гэдэгт итгэвээс бас алдаа болно. Бурханы сургаалаар явах чадваргүй болно. Хэрэв хүмүүс бүх юмыг зовлон гэж үзвэл бас эндүүрэл мөн. Бүх юмыг аз жаргал гэж үзвэл бас л эндүүрэл. Бурханы сургаал бол хоёрдмол чанар нийлж байгаа нэгдмэл нэг зам мөн. Энэ нь туйлшралаас зайлсхийх Дундач замыг зааж өгнө.

БҮРХАНЫ ЧАНАР ГУРАВДУГААР БҮЛЭГ



1. АРИУН СЭТГЭЛ

1. Энэ ертөнцөд янз янзын төрх араншинтай хүмүүс байдаг. Ариун цагаан сэтгэлтний зэрэгцээ зан араншин нь эвдэрсэн, хорт муу санаатан бишгүй байдаг. Эдгээр ялгаа нь Гэгээрлийг олоход бага ч гэсэн ач тустай.

Энэ ертөнц гэдэг нь зүсэн бүрийн ургамлаас бүрдсэн цэцгийн мандалтай адил юм. Ургамал цагаан, ягаан, цэнхэр, шар гэх мэт янз бүрийн өнгөөр цэцэглэдэг. Зарим нь усан дор, зарим нь усан дээр, зарим нь усны гадаргууд.

Хүмүүст хүйсийн ялгаа байвч энэ нь үндсэн ялгаа бус, зөв хичээлтэй зүтгэвээс бүстэй, бүсгүй хүн хэн ч адилхан Гэгээрэлд хүрнэ. Бусдыг сургагч хүмүүн бие эрүүл, бат итгэл, шургуу хөдөлмөр, үнэнхүү зорилго, мэргэн ухаан хэмээх таван чанарыг эзэмшсэн байх хэрэгтэй. Бурханы Гэгээрэх замыг дагахад дээрх таван чанарыг зайлшгүй эзэмших ёстой болно. Хэрэв хүн эдгээр таван чанарыг



эзэмшиж чадвал хүйс хамаарахгүйгээр Гэгээрэлд хүрэх боломжтой юм. Энэ бүх чанар байх аваас Бурханы сургаалыг эзэмшихэд ч удаан хугацаа шаардахгүй. Ямар ч хүн Гэгээрэлд хүрэх чадвартай.

2. Гэгээрэлд хүрэх замдаа хүн Бурханыг нүдээрээ үзэж, сэтгэлээрээ биширнэ. Бурханыг харж буй нүд, Бурханд итгэж байгаа сэтгэл нь өнөөг хүртэл хүнийг үхэл, амьдралын ертөнцөд хөтлөж байсан тэр нүд, тэр сэтгэл болой.

Хаан хүн дээрэмчдийг бариулахын тулд эхлээд орогнох үүрийг нь мэдэх хэрэгтэй болдог шиг ертөнцийн зовлонг арилгахын тулд түүний уг шалтгааныг олж мэдэх хэрэгтэй.

Гэрт байгаа хүн нүдээ нээхэд эхлээд гэр доторх юмаа харж, юуны түрүүнд өрөөний дотор талыг, дараа нь цонхоор гаднахыг нь харж болно. Үүний адил бид өрөөн доторх юмыг эхлэж харахгүйгээр гаднах зүйлсийг шууд харж чадахгүй. Хэрэв сэтгэл биеийн дотор оршдог бол, биеийн дотор юу байгааг сайтар мэдэх ёстой болно. Гэтэл хүн биеийнхээ гадна байгаа юмыг сайтар хараад, биеийн доторхийг бараг мэдэрч чаддаггүй. Хэрэв сэтгэл нь биенийхээ гадна байдаг юм бол бие сэтгэл нь тус тусдаа байж, сэтгэл нь биеэ юу мэдэж байгааг мэдэхгүй, бие нь сэтгэлээ юу мэдэж байгааг мэдэхгүй байх ёстой. Тэгвэл үнэн хэрэгтээ сэтгэл нь мэдэж байгаа юмыг бие нь мэдэрдэг, биеийнхээ мэдэж байгаа юмыг сэтгэл нь мэдэрдэг байна. Иймээс сэтгэл биеийнхээ гадна оршиж байна гэж хэлж болохгүй. Тэгвэл сэтгэлийн мөн чанар хаана орших вэ?

3. Хүмүүс эртнээс хоёр зүйлийг мэддэггүй учир өөрсдийн хийсэн үйлийн үрээр төөрч будилж иржээ. Өөрсдийн үйлийн үрээр будилж үндсэн хоёр буруу үзлээр төөрч

мунхарч ирсэн.

- 1) Үхэл амьдралын шалтгаан болсон төөрөгдлийн сэтгэлийг өөрийн мөн чанар гэж бодсоноос ба амьдрал үхлийн үндэс болон эндүүрлийн сэтгэлийг өөрсдийн мөн чанар гэж ойлгодгоос алддаг байна.
 - 2) Гэгээрлийн мөн чанар болсон ариун сэтгэл өөрсдийнх нь дотор сэтгэлийн төөрөгдлийн сүүдэр дотор нуугдаж байна гэдгийг мэддэггүй. Хүн зангидсан гараа тэнийлгэхэд гар тэнийлээ гэдгийг сэтгэл мэддэг.
 - 3) Ийм хөдөлгөөнийг юу гүйцэтгэнэ вэ? Гар уу? Сэтгэл үү? Эсвэл аль нь ч биш үү? Гар хөдөлж байвал сэтгэл нь бас хөдөлнө. Эсвэл сэтгэлийн хөдөлгөөн гарт дамжив уу? Гэвч хөдөлгөөнд орсон сэтгэл бол өнгөц юм.
4. Ерөнхийдөө хүн бүр цэвэр ариун сэтгэлтэй байдаг боловч хүний орчин ахуйгаас урган гарч ирдэг энэ ертөнцийн хүсэл шуналын тоосонд голдуу бохирлогдон хиртсэн байдаг. Ингэж хиртсэн сэтгэл бол уг хүний жинхэнэ сэтгэл бус. Айлд гаднаас орж ирсэн хүн тэр гэрийн зочин болохоос биш эзэн биш гэдэгтэй утга нэгэн билээ.

Сарыг үүл халхлах нь олонтоо тохиолддог боловч үнэн хэрэгтээ үүл сарны хөдөлгөөнийг хаахгүй, сар үүлэнд бүрмөсөн халхлагдахгүй байдгаараа л байгаа Иймээс хүмүүс өөрийн хиртсэн сэтгэлийг жинхэнэ миний сэтгэл биш гэж ойлгох учиртай. Хүн бол хөдөлгөөнгүй, бохирдоогүй жинхэнэ сэтгэлээ олж авах хэрэгтэй. Өөрийн төрөлх байдалдаа эргэж очих хэрэгтэй. Хүн байнгын биш төөрсөн сэтгэлийн урхинд орж, юмсыг буруу үзэж, эндүүрлийн далайгаар тэнүүчилж байна.



Хүний сэтгэл төөрөх, бузарлагдах нь янз бүрийн шунал хүслээс болж байна. Гаднах шалтгаанаас үл хамаарах мөнхийн хөдөлгөөнгүй, хувиршгүй бодол нь сэтгэлийн мөн чанар юм. Зочид буудалд өнжсөн хүн явснаас буудал алга боллоо гэж хэлж болдоггүйтэй адил гадны нөхцөлөөр үүсдэг арилдаг сэтгэл үгүй болсноор тэр хүн оршихоо болилоо гэж хэлж болохгүй. Гаднах орчноос болж өөрчлөгдөж байгаа сэтгэл бол сэтгэлийн мөн чанар бус.

5. Эрдмийн танхим байна гэж бодъё. Өдөр гэрэлтэй болж, нар шингэхэд харанхуй болдог. Бид нарны улмаас өдөр гэрэлтэй, шөнө харанхуй болдог гэж мэддэг боловч, гэрэл харанхуйг мэдэрч буй тэр мэдрэмжийг чухам юуны улмаас үүсдэгийг мэддэггүй, сэтгэлийн мөн чанар тэрнийх гэх зүйл бидэнд үлддэггүй. Нар гарахад бид гэрлийг хардаг. Энэ бол сэтгэлийн хоромхон зуурын үзэгдэл.

Гэрэл, харанхуй мэт гадны нөхцөл бол гэрэл, харанхуйг мэдрэх гадны мэдрэмжийг үүсгэж байгаа хэрэг. Гэвч энэ бол сэтгэлийн түр зуурын илрэл, Сэтгэл өөрөө биш, түүний мөн чанар ч биш, гэрэл харанхуйг ялгаж буй хүчний эх болох сэтгэлийн мөн чанар.

Гаднын нөхцөл байдлаар үүсч, үгүй болж байгаа сайн, муу, дуртай дургүйн сэтгэл бол хүний сэтгэл бузарлагдсанаас үүсэх сэтгэлийн түр зуурын үзэгдэл юм. Ертөнцийн шуналын тоосоор бүрхэгдсэн авч бохирдоогүй жинхэнэ цэвэр сэтгэл гэж байна.

Ус бөөрөнхий саванд дугуй, дөрвөлжин саванд дөрвөлжин харагдана. Гэвч ус бол өөрийн мөн чанараараа дөрвөлжин ч биш, дугуй ч биш. Гэтэл хүмүүс энэ тухай мартаж зөвхөн хэлбэрээр нь дүгнэдэг.

Сайн муу, дуртай дургүй, байна байхгүй гэсэн ойлголттой хүмүүс зөвхөн гадна хэлбэрээр эндүүрэн зовж шаналдаг. Хэрэв хүмүүс гадна талын нөхцөл байдлаас нөлөөлөгдөж, өөрийн чөлөөт мөн чанараа олж авах юм бол бие сэтгэл нь юутай ч холбоогүй, бүрэн дүүрэн чөлөөт байдлаа олж авна.





2. БУРХАНЫ ЧАНАР

1. Жинхэнэ ариун сэтгэл гэдэг бол өөр үгээр Бурханы мөн чанар буюу Бурханы сургаалын үр мөн. Өсгөдөг шилээр нарны туяаг уул өвсөнд онож тусгахад гал үүсдэг. Чухам яагаад уул ноцож байна вэ? Хаанаас гал гарч байна вэ? Нар болон галт шил бие биенээсээ хол байна.

Тэд хоорондоо нийлэх арга үгүй. Гэвч нарнаас туяа өсгөдөг шилээр дамжин уулыг шатаасан нь дамжиггүй. Нарны туяа уулан дээр туслаа ч гэсэн уул амархан шатдаггүй бол гал авалцахгүй.

Хэрэв Бурханыг төрүүлдэг Бурханы мөн чанар “уулан” дээр Бурханы ухааны галт шилийг тусгаваас Бурханы гал хүмүүсийн уулан дээр авалцаж, Бурханы мөн чанарыг нээгч итгэлцлийн дөл бадарна. Бурхан өөрийн ухааны галт шилийг тусгаснаар ертөнцөд итгэлийн дөл асна.

2. Бүх хүмүүст байгалиас заяасан Гэгээрлийн үндэс буй боловч хүмүүс ертөнцийн шуналын үүл мананд төөрч, санааныхаа олзлогдогсод болон бухимддаг. Хүмүүс байгалаас заяасан Гэгээрэх сэтгэлтэй хэрнээ яагаад хуурамч ойлголтыг үүсгэж Бурханы ертөнцөөс ангижирч, эндүүрлийн ертөнцөд тэнэж байна вэ?

Эрт цагт нэг хүн өглөө эрт босоод гар нүүрээ угаагаад толинд харахад толгой нүүр нь харагдахгүй байгааг мэдээд ихэд айжээ. Үнэндээ бол толгой нүүр нь байдаг газраа байжээ. Харин тэр хүн толины эсрэг талд нүүрээ харсан учир тэгж санагджээ.

Яаж ч хичээсэн Гэгээрэлд хүрч чадахгүй нь гэж тарчлах нь тэнэг хэрэг. Ер тарчлах хэрэггүй. Гэгээрэлд төөрөгдөл байхгүй. Хүн урт хугацааны турш гадны тоосоор хөдөлж байна. Хүн дүрслэлт ертөнцөд амьдарч буйгаар өөртөө эндүүрлийн ертөнцийг үүсгэж байна.

Иймээс хүн өөрийн дүрслэх ертөнцөөс явахдаа Гэгээрэл рүү эргэж очих нь дамжиггүй. Тэгж тэр Гэгээрлээс гадна дүрслэлийн ертөнц үгүй гэдгийг ойлгоно.

3. Бурханы мөн чанар гэдэг бол мөнх. Хүн энэ ертөнцөд адгуус болж төрөөд зовж, дахин бирд болж төрөх, тамын оронд төрсөн ч Бурханы мөн чанар мөнхөд оршино. Бузардсан бидэнд ч, ертөнцийн шуналын бохир ёроолд ч Бурханы мөн чанар үргэлжид гэрэлтсээр байдаг шүү.
4. Эрт цагт нэг хүн нөхрийндөө зочлохоор очжээ. Архи уугаад согтож гэрт нь хоножээ. Түүнийг унтаж байхад нь нөхөрт нь гэнэт яаралтай хэрэг гарч аргагүй замд гарчээ. Гэвч нөхрийнхөө төлөө санаа тавьж дээлийнх нь заханд эрдэнэ оёж үлдээжээ. Нөхөр нь сэрээд, үүнийг мэдэлгүй




өөр зүгт явж, өлсөж цангаж их ядарчээ. Тэр сүүлд нөхөртэйгөө уулзахад дээлийн заханд шидсэн эрдэнэ байгааг сануулжээ. Энэ үлгэрт гардаг шиг Бурханы мөн чанарын эрдэнэ бол шунал, уур, хилэнц мэт тийм ертөнцийн шуналын гүнд нуугдаж, хэзээ ч өнгө нь гутаж гунддаггүй.

Бурханы ухаан ноогдоогүй хүн гэж энэ ертөнцөд байхгүй. Ийм учраас хүмүүсийг харцнаас нь нэвт хараад Бурхан “Бүх хүн ухаантай болоод буянтай” хэмээн баярладаг. Гэвч хүн юмыг яаж харах ёстой, тэр ёсоор нь олж харж чаддаггүй. Өөртөө байгаа Бурханы мөн чанараа олж хардаггүй. Ийм учраас Бурхан хүмүүсийг сургаж, тэднийг эндүүрлээс холдуулж, уг чанартаа бол хүн болон Бурханы хооронд ямар ч ялгаа байхгүй гэдгийг ойлгуулдаг.

5. Будда бол Гэгээрэлд хүрч Бурхан болсон нэгэн билээ. Бүх хүмүүс Бурхан болох чадвартай. Гэвч тэд хараахан болоогүй байна. Энгийн хүн, Бурхан хоёрын ялгаа үүнд оршино. Хэрэв хэн нэг нь Гэгээрэлд хүрчээ гэж бодож байгаа бол тэр бас л болоогүй, эндүүрч байгаа хэрэг юм. Бүх хүнд Бурханы мөн чанар оршдог ч гэсэн хүн өөрөө Бурханы сургаалыг хүч чармайлт гаргаж сурахгүй аваас аяндаа бүтдэггүй. Бурханы мөн чанар илрэхгүй байна гэдэг нь Бурханы сургаалыг хүртээгүй байна гэсэн үг.
6. Эрт цагт нэгэн хаан амьдарч байжээ. Тэрээр сохор хүмүүсийг цуглуулаад зааныг гараар нь тэмтрүүлээд дараа нь хүн болгоноос заан ямар байгааг асуужээ. Соёог нь тэмтэрсэн хүн шар луувантай адил гэж, чихийг нь тэмтэрсэн хүн дэвүүртэй адил гэж, хоншоорыг нь тэмтэрсэн хүн том нүдүүртэй адил гэж, хөлийг нь тэмтэрсэн хүн гуалингийн тайрдас гэж, сүүлийг нь

тэмтэрсэн хүн олс байна гэжээ.

Хараагүй хүмүүс нэг нь ч гэсэн зааны тухай зөв төсөөлөл хэлсэнгүй. Үүний адил хүний биеийн хэсгүүдийг мөн тэгж хэлэх ба харин түүний мөн чанарын тухай, Бурханы мөн чанарын тухай гүйцэд мэдэх маш хэцүү болой. Бурханы мөн чанарыг Бурханы ачаар, түүний сургаалаар олох боломжтой бөгөөд тэр нь хүн нас барсан үед ч арилдаггүй, мөнхөд оршдог.





3. БУРХАНЫ ЧАНАР, ШУНАЛААС ЗАЙЛАХ

1. Хүн болгонд Бурханы мөн чанар байдаг. Гэтэл зарим хүмүүс бусад сургаалд номлодог “би” гэдгийг алдаатай ойлгож байна. “Би” гэдэг бол дууриан татагдахын ойлголт. “Би” гэдгээс зайлсхийж байх хэрэгтэй. Бурханы мөн чанарт бол ингэх хэрэгтэй. Бичгээр илэрхийлэх боломжгүй. Энд “би” гэдэг нь бидний ойлгодог би, миний гэдэг ойлголт биш. Өөрийгөө би гэдэг ойлголт байна гэж боддог хүн бол байхгүй юмыг байна гэж зүтгэж байгаагаараа эндүүрч байгаа хэрэг. Ялгаагүй мөн чанарыг үгүйсгэж байгаа хэн ч тэр байгаа юмыг байхгүй болгон боддог хүн юм.

Жишээ нь: Хүүхэд өвдлөө. Эмчид үзүүлэхэд эмч эм өгөөд, хүүхдэд эмийг нь шингэтэл сүү битгий өгөөрэй гэж хэллээ. Эх нь хүүхдээ хөхүүлэхгүйн тулд хөхөндөө гашуун

тос түрхсэн. Хүүхдийн биенд эм шингэсний дараа эх нь хөхөө угаагаад хөхүүллээ. Ээж нь хүүгээ хайрлаж байгаа учраас ингэж байна. Энэ үлгэрт гардаг эх шиг хүмүүс биеэ “би” гэх сэтгэлийн алдааг засахын тулд Бурхан “би” гэдгийг байхгүй болохыг ойлгуулж байна. Бурхан хүний алдааг засахдаа бурханы мөн чанарыг байна гэдгийг ойлгуулж эхэлдэг. “Би” эндүүрэлд хүргэнэ. Бурханы мөн чанараар Гэгээрэлд хүрнэ.

Үлгэрт гардагчилан гэрт нь алттай авдар булаатай байгааг мэдэхгүй өлсгөлөн амьдарч буй эмэгтэйг өрөвдөн хэн нэгэн алтыг нь ухааж түүнд өгдөг шиг Бурхан бол хүнд байгаа Бурханлиг чанарыг нь нээж хүмүүст үзүүлдэг юм.

2. Хэрэв хүн бүхэнд Бурханлиг чанар байдаг юм бол хүмүүс яагаад дээр доор, баян ядууд хуваагддаг юм бэ? Яагаад тэд бие биесээ хуурч мэхлэх, алж талах, бусад муу муухай үйл үйлддэг юм бэ?

Ордны нэгэн их хүчтэн байлаа. Тэрээр духан дээрээ эрдэнийн шигтгээт гоёл зүүдэг байв. Нэгэн удаа тэр барилдаж байтал үнэт чулуун эрдэнэ нь духанд нь шигдэж оров. Бөх эрдэнийн чулуугаа алдлаа гэж боджээ. Тэгээд духны шархаа янзлуулахаар эмчид очиход эмч хармагцаа арьсан дор нь эрдэнийн чулуу шигдэж орсныг мэдлээ. Эмч үнэт чулууг сугалж аваад бөхөд үзүүллээ. Үүний адил хүмүүсийн Бурханлиг чанар ертөнцийн шуналын тоосонд маш гүн давхарга болсноос хүмүүс түүнийг мэддэггүй. Түүнийг мэдүүлэхэд маш сайн багш л тусалдаг. Иймээс хүмүүст Бурханлиг чанар байдаг боловч шунал, уур, хилэнц, мунхагаас болж түүний байгааг ажигладаггүй. Тэдний үйлийн үр лай ланчиг нь төөрөгдөлд учруулна. Гэвч Бурханы мөн чанар алдагддаггүй.



Харин эндүүрэл төөрөгдөл зайлуулагдсан цагт эрт орой од мэт хүрч ирдэг. Үлгэрт гардаг бөх, эмчийн ачаар үнэт чулуугаа олж авдгийн адил хүмүүс ч өөртөө байгаа Бурханлиг чанараа Бурханы ачаар олж авдаг.

3. Хүмүүсийн эргэн тойрон дахь орчин хичнээн хувирч өөрчлөгдөхтэй огт хамаагүйгээр Бурханы чанар бол үргэлж цэвэр тогтвортой байх юм. Үнээний өнгө улаан, цагаан, хар ямар ч байлаа гэсэн сүү нь цагаан өнгөтэй байдаг. Хүмүүс ч янз бүрийн нөхцөл байдалд харилцан адилгүй аж төрж, өөрсдийн үйлийн үрээр оногдсон хувь тавилангаа эдэлж байдаг боловч тэд бүгдэд Бурханлиг чанар нь адилхан байдаг.

Энэтхэгийн Гималайд үнэт эмийн ургамал маш шигүү ширэнгэн дор ургадаг байсан тул хүмүүс түүнийг олж авч чаддаггүй байв. Урт хугацааны дараа нэгэн мэргэн хүн түүнийг үнэрээр нь олж мэджээ. Тэр хүн нэгэн ховил хийж тэр эмийн ургамлыг цуглуулж хэрэглэдэг байв. Харин тэр хүнийг нас эцэслэсний дараа тэр нууц эм ууланд нуугдан хоцорчээ. Ховил онгоцон дахь эм ч муудаж үнэр амт нь хувирчээ.

Энэ үлгэрт гардаг шиг Бурханы мөн чанар ертөнцийн шуналын шигүү ширэнгэнд гүн нуугдсан байдаг учир хүмүүс олоход хэцүү байна. Гэвч Бурхан ширэнгийг зайлуулан түүнийг илрүүлж хүмүүст үзүүлсэн. Бурханы мөн чанар нь адил байдаг боловч ертөнцийн шуналын улмаас хүмүүст янз бүрээр хүртэгдсэнээс харилцан адилгүй амьдарч байна.

4. Бурханы мөн чанар бол алмаз шиг бат бэх. Иймийн тулд түүнийг эвдэх боломжгүй. Чулууг нүхэлж болдог бол алмазыг нүхлэх боломжгүй юм. Бие сэтгэлийг бузарлаж болдог бол Бурханы мөн чанарыг тэгэх боломжгүй

юм. Бурханы мөн чанар гэдэг бол хүний хамгийн дээд зэргийн чанар мөн. Хүмүүс эр нь эмээсээ илүү, эм нь эрээсээ дор гэж үздэг боловч Бурханы сургаалаар эр эм хүний хооронд ямарч ялгаа байхгүй. Сургаал зөвхөн Бурханы мөн чанарыг үнэлэхийг сургадаг. Хэрэв цэвэрлэгдээгүй алтыг хайлуулж холимгийг ялгаж авбал цэвэр алт шижэр алт болно. Хэрэв хүний сэтгэлийн алтыг хайлуулж ертөнцийн шунал хүсэл, хувиа хичээх мэт бүхий л муу холимгийг нь ялгаж авбал ямар ч хүнээс жинхэнэ Бурханы мөн чанар илрэх юм.



ЕРТӨНЦИЙН ХҮСЭЛ ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ



1. ХҮНИЙ ЧАНАР

1. Хүний сэтгэл дэх Бурханы мөн чанарыг ертөнцийн хоёр янзын шунал дарж байдаг. Үүнд: Ухааны шунал, мэдрэхүйн шунал. Ертөнцийн бүх шуналыг энэ хоёр хэлбэрт хуваана.

Түүний гол эх үүсвэр нь харанхуй бүдүүлэг, ховдог шунал болой. Мунхаг, хомхой сэтгэл хоёр бол шуналын эх үүсвэр болно. Мунхаг гэдэг нь үнэнийг үл мэдэх бүдүүлэг байдал мөн. Шунал гэдэг нь юмыг эзэмдэх гэсэн маш хүчтэй хүсэл, амьдралд дурлах эх үүсвэр. Нүдэнд үзэгдэх, чихэнд сонсогдох бүхнийг хүснэ. Бүр үхэх хүсэл ч болж болно.

Харанхуй мунхаг шуналаас хомхой, уур хилэн, мунхаг буруу үзэл, гомдол атаа, хуурмаг зусар бялдуучлал, дээрэлхүү зан, үзэн ядах, хөнгөмсөг явдал зэрэг ертөнцийн бүхий л муу муухай сэтгэлүүд үүсч гардаг.

2. Шунал нь хүн өөртөө аятайхан санагдсан юмаа хармагц хүслээ гүйцээх юмсан, эзэмдэх юмсан гэсэн буруу хүсэл даамжирахад үүсдэг.

Уур бол өөрийн санаанд таалагдаагүй юмаа хараад өөрийн дур хүсэлд тааруулж захирах гэсэн буруу сэтгэлд автаснаас үүсдэг.

Мунхаг гэдэг бол хүн өөрийн бүдүүлгээс болоод юуг хийвэл зохистой, юуг хийхгүй байх нь дээр вэ? гэдгийг мэддэггүйгээс үүсдэг.

Буруу үзэл гэдэг нь буруу сургаалын хар гайгаар юмыг буруу сэтгэнэ гэсэн үг.

Шунал, уур, мунхаг гуравыг энэ ертөнцийн гурван хор гэж нэрлэдэг. Шуналын гал бол өөрийн хүсэлд чөлөө өгч ухаанаа гээснээр хүнийг шатаадаг.

Уурын гал бол амьд амьтны амьдралыг залгигч бөгөөд уурласан хүн уурандаа шатна.

Мунхагийн гал бол Бурханы сургаалыг үл ойшоогч төөрөлдсөн хүнийг шатаана. Яг үнэндээ энэ ертөнцөд янз янзын гал шатаж байна. Шуналын гал, уурын гал, мунхагийн гал, амьралын гал, хөгшрөлийн гал, өвчний гал, үхлийн гал шатаж байна, Түүнчлэн уйтгар, гуниг, зовлонгийн олон гал ноцож байна. Ертөнцийн энэ олон галууд зөвхөн төөрөлдөгсөдийг залгиад зогсохгүй бусдад зовлонг учруулж бие, хэл, сэтгэлийн нүглийг үүсгэж ихэсгэж байдаг. Түүнээс гадна энэ галд түлэгдсэнээс үүсэх идээ бээр нь бусад хүмүүсийг бузарлаж, тэднийг нүглийн замд нь түлхэж байна.

3. Шунал бол өөрийгөө цэнгүүлэх мэдрэмжээс үүсдэг. Уур бол сэтгэл тааламжгүй мэдрэмжээс үүсдэг. Мунхаг бол буртагт санаанаас үүснэ.



Шуналын сэтгэл багадахгүй, түүнийг зайлуулах туйлын хэцүү. Уурын хилэнц их боловч түүнийг зайлуулах хялбар. Мунхагийн хилэнц туйлын их бөгөөд түүнээс хагацах маш бэрх.

Ийм учраас хүмүүс өөрт нь аятайхан санагдсан юмаа үзэж харахдаа зөвөөр сэтгэж, өөрт таалагдаагүй юмаа харахдаа мөн тэсвэр гарган зөвөөр сэтгэн, энэ гурван галыг унтрааж, үргэлж зөвөөр сэтгэж байх ёстой. Хэрэв хүн зөв, цэвэр, ариун, сэтгэл харамгүй бодь сэтгэлийг агуулж явбал ертөнцийн шунал тэдэнд байх газаргүй болно.

4. Шунал, уур, мунхаг бол өвчтөний халуунтай адил. Хүн халуурахад ямар ч тохитой орон гэрт байсан сайн унтаж чадахгүй дэмийрч зовж байдаг.

Ертөнцийн энэ гурван хороос ангижирсан хүн бол ямарч өвлийн хүйтэн шөнө хатуу ширүүн ор дэвсгэрт амгалан тайван нойрсч чадна. Тийм хүн зуны бүгчим халуун шөнө тохигүй умгар давчуу өрөөнд ч тухтай амарч чадна.

Ертөнцийн энэ гурван шунал бол энэ ертөнц дээрх зовлон гунигийн гол шалтгаан нь юмаа. Энэ гуниг зовлонг зөвхөн урьдчилан сэрэмжилж, ухаан сэтгэлийг төвлөрүүлснээр л засаж чадах юм. Сэрэмж бол шуналын бузараас цэвэрлэж өгдөг. Сэтгэлийг зөв төвлөрүүлэх явдал нь уурын бузараас цэвэрлэж, ухаан гэдэг нь мунхагийн бузарыг арилгаж өгнө.

5. Хүний сэтгэлд хязгаар үгүй. Энэ нь давстай ус хичнээн увч амны цангаа гардаггүйтэй адил юм. Харин ч улам цангах нь ихсэнэ.

Хүн өөрийн хүслээ гүйцээхийн тулд тэмцэхэд сэтгэл ханахгүй, мэдрэмж улам хүчтэй болж цухалдаж эхэлдэг. Хүн бол хүслээ гүйцээж хэзээ ч чадахгүй. Хүн хүссэн бүхнээ биелүүлж чаддаггүйгээс болж зовдог, ухаан нь самуурдаг.

Шуналаас болж бие биетэйгээ маргадаг, хоорондоо тэмцдэг, нэг нэгийгээ хөнөөдөг. Хаан хааныхаа эсрэг, сайд сайдынхаа эсрэг, эцэг нь хүүхдийнхээ эсрэг, анд нь нөхрийнхөө эсрэг бие биийг шуналаасаа болж хөнөөж устгаж байна.

Шуналаа гүйцээх зорилгоор хүмүүс голдуу амьдралаа хөнөөж байна. Хулгай хийж, хууран мэхлэж, буруу хурьцаж байна. Зарим нь ч гэмт хэрэг үйлдэн, ял шийтгэл эдлэн тарчилж байна.

6. Хомхой сэтгэл гэдэг бол ертөнцийн шуналын эхлэлийн эхлэл бөгөөд бусад бүх хүслүүд түүнээс үүдэн гарсан байдаг. Хомхой сэтгэл нь алив сайн сайхан бүгдийг залгиж устгадаг шулам мөн.

Хомхой сэтгэл нь өнгөт цэцгэсийн дор нуугдсан хорт могой адил, өнгөтэй үзэсгэлэнтэй бүхэнд дурлагсдыг хордуулна.

Хомхой сэтгэл нь модыг сүлжин ороодог хорт ургамалын адил хүний сэтгэлийг торлож, сайн сайхан бүхнийг нь сорон авдаг. Хомхой сэтгэл нь шуламын хаясан “яс” юм. Энэ ясыг авсан хүнийг шулмын хорт муу замд татдаг. Өлссөн нохойд яс хаяхад түүн рүү дайрч зулгаан хэмлэж дэмий л ядрах болно. Түүний адил хомхой санаа нь хүний сэтгэлийг огт амраахгүй. Үмх махны төлөө ч араатнууд бие биенээ зулгаадаг. Салхи сөрж бамбар барьж яваа мунхаг хүн тэр галандаа түлэгдэж үхнэ. Хүмүүс дээрх араатан шиг дээрх мунхаг хүн шиг шуналаас л болж биеэ зовоож “шатаадаг”.



7. Гаднаас нисч ирэх хорт сумнаас биеийг хамгаалж болдог бол дотроос нэвчсэн хорноос хамгаалах боломжгүй юм. Шунал, уур, мунхаг, дээрэлхүү зан дөрвийг янз бүрийн өвчин үүсгэгч хорт дөрвөн сум гэж болно.

Сэтгэлд шунал, уур, мунхаг оршиж байхад хүний хэл худлаа хэлдэг, дэмий сул үг ярьдаг, хорт муу, дээрэлхүү ааш гардаг. Бие нь амьд амьтныг хөнөөдөг, хулгай хийдэг, буруу хурьцдаг. Сэтгэлийн 3, хэлний 4, биеийн 3, нийт 10 хар нүгэл байдаг. Хэрэв хүн санаатайгаар хуурч байвал тэр ямар ч муу үйлийг хийж чадна. Буруу муу үйл хийж байгаа учир худлаа ярихаас аргагүй болдог. Худал ярьж байгаа болохоор муу үйл нүгэл үйлдэнэ.

Хомхой сэтгэл нь, шунал, уур, хулчгар энэ бүхэн бүгд мунхагаас үүссэн, гай зовлон ч мөн мунхагаас үүснэ. Иймээс ертөнцөд хамгийн аюултай хор бол мунхаг сэтгэл байна.

8. Ертөнцийн шуналаас болж хүн муу үйлийг хийдэг. Муу үйлийнхээ хэрээр зовдог. Ертөнцийн шунал, муу үйл, зовлон энэ гурав бол эцэс төгсгөлгүй эргэх гурван хүрд мөн. Энэ хүрдний эргэлтэнд эцэс төгсгөл гэж үгүй.

Хүн эргэлтийн энэ хүрээнээс гарч чадахгүй байна. Тэр дугуй хүрээндээ л хүн нэг ертөнцөөс нөгөө ертөнцөд дахин дахин төрж төрөл арилжих үйл эцэс төгсгөлгүй үргэлжилдэг байна.

Эргэлтийн энэ цагирагт өртөгсдийн ясыг шатаан үнсийг овоолбол ямар ч өндөр уулнаас давах буй. Тэдгээрийн шимсэн эхийн сүүг хураавал ямар ч тэнгисээс их болой.

Ийм учир хүнд Бурханы мөн чанар байдаг ч гэсэн тэр нь ертөнцийн шуналын маш зузаан давхаргаар бүрхэгддэг учир түүний дотроос гарч ирж чадахгүй байна.

Хүмүүст л ажиглагдах Бурханлиг чанар байгааг огт үгүй хэмээн боддог учир тэдний эндүүрэл эцэс төгсгөлгүй байдаг.





2. ХҮНИЙ ЗАН АРАНШИН

1. Хүний зан аашийг ойлгох маш хэцүү. Орох газар нь үл мэдэгдэх битүү ширэнгэтэй адил. Хүний зангаас араатны занг ойлгоход хялбар. Зангаар нь хүнийг дөрвөн зэрэгт хуваана.

1-р зэрэг /Зовлон эдлэгч хүмүүс. Буруу сургаалын уршгаар биеийн зовлонд учирсан хүмүүс

2-р зэрэг /Бусдад зовлон учруулагч хүмүүс.
Амьтан алдаг, хулгай хийдэг, мөн бусад тэнэг үйлдлүүдийг хийнэ.

3-р зэрэг /Өөрсдийгөө зовоож, бусдад зовлон тарьдаг.

4-р зэрэг /Өөрсдөө зовдоггүй, бусдад зовлон тарьдаггүй хүмүүс.

Тэд ямар нэг хүслээс ангид энх амгалан амьдардаг. Бурханы сургаалын дагуу амьтан алахгүй, хулгай хийхгүй, зөвхөн сайн үйл, буян үйлдэнэ.

2. Түүнээс гадна энэ ертөнцөд 3 янзын хүмүүс байна. Чулуун дээр сийлсэн бичиг шиг хүн, элсэн дээр бичсэн бичигтэй адил хүн, усан дээр бичсэн бичигтэй адил хүн байна.

Чулуун дээр сийлсэн бичигтэй адил хүмүүс бол дандаа уурладаг, уур нь гардаггүй, чулуун дээр юм сийлсэн мэт арилахгүй. Элсэн дээрх бичигтэй адил хүмүүс бол голдуу уурладаг, гэвч уур нь түргэн гарна. Усан дээрх бичигтэй адил хүмүүс бол бусдад муу үг хэлдэггүй, тэнэг мулгуу үг сонслоо ч хайхардаггүй, сэтгэл нь үргэлж дөлгөөн тайван байдаг,

1-р хэлбэр нь: Зан араншингаар ердийн хүмүүс, түргэн зантай, хөнгөндүү, тогтвор муутай.

2-р хэлбэр нь: Занг нь ойлгоход бэрх, даруу томоотой, маш болгоомжтой, өөрийн хүслийг хянаж чаддаг.

3-р хэлбэр нь: Зангий нь ойлгоход тун хэцүү буюу ойлгомжгүй.

Ийнхүү ертөнц дээр маш олон янзын хүмүүс байна. Тус бүрийнх нь занг ойлгоно гэдэг туйлын хэцүү байдаг. Зөвхөн Бурхан багш л хүн бүрийн зан аашийг нь зохицуулан, сургаал айлдан, ойлгож чадна.



3. ХҮНИЙ АМЬДРАЛ

1. Хүний амьдралын тухай үлгэр байна. Нэг хүн завиар гол уруудан хөвж явжээ. Гэтэл эргийн хажуугаас хүн хашгирч: “Чи хөгжилтэй хөвж явна. Цаад доор чинь давалгаа өндөр болно. Хүн иддэг аймшигт матар, усны эргүүлэг цүнхээлтэй. Чи зайлшгүй хөнөөгдөх болно шүү?” гэжээ. Энэ гол гэдэг нь янз бүрийн шохооролд өнгөрөх амьдрал. Голын дагуу хөгжилтэй уруудана гэдэг нь өөртөө татагдах, дурлана гэсэн үг. Их давалгаа гэдэг нь зовлон хилэнцээр дүүрэн амьдралыг хэлж байна. Усны эргүүлэг гэдэг нь түр зуурын цэнгэл. Матар, шулам орших цүнхээл гэдэг нь нүглээсээ болж ойчих там юм.

Эргийн захаас хашгирсан хүн гэдэг нь Бурханыг хэлж байна. Дахин нэг үлгэрийг сонсогтун.

“Нэг хүн гэмт хэрэг үйлдээд зугтжээ. Араас нь түүнийг мөшгөн мөрдөж, зугтаах бүхий л замуудыг хаасан байна.

Мань хүн бүх талаасаа бүслэгдэн урхинд орсноо мэдээд өмнөө байгаа нэгэн худгийн хашлаганаас доош ороонгоор дамжин буухаар шийджээ. Бууж байхдаа дор нь амаа ангайсан хорт могой байхыг үзжээ. Тэгээд замын дунд дүүжлэгдэн зогсов. Удалгүй ороонгоноос зуурсан гар нь цуцаж эхэлжээ. Тэгтэл хар цагаан хоёр хулгана гарч ирээд ороонгийг мэрж эхэлжээ. Ороонгийг мэрж дуусахад гайхал оргодол могойн аман дээр ойчихоор байлаа. Тэрээр толгойг дээш өргөтөл аманд нь амтат зөгийн бал унав гэнэ. Ороонго тасрах аюулыг таг мартан балыг амтархан хүлхэв”. Энэ үлгэрт гарч байгаа гэмт хүн гэдэг нь энэ ертөнцөд нүцгэн ирж, нүцгэн буцаж байгаа хүнийг хэлж байна. Мөрдөн хөөгчид, хорт могой гэдэг нь янз бүрийн хүсэл шуналын эх болсон энэ биеийг хэлж байна. Эзгүй худгийн ороонго гэдэг нь хүний амьдрал юм. Хар цагаан хулгана гэдэг нь цаг хугацаа. Зөгийн балын дусал гэдэг нь амьдралын түр зуурын цэнгэлийг өгүүлж байна.

2. Дахин нэг үлгэр сонсдоо. “Хаан дөрвөн хорт могойг хайрцагт хийгээд нэгэн хүнд арчилж харж байхыг тушаажээ, Уурлуулбал түүний толгойг авна хэмээн зарлиг буулгажээ. Нөгөө хүн тушаалаас ихэд айж, хайрцагтай могойгоо орхиод зугтав. Үүнийг мэдмэгц хаан хойноос нь таван зарцаа илгээжээ. Тэд оргодлыг хаанд хуурч авчрахаар шийдэв. Тэр нь мэхлэгдсэнгүй, улам цааш гүйжээ. Тэгээд нэг тосгонд хүрч хорогдох газар хайж дээ. Энэ агшинд тэнгэрээс гэнэт дуу гарчээ. Тосгонд хэн ч амьдардаггүй. Энэ шөнө зургаан дээрэмчин ирнэ гэжээ. Айсан оргодол тосгоныг орхин цааш зугатав.

Түүний цааш явах замыг том гол хаажээ. Түүнийг хөндлөн гатлах нь туйлын хүнд байлаа. Голыг зайлшгүй гатлах учиртайг мэдэж сал холбон нөгөө эрэгт нь хүрээд сая

нэг жаахан санаа амрав.” Энд дөрвөн хорт могойтой авдар гэдэг нь шороо, ус, гал, хийнээс бүтсэн хүний биеийг хэлж байна. Энэ бол сэтгэлийн дайсан, хүсэл шуналын эх үүсвэр билээ. Иймээс тэр хүн тэр биеэс зугтсан байжээ. Оргодлыг хуурахаар шийдсэн таван зарц гэдэг нь хүний бие сэтгэлийг бүрдүүлж байгаа таван махбод юмаа. Хоргодох байр гэдэг нь хүний зургаан мэдрэхүйн эрхтэн. Зургаан дээрэмчин гэдэг нь зургаан мэдрэхүй эрхтэний орших цэг юм. Мэдрэхүйн бүхий л эрхтэн аюулд хүргэдэг гэдгийг хармагц тэр хүн дахин зугтаасан. Түүний замыг хаасан их гол гэдэг нь ертөнцийн шуналаар дүүрч цалгилсан амьдралыг хэлж байна.

Бурханы сургаалын “салыг” холбож тэр хүн ертөнцийн шуналын гүн хавцалт аймшигт голыг гатлаж нам, сэлүүн амьдралыг олж авчээ.

3. Эх нь хүүхдээ аварч чадахгүй, эсвэл хүүхэд нь эхээ аварч чадахгүй гурван тохиолдол ертөнц дээр байна. Энэ нь их түймэр, их усны үер, аймшигт аюул дээрэм болой. Зарим тохиолдолд эх хүү хоёр бие биендээ тусалж чаддаг гэнэ. Мөн эх, хүү хоёр бие биедээ яагаад ч тусалж чадахгүй 3 тохиолдол байдаг гэнэ.

Энэ нь хөгшрөх, үхэх, өвдөх гурав болой. Хөгширч буй эхээ харсаар ч хөгшрөх хэмээх аюулыг зогсоох аргагүй билээ. Хүнд өвчинд шаналсан хүүгээ эх нь эрүүл хүүхдээр солих боломжгүй. Эх, хүүхэд үхэлд учрахад аль нь ч түүнийг орлуулан сольж чадахгүй.

4. Энэ ертөнцөд олон нүглийг үйлдсэн нүгэлтэн нас нөгчсөний эцэст тамд унахад нь Эрлэг Номун хаан асуусан нь:

- “Чи хүмүүний ертөнцөд амьдарч байхдаа гурван сахиусан тэнгэрийн элчтэй уулзаж байсан уу?
- Үгүй ээ. Би тэнгэртэй уулзаж байгаагүй.
- Арай ядан гэлдрэх таяг тулсан өвгөдтэй уулзаж байв уу?
- Тийм өвөгчүүлийг маш олон харсан.
- Тэдгээр сахиусын тэнгэртэй чи уулзаж байхдаа би ялгаагүй хөгширнө. Сайн үйлийг бүтээхэд шамдъя гэж огт бодсонгүй юу?

Иймээс чи энд ирж ялаа эдлэж байна” хэмээжээ. Мөн харахын эцэсгүй турж эцсэн хэвтрийн өвчтөнийг чи харсан уу?

- Тийм өвчтөнийг би маш олон харсан.

Зовлонд учирсан тэдгээр тэнгэрийг чи хараад надад бас өвчин тохиолдох нь зайлшгүй гэдгийг чи ойлгоогүй юу? Иймээс чи тамд илгээгджээ. Чиний дэргэд үхэж буй хүмүүсийг чи харав уу?


- Үхэж буй хүмүүс маш олныг би үзсэн.
- Бүхнийг үхэл хүлээж байгаа шүү! хэмээн сургаж байгаа тэдгээр тэнгэртэй чи учраад, бас чи хэзээ нэгэн цагт үхнэ, буянт үйлийн тухай битгий март гэснийг ойлгосонгүй юу? Үүний тулд чи ийм шийтгэл хүлээж байна. Өөрийн хийсэн үйлийн үрийг чи өөрөө эдлэх болно” гэжээ.

5. Кисаготами гэх нэгэн баян хүний залуу эхнэр байжээ. Тэр ганц хүүгээ үхүүлснээс ухаан санаа нь ээдрэн солиорчээ. Нас барсан хүүгийнхээ хөрсөн биеийг элгэндээ тэврээд, анагааж чадах болов уу? гэсэн бүхний эрэлд гарчээ. Мэдээж хэн ч түүнд туслаж чадсангүй, зөвхөн уй гашууг нь хуваалцаж байв. Тэгтэл Бурханы



нэгэн шавь түүнийг Жегавана-д байгаа багшдаа очиж бараалхахыг зөвлөжээ.

Тэр хүүхдээ аваад Бурхан багш дээр очжээ. Бурхан тэднийг маш анхааралтай ажаад: “Чиний хүүхдийг эмчлэхэд намуу цэцгийн үр хэрэгтэй. Хотод очоод хэн нэгнээс 4-5 ширхэг үр гуйгаад ир. Гэхдээ тэдгээр үрийг хэн ч үхэл зовлон амсч үзээгүй тийм айлаас олж ирээрэй” гэжээ. Уй гунигт гашуудсан эх намуу цэцгийн үрийн эрэлд гарчээ. Гэвч үхэл зовлон амсаагүй тийм гэр бүл хаанаас ч олдсонгүй. Эцэстээ үрлээ олохгүйгээр Бурханд буцаж ирсэн даруйдаа Бурханы тайван амарлингуй дүрийг хараад Бурханы үгийн утгыг анх удаа ухаарлаа. Хүүгийнхээ шарилыг оршуулаад эргэн ирж Бурханы шавь болжээ.



4. ХҮНИЙ БОДИТ АМЬДРАЛ

Энэ ертөнц дээрх хүмүүс бие биедээ хайхрамжгүй, бие биеэ хайрладаггүй, ялихгүй юмнаас болж бие биетэйгээ маргалдаж, хар муу санаандаа автан шаналдаг. Тэдний амьдрал тэр чигээрээ зовлон зүдгүүр. Эд баялаг албан тушаал хамаарахгүй, зөвхөн мөнгөний төлөө шанална. Нэг хэсэг нь мөнгө байхгүйгээс шаналж байхад нөгөө хэсэг нь мөнгөтэйгөөсөө болж шанална.

Зөвхөн өөрийн хүслээ хангахын тулд нэг мөч ч амрахгүй санаа нь зовно. Өөртөө байгаа бүх юмныхаа төлөө санаа нь зовно. Баян хүн гэр орон эдлэн газрынхаа төлөө санаа зовно. Бэрхшээлд учирч зовлонд өртмөгцөө, эсвэл түймэрт юмаа шатаахдаа туйлдан шаналж амь насаа хүртэл хөнөөнө.

Тэр ч байтугай үхэх замд хэн ч дагахгүй, ганцаар талийдаг юм шүү дээ. Ядуус нь юу ч үгүй учир шаналан зовдог. Тэд гэр орон эдлэн газар хүснэ. Хүслийнхээ галд



шатахдаа бие сэтгэлээрээ туйлдана. Үүнээс болж тэд орчлонд олдсон насаа гүйцэд элээхгүй, цагаасаа өмнө галийдаг. Ертөнц дээр байгаа бүх юм тэдэнд дайсагнасан мэт санагддаг. Тэгж тэд үхэх зам руугаа тонилохоос өөр аргагүй болдог.

2. Энэ ертөнцөд таван хор байна.

- 1) Ертөнц дээрх бүх амьтан, хүнээс эхлээд хорхой шавьж хүртэл бүгд бие биенийхээ эсрэг дайсагналцана. Хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэж, хүчгүй нь хүчтэйгээ хуурна. Тэд бас бие биенээ үргэлж гомдоон, доромжилж дайсагналцана.
- 2) Эцэг эх, хүүхдүүд, ах эгч дүү нар, эхнэр нөхөр, ойр дотны төрөл саднууд яг чанд мөрдөх хатуу зарчимгүй, тэд эрх зүйн ялгаагүй, зөвхөн өөрсдийн төлөө санаа тавина. Бие биесээ хуурч мэхлэн үнэнч шударга ёсоо гээн, үг яриа, үйл явдал нь хол зөрөөтэй байдаг.
- 3) Бүгд тэнэг санаа агуулж, тачаангуй хурыцлаар амьдарна. Эр нь ч, эм нь ч ялгаагүй өөрт оногдсон үүргээ биелүүлэхгүй. Үүнээс болж бие биедээ дайсагналцаж нүгэлт үйлийг хийнэ.
- 4) Буянтай сайн үйлийг хийе гэж хэн ч бодохгүй. Бүгд бие биендээ муу үйлийн үлгэр жишээг үзүүлэн, тэнэг явдал үйлдэж, хууран мэхлэж, илүү үг чалчин, хорт муу санаа агуулан, дээрэлхэж, бие биесээ доромжилно, Нэгнийгээ үл хүндлэн, өөрийгөө л энэ ертөнцөд хамгийн чухал хүн хэмээн биеэ тооно. Биесээ гомдоон хүнлэг чанараа гээж байгаагаа анзаарахгүй.
- 5) Бүх хүмүүс залхуу, сайн үйлийг мэдэхгүй, үүрэг хариуцлага хүлээх, хүнийг хүндэтгэн талархах

мэдрэмж үгүй. Бусдад зовлон учруулан зөвхөн өөрийн хүслийн дагуу л хөдлөнө. Эцэстээ хүнд гэмт хэрэг үйлдэнэ.

3. Хүмүүс бие биенээ хүндэтгэн харилцан туслах ёстой. Үүний оронд өөрийнхөө хувийн өчүүхэн сонирхолоосоо болж нэгийгээ үзэн яддаг. Тэгэхдээ маргааны өчүүхэн шалтаг нь аажимдаа бузар хэрүүл, гүнзгий нуугдсан хорсол, гомдолд хүргэдэг. Энэ ертөнц дэх дайсагналцал аль аль талдаа хор хөнөөл авчир-даг ч шууд сүйрэлд хүргэхгүй. Гэлээ ч хүмүүсийн ухаан санааг хордуулж хүнийг муу санаатай болгоно. Үүнээсээ болоод төрөл арилжсан ч бие биесээ гүтгэн доромжилдог, дайсагналцдаг. Шунал хомхой сэтгэлийн энэ ертөнцөд хүн ганцаар төрж ганцаар үхнэ.

Үйлдсэн үйлийн лай ланчгийг ирээдүйд хэн ч хүлээхгүй, гагцхүү өөрөө эдлэхээс өөр аргагүй.

Үйлийн үрийн хуулиар буян үйлдсэн хүн жаргана. Нүгэл үйлдсэн хүн зовно. Энэ бол маргашгүй үнэн юм. Хүн сайхан сэтгэл буянт үйлсийнхээ төлөө түүнийхээ үрийг эдлэж аз жаргалтай амьдрах болно.

4. Хүсэл, шунал, уур хилэн, зовлонгоор сүлжилдсэн он жилүүд өнгөрөхөд хүмүүс туйлын уйтгартай болж цөхрөлд ордог.

Гүнзгий цөхрөлд орсноор хомхой сэтгэлээ гүйцээхийн тулд хорсон хилэгнэж, ухаангүй мунхаг үйл үйлдэж, бие биетэйгээ марган тэмцэж, зөв зам дээр гарч ирж чадахгүй, цагаасаа өмнө нас эцэслэж, мөнхийн шаналгаанд ордог. Хүмүүсийн тийм амьдрал бол байгалийн хуулинд ч таарахгүй, тэнгэр газрын хуулинд ч тохирохгүй. Тийм



амьдрал заавал зовлон дагуулна. Хүмүүс энэ болоод хойд насанд шаналан зовохоос аргагүйд хүрнэ.

Үнэндээ энэ ертөнц дээрх бүх юм маш хурдан урсан өнгөрч, өөрчлөгдөж байна. Найдвартай бат бэх юм гэж юу ч алга. Тийм нөхцөлд бүгд л цэнгэлд автах нь туйлын уйтгартай.

5. Хүмүүс энэ ертөнцийн зовлонд төрөөд сайн үйлийг юу ч мэдэхгүйгээр зөвхөн хорлол үйлдэж байна. Иймээс энэ ертөнцийн хуулиар бүр их зовох лай ланчгийг эдлэж байна. Цэцэглэл хөгжил удаан үргэлжлэхгүй дороо л өнгөрнө. Энэ ертөнц дээрх баяр цэнгэл ч мөн адил дороо л өнгөрнө.

6. Иймээс хүн эрүүл саруул дээрээ ертөнцийн үйлийг орхиж зөв замыг сонгон мөнхийн амьдралыг хүсэх ёстой. Зөв замаас илүү сайн сайхан юм гэж юу байх билээ. Гэвч хүмүүс зөв үйл, зөв замд хөтөлдөг, сайн үйл буяныг төрүүлдэг гэдэгт итгэдэггүй. Түүнчлэн хүн нас нөгчсөний дараа дахин төрдөг гэдгийг ч мэддэггүй. Бас бусад хүмүүст туслахад аз жаргал ирдэг гэдэгт итгэдэггүй. Ер нь нүгэл буянтай холбоотой юм болгонд итгэдэггүй. Хүмүүс зөв сургаалыг мэдэхгүй, буян гэдгийг мэдэхгүй, эндүүрэн төөрч байна.

Тэдний сэтгэлд харанхуй бүдүүлэг байдал ноёлж байна. Зовлон жаргал, амжилт, алдаа үүсэн гардаг шалтгаан хуулийг мэддэггүй зөвхөн одоогийн энэ амьдралаар гуниж гашуудаж байна. Бүх юм урсан өнгөрч байна. Ертөнцөд хувирахгүй, тогтмол орших юм гэж юу ч алга.

Гэвч хүмүүс харанхуй бүдүүлэг, хар амиа бодсон, өнөө маргаашийн хүсэл зовлонтой л холбож ойлгож байна.

Зөв сургаалыг сонсохгүй, юмыг бясалган бодохгүй, өөрсдөө олж авч чадах зөвхөн цэнгэлд л тэмүүлнэ. Тэдний баяжих, биеийн хурьцах хүсэлд хязгаар төгсгөл гэж үгүй.

7. Тоолж баршгүй хүмүүс маш эрт цагаас эндүүрэл төөрөгдлийн ертөнцөд амьдарч байна. Тэд мөнхийн түгшүүрт, даагдашгүй зовлонд амьдарч байна. Одоо ч энэ төөрөгдөл үргэлжилсээр байна. Харин одоо бол Бурханы сургаалыг мэдэж, түүнд итгэх боломжтой болсон нь азтай завшаантай хэрэг.

Уур хилэн, хорт муу сэтгэлээс зайлсхийж, гүнзгий бясалгал, буян, сайн замыг сонгож, бие сэтгэлээ ариун байлгаж, Бурханы сургаалыг дагах хэрэгтэй. Хамгийн завшаантай нь одоо үед Бурханы сургаалын бүхий л мэдлэг бидний үеийг хүрч иржээ. Иймээс Бурханы сургаалд итгэж, Бурханы оронд төрөхийг хүсэж залбирах ёстой. Бурханы сургаалыг мэдсэнээр бид зөвхөн өөрсдийгөө аврахын тулд бус, бусдыг аврахын тулд хичээх хэрэгтэй.





БУРХАНЫ АВРАЛ ТАВДУГААР БҮЛЭГ



1. БУРХАНЫ САХИЛ

1. Хүмүүс энэ эндүүрэлт ертөнцийн шуналаас чөлөөлөгдөх маш хэцүү. Эрт цагаас тэд буруу үйл хийсээр төөрөлдөж иржээ. Хүмүүст Бурханлиг чанар байдаг боловч түүнийгээ илрүүлж чаддаггүй.

Хүний чанарыг сайтар мэддэг Бурхан өнө эртнээс Дээд нигүүлсэнгүй сэтгэлийн илэрхийлэгч болсон Бодьсад болохоор шийдэж хүмүүсийг аймшигт зовлонгоос ангижруулж эхэлсэн юм. Үүний тулд олон тооны сахил авч, хичнээн хүнд сорилт өөрт нь ноогдсоныг үл анзааран, бололцоотой бүхнийг үйлдэхээр тангарагласан.

- Би Бурхан болох байлаа ч миний ертөнцөд төрж буй хүмүүс Бурхан болж чадахгүй, Гэгээрэлд хүрч чадахгүй аваас би Гэгээрэхгүй.

- Би Бурхан болох байлаа ч миний ертөнц хязгаарлагдмал, ертөнцийн бүх өнцөг буланг хүрч чадахгүй аваас би Гэгээрэхгүй.
- Би Бурхан боллоо ч гэсэн миний амьдрал хязгаарлагдмал, жилээр тоологдох аваас би Гэгээрэхгүй.
- Би Бурхан боллоо ч гэсэн арван зүгийн хамаг Бурхад миний нэрийг алдаршуулахгүй аваас би Гэгээрэхгүй.
- Ертөнцийн арван зүгийн хүмүүс миний сургаалд гүнзгий итгэлтэйгээр ороод миний оронд төрөхийг хүсэвч, үүнийгээ гүйцэлдүүлж чадахгүй аваас би Гэгээрэхгүй.
- Би Бурхан боллоо ч гэсэн миний сургаалыг дагахаар шийдсэн ертөнцийн арван зүгийн орны хүмүүс олон тооны буянт үйлийг хийгээд, чин сэтгэлээсээ миний оронд төрөхийг хүсэн залбираад үхэхэд нь би агуу их Бодьсад нараар хүрээлүүлэн очиж, тэднийг өөрийн ариун орондоо удирдан урьж чадахгүй аваас би Гэгээрэхгүй.
- Ертөнцийн арван зүгийн хүмүүс буяны үрийг тариад, чин сэтгэлээсээ миний оронд төрөхийг мөрөөдөж, энэ хүслээ гүйцээж чадахгүй бол би Гэгээрэхгүй.
- Миний оронд төрсөн хэн ч гэсэн Бурхан болж чадахгүй, бусдыг агуу их нигүүлсэнгүй, Гэгээрлийн замд хөтлөж чадахгүй аваас би Гэгээрэхгүй.
- Миний сургаалаар тэжээгдсэн хүн болон ертөнцийн арван зүгийн хүмүүс бие сэтгэлээ номхроож хүсэл шуналаа дарж, энэ ертөнцөд хамгийн сайн ухааныг олохгүй аваас би Гэгээрэхгүй.
- Хэрвээ ертөнцийн арван зүгийн амьтад амьдрал үхлийн жинхэнэ үнэнийг мэдэж, гүн ухаанд хүрээгүй аваас би Гэгээрэхгүй. Би эдгээр тангаргийг өргөж байна.
- Хэрвээ энэ бүх миний хүслүүд биелэхгүй аваас би



Гэгээрэхгүй. Мөхөшгүй гэрлийн эх үүсвэр болмогцоо би бүх орныг гийгүүлж, хүмүүсийг төөрөгдлөөс ангижруулж, буяны үйлсийг газар сайгүй дэлгэрүүлж, сургаалыг айлдах болно гэжээ.

2. Эдгээр тангараг сахилыг аваад Бурхан урт хугацааны турш тоо томшгүй их буяныг үйлдэж, маш эрт цагт Бурханы хутгийг олж, ариун орноо цогцлуулж, одоо ч ариун орондоо сургаалаа айлдсаар байна. Үүнд эргэлзээ төөрөгдөл байхгүй. Гэгээрлээс үүсэх сэтгэлийн жаргал л эдлэнэ. Хувцас хунар, идээ зоог, бусад тансаг бүхэн энэ ертөнцийн амьтны хүссэнээр олдоно. Эрүүл сайхан, анхилам салхи үнэт эрдэнэсийн модоор дамжин гайхамшигт, ариун сургаалыг номлогч дуу хоолой, агаар орчныг дүүргэж, тэнд сонсож буй бүхний сэтгэлийг ариусгана.

Энэ ертөнцөд зүйл бүрийн өнгийн Бадамлянхуа цэцэг дэлгэрнэ. Цэцэг бүр тоо томшгүй олон дэлбээтэй. Дэлбээ бүр нь өөрийн туяагаар гийгүүлэн, туяаны цацраг бүр нь Бурханы ухааныг номлож, сонссон бүхнийг мөнхийн амгалан, энхийн Бурханы сургаалд хөтлөнө. Ертөнцийн арван зүгийн амьтад Бурханы буяныг магтан дуулна. Энэ Бурханы нэрийг сонссон хэн ч гэсэн түүнд бүх сэтгэлээр итгэн Бурханы оронд төрж чадна.

Бурханы оронд хүрсэн хэн ч гэсэн Мөнхийн амгаланг олж, бусдыг аврах хүсэлд автаж, өөрийн биеийг энэ буянт үйлсэд зориулна.

Ийм хүсэлтэй хүмүүс, хүмүүний ертөнцийн мөнх бус ёсыг ойлгож аливаа шунал хүслээс ангижирдаг. Тэгж чадсанаар зөвхөн өөрт бус, бусдад тустай буянт үйлсийг үйлдэж эхэлдэг. Ертөнцийн шунал тачаалаас ангид, хүмүүсийн зовлон зүдгүүрийг хуваалцана. Тэдгээр нь энэ

ертөнц зовлон шаналангаар дүүрэн гэдгийг мэддэг.

Бурханы агуу их энэрэн нигүүлсэнгүй сэтгэлд зах хязгаар байхгүй гэдгийг мэддэг. Тэдний сэтгэлд ямар ч шунал байхгүй бөгөөд өөрийн болон бусдын хооронд зааг ялгаа тавьдаггүй. Иймээс Бурханыг таньсан хэн ч гэсэн нэг удаа ч гэсэн түүний нэрийг чин санаанаасаа дурдвал Бурханы нигүүлсэнгүйг хүртэнэ. Бүх хүмүүс Бурханы сургаалыг сонсож, тэр замаар явах ёстой. Гэгээрлийн замд хүрэхийг үнэн голоосоо хүсч буй бүхэн Бурханы авралыг эрэх хэрэгтэй. Бурханы авралгүйгээр ерийн хүмүүн Гэгээрлийг олж чадахгүй.

4. Авид Бурхан хүн бүхнээс холгүй оршино. Үнэндээ Бурханы орон маш хол байдаг боловч Бурхан өөрөө Бурханыг бодож байгаа хүн бүхний сэтгэл дотор оршиж байдаг. Хэрвээ Бурханыг сэтгэлдээ дүрслэх юм бол тэрээр үй түмэн алтан туяа цацруулсан найман түм дөрвөн мянган хэлбэр дүрсээр оршино. Хэлбэр дүрс болгон нь наян дөрвөн мянган туяа цацруулна. Туяа болгон нь Бурханыг боддог хүн бүхнийг гэрэлтүүлж, түүнийг орхиж үл одно. Хүн Бурханыг хараад сэтгэлийг нь ойлгоно, Бурханы сэтгэл гэдэг бол агуу их нигүүлсэнгүй сэтгэлээс өөр юу ч биш юм.

Бурхан өөрт итгэгчдийг авраад зогсохгүй түүний нинжин сэтгэлийг үл ойшоогч, түүнийг муушаан мартагч нэгнийг бас авардаг.

Бурханд итгэж байгаа хүнд яг сэтгэлээрээ Бурхантай нэгдэх боломж олдоно. Бурханыг бодоход хүн бүрийн сэтгэлд нэвтрэн орж, ямар ч юмыг өөрөө эзэмдэж дүүргэж чадна. Ийм учраас хүн Бурханыг бодож байна гэдэг бол түүний сэтгэл Бурханы ариун Гэгээрлээр бялхаж, өөрөөр хэлбэл Бурхан боллоо гэсэн үг. Үнэнч шударга, цэвэр ариун



сэтгэлтэй хүн ч гэсэн тэр чигээрээ Бурхан хүн байна гэж бодох хэрэгтэй.

5. Бурханы хэлбэр олон янз. Бурхан бол хүн бүрийн өмнө тэдний бурханлиг ойлгох чадварт нь тохируулж, янз бүрийн хэлбэр дүрсээр харагдаж болдог. Бурхан өөрөө бүх ертөнцийг дүүргэж, эзэлж чадна. Түүнд зах хязгаар гэж үгүй. Бурхан хүний ухаанд ойлгогдмооргүй, Бурханыг ертөнцөд, байгальд, хүн болгонд харж болно. Бурханы нэрийг бишрэлтэйгээр дурдаж байгаа болгон түүнийг харж чадна.

Бурхан хоёр бодьсад хамт гарч ирнэ. Жанрайсиг нигүүлсэхүйн бодьсад болон Манзушири Билиг билгүүний бодьсад нарын хамт Бурхан бүх ертөнцөд гарч ирэх боловч зөвхөн түүнд биширсэн хүнд харагдана. Бурхантай уулзлаа гэж бодох нь хүнд их аз жаргалыг авчирдаг бол жинхэнэ Бурхантай учрах нь хэмжээлшгүй их амгалан жаргаланг эдлүүлдэг.

6. Бурханы сэтгэл гэдэг бол агуу их ухаан, энэрэнгүй сэтгэлээс өөр юу ч бус. Ийм болохоор Бурхан ямар ч хүнийг аварч болно. Хүн өөрийн мунхагаас болж сэтгэлдээ шуналт хилэнц, муу санаа агуулснаар, хэлээрээ дэмий чалчигч, дээрэлхүү омогт, буртагт ширүүн үгийг хэлснээр, биеэрээ амьтан алж, хулгай хийж, буруу хурьцал, арван хар нүглийг үйлдсэнээр үйлийн үрээ эдлэн хойшид мөнхөд шаналан зовох болно. Үхлийн цаг тулж ирэхэд түүнд сайн нөхөр нь ирж, чамайг их зовлон хүлээж байна.

Чи Бурханы тухай бодож чадахгүй ч зөвхөн нэрийг нь дурдаад бай гэж хэлэхэд тэр хүн үнэхээр зөвшөөрч Бурханы нэрийг үнэн сэтгэлээс давтаад байх юм бол Бурханы нэрийг хэлэх болгонд түүний нүгэл нимгэрч, тэр төгсгөлгүй

шаналах төөрөгдлийн ертөнцөөс аврагдах болно.

Жинхэнэ зүрх сэтгэлээсээ залбирал үйлдвээс бүр ч сайн бөгөөд үхэх цаг тулахад Бурханы ариун нэрийг дуудан залбирч чадсан хүн бүхэн Авид Бурхан болон түүний хоёр их бодьсадтай уулзаж, тэднээр хөтлүүлэн, цагаан лянхуа дэлгэрсэн Бурханы ариун оронд төрөх болно.

Иймд хүн бүхэн “Наму-Амида-Бүцү” (Амида бурханд мөргөө) хэмээх залбирлыг тогтоон залбирах ёстой. Энэ нь “Бурхан багшид буцалтгүй итгэе” гэсэн утгатай бөгөөд энэ залбирлыг олонтаа уншсанаар Бурханы алдрыг дуудсантай утга нэг юм.





2. АВИД БУРХАНЫ АРИУН ДИВААЖИН

/Амгалант Сугаавадийн орон/

1. Хязгааргүй гэрэлт мөнхийн Авид Бурхан үнэний гэрлээ цацруулан, сургаалаа айлдан заларч байна. Түүний ариун оронд ямар ч зовлон, харанхуй үгүй, цаг мөч бүр жаргалтай. Иймээс түүнийг диваажингийн орон гэж нэрлэдэг.

Ордны төв хэсэгт эрдэнийн чулуугаар бүтсэн долоон цөөрөм байх бөгөөд түүний ус нь ариун цэнгэг, цөөрмийн ёроол алтан элсээр бүрджээ. Гадаргуу дээр нь Бадамлянхуа цэцэглэсэн байна.

Цэнхэр лянхуагаас цэнхэр, цагаан лянхуагаас цагаан туяа цацран агаар нь эдгээр цэцэгсийн үнэрээр анхилна.

Цөөрмийн орчимд алт, мөнгө, болор, индранилаар бүтсэн дөрвөн ордны гантиган шат нь усны зах руу аваачсан байна. Цөөрмийн дээд, бусад хэсгүүдэд шатны хашлага эрдэнийн чулуу шигтгэсэн хөшгөөр хаагдсан байна. Хаа сайгүй анхилуун үнэрт мод, цэцэгс ургасан байна.

Тэнгэрээс Бурханы уянгалаг хөгжим эгшиглэн, орчныг алтлаг өнгөөрөө гийгүүлнэ. Хоногт зургаан удаа тэнгэрээс цэцэгс бууж ирнэ. Хүмүүс түүнийг цуглуулж вааранд хийгээд тоо томшгүй Бурхдад өргөнө.


2. Энэ орны цэцэрлэгт гургалдай, хун, тоть бүхий л шувууд эгшиглэнт хоолойгоор тасралтгүй дуулна. Эдгээр нь буянтан, буяныг магтан дуулж, Бурханы сургаалыг номлож байдаг. Дуучин шувуудын эгшиглэнт хоолойг сонсоод хүмүүс Бурханд залбирч, хүмүүс эвтэй найртай амгалан тайван амьдрахыг залбирдаг. Энэ дууг сонсч байгаа хэн ч гэсэн Бурханы номлолыг сонсож, сүсэг бишрэл нь улам зузаарч, сэтгэл нь баяр баясгалангаар дүүрч Бурханы ариун орны гурван эрдэнэд залбиран сүсэглэнэ.

3. Яагаад энэ диваажингийн Авид Бурханыг хязгааргүй гэрэлт мөнхийн Будда гэж нэрлэнэм бэ? Түүний үнэний гэрлийн сүр жавхлан хэмжээлшгүй. Түүний гэрэл ертөнцийн арван зүгийн орон, бүх орныг гэрэлтүүлээд дундаршгүй. Амьдрал нь төгсгөлгүй, нигүүлсэнгүй сэтгэл нь хязгааргүй, үй түмэн олны амьдралд шавхагдашгүй учир тэгж нэрлэсэн билээ.


Түүний ариун оронд төрж, төгс Гэгээрлийг олсон хүн тоо томшгүй. Тэд хэзээ ч үхэл эндүүрлийн ертөнцөд эргэж төрөхгүй. Бурханы гэрлээр сэрж, шинэ зам сонгогчдын тоо бас хязгааргүй. Хүмүүс үхлийн мөчид тулахдаа нэг юмуу



долоо хоногийн өмнө ч гэсэн сэтгэлээ Бурханд төвлөрүүлж чадваас, Бурханы нэрийг гүн бишрэлтэйгээр дуудваас, тэдгээр хүмүүс эцсийн тэр мөчдөө Авид бурхан болон Ариун Гэгээдээр хөтлүүлж Бурханы ариун оронд төрөх болно. Хэрэв ямар ч хүн Авид Бурханы нэрийг сонсч, түүний сургаалд итгэн бишрэх аваас тэр хүн төгс Гэгээрэлд хүрэх чадвартай болно.



ГЭГЭЭРЭЛ



ГЭГЭЭРЭХ ЗАМ ӨӨД НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



1. СЭТГЭЛИЙГ АРИУСГАХ

1. Хүн эндүүрэл зовлонгийн эх булаг болсон энэ л ертөнцийн хүслийн урхинд оосорлогдсон байдаг. Энэ хүсэлд эзлэгдэхээс зайлсхийх таван арга байна.
 - 1) Нягт нямбай шинжилсэний үндсэн дээр юмсын тухай зөв ойлголттой байх. Түүнчлэн үйлийн үр, түүний ач холбогдлыг зөв ойлгосон байх ёстой. Бүх зовлонгийн эх үүсвэр бол сэтгэлийг зовоогч ертөнцийн хүсэл, шунал, уур хилэн гэдгийг мэдэх хэрэгтэй. Ингэхлээр энэ хүсэл шуналуудыг арилгаж чадвал зовлон ч арилна. Хүмүүс алив юмсыг зөв харж чадахгүй, өөрийн “Би”-г байна гэж үздэгээс шалтгаалан үрийн хуулийг тоомсорлохгүй байдаг. Ийм алдаатай ойлголт нь хүнийг төөрөгдүүлж зовоож байна.

- 2) Ертөнцийн хүсэл шуналыг сэтгэлийн хатуу тэвчээрээр зогсоон барьж дийлсэнээр хазаарлан зогсоож чадна. Нүд, чих, хэл, хамар, бие сэтгэлээр үүсэх хүслийг эрүүл ухаанаар дарж шуналыг үндсээр нь таслах хэрэгтэй.
 - 3) Аливаа юмсыг ашиглахдаа зөв зохистой хэрэглэх ёстой. Хувцас, хүнсийг зугаа цэнгэл болгох хэрэггүй. Хувцас нь биеийг халуун, хүйтнээс хамгаалсан, биеийн нууцыг халхлахад л зориулсан байваас зохино. Идээ ундааг бие махбодийг сэргээж, хүч сэлбэн тэтгэхэд зориулж хэрэглэх ёстой. Хэрэв хүмүүс архийг тэвчвэл ертөнцийн буруу хүсэл түүний сэтгэлд үүсэхгүй.
 - 4) Хүмүүс гэсвэр хатуужилд суралцах хэрэгтэй. Халуун, хүйтэн, өлсөж, цангах, ядрах, өвдөхийг гэсвэрлэх ёстой. Түүнчлэн аливаа доромжлол гүтгэлгийг хүлцэж сурах хэрэгтэй. Тэгвэл өөрийн шуналын галыг унтраах болно.
 - 5) Аливаа нүүрлэх аюулыг урьдчилан харж, түүнээс сэргийлэн зайлсхийх хэрэгтэй. Хэрсүү хүн догшин морь, галзуу нохойд ойртдоггүй шиг аюултай орчинд аваачиж болох муу нөхрөөс ч зугатах хэрэгтэй. Тэгвэл шуналын гал унтраах болно.
2. Энэ ертөнцөд таван бүлэг шунал байна. Эдгээр нь: дур булаам сайхныг нүдээр харах, таатай аялгууг чихээр сонсох, аятай үнэрийг хамраар мэдрэх, шүлс гоожим сайхан амтыг хэлээр мэдрэх, тааламжтай мэдрэмжийг гар (арьс) хүрэлцэн мэдрэхэд үүснэ. Энэ таван үүдээр биеийн таашаал шунал руу хөтлөгдөнө. Олон хүмүүс хойшид ирэх үр дагаварыг үл ойшоон энэхүү хүслээ гүйцээх гэж цэнгэлд умбана. Энэ нь ойн буга анчны



урхинд ордог шиг шуналын цалманд лавтай орж буй хэрэг. Мэдрэхүйгээр дамжин гарах хүслийн таван үүд нь хамгийн аюултай хавх занга болно. Хүн энэ хавханд ороход сэтгэлд нь шунал үүсч зовж эхэлдэг. Энэ хавхнаас яаж зайлах вэ? гэдгийг мэдэх ёстой.

3. Ертөнцийн шуналын хавхнаас чөлөөлөгдөх нэг ч арга алга. Жишээ авъя: Могой, матар, шувуу, нохой, үнэг, сармагчин огт өөр ийм зургаан амьтныг бөх уяагаар холбоод тавья гэж саная. Амьтан бүр өөр өөрийн авьяасаараа өөрсдийн оромж руугаа зүтгэнэ.

Могой нүх рүүгээ, матар ус руу, шувуу тэнгэрт, нохой тосгон руугаа, үнэг тал руугаа, сармагчин ой руу зүтгэнэ. Тэгэхэд хамгийн хүчтэй нь бусдыгаа чирнэ. Үүний адил нүдээр харсан, чихээр сонссон, түүнчлэн хамар, хэл, арьс, сэтгэлээр мэдэрсний аль дийлсэн нь дагуулна. Эдгээрээс хамгийн хүчтэй нь ялж, хүн тэр хүслийнхээ эрхэнд ордог. Хэрэв дээрх бүх амьтныг газарт бэхэлсэн шонд уясан бол эхлээд зүг зүг тийшээ цөхөртлөө дэвхцэж байгаад хүч нь барагдаж шонгийн хажууд хэвтэх болно. Үүний адил хүн ч гэсэн өөрийн сэтгэлийг эзэмдэн захирч сурвал таван хүслээ хазаарлан зогсоож, сэтгэл нь номхорч, энэ болоод хойд насандаа жаргалтай болно.

4. Хүмүүс хувийнхаа эрх ашгаас болж нэр алдар, магтаалыг хүсдэг. Гэвч нэр, алдар, магтаал гэдэг бол өөрөө шатаад дуусчихдаг хүжтэй адил юм. Хэрэв хүмүүс тэр нэр төр, магтаалын хойноос хөөцөлдвөл үнэний замыг алдана. Тэгээд л ноцтой аюулд учран удахгүй харамсан гашуудахад хүрнэ. Нэр төр, баялаг, мөнгөний хойноос хөөцөлдөгч хүн бол амтат баланд дүрсэн хурц хутга долоож буй хүүхэдтэй адил юм.

Балны амтыг авмагц хэлээ зүсэх аюул учирна.

Хүсэлдээ шунасан хүн хүчтэй салхины эсрэг бамбар барьж яваатай адил. Галын дөл гар нүүрийг нь хуйхлах нь дамжиггүй.

Шунал, мунхаг, уураар хордсон өөрийн сэтгэлд итгэж болохгүй. Сэтгэлийг дуранд нь туйлуулж болохгүй. Өөрийн сэтгэлийг барьж хүсэлд захирагдахгүй байх хэрэгтэй.

5. Сэтгэлийг төгс хянаж сурна гэдэг бол хамгийн хүнд сорилт. Гэгээрлийг хүсч байгаа хүн бүхэн юу юуны түрүүнд өөрийгөө шуналын бүх галаас зайлуулах хэрэгтэй. Шунал бол гал юм.

Тэгвэл Гэгээрлийг эрж байгаа хүн, өвс авч яваа хүн түймэрийн галаас өвсөө хамгаалж гарахтай адил шуналын галаас өөрийгөө хамгаалан зугатах хэрэгтэй.

Сайхан өнгө хараад сэтгэл минь эзлэгдэх нь хэмээн нүдээ ухааж авъя гэвэл тэнэг хэрэг болно. Хамгийн гол нь ухаанаа захирч чадах аваас шунал алга болно. Гэгээрэх замд хүрэх хэцүү бөгөөд Гэгээрэх замыг эрэлхийлэх сэтгэлгүй байх бүр хэцүү. Гэгээрэхгүйгээр үхэл амьдралын энэ ертөнцөд эцэс төгсгөлгүй зовно. Гэгээрэх замыг эрж буй хүн балчиг шавар дотор туучин яваа ачаатай шартай адил. Хэрэв шар нь бусад юманд огт анхаарахгүй зөвхөн замаа харан зүтгэвээс шаврыг туулж гарсны эцэст амрах болно. Үүнтэй адил ухаанаа зөв замд нь оруулбал саад болох шуналын шавар намаг үгүй болж, зовлон арилах болно. Хүслийн шавар үлэмж гүнзгий боловч зөв сэтгэлээр Гэгээрэх замаар замнавал шаврыг гаталсны дараа зовлон арилж жаргалангийн үрийг амсах болно.

6. Гэгээрлийн замыг эрж байгаа хэн бүхэн юуны урьд омог бардам занг зайлуулж чадаад Бурханы сургаалын



гэрлийг хүндэтгэн тосч авах хэрэгтэй. Ертөнцийн бүхий л баялаг, алт мөнгө, нэр төр зэрэг нь мэргэн ухаан, мэдлэг, буянтай харьцуулбал юу ч биш. Эрүүл явъя гэвэл, гэр бүлдээ жинхэнэ аз жаргалыг авчиръя гэвэл юуны өмнө дэг журам баримталж, ухаанаа удирдаж сурах хэрэгтэй.

Хүн ухаанаа удирдаж чадах юм бол Гэгээрэх замыг олж чадах бөгөөд мэргэн ухаан, буян ч түүнд зайлшгүй ирнэ. Эрдэнэ баялаг газраас гарч ирдэг шиг сайн үйлсээс буян, ариун цэвэр, туйлбартай ухаанаас мэргэн ухаан гарч ирдэг. Эндүүрэл зовлонгоор дүүрэн амьдралын зах хязгааргүй талыг мэнд туулахад өөрийнхөө ухааныг гийгүүлж, буянаар тэтгүүлэх хэрэгтэй.

Шунал, уур, мунхаг гурваас ямагт зайлсхийхийг Бурхан бидэнд сургасан. Энэхүү гайхамшигт сургаалаар явсан хэн боловч сайнаар амьдарч аз жаргалд хүрсэн билээ.

7. Хүний амьдрал гэдэг бодлынхоо дагуу хөдөлж байдаг. Шуналын тухай бодвол шунал төрөх, үзэн ядах санааг төрүүлбэл улам хорсол буцлах, өшөө хорсолын зай өсвөл өшөө авах бодол төрнө.

Намар ургац хураах цагт тариачид бэлчээрт буй үхрийг хашаанд хийж хорьдог. Энэ нь тариаг үхэрт талхлуулахгүйн тулд, үхэртэй хөөцөлдөн уур уцаараа барж ахиж зодохгүйн тулд хийж байгаа хэрэг. Хүн ч гэсэн муу үйлээс гарч байгаа гай зовлонг урьдчилан хараад, муу үйлээ таслан зогсоож, муу сэтгэлээ батад цоожлох хэрэгтэй.

Шунал, үзэн ядах өшөө хорслын сэтгэлийг таслан зогсоогоод, сэтгэл санаа нь шуналгүйгээр, үзэн ядахгүйгээр, өшөө хорслын сэтгэлийг үүсгэхгүй байх хэрэгтэй. Хавар нуга тал ногоороход малчид үхрээ бэлчээдэг. Тэгээд сүргээ нүд салгалгүйгээр байнга харж байдаг. Үүнтэй адил хүн ч

гэсэн сэтгэлийн бодлоо захирч хянаж байхын тулд байнга анхаарах хэрэгтэй.

8. Эрт цагт Шагжамүни Бурхан Каусамби хотод саатаж байжээ. Хотод түүний эсрэг хорт санаат хүн байв. Тэр бас муу хүмүүсийг ашиглан хот даяар ялж төгс нөхцсөн Бурханы тухай муу үг, гүтгэлгийг тараажээ. Бурханы шавь нар хотод өглөг цуглуулахаар ирэхэд тэдэнд юу ч өгсөнгүй. Харин өөрсдийг нь доромжилсон үг л сонсчээ.

Тэгэхэд Ананда хэлсэн нь: “Энэ хотод удахгүйгээр цааш өөр хот руу одсон нь дээр” гэжээ. Бурхан өгүүлрүүн: “Ананда, өөр хотод бас ингэж угтвал яах вэ?” гэв.

- “Тэгвэл дахиад өөр хотод очъё” гэж Ананда хариулжээ.
- “Үгүй ээ. Ананда, Биднийг ямар ч хотод ингэж угтах болно.

Тэгвэл бид нэг хотоос нөгөө хот руу эцэс төгсгөлгүй явах болно.

Биднийг хүн доромжлоход бид доромжлохоо больтол нь тэсвэрлэнэ. Тэгээд өөр хот руу явж болно” гэв.

Бурхан бол олох гээх, нэр төр ба гүтгэлэг, магтах муулах, зовлон жаргалан гэх найман ойлголтоос ангид байна. Энэ бүхэн удахгүй засрана гэж тэсвэрлэдэг.



2. ЗӨВ ЯВАХ

1. Гэгээрлийн замд хүрэхийг хүсэгч хүн бүр бие, хэл, сэтгэлээ ямагт цэвэр авч явахын чухлыг үргэлж санаж явах ёстой. Биеийн үйлийн ариун байдал гэдэг нь амьтан алахгүй, хулгай хийхгүй, буруу хурьцлаас зайлсхийхийг хэлнэ. Хэлний үйлийн ариун байдлыг хадгална гэдэг нь худлаа хэлэхгүй, ширүүн догшин дээрэлхүү үг хэлэхгүй, дэмий чалчихгүй байхыг хэлнэ. Сэтгэлээ цэвэр байлгана гэдэг бол бүх уур, шунал, хуурамч санаа зэргийг бүгдийг зайлуулна гэсэн үг. Сэтгэл ариун бус бол үйл явдал нь бас бусармаг болж зовлонгоос зайлж чадахгүйд хүрнэ. Иймээс бие сэтгэлийг цэвэр ариун хадгална гэдэг бол туйлын чухал.
2. Эрт цагт нэгэн баян бэлбэсэн эмэгтэй амьдарч байжээ, Тэр сайхан зантай, зөөлөн ааштай, даруу эмэгтэй шиг

байв. Олонд нэр хүнд сайтай байлаа. Түүний шивэгчин эмэгтэй бас ухаалаг, хөдөлмөрт дуртай нэгэн бөлгөө. Нэг удаа зарц эмэгтэй бодсон нь:

“Манай эзэгтэй олонд их нэр хүндтэй юм. Чухамдаа бол үнэхээр сайн хүн юм болов уу? Гэвч орчны нь хүмүүсийн ивээлээр тийм харагддаг байж болох юм. Шалгаж үзье” гэж шийджээ. Дараа өдөр нь зарц бүсгүй орой босож үдийн хоолонд ирсэн байна. Тэгэхэд нь эзэгтэй:

- “Яагаад чи ийм орой босож байна” гэж ууртай асуусан.
- “Намайг ганц хоёр удаа орой босоход уурласны хэрэггүй” гэж зарц бүсгүй хариулсан нь эзэгтэйг бүр ч ихээр бухимдуулав.

Дараа өдөр нь бас л орой босож ирсэнд уурссан эзэгтэй мод шүүрч аваад зарц бүсгүйг зодсон гэнэ. Үүнийг хүмүүс мэдэж, эзэгтэй хамаг нэр төр, алдар хүндээ алдсан байна.

3. Бүх хүмүүс энэ эмэгтэйтэй адил орчны нь хүмүүс сайн бол хүн даруу төлөв сайхан зантай байдаг. Гэвч орчны нь хүмүүсийн зан өөрчлөгдөн түүний эсрэг босвол тэр хүн хуучин янзаараа байж чадах уу? үгүй юу? гэдэгт гол нь байна. Хоол, хувцас муутай ядарч доройтож явахад нь өөрийнх нь эсрэг давшлах, муугаар хэлэх зэргийг сонсоод сэтгэл нь огт хөдлөхгүй тайвнаар буянт сайн үйлээ үргэлжлүүлж чадвал үүнийг буяны үйл гэж нэрлэнэ.

Хажуу дахь, тойрон байгаа хүмүүс сайнаар хандана уу?, муугаар хандана уу? хамаагүй, ухаанаа номхотгосон түвшин зангаа байнгад баримталж буянт үйлээ үргэлжлүүлж яваа хүмүүсийг бид жинхэнэ сайн хүмүүс хэмээнэ. Бурханы сургаалыг үнэхээр хүртсэн, бие сэтгэлийн дасгалыг хөгжүүлсэн хүн л үргэлж тайван дөлгөөн сэтгэлтэй байж



чадах жинхэнэ сайн хүн юм.

4. Бүх үгсийг эсрэг утгаар нь таван бүлэгт хувааж болно. Үйл явдалд зохистой, зохисгүй, зөөлөн ширүүн, ашигтай, хортой, хайрласан, үзэн ядсан гэх мэт.

Үгийг сонгохдоо тэр ярьж байгаа хүнд ийм муугаар нөлөөлнө гэдгийг үргэлж санан туйлын болгоомжтойгоор хэрэглэх ёстой.

Хэрэв бидний сэтгэл хайр энэрэл, нигүүлсэнгүйн сэтгэлээр дүүрсэн байвал аливаа муу үгэнд сэтгэл хөдлөхөө болино. Уур хилэн, үзэн ядах мэдрэмжээс гарч ирэх аливаа бүдүүлэг муу үгсийг бид уруул давуулахгүй байх ёстой.

Бид бүгд хайр энэрэл, мэргэн ухаан шингэсэн үгээр харилцаж байх ёстой. Энэ ертөнцийн бүх хир буртгийг хаяж зайлуулъя гэсэн хүн байна гэж бодъё. Энэ хүн хүрз зээтүүгээр бүх хогийг арилгая гэвэл яаж ч хичээгээд, яаж ч хөдөлмөрлөөд бүтэхгүй. Үүний адил нэгэнт хэлсэн үгийг устгаж болохгүй. Бид ухаанаа дасгалжуулж, зүрх сэтгэлээ хайр энэрлээр дүүргэх юм бол бусдын хэлсэн муу үгэнд сэтгэл гоморхохгүй болно.

Тэнгэрт зураг зурах боломжгүй, түүнчлэн их мөрнийг бамбараар хатаах боломжгүй. Бас сайтар эгшээн элдсэн арьснаас дуу гаргах аргагүй. Эдгээр жишээний адил хүн бол ухаанаа үргэлж төгөлдөржүүлж чадвал ямар ч үг сонслоо гэсэн сэтгэлээ захирч чадна. Тэр ухаанаа ертөнц шиг уужим, тэнгэр шиг хязгааргүй, тэнгис шиг гүн, сайтар элдсэн арьс шиг зөөлрүүлэх ёстой. Хэрэв дайсан чинь таныг өдөж, тарчилган зовоовол өширч сэтгэлээр унавал Бурханы сургаалыг дагахгүй байна гэсэн үг.

Ямарч нөхцөл байдалд та “Миний ухаан хөдөлгөөнгүй тайван” гэж бодож сурах хэрэгтэй. Үзэн ядах хахир ширүүн

үг миний уруулыг давж гарах ёсгүй. Би бүхий л амьд амьтанд нигүүлсэнгүй сэтгэлээр хандаж, дайсандаа ч хайр энэрлээр хандах болно хэмээн бат бодох хэрэгтэй.

5. Эрт цагт нэг хүн шөнөдөө утаа баагиулаад, өдөртөө асч гэрэлтээд байдаг шоргоолжны үүр олжээ. Тэр яах ёстой вэ? гэдгийг асуухаар нэгэн мэргэн хүн дээр очсон. Тэрээр сэлэм авч очоод тэр хавийг сэндийлж ух гэжээ. Нөгөө хүн ёсоор болгосон. Тэр хүн эхлээд дэгээ оньс, хөөс, усны бөмбөлөг, сэрээ, хайрцаг, яст мэлхий, хутга, үмх мах, хамгийн сүүлд луу олсон. Мэргэн хүн үүний учрыг ингэж тайлбарласан:

“Луунаас бусдыг бүгдийг гарга. Ганцхан лууг хөдөлгөөнгүй үлдээ” гэжээ. Энэ ёгт үлгэрт шоргоолж гэдэг нь хүний бие, оройдоо утаа баагина гэдэг нь хүн өдөртөө юу хийсэн тухайгаа бодно гэсэн үг.

Хийсэн зүйлийнхээ тухай баярлана, эсвэл харамсана гэсэн үг. Өдөр асна гэдэг нь: орой бодсон зүйлээ үг хэл, үйлдлээр гүйцэтгэнэ гэсэн үг.

Энэ үлгэрт гардаг хүн гэдэг нь: Бурханы сургаалыг баримтлагч хүн юм. Мэргэн хүн гэдэг нь: Бурханыг хэлж байна, Жад гэдэг нь ариун ухаан, гүнзгий ухах гэдэг нь өөрийгөө боловсруулах, Гэгээрүүлэх гэсэн утгатай. Дэгээ гэдэг нь: мунхагийн харанхуйг, хөөс гэдэг нь уур зовлон, сэрээ гэдэг нь эргэлдэх түгшүүр, хайрцаг гэдэг нь шунал, үзэн ядах, залхуу, зовлон сандрах тэвдэх, харамсах гэсэн үг. Яст мэлхий гэдэг нь бие сэтгэл, хутга гэдэг нь таван хүсэл, үмх мах гэдэг нь цэнгэх, дур хүсэл гэсэн үг. Энэ бүхэн хүний биеийг хордуулдаг учир зайлсхийх хэрэгтэй.

Шоргоолжны нүхнээс хамгийн гүнд үлдсэн луу гэдэг нь ертөнцийн үймээн шуугианаас ангижирсан ухаан юм. Хэрэв хүн өөртөө байгаа муу юм бүхнийг мэргэн ухааны илдээр



зайлуулбаас “луунд” хүрэх юм. Лууг хөдөлгөхгүйгээр ганцааранг үлдээ гэдэг нь ертөнцийн шуугианаас ангижирсан сэтгэлийг тайван үлдээж эцэст нь хүргэ гэсэн утга.

Бурханы Шавь Пиндола Гэгээрлийг олсныхоо дараа төрсөн нутаг Куасамбид өөрт нь сайхан сэтгэл гаргасан хүмүүсийнхээ ачийг хариулахаар буцаж иржээ. Ингэхдээ тэр Бурханы сургаалын үрийг үржүүлэх хөрсийг боловсруулж бэлтгэхээр ирсэн. Хотын захад наргил мод шигүү ургасан газар, жижиг цэцэрлэгт агуу их Ганга мөрний зүгээс сэрүүн салхи тасралтгүй үлээж байлаа.

Зуны нэгэн халуун өдөр Пиндолаг модны сэрүүн сүүдэрт бясалгал хийж байхад Удояна хаан хатадтайгаа зугаацахаар морилон ирж зүүрмэглэжээ. Хааныг нойрсч байхад хатад нь зугаалж яваад бясалгал хийж буй Пиндолаг харав.

Пиндола хатадад гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн учир түүний Бурханы сургаалд ихэд биширч ном айлдахыг гуйцгаажээ. Хаан сэрэхдээ ганцаар байв. Хатадаа эрж яваад наргил модны сүүдэрт нэгэн даяанчийг тойрон суусныг олж харжээ. Зөвхөн цэнгэх дуранд автсан хааны сэтгэлд харын манан агшин зуур бууж, уур мунхагаа барьж чадахгүйгээр:

“Чи миний хатадын сэтгэлийг үймүүлэх ямар ичгүүргүй амьтан бэ?” гэж хашгирсан. Пиндола хариуд нь юу ч хэлсэнгүй, нүдээ аньж дуугүй суусаар байжээ. Галзууртлаа уурласан хаан илдээ хуйнаас нь суга татан Пиндолагийн нүүрэнд тулгахад ч тэрээр чулуу шиг хөдөлгөөнгүй суусаар байв. Эцэстээ тултал хилэгнэсэн хаан шоргоолжны үүрийг сэндийлэн улаан шоргоолжийг бясалгагчийн нүүр рүү цацсан. Гэсэн ч Пиндола урьдын адил огт хөдөлгөөнгүй суусаар байлаа. Гэтэл хаанд гэнэт ичгүүртэй санагдан, номт мэргэнээс өршөөл гуйжээ.

Тэр цагаас эхлэн Бурханы сургаал эхлээд хааны ордонд, цаашид орон даяар түгэн дэлгэрч эхэлсэн билээ.

7. Хэдэн өдрийн дараа Удояна хаан Пиндолагынд очиж асууруун:

- “Ариун багш минь яагаад Бурханы шавь хүүхэнд дурлах шуналд авталгүйгээр цэвэр ариунаараа үлдэж чадаж байна вэ?”

Пиндола хариулсан нь: – “Хаан минь. Бурхан бидэнд эмэгтэй хүнд яаж хандахыг сургасан. Настай эмэгтэй хүнийг эхээ гэж санах хэрэгтэй, үе тэнгийнхээ хүмүүсийг эгч, дүү нартайгаа адил санах хэрэгтэй. Залуу насны охидыг, охид хүүхдүүдтэйгээ адил санахыг сургасан юм. Энэ сургаалын ачаар Бурханы шавь нар нь залуу боловч сэтгэлээ хөдөлгөхгүйгээр бие сэтгэлээ ариунаар авч үлдэж чаддаг юм. Гэвч хүмүүс ахмад насны, өөрийн насны, охидтойгоо чацуу эмэгтэй хүнд дурлаж татагддаг. Харин Бурханы шавь нар яагаад өөрийн сэтгэлээ удирдаж чаддаг юм бэ? Хаан минь. Ялж төгс нөхцсөн Бурхан бээр биднийг цус, идээ, хөлс, өөх, бусад хорт зүйлс нь хүний биеийг бохирдуулагч болохыг харуулж зааж сургасан. Бид энэ бүхнийг мэддэг учраас сэтгэлээ цэврээр авч үлдэж чадаж байгаа юм.

Бид бол бие сэтгэл, ухаанаа дасгалжуулсан байдаг. Харин хялбар боловч ийм дасгал, сургууль хийгээгүй хүмүүст хэцүү байх болов уу? Тэд нар нь ариун бусыг санахыг аль болохоор оролдох авч нүд нь үзэсгэлэнтэй өнгөний хойноос дагадаг бус уу? Тэр муухай зүйлийг хармагц гутах авч сэтгэл нь үзэсгэлэнтэй өнгөнд татагдах бус уу?

Бурханы залуу шавь нар бие сэтгэлээ ариунаар авч явах өөр ямар нэг нууц байгаа юм бус. Хаантан минь ээ-! Бурхан биднийг мэдрэхүйн таван эрхтэний үүдийг сайтар хаахыг



сургасан.

Бид үзэсгэлэнт дүрс өнгийг нүдээрээ үзэж, зохист сайхан аялгууг чихээрээ сонсож, гойд сайхан үнэрийг үнэртэж, тансаг сайхан амтыг хэлээрээ мэдэрч, зөөлөн сайхан юмыг гараараа тэмтэрч байхдаа бид тэдгээр дур булаах зүйлд татагдахгүй огт хэрэгцээгүй зүйл мэт буцаан зайлуулах чадвартай байдаг.

Бид мэдрэхүйн таван эрхтэний үүдээ зайгүй хааж сурсан болно. Бурханы сургаалын ачаар ямар ч залуу шавь нар нь сэтгэлээ ариун цэврээр хадгалж чаддаг юм. Бурханы сургаал үнэнхүү гайхамшигтай байна. Би өөрийн мэдрэхүйн хүслийн үүдийг хаагаагүй бол аливаа үзэсгэлэнт хараа булаах зүйлтэй учрахад сэтгэл хөдөлж татагддаг гэдгийг өөрийн туршлагаар мэдэж байна, Бидний үйл үргэлж цэвэр байхын тулд мэдрэхүйн таван эрхтэний үүдээ хаах нь амин чухал юм байна гэв.

8. Хүн өөрийн хувийн санаагаа үйл хэрэг болгон гүйцэлдүүлвэл заавал хариу үйлдэл ирнэ. Хэрэв хүнийг зэмлэвэл тэр чамайг хариу зэмлэнэ. Хүн бол байгалиас заяагдсан энэ урвалын эсрэг зогсох ёстой юм. Хүн салхины өөдөөс шороо цацахад цэвэр болохгүй өөрөө тоосонд дарагдана. Хариу үйлдэл хийнэ гэдэг нь үргэлж гай зовлон, өшөө хорсол авчирдаг.

9. Шуналаас зугатан өгөөмөр сэтгэлтэй болно гэдэг бол маш сайшаалтай. Түүнээс гадна Бурханы сургаалыг хүндэтгэж Гэгээрэх замруу тэмүүлбэл сайн үйл тэр мөн. Хүн хувиа хичээх замаас зайлсхийж чадваас бусдад туслах сэтгэл үүсэх болно. Хүнд тусалж аз жаргалтай болгоход хүн бас бусдыг жаргалтай болгох санаа төрнө. Аз жаргал яг ийм маягаар үүсч төрдөг. Бамбарын галнаас

мянган хүн өөрсдийн галыг асаалаа ч гэсэн түүний гал буурахгүй.

Аз жаргалыг хичнээн хуваалцлаа ч гэсэн тэр бас дундрахгүй. Гэгээрлийн замаар явж байгаа хүн алхам бүрдээ туйлын болгоомжтой няхуур байх хэрэгтэй. Зорилго хичнээн хол боловч түүнд алхам алхамаар дөхөх хэрэгтэй. Гэгээрлийн замд өдөр тутам ахин ахисаар дөхөж очно гэдгийг бүү мартагтун.

10. Гэгээрлийн замаар явах замд хорин бэрхшээл бидний өмнө тохиолдоно.

- ① Ядуу хүн өглөгч сэтгэлтэй байх хэцүү
- ② Бардсан хүн Гэгээрлийн замд сурахад хэцүү
- ③ Энэ биеийг золиослож Гэгээрэлд хүрэх хэцүү
- ④ Бурхан энэ ертөнцөд байхад төрнө гэдэг хэцүү
- ⑤ Бурханы сургаалыг сонсох хэцүү
- ⑥ Биеийн муу авьяасаас сэтгэлийг цэвэрлэх хэцүү
- ⑦ Үзэсгэлэнтэй гоё тансагийг хүсэхгүй байх хэцүү
- ⑧ Хүчтэн өөрийн хүчийг хамгаалахын тулд хүч хэрэглэхгүй байх хэцүү
- ⑨ Доромжлогдчихоод уурлахгүй байх хэцүү
- ⑩ Юу ч тохиолдсон тайван байх хэцүү
- ⑪ Өргөн гүнзгий судалгаанд биеэ зориулах хэцүү
- ⑫ Юу ч мэдэхгүй, чадахгүй хүнийг хараад шоолохгүй байх хэцүү
- ⑬ Омгийг дарж хүлцэнгүй байх хэцүү
- ⑭ Сайн нөхрийг олох хэцүү
- ⑮ Бурханы сургаалыг мөрдөж Гэгээрэлд хүрэх хэцүү
- ⑯ Гадны нөхцөл байдлын нөлөөнд орохгүй байх



хэцүү

- ☉ Бусдын авъяас чадварт тохируулж сургаал номлол өгөх хэцүү
- ☉ Байнгын номхон сэтгэлтэй байх хэцүү
- ☉ Зөв, буруу гэж маргахгүй байх хэцүү
- ☉ Зөв аргад суралцах хэцүү

11. Сайн муу хүмүүс зангаараа ялгагдана. Муу хүн гэдэг нь нүглийг ойлгодоггүй, үйлдэхээ больдоггүй. Нүглийнхээ тухай сонсох ч дургүй.

Сайн хүн гэдэг нь нүгэл буяныг ойлгодог. Буруудвал түүнийгээ хэлж өгсөн хүнд талархаад түүнийгээ даруй зогсоож чаддагаараа муу хүнээс ялгаатай. Ач тус хүргэсэн хүний ач хүчийг үнэлж чадахгүй амьтныг мулгуу хүн гэнэ. Ухаант хүн бол ачийг хариулахад хэзээд бэлэн байдаг. Зөвхөн өөрт нь ач хүргэсэн хүн төдийгүй бусдад анхаарал халамжтай хандаж байгаа хүнийг буянт сайн хүн гэнэ.



3. ЭРТНИЙ ЁГТ ҮЛГЭР ДЭХ БҮРХАНЫ СУРГААЛ

1. Эрт цагт өтгөс настнаа хол аваачин цөлдөг нэгэн хачин заншил байжээ. Гэтэл нэгэн сайд өөрийн хөгшин эцгээ хаяж зүрхэлсэнгүй. Тэр газарт нүхэн гэр бариад эцгээ нууж тэжээж байжээ. Нэгэн удаа тэнгэрээс Бурхан бууж ирээд тэр улсын хаанд хэцүүхэн асуултууд тавьжээ. “Чиний өмнө хоёр могой байна. Аль нь эр, аль нь эм бэ?, Зөв ярьж чадахгүй аваас чиний улсыг газрын хөрснөөс арчина гэж мэдээрэй” гэв. Могойн эр, эмийг хэрхэн ялгахыг хаан ч, ордныхон ч мэдсэнгүй. Тэгээд энэ асуултыг таасанд хүнд өндөр шагнал олгоно гэж хаан орон даяар зарлиг буулгажээ. Сайд энэ тааврыг эцэстээ хэлэхэд:
 - “Энэ амархан таавар байна. Хоёр могойг зөөлөн хивсэн дээр тавь. Хивсэн дээр хүчтэй атиралдаж байгаа нь эр,



хөдөлгөөнгүй хэвтэж байгаа нь эм” гэжээ. Сайд могойн эр, эмийг хэрхэн мэдэхийг хаанд хэлжээ. Хариулт зөв байжээ. Бурхан дахиад хэд хэдэн хэцүү асуулт тавьжээ. Мөн л хаан болон ордныхон хариулж чадсангүй. Гэвч нөгөө сайд мэргэн эцгийн заавраар бүгдийг зөв хариулжээ. Асуулт, хариулт гэвэл:

- “Унтаа хэрнээ сэрүүн гэж хэнийг хэлэх вэ? Сэрүүн хэрнээ унтаа гэж хэнийг хэлэх вэ?”

Хариулт нь: “Гэгээрэлд хүрэхээр бясалгал хийж буй хүнийг хэлнэ. Гэгээрэлд хүрэх замыг мэдэхгүй хүнтэй харьцуулбал тэр сэрүүн. Гэгээрчихсэн хүнтэй харьцуулбал унтаа байна.”

- “Нүсэр том зааны жинг яаж хэмжих вэ?”
- “Зааныг завинд хийж завиа усанд хөвүүлнэ. Завины хөвж байгаа түвшинг тэмдэглэнэ. Дараа нь заанаа гаргаж тэр завиндаа дээрх зааны хэмжээ хүртэл чулуу дүүргэж, тэгээд чулуугаа хэмжиж зааны жинг олж болно.”
- “Аяга ус далайн уснаас их гэсэн юу гэсэн үг вэ?”
- “Аяга усыг ариун нигүүлсэнгүйн сэтгэлээр эцэг эх, өвчтэй хүмүүст өгч мөнхийн буяныг үйлдвээс энэ буян хэзээ ч дундрахгүй. Харин далай хичнээн устай боловч ширгэх өдөр байдаг”

Дараа нь Бурхан яс арьс болтлоо тураалд орсон нэгнийг авчирахад тэрээр

“Ертөнцөд надаас илүү өлсөж байгаа хүмүүс байгаа юу? гэсэн.

- “Байна. Эцэг эх багшдаа өргөл хүндлэл үзүүлэхгүй бол хүнээс илүү өлсөөд зогсохгүй хойд насандаа ланчигаа эдлэн бирд болон төрж туйлын урт хугацааны турш өлсөж цангахын зовлонг үзэн шаналж зовох болно”.

- “Тэг дөрвөлжин модон самбар байна. Аль тал нь үндэс рүүгээ ойр байсан бэ?”
- “Хэрэв энэ самарыг усанд тавибал нэг тал нь бусдаасаа арай илүү доошоо живнэ. Тэр нь үндэс рүүгээ ойр байжээ”.
- “Чиний өмнө ихэр юм шиг адилхан хоёр гүү байлаа. Аль нь эх нь вэ? Яаж ялгах вэ?”
- “Өвс тавьж өг. Эх нь эхэлж заавал унагандаа өвс идүүлнэ”.

Энэ хэцүү асуултуудын хариултууд нь зөв байсанд Бурхан сэтгэл хангалуун байв. Хаан бас ихэд баярлав.

Хаан: – “Энэ бүхэн нүхэн гэрт нуугдсан сайдын мэргэн эцгийн хариулт байсныг олж мэдээд настангуудыг дахин хөсөр хаяхгүй, хүндэлж байх” зарлиг буулгажээ.

2. Энэтхэгийн Видехагийн хааны хатан зургаан соёотой цагаан зааныг зүүдэлжээ.

Тэгээд тэр зааны соёог өөртөө бэлэглэхийг хаанаас хүсчээ. Энэ бүтэшгүй хүсэлт боловч хатандаа ухаангүй хайртай хаан энэ хүслээс татгалзаж чадсангүй. Тэр зургаан соёотой цагаан заан хаана байгааг мэдсэн хүнийг өгөөмөр ихээр шагнахаар амлаж, орон даяар зарлажээ. Ийм цагаан заан алс холын Хималайд амьдардаг байжээ. Тэр заан Бурхан болж Гэгээрэлд хүрэх бясалгал хийж байв. Тэр бас нэгэн удаа нэг аянчныг аварсан байжээ. Аврагдсан аянчин нутагтаа буцаж ирснээ хааны зарлигийг сонсож өндөр шан харамж авахыг хүсчээ. Ингээд зааныг алж соёог нь авахын тулд урьд түүний амийг аварч байсан зүйрлэшгүй ачийг ор тас мартсан санж. Уул уруу буцаад явжээ. Зааныг Бурхан болох гэж буйг мэдээд хуурахын тулд лам хуврагийн жанч өмсгөл нөмрөөд очжээ. Тэгээд зааныг ууланд огт ажиггүй



унтаж байхад нь олж хараад хорт сум тавьжээ.

Хүнд шархадсан заан үхэл ирж гэдгийг тэр дор нь мэджээ. Гэвч тэр заан ертөнцийн шуналын олз болсонгүй, уурласангүй, харин түүнийг хараад хилэгнэн хэдэн хэсэг тасдаад хаячих бусад заанаас хамгаалжээ. Тэгээд заан өөрөөс нь яагаад түүний амь насыг хөнөөх гэсэн учрыг асуугаад, түүний соёо хэрэгтэй байсныг мэдмэгц соёогоо модонд булга татаж сугалаад анчинд өгчээ. “Үүгээр би бүх сорилтуудыг давлаа. Одоо би Бурханы оронд төрнө. Би Бурхан болмогцоо юуны өмнө чиний сэтгэлээс шунал, уур, мунхагийн гурван хорыг таслах болтугай хэмээн тангараглав.

3. Эрт цагт Хималайд хулсан ширэнгэнд нэгэн тоть бусад шувууд, араатнуудтай хамт амьдарч байжээ. Нэгэн удаа хүчтэй салхи шуурчээ. Хулсны үрэлтээс болж түймэр гарчээ. Салхинд хөгжсөн гал ширэнгэнд хоромхоноо авалцаж их түймэр дүрэлзэв. Шувууд хүртэл түлэгдэн туйлын аймшигтай юм болжээ. Тоть шувуу удаан хугацааны турш амьдарч хоргодсон хулсан ширэнгээ хайрлаж, шувууд ан амьтдаа туйлын өрөвдөж холгүй орших цөөрөмд нисэн очиж, усанд шумбаж далавчаа норгоод нисэн ирж дүрэлзэн шатаж буй түймэр дээгүүр далавчныхаа усыг сэгсэрч байлаа.

Жигүүртэн шувууд ан амьтдаа энэрэн хайрлах, амьдрах орон болсон хулсан ширэнгэнийхээ ачийг санан тоть шувуу цуцахаа мэдэхгүй тэмцэж байлаа. Ийнхүү тотийн өрөвдөн нигүүлсэх сэтгэл, амь хайргүй тэмцэл нь Тэнгэр Бурхдын сайшаалыг төрүүлжээ.

Бурхан тэнгэрээс бууж ирээд тотьноос асуусан нь:

- “Би чиний чин хүслийг ойлгож байна. Чи ийнхүү дусал усаар энэ дүрэлзэж буй ойн түймрийг зогсоож чадна гэж үү?”
- “Би үүнийг энэрэн хайрлах ачийг санах сэтгэлээр хийж байна. Иймээс боломж үгүй юм гэж надад үгүй. Би үхсэн ч хамаагүй галтай тэмцэж унтраана” гэж тоть хэлжээ.

Энэ хариултыг сонсон таашаасан Бурхан тотинд туслан хур оруулж түймрийг хамт унтраажээ.

4. Эрт цагт Хималайд нэг биетэй хоёр толгойтой шувуу байлаа. Нэг удаа нэг толгой нь амтат жимс идэхийг хараад нөгөө толгойд атаархал буцалж хорт жимсийг идсэнээр шувуу үхжээ.

5. Могойн сүүл нь толгойтойгоо маргажээ.

Сүүл: “Чи үргэлж урд нь явна. Энэ бол шударга биш. Би эхэлж явъя” гэжээ.

Толгой: “Нэгэнт тэгж заяагдсанаас хойш би урд нь явах ёстой. Би чамайг түрүүлж явуулахгүй” гэжээ. Тэд удаан маргажээ. Хичнээн мэтгэлцлээ ч толгой урдаа л байлаа. Сүүл нь уурлаж толгойг урагш нь явуулахгүйн тулд модонд ороож зангидлаа. Толгой нь яаж ч болохгүй болмогц сүүл нь модноос тавигдаж түрүүлж мөлхөв. Тэр нүдгүй учир удалгүй галтай нүхэнд унаж шатжээ.

Ямар нэг юманд өөрийн эзлэх байр, түүнд оногдсон үүрэг гэж байдаг байна. Өөрт оногдсон хувьдаа ханахгүй болбол сөнөхөд хүрнэ.

6. Нэгэн түргэн ууртай хүн байжээ. Нэг удаа түүний



гэрийн өмнө хоёр хүн ярихдаа: “Энэ гэрийн эзэн маш сайн хүн. Түүнд ганц дутагдал буй. Тэр нь юу вэ? гэвэл маш түргэн ууртай” гэжээ. Нөгөө хүн үүнийг сонсоод уурлаж, гэрээс үсрэн гараад нөгөө ярьж байсан хоёр руу дайрч зоджээ. Ухаант хүн бол алдааг нь хэлбэл дутагдлаа засахыг хичээнэ. Харин тэнэг хүнд алдааг нь хэлбэл бүүр ч дордож улам их алдаа гаргана.

7. Баян хэрнээ тэнэг хүн байжээ. Нэгэн удаа тэр өндөр сайхан цамхагтай 3 давхар байшин харжээ. Тэрээр яг тийм байшин өөртөө бариулья гэж шийдээд, яг тийм байшин барихыг мужаанд тушаав. Мужаан ажлаа эхэлмэгц юуны урьд суурийг нь ухааж эхэлсэн. Тэгээд дараа дараагийн давхруудыг барихаар зэхэж эхэлсэн. Үүнийг харсан тэнэг баян тэсгэлгүй. Хэлсэн нь: “Надад суурь болоод нэг, хоёрдугаар давхар хэрэггүй Зөвхөн гуравдугаар давхартай өндөр цамхаг хэрэгтэй. Түүнийг л даруйхан босгож өг” гэжээ. Тэнэг хүн хөдөлмөрийг мэддэггүй. Тэр зөвхөн үр дүнг шаардаж байдаг, суурьгүйгээр гуравдугаар давхарыг яаж барих билээ. Түүнчлэн хөдөлмөргүйгээр сайн үр дүнд яаж хүрэх билээ.
8. Нэг тэнэг хүн бал чанаж байтал гэнэт нөхөр нь иржээ. Тэр нөхөртөө чанаж байсан балнаасаа өгөх гэсэн боловч маш халуун байлаа. Иймээс балаа хөргөх гээд гал дээрээс авахгүй сэвж байв. Түүнчлэн ертөнцийн тэнэглэлийн галыг унтраахгүйгээр Гэгээрэлд хүрэх боломжгүй.
9. Нэг удаа хоёр чөтгөр нэг хайрцаг, таяг, сэрээ, хос гутлыг булаацалдаж, хэн нь юуг авахаа өдөржин маргаад шийдэж чадсангүй.

Үүнийг харсан нэгэн бээр асууруун: “Та нар юунд маргав? Эдгээрийн ид шид гэж юу вэ? Яагаад хоорондоо хуваагаад авч чадахгүй байна вэ? гэв. Тэд хариулсан нь: Энэ хайрцагнаас хоол унд, эрдэнэс, хүссэн бүхнээ гаргаж авч болох юмаа. Энэ гутлыг өмсвөл тэнгэрт чөлөөтэй нисч болно. Энэ сэрээгээр ямар ч дайсныг дарж чадна”.

Нөгөө хүн хэлсэн нь: “Та хоёр надаас жаахан холдож бай. Би та хоёрт яг тэнцүүхэн хувааж өгье. Тэгвэл маргах юм огт байхгүй болно” гэжээ. Нөгөө хүн чөтгөрүүдийг холдуулаад сэрээ хайрцагийг авч, гутлыг өмсөөд агаарт нисч одов. Энд чөтгөр гэдэг нь тэрс үзэлтэн, хайрцаг гэдэг нь өглөг. Өглөг үйлдсэнээр олон буян төрдөг гэдгийг мэдэхгүй байна. Сэрээ гэдэг нь сэтгэл төвлөрөхийг хэлж байна. Сэтгэлийг төвлөрүүлснээр ертөнцийн шуналыг дарж чадна гэдгийг мэдэхгүй байна. Гутал гэдэг нь ариун сургаал. Ариун сургаалын ачаар ямар ч маргааныг шийдэж чадна гэдгийг мэдэхгүй байна.

Иймээс тэд марган гутал, сэрээ, хайрцагийг хувааж авч чадахгүй байлаа.

10. Нэгэн аялагч нэг удаа хоосон байшинд буудаллав. Шөнө дунд чөтгөр ирэв. Тэр чөтгөр нэг хүний хүүр авч ирээд шалан дээр чулуудсан. Дахиад нэг чөтгөр ирээд: “Энэ миний авчирсан хүүр” гэж хэлснээс хоёр чөтгөр маргаж эхэлсэн. Тэгээд эхнийх нь чөтгөр нөгөөдөхдөө хэлсэн нь: “За чи бид хоёр юу ч шийдэхгүй юм байна. Нэг гэрч олж авъя.

Тэр хэнийх нь хүүр болохыг хэлж өгөг” гэжээ. Хоёр дахь чөтгөр нь зөвшөөрч. Нэг дэх чөтгөр энэ байдлыг нэгд нэгэнгүй айн дагжин харж зогссон аянчийг чирж гаргаж ирээд “Хэн нь анх энэ хүүрийг авч ирсэн бэ? хэлж өг! гэсэн. Айн дагжсан тэр яах ч аргагүй болсон. Хэрэв тэр нэгнийх нь



талд орж нөгөөг нь гомдоовол зайлшгүй алагдана. Тэгээд яалаа ч гэсэн түүний үхэл ирсэн нь гарцаагүй гэдгийг ойлгоод харсан бүхнийг үнэнээр нь хэлэхээр шийдсэн. Яг бодож байснаар нь нөгөө чөтгөр нь уурлаж, түүний гарыг тасдан авсан. Тэгэхэд нөгөө чөтгөр нь хүүрийн гарыг тасдан авч нөгөө хүний гарын оронд тавьсан. Уурласан чөтгөр гэрч хүний хоёр хөлийг тасдаж авсан. Түүнчлэн их бие, толгойг нь хүртэл тасдсан.

Нөгөө чөтгөр нь бүгдийг хүүрийн эрхтэнээр нь орлуулжээ.

Чөтгөрүүд сүүлдээ ядраад өрөөгөөр нэг тарсан гар, хөл бусад эрхтэнүүдийг идчихээд явцгаасан. Аялагч хүн эзгүй гэрт ганцаар үлдсэн. Эцэг эхээс заяасан хөл, гар, толгой, их биеийг чөтгөрүүдэд идүүлж, оронд нь огт танихгүй хүний хүүрнээс бүгдийг нөхүүлж авсан, өөрөө өөрийгөө мөн үү? гэдгийг ойлгохоо больсон. Үүрээр тэр аймшигт шөнийг үдсэн байшинг хагас ухаантай орхиж одов.

Тэгээд замд нь Бурханы сүм тааралдсанд баярлаж ороод шөнө тохиолдсон бүгдийг яриад, явал дээр вэ? гэдгийг асуулаа.

Аянчны энэ яриаг сонсоод хүмүүс “Би байхгүй” гэдэг үнэнийг мэдэж бүгд сэтгэл амар болцгоожээ.

11. Нэг удаа сайхан хувцасласан үзэсгэлэнтэй бүсгүй ирэв гэнэ. Гэрийн эзэн “Чи хэн бэ?” гэж асуув. Эмэгтэй “Би аз жаргалын Бурхан, хүмүүст аз жаргал авчирч байна” гэв. Эзэн баярлаж түүнийг зочлон дайлж, хүлээн авав. Хэсэг хугацааны дараа бас нэг хүүхэн ирэв. Тэрээр муу хувцастай, муухай царайтай байлаа.

Эзэн түүнээс хэн болохыг асуухад, тэр: “Ядуурлын Бурхан” гэв. Эзэн түүнийг гэрээсээ хөөхөөр завдахад тэр:

“Аз жаргалын Бурхан миний төрсөн эгч. Бид эв найртай үргэлж хамт амьдардаг. Намайг хөөвөл миний эгч ч гэсэн бас хамт явна” гэхэд тоосонгүй хөөжээ. Ядуугийн Бурхан явахад аз жаргалын Бурхан ч бас явлаа. Амьдрал үхэлтэй хамт байдаг. Аз жаргал байдаг бол зовлон байдаг. Сайны зэрэгцээ муу байдаг. Хүмүүс үүнийг мэдэх хэрэгтэй байдаг юм.

Ухаангүй хүн зовлонгоос зугтаж аз жаргалыг эрдэг. Гэгээрлийн замаар явж байгаа хүн бол энэ 2 ойлголтоос огт өөр. Алинд ч дурлаж татагдахгүй байх ёстой.

12. Эрт цагт нэг ядуу зураач гэр орон, эхнэр хүүхдээ орхиод аз жаргалын эрэлд гарчээ. Гурван жил тэр хөлсөө шавхан ажиллаж 300 алтан зоос олжээ. Буцах замдаа тэр нэгэн өргөл барьцын зан үйл үйлдэж буй сүмд оржээ. Тэр ихэд баярлаж хэзээ ч буяны үрийг тарьж байсангүй. Ийм боломжийг яаж алдах билээ гэж сэтгээд сүмд бүх мөнгөө юу ч үлдээлгүй өргөл барьжээ. Гэртээ хов хоосон эргэн ирсэн нөхрөөсөө олсон мөнгөө хэрхэн үрснийг эхнэр нь асуужээ. Тэр баялгийг найдвартай гарт хадгалууллаа гэж хэлжээ. Эхнэр нь найдвартай агуулах гэж юуг хэлж байна вэ? гэвэл “буянт лам нарын гарт өглөө” гэжээ.

Уурсан эхнэр нь шүүхэд заргалдаж, нөхрөө барьж өгч, түүнийг байцааж эхэлжээ.

Тэр: “Хөлсөө шавхаж олсон мөнгөө би дэмий үрсэнгүй. Одоо болтол би буяны үрийг тарьсангүй явлаа. Аз жаргалын үндэс болох буяны үр тарих өглөг өгч буйг хараад би огт харамсахгүйгээр өөрт байсан бүхнийг өгсөн болно. Иймээс би жинхэнэ баялаг бол үнэт зүйлс бус сэтгэл гэж ойлгосон” гэв. Шүүгчид түүний үгийг сонсоод баясч, түүнийг хөхүүлэн сайшаав. Тэр цагаас эхлэн зураач бүхний итгэлийг хүлээн, ихэд баяжин, эхнэртэйгээ аз жаргалтай амьдрах болжээ.



13. Оршуулгын газраас холгүй нэг хүн амьдарч байжээ. Нэг шөнө шарил дотроос түүнийг дуудахыг сонсоод үхтэлээ айжээ. Өглөө энэ тухай нөхөддөө хэлжээ. Тэдний нэг зоригтой нь маргааш шөнө нь шарилаас дахин тийм дуу сонсогдвол очиж ямар учиртай болохыг нь мэдэхээр шийдэв. Дараа шөнө нь түрүүчийн адил оршуулгын газраас хүний дуудах дуу сонсогдов. Нөгөөх нь энэ дууг сонсоод дагжин чичирч байлаа. Зоригт нөхөр нь дуу гарч байгаа газар очоод хэн болохыг нь асуусан.

Газар дороос: “Би газар доор нуугдсан эрдэнэ байна. Би нэрийг нь дуудсан хүнд очмоор байна. Гэвч тэр надаас айгаад ирэхгүй байна. Чи маш зоригтой боломжийн хүн юм.

Маргааш би гэр бүл, зарц нарын хамт гэрт чинь очъё” гэв.

Зоригт хүн хэлсэн нь: “Их сайн байна. Би таныг хүлээж байя. Харин яаж угтах вэ” гэжээ. Тэр хүн хариулсан нь: “Бид танайд лам нарын дүрээр очно. Юуны урьд угаалга үйлдэх өрөө гаргаж ус, шингэн будаатай найман аяга бэлдээд биднийг хүлээж бай. Хоол идсэний дараа биднийг нэг нэгээр нь өөр өөр өрөөнд оруулахад бид алттай хувин болж хувирна” гэжээ.

Маргааш өглөө нь тэр хэлсэн ёсоор нь бүгдийг бэлдээд хүлээж байлаа. Удалгүй найман лам өргөл барихаар ирэв. Тэднийг гэртээ урьж, цагаан будаа, ус зэргийг барьж, дараа нь тусгай бэлтгэсэн өрөөнүүдэд оруулбал найман лам алтаар дүүрсэн сав болж хувирав. Энэ тухай нэг атаач хүн сонсчээ. Тэр бас алттай болохыг хүсч найман гэлэнг гэртээ урьжээ. Тэднийг хооллосныхоо дараа булангийнхаа өрөөнд оруулаад цоожлов.

Найман гэлэн алт болсонгүй, шүүхэд хандвал атаач хүн баригдаж ялаа эдлэв. Оршуулгын газрын ойролцоо амьдрах

хулчгар хүн нэрээ эрдэнэсийн газраас дуудахыг анх сонссон учраа хэлж, ер нь тэдгээр алт минийх байх ёстойг сануулж алтыг авахаар зоригт хүнийхээ гэрт очив. Гэтэл тэнд алт байсангүй, алтны оронд олон могой болон хувирч угтжээ. Энэ тухай хаан мэдэж: “Алт бол зоригт хүнд оногдоно” гэж зарлиг буулгажээ.

Түүнчлэн энэ ертөнц дээрх бүх юм үүнтэй адил байна. Тэнэг хүн бол зөвхөн үр дүнг хүсч байдаг. Гэвч дан ганц үр дүн гэж байдаггүй, Сургаал номыг цээжээр дагавч жинхэнэ итгэл байхгүй хүнтэй адил. Иймээс сэтгэлийн жинхэнэ амгаланг олж чадахгүй.



ЖИНХЭНЭ МЭДЛЭГИЙН ЗАМ ХОЁРДУГААР БҮЛЭГ



1. ҮНЭНИЙ ЭРЭЛД

Ертөнц яаж үүсэн юм бэ? Ертөнц мөнх үү? Эсвэл хэзээ нэгэн цагт сөнөх үү? Ертөнц төгсгөлгүй юу? эсвэл нэг газар эцэс төгсгөл гэж байна уу?

Хүний нийгэм яаж үүссэн бэ? Нийгмийн ямар хэлбэр нь өөгүй сайн бэ?

Энэ бүх асуултанд хариулахаасаа өмнө Гэгээрэх замын тухай эхлэхгүй бол Гэгээрэлд хүрэхээсээ өмнө бүгд мөхөж болно. Хорт сумаар шархадсан хүний төрөл төрөгсөд, ойр дотнынхон нь цуглаад түүнд туслахаар эмч дуудуулж сумыг нь авахуулахаар завдаж байтал цаад хүн гэнэт:

“Байзнаарай! Сумыг битгий ав! Би хэн харвасныг мэдмээр байна. Эр хүн үү? эм хүн үү? Ер нь ямар хүн бэ? Язгууртан сайн удамт хүн юм уу? Тариачин хүн юм уу? Ямар нум хэрэглэж вэ? Том уу?, жижиг юм уу? Мод юм уу? хулс юм уу? Нумны хөвч нь юугаар хийгдсэн байж вэ?

Шөрмөсөөр үү? Ороонгоор уу? өлөн гэдсээр үү? Сум нь бас юугаар хийгдэж вэ? Богино уу? урт уу? Хулс юм уу?, мод юм уу? Ямар өд хэрэглэж вэ? Сумыг авахаас өмнө би энэ бүх зүйлийг мэдмээр байна” гэвэл юу болох вэ? Мэдээж дээрх асуултуудад хариулт авахаас өмнө хор бүх биеэр нь тарж, тэр хүн нас барна.

Энд юуны өмнө хор биеэр тарахаас урьтаж сумыг авч эмчлэхээс өөр аргагүй.

Ертөнц юугаар бүтсэн?, нийгмийн ямар хэлбэр өөгүй сайн бэ? гэж ярихаас өмнө бидэнд нүүрлэн байгаа аюул хөнөөлийг зайлуулах нь чухал.

Манай ертөнц мөнх үү?, мөнх бус уу? гэдгээс үл хамааран өвдөх зовох, үхэх төрөхийн зовлон мөнхөд шаналгаж байна. Ертөнцийн эдгээр зовлонгуудаас анги-жирахын тулд бид Гэгээрэх замыг баримтлах хэрэгтэй.

Үхэх төрөх, өтлөх өвдөхийн зовлонг гэтлэх арга олтол ертөнц мөнх эсэх, хязгаартай юу? үгүй юу? гэсэн асуултдаа хариу олохыгөө түр хүлээнэх нь зөв байх.

Бурханы сургаалд юуг мэдэх нь чухал, юу чухал бус, хүмүүс юу сурах ёстой, юунаас зайлах ёстойг, Гэгээрэх замд яаж орохыг зааж өгсөн.

Иймд хүмүүс хамгийн чухал зүйлээ юуны түрүүнд шийдэх ёстой, ямар асуудал байна вэ? гэдгийг тодорхой олж харах хэрэгтэй. Үүний тулд юуны түрүүнд өөрийн сэтгэлийг хянаж сурах хэрэгтэй.

Гуалин авахаар ойд очсон хүн навч мөчир цуглуул-чихаад гуалин авлаа гэж бодвол тэнэг хэрэг. Заримдаа гуалинд яваад модны холтос хамж ирээд сэтгэл цатгалдаж гуалин авч ирлээ гэж бодох нь ч бий шүү дээ.

Өвдөх, өтлөх, үхэх, төрөх уй гашуун зовлонгоос салахын тулд хүн Гэгээрэх замыг эрдэг. Энэ бол гуалин гаргахтай адил.



Гэтэл багахан шиг алдар хүндийг хүртээд, үүндээ сэтгэл нь ханан, биеэ тоон бусдыг дорд үзэн ихэрхэх хүмүүс байдаг. Ийм хүмүүс бол дээрхтэй адил зөвхөн мөчир навчийг нь аваад модны их биеийг нь авлаа хэмээн бодохтой адил. Зарим хүмүүс багахан шиг хүч гаргаад жаахан амжилтанд хүрснийгээ санасандаа хүрсэн мэт боддог. Тэд бас үүндээ сэтгэл нь ханаж биеэ тоож бусдыг доромжилдог. Тийм хүмүүс модны гадна холтсыг нь аваад модны их биеийг авлаа гэж санасантай адил юм.

Сэтгэл санааны багахан тайвшралыг олоод сэтгэл нь ханадаг хүмүүс байдаг. Тэдгээр хүмүүс их зан гарган биеэ тоон, бусдыг дорд үзэж байдаг. Тийм хүмүүс модны хальсыг нь аваад модны голыг авлаа хэмээн санаж байгаа хэрэг. Ажил хэргийн язгуурыг олж харж эхэлмэгц хүрсэн амжилтандаа сагсууран биеэ тоож ихэрхэн бусдыг дорд үзэх хүмүүс ч байдаг. Тийм хүмүүс модны үртсийг нь авчихаад модны ишийг авлаа гэж боддог. Ийм хүмүүс өөрийн хүч чармайлтыг зогсоож залхуурдаг. Ингэснээр дээрх хүмүүс дахин зовлонд учирна.

Гэгээрэлд хүрэхэд алдар хүнд, өргөл барьц, зорилго бус, ялимгүй зовлон, зарим нэг сэтгэл санааны тайвшрал, бага мэдлэг чадвар ч зорилго бус, юуны өмнө энэ ертөнц дэх амьдрал, үхлийн үнэн чанарыг таних ёстой.

3. Ертөнц өөрийн гэх мөн чанар байхгүй. Сэтгэлийн муу муухай юмыг зайлуулах замыг эрэх хэрэгтэй.

Төөрөгдөл эндүүрэл өөрийн сэтгэлд оршдог болохоос биш гадна нөхцөл байдалд оршдоггүй. Эндүүрэл гэдэг нь ухаанаас өөрөөс нь гарч ирдэг.

Сэтгэлийн хүсэл шуналын галыг бадрааж тэр гал түймэрт нь хүн өөрөө тарчлан шаналдаг. Мунхагийн харанхуй оюун ухааныг нь тагласнаас болж хүн энэлэн шаналж гутан

гунихардаг. Мунхаг хүн л өөрөө өөртөө эндүүрлийн гянданг барьж өгдөг.

Гэгээрлийн замыг эрж байгаа хүн бол зорилгодоо хүрэхийн тулд энэ мунхаг сэтгэлтэй тэмцэхэд бэлэн байх ёстой.

4. Сэтгэл зүрх минь чи юунд амьдрал хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдал бүхэнд дэнслэнэ билээ? Чухам юунд чи намайг нэг мөч ч амраахгүй зовооноом билээ? Юунд чи намайг ийм их зүйлийг цуглуулахаар шавдуулнам билээ?

Газарт хүрэхийн өмнө хугарч, газар хагалж болохгүй болсон хэрэгцээгүй зээтүү шиг, би тоо томшгүй олон төрлийг элээсэн авч эндүүрлийн далайгаар мөнхөд будилан тэнэж өөрийн сэтгэлийн газрыг хагалж боловсруулж эс чадлаа.

Сэтгэл минь чи надад хааны бардам амьдрал хайрлалаа, бас гуйлгачин шиг амьдралд хальтрууллаа, гутамшигтайгаар хэрэн тэнүүчлүүлээ. Бас Бурхадын амьдралын ертөнцөд цэнгүүллээ. Галд шатаан тамд унагаан үйлийг минь үзлээ. Гэнэн тэнэг сэтгэл минь намайг янз янзын замд аваачлаа.

Одоо болтол би чамайг дуулгавартай дагалаа. Сэтгэл минь таны дураар би явлаа.

Харин одоо бол би Бурханы сургаалыг олж мэддээ. Дахин намайг бүү зовоо. Надад бүү саад бол. Зовлонгоос ангижирч, удахгүй Гэгээрлийг олох боломж олго. Сэтгэл минь хэрэв чи үнэнийг ухаарч ойлговол энэ ертөнц дээр өөрийн гэх мөн чанар байхгүй. Энэ ертөнц дээрх бүх юм өөрчлөгдөн хувьсаж өнгөрч л байдаг. Хэрэв чи юманд татагдаж дурлахаас ангижирч чадвал аливаа юмыг өөрийн гэж үзэхгүй болно. Уур, мунхаг шуналаас чөлөөлөгдөн энх



амгаланг олох болно.

Сэтгэл минь чи намайг Гэгээрлийн замд зүтгүүллээ. Харин одоо чи намайг яагаад алдар нэр, ертөнцийн сонирхолд хөтөлж зовоож эхлэв. Хэлбэр дүрс үгүй, алс холд хулжин гүйсэн сэтгэл минь туулахад хэцүү эндүүрлийн далайг гатлах боломж өгөөч. Одоо хүртэл би чиний хүсэл бүхэнд захирагдаж явлаа. Харин одооноос чи миний хүссэнд захирагдаж хамтдаа Бурханы сургаалыг дагая.

Зүрх, сэтгэл минь уул гол, тэнгис хүртэл бүгд өөрчлөгдөж байна. Энэ амьдрал бүгд гай зовлонгоор дүүрэн. Эндүүрлийн энэ ертөнцөд хаана энх амгалан байна? Бурханы сургаалиар Гэгээрлийн нөгөө ирмэг рүү даруйхан зүтгэе.

5. Хэрэв хүн Гэгээрэлд хүрэхийг үнэнхүү хүсч байвал ийм замаар өөрийнхөө сэтгэлтэй тэмцэж, мятаршгүй зоригоор урагшлах хэрэгтэй. Бусдад яаж ч доромжлогдсон сэтгэл нь огт хөдлөхгүй, алгадуулж, чулуудуулж, илдээр цавчуулсан ч уурлахгүй, толгойг нь таслаад авсан ч сэтгэл нь хөдлөхгүйгээр Бурханы сургаалыг дагая.

Хэрэв дээрх зүйлд ухаан нь самгардаж будилах аваас Бурханы сургаалыг баримталж чадахгүй гэсэн үг. Гэгээрлийг олохын тулд юу ч тохиолдсон тогтвортой, хөдөлгөөнгүй, нигүүлсэнгүй, буяны гэрлийг цацруулж байх ёстой.

Ямар ч гай зовлон, доромжлол ирсэн сэтгэл нь огт хөдлөхгүй. Гэгээрэлд хүрэхийн тулд боломжгүйг гүйцэлдүүлэхийн төлөө, тэвчишгүйг тэвчихийн тулд хичээх хэрэгтэй. Юу байгаагаа бусдад өгөх хэрэгтэй.

Гэгээрэлд хүрэхийн тулд хоолоо хязгаарлан, өдөрт нэг ширхэг будаа идэх хэрэгтэй бол түүнийг мөрдөх ёстой. Галд шатах учир бол гал руу орох хэрэгтэй. Ойр дотны хүндээ

өглөг өгөөд өглөг өглөө гэж бүү бод. Зөв ухаалаг үйлийг хийх ёстой. Эх нь хүүхэддээ сүүлчийн үлдсэн юмаа өгөхдөө юм өглөө гэж боддоггүй, өвчтэй хүүхдээ асарч сувилахдаа асарч сувиллаа гэж шан харамж нэхдэггүй шүү дээ.

6. Эрт цагт нэг хаан байжээ. Тэрээр ухаалаг сайхан сэтгэлтэй, түмэн олондоо хайрлагдсан нэгэн байв. Гүрэн улс нь энх амгалан цэцэглэн хөгжиж байлаа. Тэрбээр Бурханы сургаалыг биширдэг бөгөөд Гэгээрэх замыг эрж байлаа.

Бурханы гайхамшигт сургаалд өөрийг нь сургасан хэнийг ч болов баялаг эрдэнээр шагнахаар орон даяар зар түгээжээ. Үнэнийг олох хааны энэ хүсэл Бурханы оронд ч бахдал сайшаал төрүүлж байв. Нэгэн удаа Бурхан, Хааны хүсэл үнэн ариун уу, үгүй юу гэдгийг шалгахаар чөтгөр болон хувирч хааны ордны хаалгыг тогшиж гэнэ.

– “Би ариун сургаалыг мэднэ. Энэ тухай хаанд дамжуулна уу?” гэж хэлэв. Энэ тухай сонсоод хаан баярлан, ордондоо урьж оруулан сургаалаа номлохыг хүсэв гэнэ.

Тэгэхлээр нь нөгөө чөтгөр нүцэглээд, сэлэм шиг соёогоо гаргаж “Би маш их өлсөж байна. Хоосон ходоодтой сургаал хэлж чадахгүй” гэв. Чөтгөрийг зочлон дайлсан боловч тэр “Би зөвхөн амьд хүний мах идэж, цус уудаг” гэхэд хааны агь, хатан хоёр биеэ идүүлэхийг зөвшөөрчээ. Чөтгөр хоёуланг нь идсэн ч цадахгүй, хааныг биеэ идүүлэхийг шаардав. Хаан хариуд нь:

– “Миний амьдрал надад харамсалтай биш. Хэрвээ чи намайг идчихвэл би яаж чиний сургаалыг сонсох билээ. Чи сургаалиа хэлж дуусаад намайг идэгтүн. Хоёул ингэж тохиръё” гэжээ,



Тэгэхэд чөтгөр ийн сургажээ. “Шуналаас сэтгэл хямрах ба айдас төрнө. Шуналаас ангижирч чадваас сэтгэл зовон айх юм үгүй болно” хэмээн номлож дуусангуут Бурхан биеэр болон хувирч, хатан агь хоёр ч амилжээ.

7. Эрт цагт нэгэн даяанч хүн Хималайд үнэний замыг эрж явлаа. Тэр зөвхөн эндүүрэл төөрөгдлөөс гэтлэх сургаалыг эрж явлаа. Түүнд өөр юу ч хэрэггүй байлаа. Энэ ертөнцийн бүх эрдэнэс, тэнгэрийн орны цэцэрлэг, ер нь юу ч хэрэггүй байлаа. Тэр хүний гайхамшигт чин хүсэлд Бурхан хүртэл баясч, түүний сэтгэлийг шалгахаар болов.

Нэгэн Бурхан чөтгөрийн дүрд хувилаад Хималайд явж очив. “Энэ ертөнц дээрх бүх юм өөрчлөгдөнө. Гарч ирнэ, алга болно” гэж дуулсан. Нөгөө хүн энэ дууг сонсоод их баярлаж цангаж үхэх шахсан хүн хүйтэн булаг олсон мэт, олзлогдсон боол гэнэт эрх чөлөөтэй болсон мэт баясалтай жаргалтай болов.

Энэ жинхэнэ үнэн, ёстой сургаал, чиний эрж явсан “үнэн” мөн гэж бодоод дуу гарсан зүг эрж хайж байтал нэгэн аймшигт чөтгөр гарч ирсэнд сэтгэл жаахан тавгүйрсэн боловч тэр дөхөж очоод: “Саяын дууг та дуулав уу? Хэрэв тийм бөгөөс гүйцээж дуулна уу?” гэж хүсэв. Чөтгөр хэлсэн нь: “Би тэр дууг дуулсан, одоо их өлсөж буй учир үргэлжлүүлж чадахгүй” гэв. Бадарчин дахин хэлсэн нь: “Энэ дуугаа үргэлжлүүлэхийг гуйя. Миний эрж буй ариун үнэн энэ дуунд агуулагдаж байна. Дуугаа гүйцээж дуулж өгнө үү?” гэж гуйв. Чөтгөр хариулсан нь: “Би туйлдаа хүртэл өлсөж байна. Би амьд хүний махыг идэж цусыг уувал үргэлжлүүлж дуулж чадна” гэв. Тэгэхэд “Хэрэв та дуугаа дуустал дуулж өгвөл намайг идэж болно” гэж бадарчин хэлжээ.

Чөтгөр дуулсан нь: “Энэ ертөнц дээрх бүх юм өөрчлөгдөнө. Гарч ирнэ, алга болно. Үхэх төрөхийн зовлонгоос ангижирч чадна. Төгс амгаланд хүрч чадна”.

Үүнийг сонсоод тэр хүн сургаалыг ойр орчны мод чулуун дээр бичээд, модонд тайвнаар авирч, чөтгөрийн ам руу үсэртэл чөтгөрч алга болж, гэрэл цацраасан Бурхан түүнийг тосон авчээ.

8. Эрт цагт Садалрарүдита хэмээгч Гэгээрэх замыг үнэнчээр эрэлхийлэгч нэгэн байв. Алдар нэр ашиг хонжоог бүгдийг хойш тавьж, гагцхүү үнэнийг амиараа дэнчин тавин эрж байлаа. Нэгэн удаа тэнгэрээс “Садалрарүдита! Зүүн зүг явагтун! Хаашаа ч хазайлгүй шулуухан явагтун! Алдар нэр, ичгүүр сонжуур, халуун хүйтнийг мартан буян нүглийг бодож зүүн зүгийг чиглэн яв! Тэгвэл чи жинхэнэ багшийг олж Гэгээрэлд хүрэх болно” гэжээ. Садалрарүдита ийм тодорхой зааврыг аваад туйлын ихээр баярлаж зүүн зүг Гэгээрлийн замын эрэлд шалавхан гарлаа. Эзгүй тал зэрлэг уулаар өнжин хонон явсаар, танихгүй газар хөөгдөн туугдан, доромжлогдож, ер түмэн бэрхшээл амсчээ. Эцэст нь тэр үнэнч багшийг олж өөрийгөө шавь оруулахыг гуйжээ, Сайн үйлийг хийхэд бэрхшээл их гэгчээр Садалрарүдита үнэнийг эрэх замдаа маш их бэрхшээлийг даван туулж багшдаа өргөх цэцэг ч худалдаж авч чадсангүй.

Хөлсний ажил хийе гэж хичээвч хэн ч түүнийг авсангүй. Хаа орсон газраа хөөгдөж байв. Гэгээрэлд хүрэх зам үнэндээ хүнд байлаа. Багшаас ариун сургаалыг хүртэж байхдаа бэх цаасгүй учир гараа хутгаар зүсэж цусаараа багшийн заасан үнэний сургаалыг бичдэг байв. Тэгж явж ариун үнэнд хүрсэн гэдэг.



9. Эрт цагт Судана гэдэг хүү байжээ. Тэр Гэгээрэлд хүрэхийг хүсч үнэнийг эрж байжээ. Далайд загасчилж буй загасчин дээр очиж далай тэнгисийн тухай мэдлэгийг олж, өвчтэй хүнийг анагааж буй эмчээс хүнийг энэрэн хайрлах сэтгэл чухал юм гэдгийг мэдэж авчээ.

Баян хүнээс ганц зоос хэмнэснээр баяжихын их булаг болдгийг мэдэж авчээ. Бясалгал хийж байгаа хуврага хүнээс түүний тогтсон сэтгэл нь нүүрэн дээрээ илэрч буйг, бусдын сэтгэлийг ариусгаж, бусдад хичнээн гайхамшиг нөлөө үзүүлдэг болохыг мэджээ.

Ариун сэтгэлт эмэгтэйтэй уулзаж, бусдын тусын тулд хэзээд бэлэн сэтгэлийг таньж гайхав. Гэгээрэлд хүрэхийн тулд биеийг үл хайхран хатуужил үйлдэж буй даяанчтай уулзаж жинхэнэ Гэгээрэлд хүрэхийн тулд жад шиг хурц ууланд авирч, гал дундуурч туулах зайлшгүйг ойлгов.

Тэгээд тэр чин сэтгэлийг эрхэмлэвэл чихээр сонссон, нүдээр үзсэн бүхэн эрдэм болдгийг мэдэв.

Ядуу бүсгүй хүнд ч гэсэн Гэгээрэлд хүрэх сэтгэл байдаг. Гудамжинд тоглож буй хүүхдэд ч гэсэн өөрийн ертөнц байдаг гэдгийг ойлгосон. Эелдэг найрсаг, дөлгөөн зантай хүнээс бүх ертөнцийн хүмүүс эвтэй найртай амьдрах нууцыг олж мэдэв.

Хүжийн найрлага цэцэг чимгийн урлагт ч гэсэн Бурханы сургаал, Гэгээрлийн зам буйг олж мэдэв. Нэгэн удаа тэр ойд амарч байгаад модноос шинэ мөчир ургаж гарахыг харж ертөнц оршихын мөнх бусыг олж мэдэв, Нарны гэрэл, шөнийн одод Гэгээрлийг эрж буй Суданы сэтгэлийг ариутгаж байв. Хүү хаа сайгүй Гэгээрэлд хүрэх замыг хайж байлаа. Газар бүр сайн сургаалыг хүртэж, газар бүр Гэгээрлийн хэлбэрийг үзэж байлаа. Үнэндээ Гэгээрэлд хүрэхийн тулд сэтгэлийн бат бөхийг хамгаалж, түүнийг

улам чимэн баяжуулж байх хэрэгтэй юм гэдгийг ойлголоо.

Сэтгэлийн хэрмийн хаалгыг онгойлгож, дотор нь Бурханыг нандин шүтээн болгож залаад баяр бахдалын цэцгэн хэлхээ, итгэлийн хүжийг өргөх хэрэгтэй.





2. ГЭГЭЭРЭЛД ХҮРЭХ АРГА ЗАМУУД

1. Гэгээрлийг эрж буй хүмүүст ойлгож мөрдөх гурван зам байна.
 - ① Үйл явдлаа засах сургаал номлол
 - ② Ухааны зөв төвлөрөлт
 - ③ Мэргэн ухаан

Сургаал гэж юу вэ? Энгийн хүн ч, Гэгээрэх замыг хайж байгаа хүн ч зөв явдлын журмыг мөрдөх хэрэгтэй. Бие сэтгэлээ хянан удирдах учиртай. Таван мэдрэхүйн хаалгыг хаах хэрэгтэй. Хамгийн бага нүглээс ч зайлсхийх хэрэгтэй. Сэтгэлийн төгс байдалд хүрч цаг үргэлж буяныг үйлдэх хэрэгтэй.

Сэтгэлийг төвлөрүүлнэ гэж юу вэ? Шуналт нүгэлт хүслийг гарч ирмэгц түргэн зайлуулж, сэтгэлээ ариутган амгалан тайвнаар хадгалах явдал мөн.

Мэргэн ухаан гэж юу вэ? Дөрвөн үнэнийг төгс ойлгох чадварыг хэлнэ. Зовлон, түүний шалтгааныг мэдэж арилгах үнэн, зовлонг зогсоох замын үнэнийг мэдэхийг хэлнэ. Энэ гурван ухааныг судалж байгаа хүнийг бурханы шавь гэнэ. Гадна хэлбэрээрээ ч, дуугаараа ч гэсэн илжиг үхэртэй адилгүй, үхэртэй хамт хичнээн байсан ч хэн ч илжгийг үхэр гэж харахгүй.

Гэгээрлийн дээрх гурван ухааныг мөрдөхгүй байгаа Бурханы шавь, Гэгээрлийг эрэгч хэмээн өөрөө чалчигч тэнэг хүн яг дээрх илжигтэй адил. Намар ургац авахын тулд тариачин хавар нь газар хагалж, үр суулгаж, талбайгаа услан, хогийн ургамлыг зулгааж бэлтгэл хангана.

Үүний адил Гэгээрлийг хүсэгч хүн дээрх гурван ухааныг судлах нь зайлшгүй хэрэгтэй. Өнөөдөр үр суулгаж ургуулаад, маргааш нөгөөдөр нь шинэ ургац хураахыг тариачин хичнээн хүсэвч бүтэхгүй.

Үүний адил Гэгээрлийг эрж буй хүн өнөөдөр ертөнцийн хүслээс ангижирч, маргааш нь юманд дурлан татагдах хүслээс хөндийрч нөгөөдөр нь Гэгээрэх боломжгүй.

2. Энэ ертөнцөд баяжих, алдаршихыг хүсэгч, шунал нь буцалж буй хүн Гэгээрэх замд орох маш хэцүү. Учир нь энэ ертөнцөд зугаа цэнгэлийг эрэгч, Гэгээрлийн замын жаргал цэнгэлийг эрэгч хоёр маш их ялгаатай юм. Дээр өгүүлсэнчлэн сэтгэл бол бүх юмны эх үүсвэр болдог.

Хэрэв сэтгэл ертөнцийн явдлыг таашаавал эндүүрэл зовлон зайлшгүй дагалдана.

Хэрэв сэтгэл үнэн замыг дагавал аз жаргал, Гэгээрэл зайлшгүй дагана. Иймээс Гэгээрлийг эрэгч хүн бол сэтгэлээ ариутгаж, Бурханы сургаалыг үнэнчээр дагаж, номлолыг мөрдөх хэрэгтэй.



Хэрэв сахилаа хадгалж чадвал сэтгэлээ төвлөрүүлж чадах нь зайлшгүй. Сэтгэлээ төвлөрүүлж чадвал ариун ухаанаа Гэгээрүүлж чадна. Тэгээд мэргэн ухаан нь Гэгээрэлд хүргэнэ. Үнэндээ энэ гурван зам бол сахилаа хадгалах, ухаанаа төвлөрүүлэх, зөв явах явдал юм.

Эдгээр нь Гэгээрэлд хүрэх үнэн зам юм. Тэдгээрийг дагахгүйгээр хүмүүс урт хугацааны турш оюун санааны төөрөгдөлд орно. Тэд ертөнцийн хүмүүстэй маргах хэрэггүй. Ариун сэтгэлийн дотоод ертөнцдөө Гэгээрлийг олохын тулд бясалгал үйлдэх хэрэгтэй.

3. Хэрэв энэ гурван ухааныг тодруулан авч үзвэл найман гэгээн зам, дөрвөн үзэл, зөв явах дөрвөн хэмжээ, таван хүч, зургаан үйл болно. Зөв найман зам гэдэгт: зөв үзэл, зөв санаа, зөв үг, зөв явдал, зөв амьдрал, зөв хүсэл, зөв ухаан, зөв төвлөрөл орно.

Зөв үзэл гэдэг нь: дөрвөн үнэнийг танихыг хэлнэ. Шалтгаан сэтгэл, үнэн юмны заавар үзэхийг хэлнэ.

Зөв санаа гэдэг нь: хүсэлд автахгүй, уурлахгүй, шунахгүй, бусдад хор хөнөөл учруулахгүй байхыг хэлнэ.

Зөв үг гэдэг нь: худлаа хэлэхгүй, дэмий чалчихгүй, хатуу ширүүн, бүдүүлэг үг хэлэхгүй байх.

Зөв явдал гэдэг нь: амьтан алахгүй, хулгай хийхгүй, буруу хурьцахгүйг хэлнэ.

Зөв амьдрах гэдэг нь: Хүний ертөнцийн амьдралаас ангид, ичгүүртэй амьдрахгүй байхыг хэлнэ.

Зөв тэмүүлэл гэдэг нь: зөв зорилгод хүрэхийн тулд хүчээ дайчлах, залхуурахгүй үргэлж хөдөлмөрлөхийг хэлнэ.

Зөв дурдтгал гэдэг нь: Ажил үйл болгоноо бодож боловсруулж байж гүйцэтгэхийг хэлнэ.

Зөв төвлөрөлт гэдэг нь: ухаанаа Гэгээрүүлэх, зөв зорилтыг өмнөө тогтоох, үүний тулд дотроо бясалгал хийхийг хэлнэ.

4. Дөрвөн үзэл гэдэг нь: Хүний бие ариун бус, түүнд дурлах хэрэггүй. Ямар ч сэрэхгүй зовлонг үүсгэнэ. Хүний сэтгэл үргэлж өөрчлөгдөн, тасралтгүй хөдөлгөөнд оршино.

Ертөнц дээрх бүх юм нөхцөл шалтгаанаас гарч ирнэ. Иймээс энэ ертөнц дээр мөнх юм гэж огт үгүй.

5. Зөв явах дөрвөн хэв нь: болзошгүй нүглийг зайлуулах, үйлдсэн нүглийг наманчлах, буяны үйлийг арвижуулах, улам дэлгэрүүлэх эдгээр болой.

Энэ дөрвийг үргэлж мөрдвөл сайн.

6. Таван хүч гэдэг нь: итгэх, хичээх, үйл явдлаа тунгаан бодох, бясалгах, ухаанаа гэгээрүүлэх эдгээр нь Гэгээрэлд хүрэх маш чухал хүч болдог.

7. Гэгээрлийн нөгөө эрэгт хүрэх зургаан дадал заншил: өглөг өгөх, сахил тангаргаа сахих, тэвчээр, гавшгай шалмаг явдал, бясалгал, ухаан юм. Энэ зургааг эзэмших аваас эндүүрлийн эргээс Гэгээрлийн нөгөө эрэгт хүрнэ.

Өгөөмөр сэтгэл, шуналыг хазаарлаж, номлолыг дагана гэсэн үг. Өөрөөр хэлбэл зөв үйлийг хийнэ гэсэн үг. Тэвчээр гэдэг нь уурлахгүй байхыг хэлнэ. Гавшгай гэдэг нь залхууг арилгана гэсэн үг. Бясалгал гэдэг нь сэтгэлээ номхотгоно гэсэн үг.

Ухаан нь мунхаг сэтгэлийг гэрэлтүүлнэ гэсэн үг.



Өгөөмөр сэтгэлтэй байж, сахил тангаргаа сахина гэдэг нь Бурханы сургаалыг мөрдөх үндэс болно. Тэсвэртэй, хөдөлмөрч чанар бол гаднаас ирэх дайснаас хамгаалах хана хэрэм болдог.

Бясалгал, мэргэн ухаан бол үхэл, амьдралд дурлан татагдах сэтгэлээсээ зайлахад биеийг хамгаалах хүч болно. Гуйж байгаа хүнд өглөг өгөх нь жинхэнэ өглөг бус. Жинхэнэ өглөг бол хэн ч гуйгаагүй байхад өрөвдөж хайрласнаас өгдөг өглөг юм.

Хааяа ганц нэг удаа өглөг өгөх нь өглөг бус, үргэлж өгч байвал жинхэнэ өглөг болно. Өглөг өгснийхөө дараа харамсах юмуу, бардамнах бол жинхэнэ өглөг бус, жинхэнэ өглөг бол хүн өөрийн хийсэн үйлдлээ эргэн, хариу бодох бус мартагдах ёстой.

Өөрөөр хэлбэл нигүүлсэнгүйн сэтгэлийн үүднээс бусдыг баярлуулож, Гэгээрэх замд хүрэхийг хүсч буй хэрэг. Ертөнц дээр хөрөнгөгүй ядуу хүн ч хийж чадах долоон төрлийн өглөг байдаг.

- Биеэ зориулах. Энэ нь биеийн хүчийг үнэлж үнэнч хөдөлмөрлөх.
- Сэтгэлээ зориулах. Орчны хүн амьтан, ямар ч зүйлд туйлын элэгсэг, үнэнч хандах.
- Нүдээ зориулах. Орчноо тайван амгалан итгэлтэй харцаар харж байх.
- Нүүрээ зориулах. Байнга дулаахан инээмсэглэж, баяс-галантай байх.
- Үг яриагаа зориулах. Бусдын сэтгэлд нийлэмжтэй, зөөлөн элгэмсэг үгийг хэлж байх.
- Суудлаа зориулах. Өөрийн суудлыг ядарсан бусдад тавьж өгч байх.

– Гэр орноо зориулах. Зорьж ирсэн хүмүүсийг орон гэртээ тав тухтай хонуулж өнжүүлэх.

Эдгээрийг өдөр тутмын амьдралдаа хийж гүйцэтгэж байх хэрэгтэй.

8. Эрт урьд цагт Саттва нэртэй жонон амьдарч байжээ. Нэгэн удаа хоёр ахтайгаа хамт ойд тоглохоор явлаа. Тэд ойд бамбараа төрүүлсэн барыг харжээ.

Хаан хүү Саттва өлөгчин барыг өөрийн биеэр хооллохоор шийдэн ойд үлджээ.

Тэрээр өндөр хавцлын оройд авирч гараад бар руу үсэрч түүний идэш болсон. Бар Саттва хүүгийн биеэр хооллосон учир цадаж бамбаруудаа барьж идсэнгүй.

Хаан хүү: Миний бие мөнх бус, үргэлж өөрчлөгдөнө. Одоог хүртэл би үргэлж өөрийн тухай бодож байсан болохоос биш өглөг өгч байсангүй.

Одоо би Гэгээрэлд хүрэхийн тулд өлөгчин баранд өөрийн биеэр өглөг өгч бамбаруудыг аваръя гэжээ.

9. Гэгээрлийн замыг эрж байгаа хүнд сэтгэлийн дөрвөн зам байдаг. Нигүүлсэнгүй сэтгэл, энэрэх, баярлах, аймшиггүй байх.

Нигүүлсэнгүй гэдэг нь шуналаас зайлсхийж сэтгэлээ номхотгох, энэрэн хайрлах сэтгэл нь уурлахаа больж амгалан байх, баясах сэтгэл нь зовлон зүдгүүрийг арилгана. Аймшиггүй байна гэдэг нь ямар нэгэн буянт үйлийн төлөө зоригтой, гэвчээртэй байхыг хэлнэ.

Хүмүүсийг баярлуулж, тэдэнд аз жаргал өгч, хэнийг ч ялгалгүй адилхан хандана гэдэг бол агуу их нигүүлсэнгүй, их амгалан, их баяр баясгалан юм. Иймд сэтгэлийн дөрвөн

замыг ямагт замнаж байх ёстой. Тэвчээр гэдэг амархан зүйл биш. Сайхан сэтгэл гэдэг ой дахь хулжсан буга шиг амархан арилна. Тэнэг санаа хадан дээрх бичиг лугаа арилах нь удаан. Сайн санаа усан дээр бичсэн бичгийн адил амархан угаагдана. Тэнэг санаа нохой хөөхтэй адил. Иймээс сэтгэлийн дөрвөн замыг барьж, асар их тэвчээртэй байж, Гэгээрлийн төлөө дасгал хийх хэрэгтэй.

10. Бурханы шавь Срон баян язгууртны гэрт төрсөн. Тэр их бие султай ч Гэгээрэлд хүрэхийн тулд их бэрхшээлийг туулж, хөлөө шархдуулж, багагүй зовж, Бурханы үнэнч шавь болов.

Бурхан түүнийг өрөвдөн: “Чи гэртээ байхдаа ятга хөгжим тоглож байсан уу? Хөгжмийн утсыг хэт чанга, эсвэл хэт сул татвал сайхан хөг гарахгүй. Хэдий хэрийн хэмжээнд хөглөгдөж, яаж чавхдасыг татвал таарахаас хамаарч сая сайхан хөг аялгуу гарна. Гэгээрэхэд ч гэсэн зохих хэмжээний тэвчээр хөдөлмөр, хүч чармайлт гарна. Хэт их залхуу, хэт их улайрч биеэ зовоох хоёрын аль нь ч тус болохгүй” гэв. Энэ айлдварыг сонсоод Срон удахгүй Гэгээрэлд хүрчээ.

11. Эрт цагт таван зүйл зэвсгийг гайхамшигтай эзэмшсэн нэгэн хан хүү байжээ. Ном сургуулиа дүүргээд хан хүү гэртээ харьж явжээ. Аян замдаа алжааж ядарч явтал мангас таарч хүү рүү дайрчээ. Хүү нум сумаар харавсан боловч сум түүний зөвхөн арьсан дээр нь наалджээ. Илд жад нь хүртэл наалджээ. Хан хүү агаарт эргэн толгойгоороо мөргөтөл бас наалдчихжээ.

Мангас: – Одоо чи миний гарт орлоо. Би чамайг иднэ гэв.

Хүү: – Чи намайг бүх зэвсгээ бүгдийг наалдуулчихсан гэж бодож байна уу? Чи намайг залгисан ч би чамайг дотроос чинь хэрчиж тасдана гэв.

Мангас хөх инээд нь хүрч: Чи яаж чадах юм бэ? гэв.

Хан хүү: – Би үнэний хүчээр чадна гэжээ. Мангас хан хүүгийн үгийг авч түүнийг явуулаад, дахин муу үйл хийхээ больсон гэнэ.

12. Ичгүүр сонжуураа мэдэхгүй аваас нийгэм замбараагаа алдана. Ичгүүр байна гэдэг нь дэг журамтай байхад нөлөөтэй. Хүмүүс ичих зовох мэдрэмжтэй байх аваас нэр төр, эцэг эх, ахмад хүмүүс ах эгч, багш нар, найз нөхдөө хүндэлнэ. Бусдын ичгүүртэй явдлыг хараад өөрийн үйл явдлыг хянаж цэгнэх хэрэгтэй. Хэрэв алдаандаа үнэхээр гэмшиж, харамсаж чадвал нүгэл нимгэрч арилна.

Зөв сургаалыг сонсоод түүнийг сайтар бодож, алдалгүй дагаж биелүүлбэл үнэхээр хэрэгтэй. Хэрэв зөв сургаалыг сонсоод сайтар бодохгүй, дагахгүй бол Гэгээрэлд хүрэхгүй. Итгэлтэй байх, ичиж зовдог байх, даруу зантай, хөдөлмөрч, ухаалаг байна гэдэг бол энэ ертөнцийн нэг их хүч мөн. Энэ дотроос мэргэн ухаан бол хамгийн агуу нь юм. Бусад мэргэн ухааны хүчийг бүрдүүлж байдаг. Гэгээрэх замд орохоор дасгал хийж байгаа хүн их унтах, дэмий ярих, цагаа үр ашиггүй үрэх зэргээс болж Гэгээрэх замаас хоцрох болно.

13. Гэгээрэх замын дасгалд зарим хүн бусдаас хурдан сурч болно. Иймээс Гэгээрэлд хүрч буй нэгнээ хараад гомдох атаархах хэрэггүй.

Нум сум харваж сурахад эхлээд байндаа ховорхон ононо. Дасгал сургуулиа орхилгүй үргэлжлүүлээд байвал онох нь улам ихсэнэ.



Гол ч гэсэн жижиг булаг горхинуудаас эхлэн томрон томорч нийлсээр их далайд цутгадаг. Үүний нэгэн адил Гэгээрэлд хүрэх дасгалыг байнга тэвчээртэй гүйцэтгэх аваас Гэгээрэлд зайлшгүй хүрнэ. Дээр дурдсанчилан нүдэнд харагдаж байгаа бүхэнд сургаал оршиж буй. Түүнтэй адил Гэгээрэх боломж хязгааргүй. Нэг хүн хүж асааж байжээ. Тэгээд хүжний анхилам сайхан үнэр хаанаас ч ирдэггүй, алга болдоггүй гэдгийг мэджээ.

Үүний мөн чанарыг мэдсэнээр тэр хүн Гэгээрэх замд хүрч чадсан байна. Замаар явж байсан хүний хөлд өргөс орсноос өвдсөн. Гэтэл тэр хүн өвдөлт бол сэтгэлийн урвал юм байна гэдгийг ухаарснаар сэтгэл нь улам гүнзгийрч хэрэв хүн ухаанаа удирдаж чадахгүй бол сэтгэл алдарч, удирдаж хянаж чадвал сэтгэл ариусдаг гэдгийг ойлгожээ.

Үүний мөн чанарыг зөв олж чадсанаар тэр хүн мөн Гэгээрэлд хүрчээ. Бас нэг их харамч хүн байжээ. Тэр нэг өдөржингөө харамч сэтгэлийн тухай маш ихээр эргэцүүлэн бодоод шуналын “мод” бол эцэстээ ухааныг шатаах дөл болж болох юм гэдгийг мэдсэнээр Гэгээрэлд хүрэх замыг олох эхний алхмаа хийжээ.

“Сэтгэлээ түвшин байлга! Сэтгэл чинь түвшин байвал бүх ертөнц түвшин байдаг” гэсэн эртний үг байдгийг санагтун! Ертөнцөд байгаа бүх ялгаа бол сэтгэлийн чанараас үүснэ гэдгийг мэдэж авах хэрэгтэй. Энэ мэтчилэн Гэгээрэлд хүрэх замууд хязгааргүй.

3. ИТГЭЛИЙН ЗАМ

1. Бурхан, ном, хуврага гурван эрдэнэд итгэдэг хүнийг Бурханы шавь гэдэг. Бурханы шавь нар ном, сахил, итгэл, өглөг гэсэн сэтгэлийг хянах дөрвөн зүйлийг мөрддөг. Бурханы шавь түүнчлэн амьтан алахгүй, хулгай хийхгүй, худал хэлэхгүй, буруу хурьцахгүй, архи дарсанд дурлахгүй байх таван сахилыг дагадаг.

Бурханы төгс ухаанд итгэх итгэлийг шавь баримтлана. Шунал, уур, хилэнцээс зайлсхийж өргөл буян үйлдэх нь шавийн өгөөмөр сэтгэл мөн. Үйлийн үр, шалтгааны хуулийг мэдэж, бүх юм энэ ертөнц дээр хувирч өөрчлөгдөж байна гэдгийг мэдэх ёстой. Зүүн тийшээ хазайсан мод зүүн тийш унах нь зайлшгүй. Түүнчлэн Бурханы сургаалыг сонсож түүнд итгэсэн хүн Бурханы ариун оронд төрөх нь дамжиггүй.



2. Бурхан, ном, хуврага, гурван эрдэнэд итгэсэн хүнийг Бурханы шавь гэж нэрлэнэ. Бурхан гэдэг бол төгс Гэгээрэлд хүрч хүн төрөлхтөнийг зовлонгоос аврагч үнэн Бурхан бөгөөд Дарма гэдэг бол Гэгээрлийн үнэнийг тайлбарлаж байгаа Бурханы сургаалын ном юм.

Хуврага гэдэг бол Бурханы номд итгэсэн, зөв замд шулуудсан ахан дүүс. Бурхан, ном хувраг нь тусдаа юм шиг байвч нэг бүхэл цогцсыг бүрдүүлнэ. Ингэхлээр ном, хуврагт итгэнэ гэдэг бол Бурханд итгэнэ гэсэн үг. Бурханд итгэнэ гэдэг бол ном, хуврагт итгэнэ гэсэн үг. Ингэхлээр хүн Бурханд итгэснээр аз жаргалыг олж Гэгээрэлд хүрч чадна. Бурхан бүх хүмүүсийг өөрийн ганц хүү мэт хайрлаж чадна. Тэгэхээр хүмүүс эцэг эхдээ итгэдэг шиг Бурханд итгэвэл Бурханыг үзэж, Бурханы авралыг хүртэх болно. Бурханд итгэсэн хүн бүхэн түүний гэгээн саруул ухаан, энэрэл нигүүлсэнгүйгээр ивээгдэх болно.

3. Энэ ертөнцөд Бурханд итгэхээс илүү сайн юм гэж үгүй. Бурханы нэрийг сонсож агшин зуур ч болов түүнд итгэж байсан бол хамгийн их аз завшаан тохиолоо гэсэн хэрэг.

Энэ дэлхийн хаа сайгүй дүрэлзэж байгаа гал дотор ч гэсэн Бурханы сургаалыг сонсож итгэхийн тулд орох хэрэгтэй. Бурханы номыг тайлбарлаж чадах багштай уулзах хэцүү. Бурхантай уулзах бүүр ч хэцүү. Бурханы сургаалд итгэх хамгийн хэцүү. Харин та одоо уулзахад хэцүү Бурхантай уулзлаа. Сонсоход хэцүү сургаалыг нь олж уншлаа. Амьдралд ховор тохиолдох энэ завшааныг алдахгүйн тулд Бурханд итгэх хэрэгтэй.

4. Хүний амьдралын замд итгэл бол хамгийн сайн дагуул, хамгийн үнэт эрдэнэ болно. Итгэл бол Бурханы сургаалыг тосч авах ариун гар мөн. Итгэл бол ертөнцийн

шуналын бохир болгоныг устган шатаах гал мөн. Зовлонг зайлуулж зөв замд оруулах хөтөч мөн. Итгэл бол уур омог, бардам зан, аймшгийг таягдан хаяж, хүнийг даруу, бусдыг хүндэлдэг болгон хүний сэтгэлийг ариутгана.

Бэрхшээл зовлонг туулах хүч урмыг өгч, хүний ухааныг мэргэнээр баяжуулна. Итгэл бол урт хугацааны уйтгарт замд хүнийг сэрээж Гэгээрэлд хүргэдэг юм. Итгэл бол биднийг Бурханы өмнө, Бурханы гар оролцож байгаа газар бүхэнд аваачна. Итгэл бол бидний хатуу ширүүн, хувиа хичээсэн сэтгэлийг зөөлрүүлж, орчин тойрноо хайрлан энэрдэг, зөөлөн найртай сэтгэлтэй болгож өгч байна.

5. Бурханы сургаалыг хүртэе гэсэн итгэлтэй хүнд бол Бурханы сургаал ямар ч дуу хоолойгоор сонсогдлоо гэсэн ялгагдах учиртай.

Мэргэн ухааныг хүртэх итгэлтэй хүн бол юм бүр нөхцөл шалтааны үр дүнд гарч ирж байна гэдгийг ойлгож, байх ёстой юм ёс жамаараа байна гэдгээр нь хүлээн авч, тухайн нөхцөл байдалд тайвнаар зохицох чадвартай болно. Бүх юм хувьсан өнгөрөх энэхэн ертөнцөд хувиршгүй зүйл бол зөвхөн үнэн юм. Амьдрал өөдөлж уруудахад харамсах хэрэггүй, гайхах ч хэрэггүй гэдгийг ойлгох хэрэгтэй.

Итгэл бол гэмших, харуусах, залбирах, сөгдөх, гуйх, уярах, хайлах гурван хэлбэрээр гарч ирдэг. Өөрийн явсан явдалдаа гүнзгий дүн шинжилгээ хийгээд, хийсэн нүгэл, бузар хэрэгтээ хүн харамсан гэмшдэг. Хүн буянтай үйл хийхийг хараад өөрөө хийсэн мэт баярлан түүнд буяныг ерөөдөг.

Бурхантай үргэлж хамт байхыг хүснэ, үргэлж хамт буян үйлдэхийг хүснэ. Итгэж байгаа сэтгэл гэдэг бол Бурхан түүнийг өөрийн орондоо дагуулж байгаа гэж баясч буй



жинхэнэ гүн сэтгэл мөн. Ингэхээр ариун оронд хүмүүсийг хөтлөж байгаа итгэлд Бурхан хүчийг өгдөг юм.

Тэр хүч нь тэдгээрт итгэлтэй хүмүүсийг ариутган цэвэрлэж, эндүүрэх зовлонгоос авардаг юм. Хэрэв тэд бүх ертөнцөөр шагших Бурханы нэрийг сонсож байхдаа ганц хором ч гэсэн итгэл төрсөн бол тэд Бурханы ариун оронд очих болно.

6. Бурханд итгэж байгаа энэ сэтгэл бол хүн бүхний сэтгэлийн гүнд оршдог. Бурханы мөн чанар илэрч байгаа нь тэр. Учир нь Бурханыг таньж байгаа хүн бол өөрөө Бурхан мөн. Бурханд итгэж байгаа хүн бол өөрөө Бурхан мөн. Бурханы мөн чанар хэдийгээр хүн бүхэнд байдаг ч гэсэн тэр нь ертөнцийн шуналын хүлээсэнд гүнээ бохирлогдон далдлагдсан байдаг тул бүрэн дүүрэн гарч ирэх нь маш хэцүү. Уур, шуналын эргүүлгэн дотроос Бурханд тэмүүлэх цэвэр сэтгэл гарч ирж чадна гэж үү? Хорт эранда ургадаг ойд анхилам чандана ургаж чадна гэж үү? Хэрэв ургах аваас гайхамшиг мөн. Түүний адил хүний сэтгэлд Бурханд итгэх итгэл төрвөөс гайхамшиг мөн.

Иймээс Бурханд итгэсэн сэтгэлийг “үндэсгүй” итгэл гэж нэрлэнэ. Энэ нь хүний сэтгэлд ургах үндэсгүй, харин Бурханы нигүүлсэнгүйн сэтгэлд ургах үндэстэй байдаг юм.

7. Итгэл бол ариун байна. Зөв замд хөтлөж буяны эх үүсвэр болдог. Итгэл бол зөв замыг эрж байгаа хүн болгонд шууд төрдөггүй таван эргэлзээ байна.
- ① Бурханы ухаанд эргэлзэх
 - ② Сургаалын үнэнд эргэлзэх
 - ③ Бурханы сургаалыг айлдаж байгаа хүнд эргэлзэх

- ② Зөв замын эрэлд төөрснөөс эргэлзэх
- ② Бурханы сургаалыг дагаж байгаа хүмүүст үл итгэх зэрэг болой.

Эдгээр эргэлзээ тэвчээргүй байдлаас үүдэн гарна. Итгэл үгүй эргэлзээнээс өөр аймшигтай юм энэ ертөнцөд байхгүй.

Эргэлзээ бол хүмүүсийг холдуулж, найз нөхдийн холбоог салгах хор, найрамдлыг зогсоох өргөс, амь насанд аюултай хугга мөн.

Итгэл авсан хүн бол эрт цагт Бурханы нигүүлсэнгүйн авралаар түүний сэтгэлд итгэлийн үр тавигдсан гэдгийг ойлгох хэрэгтэй. Хүний сэтгэлийн эргэлзлэлийн харанхуйг Бурхан итгэлийн гэрлээр Гэгээрүүлээ гэдгийг мэдэх хэрэгтэй. Итгэлийг авсан хүн энэ ертөнцөд байхдаа эрт цагт Бурхан хүмүүсийн сэтгэлд итгэлийг өгчээ гэдэгт баярладаг. Бурханы агуу их энэрэн нигүүлсэхүйд хойтдоо Бурханы оронд төрөх болсондоо баясдаг. Энэ ертөнцөд хүн болж төрнө гэдэг бол үнэндээ хэцүү. Бурханы сургаалыг сонсох ч хэцүү. Итгэх бүүр ч хэцүү. Ийм учраас хүн бүхэн Бурханы сургаалыг сонсохын тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй.





4. АРИУН СУРГААЛ

1. “Тэр намайг зэмлэсэн, дооглосон, цохисон” гэж бодоод байвал гомдол тасрахгүй. Гомдлыг үргэлж бодсоноор тайлахгүй. Түүнийг зөвхөн мартсанаар арилгаж чадна.

Муу дээвэр цас борооны усыг гоожуулдаг шиг сэтгэлээ хянаж чадахгүй хүнд шунах сэтгэл яг тэгж орж ирнэ. Залхуурал бол үхэлд хүргэх хамгийн хялбар зам мөн. Хичээнгүй оролдлого бол амьдрах арга мөн. Тэнэг хүн залхуу, мэргэн хүн оролдлоготой байдаг. Сум хийгч хүн сумаа шулуун хийнэ.

Мэргэн хүн өөрийн сэтгэлийг шулуун байлгахыг хичээнэ. Самуурсан сэтгэлийг хянаж барихад хэцүү. Тэрбээр энд тэндгүй дүүлэн чавхдаж байдаг. Харин тайван сэтгэл гэдэг номхорсон амгалан байдаг учир хянаж удирдаж болдог.

Хүнд өөрийнх нь сэтгэл хор хөнөөл авчирч байгаа

болохоос биш гадны дайсан хорлож байгаа юм биш. Шунал уур мунхагаас сэтгэлээ хамгаалж чадаж байгаа хүн бол жинхэнэ энх амгалангаар жаргаж байна гэсэн үг.

2. Амаараа сайхан үг ярьж, ажил хэрэг дээрээ биелүүлдэггүй хүн бол үнэргүй сайхан цэцэгтэй адил. Цэцэгсийн үнэр салхины эсрэг тарахгүй боловч сайн хүний алдар бүх дэлхийгээр салхины эсрэг ч тарна. Нойргүй хүнд шөнө урт санагддагийн адил зөв сургаал мэдэхгүй хүнд зовлонт эндүүрэлт хугацаа урт санагдана.

Хүн замд гарахдаа өөртэйгээ адил юмуу өөрөөсөө илүү ухаантай хүнтэй ханилах хэрэгтэй. Тэнэг хүнтэй хамт явснаас ганцаараа явсан нь дээр. Зэрлэг араатнаас бус муу нөхрөөс айх хэрэгтэй. Зэрлэг араатан биеийг чинь шархтуулдаг бол нүгэлт муу нөхөр сэтгэлийг чинь шархтуулна.

Хүн сэтгэлээ удирдаж чадахгүй бол яаж сэтгэл нь ханах юм бэ? Тэнэг хүн “би, минийх” гэсэн бодлоосоо салж чадахгүйгээсээ болж зовдог. Хүн өөрөө өөртөө хүртэл хамаарагдахгүйгээр байгаль, хүүхэд болон эрдэнэ яаж түүнд хамаарагдах билээ. Өөрийнхөө тэнэгийг мэддэг тэнэг өөрийгөө цэцэн гэж боддог тэнэгээс дээр.

Тэнэг хүн ухаант хүнтэй харьцахдаа халбага хоолныхоо амтыг мэдэрдэггүйтэй адил ухаант хүнийхээ үгийг ойлгодоггүй. Шинээр саасан сүү эрт гашилдаггүйтэй адил муу үйлийн дараа лай ланчиг тэр бүр даруй ирдэггүй. Гэхдээ муу үйл бол үнсэн доорх цог шиг чимээгүйхэн асаж, хэтдээ түймэр болон ноцно. Ухаангүй хүн бол өөрийн ашиг орлогын талаар үргэлж зовж байдаг. Тийм хүн үргэлж өндөр албан тушаал эрх эдлэхийг хичээж их олзонд тэмүүлж байдгаас мөнхөд зовно. Хүний алдаа дутагдлыг засуулахын тулд ил хэлж өгч байгаа нөхөртөө нуугдмал эрдэнийн

хөмрөг зааж өгч буй ачтанаа хүндлэх мэт талархах ёстой.

3. Бурханы номыг хүртсэн хүний сэтгэл ариуссанаар шөнө бөх нойрсдог. Мужаан хүн модыг жигд харуулдахыг, сум хийгч хүн сумаа шулуун болгохыг, усчин хүн усаа сувгаар жигд урсгахыг эрхэмлэнэ. Мэргэн хүн сэтгэлээ үнэнч шулуун байлгахыг хичээнэ. Хадан хясаа салхинд ганхдаггүйтэй адил зэмлэл магтаал хичнээн сонслоо ч гэсэн ухаант хүний сэтгэл хөдөлдөггүй уужим байдаг билээ. Тулалдааны талбарт тоо томшгүй олон дайсан ялснаас өөрөө өөрийгөө ялсан ялалт илүү үнэтэй.

Сургаал сонсолгүй зуун жил амьдарснаас сургаалыг мэдэж нэг өдөр амьдарсан нь дээр. Хүн өөрийгөө жинхэнэ ёсоор хайрлаж чадвал хорт нүглээс хамгаалж чадна. Хүн амьдрах хугацаандаа ядаж нэг удаа ч гэсэн залуу, идэр, ахимаг насны алинд ч болов итгэл үйлдэх хэрэгтэй. Энэ ертөнц бол шунал, уур, мунхагийн галаар мөнхөд шатаж байна. Хүн энэ аюулаас аль болох хурдан зайлсхийх хэрэгтэй. Энэ ертөнц бол аалзны тор шиг хөөс хир дүүрэн тортой адил байна. Хүн бүр өөрийн сэтгэлийг байнга ариусган хамгаалж байх хэрэгтэй.

4. Ямар нэг нүглээс зайлсхийх, буяныг эрэх, сэтгэлээ ариун байлгах зэрэг нь Бурханы сургаалын гол цөм мөн. Тэвчиж сурна гэдэг бол маш хэцүү ч тэвчиж чадсан хүн л ялалтанд хүрдэг. Хүн гомдоохоор ашигласан ч гомдох хэрэггүй. Хэцүү үед ч уйтгарлах шаардлагагүй. Шунахаар байсан ч шуналаа дарж сурах хэрэгтэй. Ямарч эд юмыг миний юм гэж бодох хэрэггүй, хувиа хичээлгүй цэвэр ариунаар амьдрах хэрэгтэй.

Эрүүл байна гэдэг л хамгийн их баялаг. Сэтгэл ханана гэдэг бол бас их баяр. Итгэлцэл бол эв найрамдлын дөт зам.

Гэгээрэлд хүрнэ гэдэг дээдийн аз жаргал. Нүглээс зайлж (нам гүм) Бурханы сургаалд баярладаг хүнд айх, сэтгэл зовох юм гэж огт үгүй. Дуртай юмандаа бүү татагдаж шуна. Дургүй юмандаа бүү зэвүүц. Гунихрал, аймшиг, боолчлол бол дуртай дургүйн ялгаанаас гарч ирдэг.

5. Зэв төмрөөс гарч төмрөө иддэг бол нүгэл гэдэг муу санаат хүнээс гарч хүнээ иддэг. Уншдаггүй ном судар удахгүй тоосонд дарагдана. Засах хэрэгтэй байшинг засахгүй бол эвдэрч унана. Залхуу хүн засрахгүй бол бохир заваан нь улам дордож, ариун бус явдал хүнийг бузарладаг. Нүгэл бол энэ болоод хойд насны бузар буртаг мөн. Гэхдээ хамгийн бузар хир бол мунхагийн харанхуй юм. Үл мэдэхийн мунхагийн харанхуй арилахгүй аваас бие сэтгэлийг цэвэрлэж ариутгах аргагүй. Хэрээ шиг, турлиах шиг өөрийн шившгээс ичдэггүй, бусдыг зовоогч, түүнийгээ мэддэггүй бол эрээ цээрээгүй болох амархан.

Дур шохоорхолоо хязгаарлаж буянтай үйлийг хийгч бусдыг хүндэлдэг даруу хүн болох хэцүү. Бусдын алдааг засах амархан, өөрийн алдааг мэдэх хэцүү. Бусдын нүглийг бодлогогүйгээр цацаж тараадаг мөртөө өөрийн нүглийг шагай таалцаж тоглож байгаа мэт нуух нь гутамшиг юм. Тэнгэрт утаа, шуурга, шувууны мөр байдаггүйтэй адил хуурамч сургаалд Гэгээрэл гэж юу ч байхгүй. Энэ ертөнцөд тогтвортой юм гэж байхгүй. Гэгээрлийн ухаан бол хөдөлшгүй зүйл.

6. Цоож түгжээ хэрэмт хаалгыг манадаг шиг сэтгэлээ гадна дотны аюулаас нэг мөч ч марталгүй манах хэрэгтэй. Хүн бүхэн өөрөө өөртөө эзэн байх хэрэгтэй.

Иймд юуны өмнө өөрийгөө хянах хэрэгтэй. Өөрийгөө хянана гэдэг нь энэ тухай гүнзгий бодохын утга билээ.



Энэ нь бүх л бачимдал шахалтаас чөлөөлөгдөх боломж олгодог. Нар өдөр, сар шөнө гэрэлтэнэ. Сахилга бат цэргийн хүний нэр төрийг сайжруулна. Тайван бясалгал Гэгээрлийг эрэгчийг ялгаруулна. Мэдрэхүйн таван эрхтэнийхээ хаалгыг гадны орчноос нөлөөлөн хааж чадахгүй хүн бол Гэгээрлийн замаар явж чадахгүй.

Мэдрэхүйн таван эрхтэний хаалгыг сайтар бэхэлж чадах хүн бол сэтгэл амгалан явж чадна.

7. Дуртай дургүй ялгаагүй түүнд нөлөөлөгдөх нь орчин тойрны юмсын жинхэнэ чанарыг олж харж чадахгүйд хүргэнэ. Хэрэв хүн дурлах, татгалзах сэтгэлээс эс ангижирч чадвал юмсын үнэнийг зөвөөр харж чаддаг болно.

Татагдах, татгалзахаасаа ангижирсан сэтгэлд аливаа юмс шинэ ач холбогдолтой болдог. Аз жаргалын дараа уй гашуу ирдэг. Уй гашуу ч бас аз жаргалаар солигддог тал байдаг. Эрх чөлөө гэдгийг таних чадвартай болбол сайн муу үйл, уй гашуу, аз жаргалын хооронд дахин ялгаа гарахгүй болно.

Зөвхөн ирээдүйн төлөө болоогүй юмны төлөө санаа зовоод байвал, эсвэл аль өнгөрсөн юмны төлөө харамсаад байвал хүн тасарсан өвс шиг хатна. Бие сэтгэлийн эрүүл энхийн нууц бол өнгөрсөн болон ирээдүйн төлөө санаа тавих, гай төвөгт оролцохгүй байхад бус яг одоо үедээ зөв мэргэн үнэнчээр амьдрахад оршиж байна.

Өнгөрсөн өдрүүдийн төлөө харамсахгүй, ирээдүйн тухай мөрөөдөхгүй, болоогүй юмны төлөө санаа зовохгүй яг одоо цагаа л эрхэмлэж байвал хүн бие сэтгэлээр эрүүл болно. Өнгөрсөн юманд харамсах хэрэггүй. Ирээдүйгээ хүлээх хэрэггүй.

Зөвхөн одоогийн энэ агшнаар амьдрах хэрэгтэй. Өнөөдрийн хийж болох юмыг маргааш гэж хойшлуулах хэрэггүй. Өнөөдрийн хийх ёстой юмыг найдвартай сайн хийгээд өнөөдрийг сайхан үдэж болно.

Ухаан бол хүний хамгийн сайн хөтлөгч, итгэл бол хамгийн сайн нөхөр мөн. Гэгээрлийн гэрлийг эрэхдээ зовлонгийн сүүдрээс зугатах хэрэгтэй.

Хэрэв хүн бие сэтгэлээ хянаж чадаж байвал буяны үйлийг хийж чадна. Энэ бол ариун үүрэг мөн. Итгэл бол баялаг, үнэнч явдал бол амьдралыг өгдөг. Буянт үйлийг арвижуулах нь ариун зорилго болдог. Амьдрах аялалд итгэл бол тэжээл болдог. Буянт үйл бол хоргодох газар нь болдог.

Мэргэн ухаан бол гэрэл дэнлүү болдог.

Зөв санаа бол шөнийн хамгаалалт болно.

Ариун буянт хүний амьдрал бол мөнх байдаг.

Шунал хүслийг ялж чадсанаар хүн чөлөөтэй болдог.

Гэр бүлээ аврахын тулд өөрийгөө мартаж хэрэгтэй.

Тосгоноо аврахын тулд гэр бүлээ мартаж хэрэгтэй. Үндэснийхээ төлөө тосгоноо мартаж хэрэгтэй. Гэгээрлийн төлөө бүхнийг мартаж хэрэгтэй.

Бүх юм өөрчлөгдөнө. Бүх юм гарч ирнэ, алга болно. Амьдрал үхлийн тэмцлийн цаад талд гартал энх амгалан ирэхгүй.

АХАН ДҮҮС



АХАН ДҮҮСИЙН ҮҮРЭГ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



1. ХУВРАГИЙН АМЬДРАЛ

1. Миний шавь болохыг хүсч байгаа хүн өөрийн гэр бүлтэй бүх харилцаануудаа шууд таслан, энэ ертөнцийн бүхий л амьдрал эд хөрөнгө гэр орон, нийгмийн харилцаа бүхнээ таслах хэрэгтэй.

Бурханы номын төлөө бүхнийг хаяж буй хүнийг гэрээ орхигч тойн хуврага гэж нэрлэнэ. Хэрэв хүн миний хувцаснаас барьж, миний мөрийг дагаж гишгэвч ухаан сэтгэл нь шуналд автсан бол тэр надаас их хол байна гэсэн үг.

Лам хувцас өмсөвч Бурханы сургаалыг дагахгүй бол намайг олж харахгүй. Бүх шунал хүслээ таягдан хаяад, ухаан сэтгэл нь цэвэр ариун, амгалан бол мянга мянган бээр хол оршивч надад маш ойр байна.

Бурханы номыг дагаж байгаа бол түүн дотор намайг үзэж байна гэсэн үг. Миний сургаалыг үзэж байвал намайг



үзэж байгаа гэсэн үг.

2. Миний шавь хуврагууд амьдралдаа дараахи дөрвөн нөхцөлийг мөрдөх ёстой.
 - 1) Хуучин эд бөсөөр хувцас хийж өмсөх
 - 2) Хоол ундыг бадар барьж хэрэглэх
 - 3) Модон дор хоргодож, чулуун дээр хоног өнгөрөөх
 - 4) Ах дүү нарын бэлтгэсэн тумгай эмийг хэрэглэх

Гартаа бадрын аяга барьж айлаас айлд юм гуйх нь гуйлгачингийн амьдрал. Гэхдээ гуйланчлал нь хуурамчгүй, хүн айлгаж заналхийхгүй байх ёстой. Бадар барин хэсэх амьдрал нь ертөнцийн бүх шуналаас яаж зайлсхийх, эндүүрэл төөрөгдлөөс яаж гарахыг олох арга юм. Гэрээ орхисон хуврагуудын амьдрал тийм ч хялбаргүй.

Хүн хуврагын сахил хүртээд уур хилэн шуналаас ангижирч чадахгүй бол, мэдрэхүйн таван эрхтэний хаалгыг хааж чадахгүй бол жинхэнэ хуврага болох гавъяагүй.

3. Өөрийгөө хувраг хүн гэж бат итгэсэн хүн бол дараахи асуултанд байнга хариулж чадах чадвартай байх ёстой.

“Би гэрээ орхисон хуврага хүний үүргийг заавал биелүүлэх ёстой. Надад өргөл барьц барьж байгаа бүхэнд би аз жаргалыг үнэнээсээ хүснэ. Хуврага болсны зорилтыг биелүүлэхийн тулд би бүхнийг хийнэ. Сахилгатай хүн юу хийх ёстой вэ? өөрийн алдаа дутагдал, шударга бус явдлыг нанманчилан дахин давтахгүй байх ёстой.

Бие, хэл, сэтгэлийн үйлээ ариутган, мэдрэхүйн таван эрхтэний хаалгыг чандлан хааж сэтгэл хөдлөн цэнгэлд урвахгүй. Биеэ магтаж бусдыг зэмлэхгүй, залхуурч, нойронд дарагдахгүй байх ёстой. Оройдоо бясалгал үйлдэн

тайван сууж, унтахын өмнө салхинд гарах хэрэгтэй. Шөнө унтахдаа хөлөө нийлүүлээд баруун талаараа хэвтэж, маргаашийнхаа тухай бодон тайван унтана. Үүрээр босч дахин сууж бясалгал үйлдээд жаахан салхинд гарна. Өдөр бүхэн хувраг хүний сэтгэл сонор соргог байвал зохино. Нам гүм газрыг сонгон аваад бие сэтгэлээ шулуутган шунал, уур, мунхаг сэтгэлийн хөдөлгөөн, харамсал, эргэлзээ, нойрмог хайхрамжгүй байдал зэрэг ертөнцийн бүхий л явдлаас зайлсхийж, сэтгэлээ ариусгах ёстой. Тийнхүү сэтгэлийг төвлөрүүлмэгц ертөнцийн хүслээс ангижрах, төгс Гэгээрэлд хүргэх мэргэн ухааныг үүсгэх хэрэгтэй”.

4. Хэрэв хүн хуврагын сахилыг аваад уур хилэн, шуналаас ангижирч чадахгүй, шунал, гомдол, атаархал, сайрхал, хууран мэхлэх нүглээ нуусаар явах юм бол биедээ хоёр иртэй хутга нууж яваа хүнтэй адил. Тэр бол хуврагын өмсгөл өмссөн болохоос сахилтан хуврага биш.

Бадрын аяга барьж гуйлга гуйж яваа болгон хуврага биш. Номыг уншиж чадах болгон хуврага ч биш. Зөвхөн гадна байдлаараа хуврага дүртэй, гаднах дүрийг харуулснаар ертөнцийн шуналаас ангижирч чадахгүй.

Сэтгэлээ зөв төвлөрүүлж, ухаанаа Гэгээрүүлж, ертөнцийн шуналаас ангижирч чадаж байгаа хүн л Гэгээрэх замаар явж байгаа жинхэнэ хуврага хүн болно. Хэрэв хүн цус нь хатаж яс нь үйрсэн ч биеэ хайрлахгүй сахил хүртсэнийхээ хэргийг гүйцээх аваас үйл явдал нь ариун цагаан, зорилгодоо хүрэх нь дамжиггүй.

5. Хуврага хүн Бурханы сургаалыг номлох ёстой. Бүх хүмүүст сургаалийг айлдах ёстой. Унтаж буй нэгнийг сэрээж, сэтгэл нь хиртсэн хүнийг ариутган, амь биеийг үл хайрлан сургаалыг газар сайгүй дэлгэрүүлэх ёстой,



Номыг айлдагчид Бурханы хувцасыг өмсөн, Бурханы суудалд сууж, Бурханы өрөөнд орох хэрэгтэй. Үүнд: Бурханы хувцасыг өмсөнө гэдэг нь зөөлөн, тэвчээртэй байх утга. Бурханы суудал дээр сууна гэдэг нь бүх юм бодис өөрийн гэх биегүй, түүнд дурлах татагдах юм үгүй гэсэн үг. Бурханы өрөөнд орно гэдэг нь бүх хүмүүст агуу их энэрэн нигүүлсэхүй сэтгэлээр хандана гэсэн үг.

6. Энэ сургаалыг айлдахыг хүсэгчид дараахи дөрвөн зүйлд онцгой анхаарал хандуулах ёстой.
 1. Өөрийн явдал үйл
 2. Хүмүүст ойртож, хүнийг сургах үгийг шилж сонгох
 3. Сургах шалтгаан, сургах үйлээ гүйцээх
 4. Агуу их нигүүлсэнгүй сэтгэлийг баримтлах

Нэгдүгээрт: Сургаал айлдагч энэ ертөнцөд туйлын тэвчээртэй амьдрах ёстой. Ширүүн дориун явдлаас ангид, зөөлөн (ямар ч юманд өөрийн гэх бие байхгүй) гэдгийг ойлгодог. Аливаа юм хоосон чанартай гэдгийг ухаарсан, юунд ч дурлаж татагдахгүй байх ёстой. Энэ бүхнийг гүйцээвээс зөв явдалтай болно.

Хоёрдугаарт: Өөрт нь ирж байгаа хүн бүхэнд туйлын анхааралтай хандах ёстой.

Буруу амьдралаар яваа, хөрөнгөтэй хүнээс зайлсхийх хэрэгтэй. Түүнчлэн бүсгүй хүнтэй ойртохгүй байх ёстой. Нам гүм газар сууж сэтгэлийг ариутган, ертөнц дээрх бүх юм үйлийн үр шалтгаан нөхцөлөөс гарч ирдэг гэдгийг ойлгож, хүмүүсийг зэмлэн буруушааж, алдаа дутагдлыг дурдах хэрэггүй аль болох хүндэтгэл үзүүлж байх хэрэгтэй.

Гуравдугаарт: Сэтгэлээ тайвнаар байлгаж, Бурханыг Гэгээрэх замд багш нь болж хөтөлсөн оюун санааг эцгээ гэж

хүндэтгэн хүн бүхнийг агуу их нигүүлсэнгүй сэтгэлээр үзэх хэрэгтэй.

Дөрөвдүгээрт: Бурхан шиг үргэлж нигүүлсэнгүй, энэрэн хайрлахын сэтгэл үүсгэж, Гэгээрэх замыг үл мэдэгч хүмүүст сургаалыг заавал сонгох, сэтгэл гарган энэ хүслээ биелүүлэхийн тулд чадах бүхнээ гүйцээх ёстой.





2. СҮСЭГТНИЙ ЗАМ

1. Бурханы шавь болохын тулд Бурхан, ном, хуврага гурван эрдэнэд итгэх хэрэгтэй гэдгийг дээр тайлбарласан билээ.

Түүнчлэн сүсэгтэн хүн бол Бурхан болон түүний сургаал, хуврагад хөдлөшгүй итгэсэн байх хэрэгтэй. Сүсэгтэн хүн сахил тангаргийг даган биелүүлж байх ёстой. Дараахи таван зүйл сахил тангараг байна.

- Амьтан алахгүй.
- Хулгай хийхгүй.
- Буруу хурьцахгүй.
- Худал хэлэхгүй.
- Архи уухгүй гэсэн.

Гурван эрдэнэд бат итгэж, энэ таван сахилыг чанд сайн мөрдвөл, бусад хүнд сахилыг мөрдөж гурван эрдэнэд итгүүлэх сүсэгтэй замд оруулж чадна. Эхлээд эцэг эх, найз

нөхөр, танилуудынхаа дунд сүсэгтний хүрээг өргөтгөх хэрэгтэй. Тэгвэл тэд тань Бурханы нигүүлсэхүй, энэрэн хайрлах сэтгэлтэй болно. Ертөнцийн хүн гурван эрдэнэд итгэх, сахилыг мөрдөж биелүүлж байгаа нь Гэгээрэхийн тулд гэдгийг үргэлж санах ёстой. Иймээс ертөнцийн хүслийн ертөнцөд амьдарч байгаа боловч хүслээс ангижрахыг чармайх хэрэгтэй.

Сүсэгтэн хүн бол: Эрт орой, хэзээ нэгэн цагт өөрийн эцэг эх, гэр бүлээсээ салах цаг ирнэ гэдгийг, үхэл амьдралын энэ ертөнцийг орхино гэдгийг үргэлж санаж явах хэрэгтэй.

Салж хагацах бүхэнд дурлан татагдаж болохгүй. Харин салах хагацахын зовлонг үзэхгүй. Гэгээрлийн ертөнцийг хүсэх хэрэгтэй.

2. Хэрэв сүсэгтэн Бурханы сургаалыг сонсож, итгэл нь гүнзгийрч байвал энх амгалангийн аз жаргал өөрөө ирэхийг мэдэрнэ. Ийм түвшинд хүрсэн хүн бол бүх юмны гэрэл, баяр баясгаланг харж чадах болно. Ийм сэтгэл бол цэвэр ариун, зөөлөн болж ирнэ. Туйлын тэсвэртэй, амгалан тайван, бусдад зовлон хэзээ ч учруулахгүй, Гурван эрдэнэд сүсэглэж, баяр цэнгэл өөрөө ирж, юм болгонд гэрэл гэгээг олж харах болно.

Аз жаргал сэтгэлд нь аяндаа ургаж, Гэгээрлийн гэрлийг газар сайгүй харах болно. Итгэлийн ачаар Бурхантай нэгдэж, биеэ огт бодохгүй, огт харамсахгүй болно, Энэ ертөнц дээрх гүтгэлэг, ер юунаас ч айхгүй болно. Бурханы оронд төрнө гэдэгт итгэнэ. Үхлээс ч айхгүй. Тэр үнэнд итгэнэ. Сургаалын үнэтэйд итгэнэ. Тиймээс хүмүүсийн өмнө юунд итгэж байгаагаа аймшиггүй ярих болно. Тэдгээрийн сэтгэл нь бүх хүмүүст адилхан нигүүлсэнгүйн сэтгэлээр хандах учиртай. Дуртай, дургүйн ялгаа бодол байхгүй, сэтгэл нь цэвэр ариун, ямагт буянт үйлсийг л бүтээнэ.



Аюултай хэцүү үед ялгаагүй итгэлээ бэхэлж өөрийн дутагдлаас зовж, сургаалыг хүндэтгэн үг хэл, үйл хэрэг нь зөрөхгүй аливаа юмыг Гэгээрлийн нүдээр харж сэтгэл нь уул шиг гуйвалтгүй, Гэгээрлийн замаар урагшлах болно. Ямар ч тохиолдолд хүмүүсийг Бурханы сургаалаар дагуулна. Булингартай энэ ертөнцөд бузартсан хүмүүстэй уулзахаа ч гэсэн тэднийг буянт үйлийн зүг рүү татахыг хичээнэ.

3. Ийм учир хүмүүс юуны урд Бурханы сургаалыг сонсох хүсэлтэй байх хэрэгтэй. Хэрэв хэн нэгэн нь Гэгээрэлд хүрэхийн тулд гал дундуур өнгөрөх хэрэгтэй гэвэл галаас айхгүй бэлэн байх хэрэгтэй.

Энэ ертөнцийн шатаж буй галын дундуур орохдоо Бурханы сургаалыг сонсож авралыг эрэх ёстой. Хэрэв хүн Бурханы сургаалыг дагахыг хүсвэл бүх амьд амьтны төлөө буяны сэтгэлийг барьж хувиа хичээж болохгүй. Хүндэлбэл зохих хүмүүсийг хүндлэх хэрэгтэй. Үйлчлэх ёстой хүмүүст үйлчлэх учиртай. Бүхэнд энэрэн хайрлах сэтгэлээр хандах ёстой. Гэгээрэлд зорьсон хүнд хар амиа хичээх, бачимдаж сандрах зан тохирохгүй. Сургаалыг сонсоод итгэх хэрэгтэй. Бусдад атаархаж болохгүй. Бусдын үгэнд орж төөрөгдөж болохгүй.

Хамгийн гол нь өөрөө үйл явдлыг гүнзгий дүгнэх хэрэгтэй. Бусдын явдлыг бодохгүй Бурханы сургаалд итгэхгүй хүн бол зөвхөн өөрийнхөө тухай боддог. Сэтгэл нь байнга долгилдог. Үзэл нь давчуухан байдаг. Харин Бурханы сургаалд итгэдэг хүн бол энэ бол бүхний төлөө санаа зовох агуу их нигүүлсэнгүй сэтгэл, агуу их мэргэн ухаан гэдэгт итгэж, энэ итгэлээрээ үргэлж уужим тайвуун сэтгэлтэй болдог.

4. Бурханы сургаалыг сонсож байгаа хүн энэ бие мөнх бус, тэр нь зовлонгийн их уурхай, зовлон шаналгаа

хуримтлагдсан гэдгийг мэдэж байдаг. Гэвч энэ биеэ жаргааж цэнгээхийн төлөө бус Гэгээрлийн ухааныг олж авч бусдад туслахын тулд энэ биеийг хамгаалах хэрэгтэй гэдгийг мартаж ёсгүй. Хэрэв биеэ гамнахгүй бол удаан амьдрах боломжгүй. Хэрэв хүн урт насалж чадахгүй бол Бурханы сургаалыг хүртэж бусдад дамжуулж чадахгүй. Хүн голыг хөндлөн гатлах сал онгоцоо хайрлана. Үүнтэй адил Бурханы сургаалыг дагах хүн биеэ хайрлах ёстой.

Бурханы сургаалыг дагах хүн гоё харагдахын тулд хувцасладаггүй, халуун хүйтнээс биеэ нууцаа халхлахын тулд хувцас өмсдөг. Хоол ундыг цэнгэж тамшаалахын тулд бус биеэ тэжээх, Бурханы сургаалыг дагах, түүнийг түгээхийн тулд хэрэглэнэ.

Орон сууцыг ч гэсэн жаргаж цэнгэх эсвэл бусдад эд юмаа гайхуулахын тулд ч биш амралт эдлэхийн үүднээс ашиглах ёстой. Хүн Гэгээрлийн ордонд амьдарч байна. Ордны хана нь түүнийг ертөнцийн шуналаас тусгаарласан, хуурамч сургаалын хур бороо, салхинаас хамгаалж байгаа гэж бодож байх хэрэгтэй. Ийнхүү өөрийн жаргал цэнгэлийн талаар бус, харин Гэгээрэхийн төлөө өөрийн давуу талыг үзүүлэхийн тулд Бурханы сургаалыг хүртэхийн төлөө, бусдад дэлгэрүүлэхийн төлөө бүхнийг зориулах ёстой. Иймээс хүн гэр орондоо, гэр бүлтэйгээ байхдаа ч гэсэн нэг мөч ч гэсэн Бурханы сургаалыг мартаж болохгүй. Тэднийхээ төлөө, тэдний сэтгэлийг сэрээх, хөглөх ямар арга байгааг эрэлхийлж, ухаалаг хайр, энэрлийн сэтгэлээр санаа тавих хэрэгтэй.

5. Бурханы шавь нар дараахи хичээлийг өдөр бүр судалж байх ёстой. Эцэг эхдээ яаж үйлчлэх вэ? Эхнэр, хүүхэдтэйгээ яаж амьдрах вэ? Өөрийгөө яаж хянах вэ? Бурханд яаж үйлчлэх вэ? гэдэгт байнга санаа зовж, тэдэнд тайван байдал, аз жаргалыг өгч байх хэрэгтэй. Эхнэр, хүүхэдтэйгээ байхдаа дурлан татагдахын хүлээснээс



ангижрахыг байнга бодож байх хэрэгтэй. Хөгжим сонсож байхдаа Бурханы сургаалын цэнгэлийг эрж байх ёстой. Өрөө тасалгаанд сууж байхдаа ухаант хүний байдалд хүрэхийг хичээж, бузар бохир явдлаас чөлөөлөгдөхийг үргэлж хүсэх ёстой. Хэн нэгэнд өргөл өгөхдөө ямар нэг юмнаас татгалзаж, шуналаас ангижрахыг үргэлж хүсэх хэрэгтэй. Хүмүүсийн дунд хуралд сууж байхдаа Бурханы чуулганд сууж байгаа мэт бод.

Хэрэв гай тохиолдвол сэтгэл тайван байгаасай гэж залбирах хэрэгтэй. Бурханы авралд багтаж болох бүхэнд зөв замыг хайх хэрэгтэй. Бурханы авралд багтах үед түүний далай шиг мэргэн ухааныг гуйх хэрэгтэй. Бурханы хуврагийн авралд багтах үед бүх гай бузарыг арилгаж, зайлуулахыг залбирах хэрэгтэй.

Номхон даруухан хувцас өмсөхөө мартаж болохгүй. Их, бага хэрэгцээг залгахдаа уур, мунхаг, шуналаас зайлсхийх хэрэгтэй. Уулын дээш өгсөх замыг харахдаа ертөнцийн эндүүрлээс гарах дээд замаар өгсөхийг хүсэх хэрэгтэй. Доошоо уруудсан замыг харахдаа Бурханы сургаалын гүнийг мэдэх юмсан гэж бодох хэрэгтэй. Гүүр хараад хүмүүст Бурханы сургаалын гүүр босгох юмсан гэж бодох ёстой.

Уй гашуу болсон хүнийг хараад үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг ертөнцийн мөнх бусад гэмших ёстой. Шуналд автсан хүнийг хараад хуурамч амьдралаас ангижирч Гэгээрэлд хүрэхийг хүсэх хэрэгтэй. Амтат хоолыг хүртэж байх үедээ дурлалаас чөлөөлөгдөж хүслийг багасгахыг хүсч хэр тааруухан идэх хэмжээг эрхэмлэх ёстой. Зуны тэсэшгүй халуунд ертөнцийн шуналын халуунаас ангижирч Гэгээрлийн сэрүүнийг хүсэх хэрэгтэй. Өвлийн тэсэшгүй хүйтэнд агуу их нигүүлсэнгүй халууныг хүсэх хэрэгтэй.

Залбирлыг уншиж байхад Бурханы сургаалыг үйл явцдаа ёсчлон биелүүлэхийг үл мартахыг хүсэх ёстой. Шөнө унтаж

байхдаа сэтгэлээ ариутгаж бие хэл сэтгэлийн амгаланг хүсэх хэрэгтэй.

Сэрэхдээ орчин тойрныг бүгдийг нэвт мэдэрч, ухаан сэтгэл нь өдрийн турш ариун цэлмэг, бүх юмыг ойлгохыг хүсэх ёстой.

6. Бурханы сургаалд итгэгчид юмыг жинхэнэ байгаа байдлаар нь хардаг. Аливаа юм өөрийн гэх биегүй өөрөөр хэлбэл юм бүхэн хоосон чанартай гэсэн, ертөнцийн онолыг мэддэг. Ертөнцийн ажил хүний бусад үйл ажлыг болгоомжлохгүй, харин түүнийг Гэгээрэх замд ажигладаг. Хүний ертөнцөд эндүүрэл, төөрөгдөл дүүрэн учир бүх юм утгагүй гэж болдоггүй. Энэ ертөнцөд байгаа бүх юманд Гэгээрэх замыг эрдэг. Хэрэв ертөнцийг бүдүүлэг, мунхаг харанхуй нүдээр харвал гажиг, утгагүй харагдана. Саруул ухаанаар харвал Гэгээрлийн ертөнц болно. Энэ ертөнцөд утгагүй юм гэж байхгүй, утгатай юм ч гэж байхгүй. Сайн юм гэж байхгүй, муу юм гэж бас байхгүй. Өөрөөр хэлбэл нэг нь утгагүй, нөгөө нь утга төгөлдөр, нэг нь сайн, нөгөө нь муу хоёрт ертөнц биш ганц л дэлхий байна.

Хүмүүс зөвхөн сэтгэлээрээ сайн, муу гэж хувааж бодож байна. Энэ ялгаатай үзлээсээ ангижирч чадах юм бол сэтгэлээ мэргэн ухаанаар ариутгаваас бүх юм утга төгөлдөр ганцхан ертөнц байгааг олж харна.

7. Бурханы сургаалд итгэж байгаа хүн бол Бурханд өөрт нь итгэнэ. Итгэсэн сэтгэлээрээ ертөнц дээрх бүх юманд ариун нандин чанар оршсон гэж бодож өөрийн тухай бодохгүйгээр бусдад туслахын тулд зүтгэнэ. Бурханы сургаалд итгэсэн хүн бол тэр дагуу бусдад үйлчилдэг. Бүхнийг өөр нүдээр, өөр дээрээ бүхнийг тээж байгаа дэлхий шиг агуу сэтгэлтэй, ямар ч зовлонг туулахад



бэлэн, залхуурдаггүй байх боломжийг хүртдэг. Бурханы сургаалын үрийг тарьж ядуу хүмүүст буян үйлдэхэд бэлэн байдаг. Тэгэхээр энэ сэтгэл бол ядуу хүмүүсийг энэрэн хайрлаж, бүх хүмүүсийг зөв замд залруулахын тулд эхийн адил хайрлаж, агуу багш нарын адил хичээнгүйлэн зүтгэх мэт хайрлах ёстой. Ийм учраас Бурханы сургаалд итгэсэн хүнийг үзэн ядах, хорлохыг санаархах нь их далайд дусал хор хийсэнтэй адил.

8. Бурханы сургаалд итгэгч хүн өөрийн жаргалын тухай бодохдоо: Бурханд итгэсэн түүний итгэл нь Бурханы өөрийн нь өршөөл Бурханы итгэлээр бүтэж байгаа гэдгийг ойлгодог, Ертөнцийн шуналын шаварт Бурханы сургаалд итгэх үргүй боловч Бурханы өршөөлөөр энэ шаварт итгэлийн үр таригдаж түүнээс Бурханыг итгэх сэтгэл төрдөг.

Хортой Эранда мод ургадаг ширэнгэд анхилам зандан тарьж болохгүй. Түүний адил ертөнцийн шунал оволзон байгаа цээжинд Бурханы итгэлийн үр ургах аргагүй. Гэвч ертөнцийн шуналт цээжинд цэцэг цэцэг-лэнэ. Энэ цэцэгний үндэс нь энэ хүний цээжинд эндүүрэл төөрөгдөлд бус харин Бурханы цээжинд байна гэж ухаарах хэрэгтэй. Бурханд итгэсэн хүн өөрийнхөө тухай бодож эхэлбэл уур, мунхаг, шуналын харцаар бусдад атаархаж, үзэн ядах, тэднийг хорлохыг оролдоно.

Харин Бурханы авралыг эрж байгаа хүн бол дээр дурдсан Бурханы агуу их үйлийг хийх болно. Энэ бол үнэнхүү жинхэнэ гайхамшиг мөн.

АМЬДРАХ ҮНЭН ЗАМЫН БОДИТ ЧИГ ХОЁРДУГААР БҮЛЭГ



1. ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛ

1. Гай гамшиг өөрийн сэтгэлээс урган гардагийг үл ухааран гаднаас, баруун, зүүнээс гарч ирлээ хэмээн бодох нь буруу хэрэг.

Ингэхлээр сэтгэлээ хяналгүй орхиж, гаднаас ирсэн гай гамшигийг зогсооно гэдэг тэнэг хэрэг болой. Эрт цагаас эдүгээ хүртэл энгийн хүмүүний мөрдөж буй өглөө эрт босч, гар нүүрээ угааж, амаа зайлаад баруун зүүн, умар, өмнө, дээш, доош зургаан зүгээс гай гамшиг ирэхгүй байхыг залбирч, энх амгалан энэ өдөр ирэхийг сүсэглэх нэгэн заншил байдаг.

Бурханы сургаалд энэ нь өөр байна. Бурхан болбоос бид үнэний зургаан чигт бишрэн залбирч, бие сэтгэлээ мэргэн зөв удирдсанаар бүхий л гай гамшигийг сэргийлнэ хэмээн сургадаг.

Хүмүүс энэ зургаан чигийг гаргахын тулд дөрвөн



нүглийн гэмийг зайлууж дөрвөн хорт сэтгэлийг хянаж, баялгийг гээх шалтгаан болсон зургаан үүдээ бөглөх хэрэгтэй.

Дөрвөн нүгэл хэмээх нь: Амьтныг алах, хулгай хийх, буруу хурьцах, худал хэлэх болой. Дөрвөн хорт сэтгэл гэдэг нь: Шунал, уур, мунхаг, айдас дөрөв болой. Баялгийг гээх шалтгаан болсон зургаан үүд хэмээх нь: Архинд донтож дэмийрэх, шөнө дөл өнгөртөл зугаацан сэлгүүцэх, хөнгөмсөг зан, хөгжим цэнгээнд хэт дурлах, хорт муу хүнтэй нөхөрлөн мөрийтэй тоглох, үүрэг хариуцлагаа хайхрахгүй байх зэрэг болой. Тэр дөрвөн нүглийг зайлуулж сэтгэлийн дөрвөн хороос зугатаалган, үзэгдэх гээхийн зургаан үүдийг таглах аваас Бурханы сургаал нь үнэний зургаан чигт гүнээ бишрэн хүндэтгэл үзүүлэх болно. Одоо үнэний зургаан чиг гэдэг маань чухам юуг хэлээд байгааг тодруулья. Эцэг эх, хүүхдийн зүүн зүг, багшийн өмнө зүг, эр эмийн баруун зүг, эр хүн түүний нөхрийн хойд зүг, эзэн зарцын доод зүг, бурханы сургаалын замын дээд зүг болой.

Хүүхэд эцэг эхээ хүндэлж, тэдний төлөө чадах бүхнээ хийнэ. Тэд эцэг эхдээ үйлчилж ажил хөдөлмөрт нь туслана, удам судраа дээдлэнэ, гэрийн эд хогшлыг хамгаална. Эцэг эхээ насан өөд болоход хойд ажлыг гүйцэтгэнэ.

Тэгвэл эцэг эхчүүд хүүхэддээ зориулж доорх таван зүйлийг хийх ёстой. Хорт муу үйлээс сэргийлэх сайн үйлийн үлгэр жишээг үзүүлэх, боловсрол олгох, гэрлэлтийг нь зохицуулах, зохих ёсоор гэр бүлийн эд хөрөнгийг өвлүүлэх зэрэг болно. Хэрэв эцэг эх хүүхдүүдийн эл ёс журмыг дагах аваас өрх гэртээ үргэлж амгалан тайвнаар амьдрах болно. Шавь бол багшийг морилон ирэхэд босч, өгсөн даалгаврыг нь туйлын хичээнгүй гүйцэд биелүүлж сургаал айлдварыг бишрэн сонсох учиртай. Багш нь бас шавьдаа зөв явдлыг үзүүлж, сайн сайхны жишээг тод харуулах ёстой. Багш нь сурсан эрдмээ шавьдаа үлдээлгүй дамжуулж, аргын дээдийг

ашиглан ашиглан нэр төртэй шавь бэлтгэхийг мэрийн, буянд шамдах замыг удирдана. Шавийгаа бололцоотой бүхий л аргаар хорт явдлаас сэргийлэх ёстой гэдгийг мартах учиргүй Хэрэв багш шавь хоёр энэ ёсыг дагах аваас тэдний холбоо барилдлага нь ямар ч саадгүй улам гүнзгийрэн урагшлах болно.

Эр нөхөр нь эхнэрээ хүндэлж маш халамжтай, эелдэг харилцах ёстой. Гэр зуурын хэргийг эхнэрт мэдүүлж хэрэгцээт юмсаар нь хангаж байх үүрэгтэй. Эхнэр нь ч бас гэр орныхоо ажилд санаа тавьж гэрийн ажилчдаа ухаалаг зарж, буян заяагаа сайн гэргийн ёсоор дэлгэрүүлж байвал зохино. Эр нөхрийн олзыг дэмий үрэлгүй, эд хогшлоо бас зөв арчлан аривжуулах ёстой. Энэ журмыг ёсчлон дагаваас хэрүүл маргаангүй гэр бүл байх нь дамжиггүй.

Нөхөрлөлийн ёс гэдэг нь харилцан бие биеэ ойлголцож, нэг нь нөгөөдөө юу дутагдаж байгаагаар нь туслаж, аль болох нэгэндээ тус үзүүлэхийг оролдох, найртай чин сэтгэлээр харилцах ёстой.

Нөхрөө буруу замд халтиран орохоос сэргийлж, нэгнийхээ эд хөрөнгийг хамгаалж, хэцүү бэрх үед нь туслах ёстой. Золгүй явдал тохиолдоход нь өгөөмөр гар сунгаж, шаардлага гарвал гэр бүлийг нь ч тэтгэн дэмжих учиртай. Ингэх аваас нөхөрлөл улам зузаарч хоёулаа улам улам аз завшаантай, сэтгэл хангалуун амьдрах болно.

Эзэн зарцтайгаа харилцахдаа доорх таван зүйлийг мөрдөх ёстой. Эзэн зарцын чадварт тохирох үйлийг хариуцуулж, түүнд зөв зохицуулалт хийх, өвчтэй зовлонтой үед нь санаа тавьж, баярт үйл явдлыг нь хуваалцан, зохих ёсоор нь амрааж байх хэрэгтэй. Зарц ч бас дараахи таван зүйлийг ёсчлон биелүүлэх үүрэгтэй. Өглөө эзнээ дээшлэхээс өмнө босч, нойрссоных нь дараа унтаж, үргэлж үнэнч шударга, даалгасан ажлыг өөдтэй бүтээхийн төлөө чармайж, эзнийхээ нэрийг сэвтээхгүйн төлөө хүчээ дайчлах ёстой. Хэрэв энэ



ёсыг мөрдөх аваас эзэн зарц хоёрын хооронд маргаан үгүй амгалан тайван оршиж, зөрчилгүй амьдрах болно.

Бурханы шавь нь түүний гэр бүлийнхэн Бурханы номлолыг хэрхэн ёсчлон биелүүлж буйг үргэлж анхаарах ёстой.

Тэд Бурханы сургаалын багш нарт хүндэтгэлтэйгээр хандаж, үргэлж тахил мандал өргөж, түүний сургаалыг ёсчлон биелүүлж байх ёстой. Бурхан багшийн сургаалын багш нь сургаалыг зөв ойлгож, буруу тайлбарыг няцааж, сайн үйлийг онцолж, сүсэгтнийг зөв замд хөтлөхийг эрмэлзэнэ. Өрх гэр энэ замыг баримталбаас үнэн сургаалыг зүрхэнд хадгалан, аз жаргал улам дэлгэрэх болой. Энэ зургаан чигт шүтсэн хүн бол гадна талын гай гамшигаас зайлсхийх гэж оролдохын хэрэггүй, санасан зүйл нь аяндаа бүтнэ.

2. Хүн бол хэнтэй нөхөрлөж болох, хэнтэй нөхөрлөж эс болохыг сайтар тунгаан ялгаж нөхрөө таних ёстой. Шуналтай, хуурамч, уран үгтэй, бялдууч, үрэлгэн хүмүүстэй нөхөрлөх хэрэггүй.

Хүнд хэцүү үед чинь тус болж чадах хүнтэй нөхөрлөх хэрэгтэй. Нөхрийн зовлонг хуваалцахад бэлэн, ашигтай зөвлөгөө өгч чаддаг, өрөвч энэрэнгүй сэтгэлтэй хүнтэй нөхөрлөх ёстой. Өөрт чинь түшиг болох, өөрийн чинь төлөө сэтгэл нь зовж чадах, хэрэгтэй үед нь нөхрийнхөө төлөөнөө өөрийгөө зориулж чадах хүнтэй нөхөрлөж, тийм хүнд мөн хариу тийм сэтгэлээр үйлчлэх ёстой.

Ийм нөхрийг олох хямдгүй. Өөрөө ийм хүн болохын төлөө чармайх ёстой. Сайн хүн сайн үйлээр бусад хүнд наран гэрэлтүүлэх мэт нөлөөлнө.

3. Эцэг эхийн ачийг юугаар ч хариулах боломжгүй. Эцэг эхээ мөрөн дээрээ суулгаад зуун жил явсан ч биеийг нь анхилуун тосоор илж, ертөнцийн бүхий л баялгийг өгч, алдрын титэм өмсгөвч хариулах аргагүй билээ. Харин тэднийгээ Бурханы сургаалд итгүүлж, ямар нэг шунал хүслээс нь татгалзуулж, буруу замыг орхиулан, зөв замыг мэдүүлэх аваас агуу их ачыг нь хариулах болно. Энэ нь ачыг нь хариулснаас ч илүү ач болой. Хүүхдүүд нь эцэг эхээ хүндлэн хайрлаж байгаа гэрт амьд Бурхан заларч байдаг.

4. Гэр бүл гэдэг нь сэтгэл, ухаанаараа харилцан сүлэлдэж байдаг орчин юм. Иймээс гэр бүл эвтэй найртай, бие биеэ хүндлэн, ойлголцож чаддаг байвал өнгө алаглаж, таатай үнэр анхилуулсан цэцгийн мандал шиг үзэсгэлэнтэй сайхан байдаг. Харин сэтгэлийн эв эвдэрвэл гэр бүл сарниж сүйднэ. Ийм нөхцөлд бусдыг зэмлэн буруутгалгүй өөрийн сэтгэлийг засч зөв замаар явах ёстой.

5. Эрт цагт эцэг нь нас барж, эхийнхээ хамт амьдардаг сүсэг бишрэлтэй нэгэн залуу байв. Удалгүй хүү нь гэрлэн гурвуулаа болж, бүх юм аятай тохитой, жаргалтай байлаа. Гэтэл нэгэн удаа хадам эх, бэр хоёрын хооронд ялимгүй маргаан гарч хэрүүл тэмцэл тасрахгүй болсонд эх нь гэрээ орхин явахад хүрчээ. Эхийг явснаас хойш бэр нь хүүхэд төрүүлж, “Хадам эх намайг гомдоосон учир хамт байх үед бидэнд хүүхэд заяагаагүй. Харин түүнийг явснаас хойш Бурхан бидэнд үр хүүхэд заяалаа” хэмээн бусдад ярьсан нь сонсдож ядарсан хөөрхий эхийг улам ихээр гомдоон шаналуулжээ.



Эх:

– “Энэ ертөнц дээр шударга юм гэж нэг ч алга. Хадам эхээ гэрээс нь хөөсөн бэрд Бурхан үр хүүхэд заяадаг юм бол шударга ёс гэдэг чинь толгой нь эргэсэн зүйл байдаг байх нь ээ! Ийн шударга ёсыг булшлах хэрэгтэй” гэж галзуурсан мэт хашгиран оршуулгын газар руу гүйв. Бурхан үүнийг мэдээд түүний өмнө зогсон сэнхрүүлэх гэсэн авч тус болсонгүй.

Тэгэхэд нь Бурхан:

– “За яахав, чиний тэр үзэн ядаж байгаа бэрийг чинь ачийн чинь хамт шатаагаад өгвөл чи баярлах юм шив дээ?” гэв. Бурханы энэ үгнээс хөөрхий эх сэхээ авч буруугаа ойлгон нүглээ наминчилж, бэр ач хоёроо тийм хатуугаар цээрлүүлэхгүй байхыг Бурханаас гуйжээ. Хүү бэр хоёр нь өөрсдийн будилж эндүүрэн, эхээ гомдоосноо тэр мөчид ойлгон эхийнхээ хойноос явж, оршуулгын газраас эргэн ирж байгаа эхтэйгээ тааралдан, Бурхан хадам эх, бэр хоёрыг эвлэрүүлж, тэр гэр бүл дахин амгалан жаргалтай болсон гэдэг.

Шударга ёсноос гажихгүй байвал сургаал гэдэг мөнх оршино. Сургаал номлол ямар үед алга болж байна вэ? Гэвэл хүн үүнийг гэсэн, умартсанаас болдог. Сэтгэл санаа зөрөлдөн нийлэмжгүй байх, ялимгүй ч гэсэн хэрүүл маргаантай байх нь гэр бүлд гай гамшиг, уйтгар гуниг авчирдаг тул үүнээс ямагт болгоомжилж байх хэрэгтэй.

6. Гэр бүлээ оршин тогтноулахын тулд хүн шоргоолж шиг, эсвэл ажилчин зөгий шиг хөдөлмөрлөх ёстой. Бусдад найдаж, ямар нэг хишиг харамж горьдох хэрэггүй.

Хөдөлмөрлөж олсон хөлсөө ганцхан өөртөө зориулж үл болно. Олсон хөрөнгийн нэг хэсгийг бусадтайгаа хуваах ёстой. Нэг хэсгийг нь өөрийн гэр бүлийн амьдралд, нэг

хэсгийг чухал шаардлагатай, яаралтай үед хэрэглэхээр тооцож нөөцлөх, нэг хэсгийг нийгэм болоод үндэстний хэрэгцээнд (албан татвар), зарим хэсгийг ариун номын багш нартаа өргөхөд зориулах ёстой.

Энэ ертөнц дээр ямар ч юманд “минийх” гэх ойлголт үгүй гэдгийг ухаарвал зохино. Хүнд тохиолдож, ирж байгаа аливаа юм үйлийн үрийн улмаас ирдэг. Тэдгээр юм хүнд зөвхөн түр зуур л байна. Иймээс юмыг хувиа хичээсэн, олиггүй зорилгоор ашиглаж үл болно.

7. Удояна хааны хатан Сямавати Анандад таван зуун хувцас сэлтийг өргөл болгон илгээжээ. Ананд үүнийг баясан хүлээж авсныг хаан сонсоод: Анандыг нэр төргүй хэрэг үйлдэж байна уу даа хэмээн бодож Ананд руу очиж эдгээрээр чухам юу хийх гэж байгааг нь асуув.

Ананд: – “Хаантан минь ээ! Олон лам хуврагууд минь уранхай ноорхой хувцас эгэлдрэглэж явна. Би тэдэндээ тарааж өгнө.

- Тэдний хуучин хувцасыг тэгэхээр яах вэ?
- Орны бүтээлэг хийж болно.
- Орны бүтээлэг чинь элэгдэхээр яах вэ?
- Алчуур хийнэ.
- Алчуур чинь элэгдэхээр яах вэ?
- Шалан дээрээ дэвсэнэ.
- Тэр чинь элэгдэхээр яах вэ?
- Гутлын алчуур хийнэ.
- Гутлын алчуур чинь элэгдэхээр яах вэ?
- Шалны алчуур хийнэ.
- Шалны алчуур чинь элэгдэхээр яах вэ?
- Дээдийн хаан минь ээ! Бид үүнийг жижиглэн шавартай



хольж байшингийнхаа ханыг таглаж шавардана. Бидний гарт орж ирж буй юмыг туйлын хямгатай ашиглах ёстой. Учир нь эдгээр юмс бидэнд түр зуур хэрэглэгдэх болохоос биш, бидний өмчийн мөнхийн юмс гэж үгүй билээ” хэмээн хариулсан гэдэг.



2. БҮСГҮЙ ХҮНИЙ АМЬДРАЛ

1. Эмэгтэй хүн дөрвөн янз байдаг.

1-рт: Ялимгүй шалтгаанаас уурладаг, олон зантай. Бусдын аз жаргалд атаархуу, шуналтай, харамч, өглөг буян хийдэггүй.

2-рт: Ялихгүй зүйлд үе үе уурладаг, олон зантай, хэрцгий ширүүн, гэвч бусдын аз жаргалд атаархдаггүй, өргөл барьц үйлддэг.

3-рт: Аажуу тайвуу ухаантай, тэр болгон уурладаггүй, шуналт сэтгэлийг яаж дарах вэ? гэдгийг мэддэг, гэвч атаархах сэтгэлээс зайлсхийх чадваргүй, өглөг буян хийдэггүй.

4-рт: Уужим тэнүүн сэтгэлтэй, шуналын сэтгэлийг тэвчиж чаддаг, сэтгэл санаагаа тайван эзэмдэж захирдаг, уурлаж уцаарладаггүй, бусдад хэрэгтэй үед нь сэтгэл гарган тусалдаг, өглөг буян үйлддэг эдгээр болой.



2. Залуу бүсгүй гэрлэхдээ дараахи зүйлийг мартаж үл болно. “Би нөхрийнхөө эцэг эхийг гүнээ хүндэтгэн, тэдэнд үйлчлэх ёстой.

Бидний сайн сайхны төлөө үргэлж санаа тавьж явдаг, бидний мэргэн хамгаалагчид учраас тэдний ач тусыг санан, хэзээ ч гэсэн хэрэгтэй үед нь үргэлж туслаж, халамжлах ёстой.

Би нөхрийнхөө багшийг хүндэтгэх ёстой. Миний нөхөрт нандин сургаалаа хайрласан, тэр сургаалын ачаар бид хүний ёсоор амьдарч буйн учир би багштаны нь өмнө гүнээ мэхийн хүндлэх ёстой. Учир нь хүн оюун санааны багш үгүйгээр амьдрана гэдэг хэцүү.

Нөхрийн ажлыг ойлгож түүнд туслахын тулд эхнэр нь өөрөө суралцаж боловсрох ёстой. Нөхрийн ажил үйлсэд хөндлөнгийн хүн шиг хайхрамжгүй хандаж хэрхэвч болохгүй.

Би нөхрийн ажил хэрэгт оролцож буй болон түүнд захирагдаж буй хүмүүсийн зан авир, авьяас чадвар, дур сонирхол зэргийг чадлын хэрээр мэдэхийг хичээнэ. Тэдэнд аль болох эелдэг зөөлөн сайн санаагаар хандах болно.

Би нөхрийн олсон орлогыг хайрлан хамгаалж хямгатай зарцуулна. Зөвхөн өөрийн хувиа хичээсэн ямар ч зорилгоор үрэхгүй.

3. Эхнэр, нөхрийн харилцаа гэдэг бол зөвхөн нэг гэрт тав тухтай, тохилог амьдрахыг л хэлэх бус, харин ч оюун санааны нандин сургаалаар бие биеийнхээ сэтгэлийг ариутган Гэгээрүүлдэг байх ёстой.

“Жаргалтай хосууд” гэж нэрлэгдсэн хоёр настан буурал Бурхангай учирч ингэж учирлажээ. “Бид хар бага наснаасаа танилцан дасч, гэрлээд өдий насыг наслахад бидний аз

жаргалд ямар нэг толбо байсангүй, хойд төрөлдөө бид дахин гэрлэж болох болов уу? болгоож айлдана уу?” гэжээ.

Бурхан тэдэнд “Хэрэв та хоёр яг адил сүсэг бишрэлтэй, Бурханы сургаалыг яг адилхан тусгаж авдаг, өглөг хишиг харамгүй түгээдэг, мөн мэргэн ухаан тань бас яг адил аваас хойд төрөлдөө мөн нэгэн сэтгэлтэй нэг хүн мэт цуг төрөх нь дамжиггүй” хэмээн айлджээ.

4. Баян худалдаачин Анатапиндадагийн ууган хүүгийн залуу эхнэр Сужата гэгч сэхүүн дээрэлхүү зантай, бусдыг хүндэлдэггүй, хадам болоод нөхрийн үг сургаалыг үл ойшоогч нэгэн байснаас гэр бүл хэрүүл маргаанаар тасардаггүй байжээ.

Нэгэн өдөр Бурхан Анатапиндадагийн зочлон очоод тэр айл ямар байдалтай байгааг мэджээ. Тэрээр залуу эхнэрийг өөр рүүгээ дуудаж дараах зүйлийг тун эелдэгээр айлдаж сэнхрүүлжээ. “Сужата! Эхнэр хүн долоон янз байна.

1-рт: Урвагч шиг эхнэрүүд байна. Тэр бол ариун бус сэтгэлтэй, эр нөхрөө хүндэлж хайрладаггүй, өөр бусдад сэтгэл нь урвадаг.

2-рт: Хулгайчтай адил эхнэр байна. Тэрээр хэзээ ч нөхрийн хүчийг ойшоохгүй. Зөвхөн өөрийн тансаг амьдралын хүсэлд л хөтлөгдөнө. Нөхрийн орлогыг өөрийн дур сонирхолоо хангахын тулд түүнээс хулгайлан үрж сүйтгэдэг.

3-рт: Эзэн шиг эхнэр байна. Тэрээр нөхрөө үргэлж эсэргүүцэн гэр орны ажлыг үл хайхран, нөхрийг хатуу ширүүн үгээр доромжлон шийтгэж байдаг. Хүмүүстэй бүдүүлэг харилцдаг.

4-рт: Ээж шиг эхнэр байна. Тэд хүүхдийнхээ төлөө эх нь санаа тавьдаг шиг нөхрийн төлөө үргэлж санаа тавьдаг.



Түүнийг эх нь үрээ элбэрдгийн адил хайрлан хамгаалдаг. Орлого олзыг нь туйлын хямгатай зарцуулна.

5-рт: Эгч шиг эхнэр байдаг. Энэ хүн туйлын даруу төлөв, ухаалаг, болгоомжтой харилцдаг.

6-рт: Анд нөхөр шиг эхнэр буй. Тэр алс газар өнө удаан хугацаагаар одоод дөнгөж эргэн ирж уулзаж буй нөхөр мэт. Тэр их даруу. Нөхрийн сэтгэлийг таатай байлгахыг ямагт чармайна. Биеэ зөв авч явж нөхрөө туйлын ихээр хүндэлдэг.

7-рт: Шивэгчин шиг эхнэр байна. Тэр хүн нөхөртөө туйлын нямбай, туйлын үнэнч шударга, нөхрийг хүндэлнэ. Хэлснийг нь үг дуугүй биелүүлнэ. Түүнд өөрийнх нь төлөө хүсэл гэж огт үгүй. Муу сэтгэл ч үгүй. Зөвхөн нөхрөө л аз жаргалтай байлгахын төлөө чармайна.

Тэгээд Бурхан: – Сужата! Та чухам хэнтэй нь адил байна? Эсвэл хэн нэгэнтэй нь адил болохыг хүсч байна уу? хэмээв.

Бурханы айлдсаныг сонсоод тэрээр өнгөрсөн олхиогүй явдлаасаа туйлын их ичин зовж, шивэгчин янзын эхнэр болохыг хүснэ хэмээн хариулжээ. Гэмт явдлаа засч ханийнхаа үнэнч туслагч нь болон улмаар хамтдаа Гэгээрэх замын эрэлд гарчээ.

5. Амрапали гэгч Вайсалийн нэртэй баян янхан байжээ. Тэр олон сайхан залуу үзэсгэлэнтэй эмстэй хамт Бурханаас ариун сургаал хайрлахыг хүсчээ. Бурхан айлдсан нь: Амрапали! Бүсгүй хүний сэтгэл гэдэг бол тун эмзэг, амархан хиртэж гутдаг, хүсвэл шуналд эр хүнээс хялбархан татагддаг. Ийм учираас гэгээн замыг дагахад эмэгтэй хүнд илүү хэцүү. Энэ нь ялангуяа залуу үзэсгэлэнтэй хүнд туйлын үнэн болох нь харагдана.

Шунал, хүсэл, тачаалыг тэвчин дарж, ариун замын зүгт алхам хийх хэрэгтэй. Амрапали! Залуу нас, үзэсгэлэн гоо гэдэг бол удаан үргэлжлэхгүй, өвчин зовлон, өтөл насаар солигдоно гэдгийг санагтун! Эд баялгийг олж авах хүсэл, хайр сэтгэл хэмээх нь бүсгүй хүний татагдах хүсэл авч тэдгээр нь насгүй бөгөөд мөнхийн эрдэнэ биш. Гагцхүү Гэгээрэх гэдэг бол үнэ цэнээ үл алдах мөнхийн эрдэнэ болой.

Хүн хүч чадалтай ч өвчин эмгэгт нэрвэгдэнэ. Өсөх нас өтөл насаар солигдоно. Амьдрал үхлээр солигдоно. Хүн хайртай хүнээсээ хагацаж, үзэн ядсан нэгтэйгээ амьдрах тохиолдол бий. Чухам уулзахгүй гэсэн хүнтэйгээ 3 уулзана, унахгүй гэсэн морио 3 унана гэдэг үгтэй адил. Удаан хүлээж хүссэн юм санаснаар болохгүй. Энэ бол амьдралын хууль. Хүнийг ивээн тэтгэж, мөнхийн амгаланд хөтлөх цорын ганц зам болбоос Гэгээрэл мөн. Амрапали! Та энэ мөчөөс эхлэн Гэгээрэх замыг эрэгтүн! гэжээ. Амрапали ч Бурханы сургаалыг даган Бурханы шавь болохоор шийдэн, үзэсгэлэнт сайхан цэцэрлэгээ Бурханы үйлсэд хандивлажээ.

6. Гэгээрэлд хүрэх замд хүйс, бэлгийн ялгаа гэж байхгүй. Хэрвээ бүсгүй хүн сэтгэлээ Гэгээрүүлбээс тэрбээр үнэн мөн замын баатар болох болой.

Парасенажи хааны охин Айодхи хааны хатан Малилика бол ийм баатруудын жишээ байлаа. Тэд нар Бурханы сургаалд агуу их замыг туулан хүрч, Бурханы дэргэд дараах арван сахилыг сахижээ.

- ② Бурхан минь! Гэгээрэх замыг олтлоо би нандин сахилыг зөрчихгүй.
- ② Надаас нас ах хүмүүсийн өмнө би омог бардам зан гаргахгүй.



- ② Би хэнд ч уурлахгүй, би бусдад болон тэдний хөрөнгөнд үл атаархана.
- ② Би сэтгэлээрээ ч, эд юмсаар ч хувиа хичээхгүй. Надад буй зүйлсээр ядуу хүмүүсийг баярлуулж байхыг чармайна. Юмсыг өөрт зориулж хураахгүй.
- ② Би бүх хүмүүстэй эелдэг харилцана. Тэдэнд шаардагдах зүйлийг өгч, эвийг хичээж, өөрийн бус тэдний амьдарч буй орчныг харж үзнэ. Тэдэнд сэтгэл хоёрдолгүйгээр тус дэм үзүүлэхийг чармайна.
- ② Би хүнийг ганцаардмал байх, шоронд байх, өвчнөөр юмуу бусад зовлонгоор шаналж байхыг харваас, түүнийг хөнгөвчилж тэднийг аз жаргалтай байлгахын төлөө чармайна. Ингэхдээ шалтгаан жамын хууль (үйлийн үр)-ийг тайлбарлан таниулахыг хичээнэ.
- ② Хэрвээ би бусад хүмүүс ямар нэг амьд амьтныг тамлан зовоож байхыг харваас тэднийг шийтгэвэл зохих ёсны дагуу шийтгэж, юмыг ойлгох болтол нь сургана.
- ② Аливаа үйл явдалд тэд чухам юу хийснийг нь тэдний алдааг зөвөөр ойлгуулахын тулд би чадах бүхнээ хийнэ.
- ② Зөв сургаалыг сонсохоо би мартажгүй. Хэрвээ хүн зөв сургаалд хайхрамжгүй хандваас үнэний замаас түргэн хальтирч, Гэгээрлийн эрэгт хүрэхийн даваан дээрээс гулсдаг билээ.
- ② Ядуу хүмүүсийг аврахын тулд тавих гурван зорилт хэмээвээс
 - а) Би бүх хүмүүсийг амгалан тайван амьдруулахыг чармайна. Энэ хүсэл ирээдүйд миний олж авах ямар ч төрөлд сайн сайхны буяны үндсэн шалтгаан болж тэр нь зөв сургаалын мэргэн ухаан болно гэдэгт итгэнэ.
 - б) Сайн сургаалын мэргэн ухааныг хүртсэнээр бүх хүмүүсийг цуцалтгүй сургана.

в) Би зөв сургаалыг өөрийн амьд бие, амьдрал, хөрөнгөөр дэнчин тавьж хамгаалах болно. Гэр бүлийн амьдралын үнэн утга учир бол харилцан бие биендээ урам өгч, Гэгээрэх замыг хамтдаа зорих явдал болой. Хамгийн эгэл бүсгүй хүн ч гэсэн Гэгээрэх замыг эрэх тийм сэтгэлтэй аваас дээрхтэй адил сахил журмыг гүйцэтгэвээс дээр өгүүлсэн Малиликатай адил Бурханы агуу их шавь болох нь дамжиггүй.





3. УДИРДАН ЖОЛООДОХ

1. Улс орныг цэцэглүүлэн хөгжүүлэх долоон сургаал байдаг.
 - Хүмүүс үндэсний аюулгүй байдлыг хангаж, улс төрийн хэргийг ард олон цугларч хэлэлцэж байх ёстой.
 - Нийгмийн бүх давхаргын хүмүүс эв зохицолтой амьдарч, улс гүрнийхээ хэргийг хамтран зөвшилцөж байх ёстой.
 - Хүмүүс хуучин заншлыг баримтлан хүндэтгэх, тэдгээрийг шалтгаангүйгээр өөрчлөхгүй байх ёстой. Үүрэг хариуцлагаа гүнзгий ухамсарлаж шударга ёсыг эрхэмлэх ёстой.
 - Хүйсийн ялгаа, ах захын ялгааг сайтар ойлгож, нийгэм, гэр бүлийн цэвэр ариун ёсыг чанд сахих учиртай.
 - Эцэг эхдээ үр ачийн нандин үүргийг хүлээж, ахмад настан, багш нартаа шударга зүтгэнэ.

- Дээдсийн дурсгалт онгон газрыг шүтэж жил бүрийн шашны ёсыг гүйцэтгэж байх хэрэгтэй.
- Олон түмний ёс суртахууныг чухалчилж, буянт явдлыг эрхэмлэж, номч мэргэн багш нарын айлдварыг бишрэн сонсч, өглөг барьж байх ёстой. Хэрэв энэхүү сургаалыг хуудуугүй сайн баримтлан гүйцэтгэх аваас улс орон цэцэглэн хөгжих нь дамжиггүй.

Ингэж чадваас бусад улс гүрний ч дэмжлэг хүндэтгэлийг хүлээж чадах ажгуу.

2. Эрт цагт улс гүрнээ мэргэнээр жолоодож байсан нэгэн их хаан байжээ. Мэргэн ухаантай учир Их гэрэлт хэмээх их алдрыг хүлээв.

Тэрбээр өөрийн захирах зарчмыг тайлбарлахдаа:

Удирдагч хүнд улс гүрнээ захирах хамгийн эрхэм арга бол юуны өмнө өөрийгөө удирдах арга гэжээ. Удирдагч нь хүн ардаа нигүүлсэнгүй сэтгэлтэй болгож үнэт сургаалаа хайрлан, тэднийг сэтгэлийн бүхий л буртаг хирнээс ангижруулахад удирдлагаа чиглүүлэх ёстой.

Зөв сургаалыг баримталснаар бидний хүртэх ёстой зүйл нь аз жаргал бөгөөд ертөнцийн үнэт баялагийн таашаалаас ч хавьгүй дээр.

Тиймийн тулд ард олондоо зөв сургаал айлдаж, тэдний сэтгэлийг тогтвортой шударга байлгахыг хичээ. Хүмүүс ирэхэд дэлгүүр агуулахаа нээж юу хүссэнийг нь авахуулна.

Дараа нь тэдэнд бүх шунал, хорт муу явдлаас өөрсдөө зайлах мэргэн ухаанд сургаж боломжийг олгоно. Хүн бүр өөрийн ухааныхаа хэрээр юмыг тусган ойлгох чадвар янз бүр байдаг. Амьдарч буй хотоо зарим нь үзэсгэлэнтэй гоёоор харна. Зарим нь өөдгүйгээр төсөөлнө.



Зөв сургаалыг бишрэн мөрдөгч хүмүүс бүхий л эрдэнийн гайхамшигт өнгө гэрлийг олж хардаг байтал шуналтнууд өөрийн сэтгэлийг яаж удирдахыг мэдэхгүй, алтан ордон өмнө нь гялбасан ч сохор мэт ажгуу. Өдөр тутмын амьдралын юм бүхэн үүнтэй агаар нэг. Сэтгэл гэдэг бол бүхний уг.

Тэгэхээр удирдагч хүн юуны түрүүнд хүний сэтгэлийг удирдах замыг эрэлхийлэх ёстой.

3. Мэргэн удирдлагын гол зарчим бол Их Гэрэлт хааны зарчимтай яг адил. Хүмүүсийг сэтгэлээ дасгалжуулж сургахад оршино. Сэтгэлээ (ухаанаа) дасгалжуулна гэдэг нь Гэгээрэх замыг хайна гэсэн үг. Ингэхлээр мэргэн удирдагч гэдэг бол юуны түрүүнд Бурханы сургаалд гол анхаарлаа төвлөрүүлж байх ёстой. Хэрэв удирдагч хүн Бурханд үнэнч, түүний сургаалд бие сэтгэлээ зориулсан бол нигүүлсэнгүй, буянтан байх бөгөөд хүмүүст үнэнхүү хүндлэгдэж чадна. Нөхөр, дайсан хэмээн алагчилахгүй аваас улс гүрэн цэцэглэн хөгжсөөр байх ажгуу. Хэрэв улс гүрэн нь хөгжингүй жаргалтай аваас бусад улс дайрч давшлах, зэвсэг сэлт ч юун хэрэг болох билээ.

Хүмүүс нь аз жаргалтай, сэтгэл хангалуун, тэгш ёсыг олсон, буян нь ихэссэн бусад улсаар дэмжин хүрээлэгдсэн үед олон түмэн бие биеэ хүндэлдэг. Тэгээд юм бүр цэцэглэн хөгжинө. Цаг агаар хүртэл дулаарч, нар, сар, од жам ёсоороо мандан хур бороо цагтаа орж, байгалийн бүх гамшиг арилна,

4. Удирдагчийн үүрэг бол зон олноо хамгаалахад оршино. Тэр өөрийн албат нарын эцэг, эх бөгөөд тэднийг хуулиараа хамгаална. Түмэн олондоо эцэг эх нь үр хүүхдээ яаж бойжуулдагтай адил ханддаг байх ёстой.

Эх хүн хүүхдээ уйлахыг нь хүлээхгүй норсон хувцасыг сольдогтой адил юм. Хаан хүн гэдэг бол улс түмнээ зовлон зүдгүүрээс салгаж, тэдний аз жаргалын төлөө санаа тавих хэрэгтэй. Хаан хүнд ард түмэн гэдэг бол төрийн жинхэнэ эрдэнэ мөн. Яагаад гэвэл түмэн олонгүй төр гэж байдаггүй. Улс орон нь хангалуун амьдарч байгаа цагт төр хүчтэй бат бөх байна. Хаан хүн ард олныхоо төлөө үргэлж санаа зовж байх хэрэгтэй.

Ард түмнийхээ зовлон жаргалыг ил харж түүний ирээдүйн төлөө санаа зовох ёстой. Үүний тулд тэр ус, салхи, бороо, хур, ургац, ган, зуд, ер бүхнийг урьдчилан харах ёстой. Ард түмэн нь юунд баясч, юунд санаа зовж байна гэдгийг ч мэдэж байх ёстой. Түүнчлэн хүмүүсийн байгуулсан гавьяа, зүтгэл, гэмт хэргийг сайтар мэдэж байх ёстой. Гэмт хэрэг өдөөгчдийн ял шийтгэлийг хүнд хөнгөнийг тааруулан яллаж, гавьяат үйлс бүтээгчдийг хөхүүлэн шагнаж байх ёстой. Хаан хүн олон түмэндээ өглөг хүртээх ёстой бөгөөд чухам хэрэгтэй цагт нь өгөх нь зохимжтой. Татвар авах хэрэгтэй бол нарийн нягт тогтоосны эцэст авах хэрэгтэй. Ард түмнийг хоосолж цөлмөхгүйн тулд татвар хэр хэмжээндээ тохирсон байх хэрэгтэй. Тийм болвоос олон түмний сэтгэл хангалуун амьдрах болно.

Мэргэн жолоодогч түмэн олноо эрдмийн хүч, өндөр нэр сүрээрээ хамгаална. Ард түмнийхээ төлөө өөрийн төлөө юм шиг санаа зовж чадаж байвал түүнийг зон олон зүй ёсоор удирдагч хэмээн хүлээн зөвшөөрч тойрон нягтардаг.

5. Үнэний хаан бол хаадын хаан мөн. Түүний гарал үүсэл ариун болоод дээд гаралтай. Тэр нь ертөнцийн бүхий л орныг жолоодоод зогсохгүй мэргэдийн Бурхан, бүхий л буянт сургаалын хамгаалагч болой. Түүний явсан газар хэрүүл маргаан зогсч муу юм арилдаг. Тэр нь үнэний хүчээр буяныг үйлдэнэ. Хорт муу санааг үндсээр нь



арилгаж, түмэн олонд энх амгаланг авчирна. Үнэний хаан бол амьтны амь тасалдаггүй, хулгай хийдэггүй, худал хэлдэггүй, буруу хурыцдаггүй, дэмий чалчдаггүй, шунадаггүй, уурладаггүй, мунхагладаггүй, зусардаж бялдуучилдаггүй.

Энэ нь арван цагаан буянаар арван хар нүглийг зайлуулдаг, үнэний хүчээр бүхнийг удирдаж чадна. Үнэн илэрч байгаа газар хүчирхийлэл зогсч, нүгэлт муу санаа арилна. Хэрүүл т эмцэл зогсоно. Ингэхээр түмэн олон нь түвшин жаргалтай, төр улс нь бат бэх байдаг. Ард түмэн аз жаргалтай амьдарч байгаа учраас удирдагчаа Үнэний хаан хэмээн өргөмжилдөг юм. Үнэний хаан бол хаадуудын хаан гэж дээр хэлсэн билээ. Бусад бүх хаад түүний буянд бахархан биширч өөрсдийн орныг түүний жишээгээр жолооддог юм. Үнэний хаан бол Бурханы сургаалын дагуу өөрийн орныг жолоодож байгаа учраас бүх хаадын өмөг түшиг юм.

6. Мэргэн удирдагч аливаа нэгэн гэмт хэргийг үзэж шийдэхдээ энэрэн нигүүлсэнгүйн сэтгэлээр хандана. Аливаа хэрэг явдлыг мэргэн ухаанаар шүүж шийдвэр гаргахдаа дараах таван зүйлийг баримталдаг.
 - ② Тухайн тэр баримтын үнэн бодит байдалд үндэслэн шийдвэр гаргана.
 - ② Хаан хүн нэр төртэй байсан цагт түүний айлдвар зарлиг ямагт хүчтэй биелж байдаг. Нэр хүнд үгүй бол гарсан шийдвэр нь олны дургүйцлыг төрүүлнэ. Иймд хаан цаг үеээн олсон зөв шийдвэрийг гаргах хэрэгтэй.
 - ② Шударгаар шүүх хэрэгтэй. Гэмт хэрэгтний сэтгэл зүйд нэвтэрч, хэргийг санаатайгаар үйлдсэн үү? Санамсаргүй

үйлдэж үү? гэдгийг тогтоох хэрэгтэй. Хэрэв үнэхээр санамсаргүй аваас өршөөл үзүүлж чаддаг байх хэрэгтэй.

- ② Ямар ч үед хэрэгтэнтэй бүдүүлэг зан гаргалгүй эелдэг зөөлөн харилцах ёстой. Хэрэгтэн чухам ямар хууль зөрчсөнийг нарийн мэдэж байх нь хэрэг шийдэхэд чухлаар нөлөөлнө.

Хэрэгтний ялыг хуулинд заагдсан зохих хэмжээнээс хэтрүүлж болохгүй. Эелдэг зөөлөн үгээр тухайн хэрэгтнийг хийсэн хэргээ ойлгож ухаартал нь түүний сэтгэлд нэвтэрч орох хэрэгтэй.

- ③ Хэрэгтэнд энэрэн нигүүлсэх, өрөвдөх сэтгэлээр хандах ёстой. Ямар ч тохиолдолд үзэн ядаж болохгүй. Гэмт хэргийг нь үзэн ядаж болохоос бус хүний нь хувьд үзэн ядаж болохгүй. Хэрэгтнийг өөрийнх нь хийсэн хэрэгт гэмшиж харамсуулахын тулд энэрэн нигүүлсэх, өрөвдөх хайрлах сэтгэл туйлын чухал юм.

7. Хэрэв чухал албаны сайд хүн улс орныхоо эрх ашгийг мартан зөвхөн хувиа хичээн хээл хахууль авч, албан тушаалаа ашиглаваас нийгмийн ёс суртахуунаар ялзарч хүмүүс бие биеэ мэхлэн, хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэн, дээд язгууртан нь доод гаралтнаа үзэн ядаж, баян нь ядуугаа зарцалж, шударга ёс үгүй болно. Гай зовлон улам нэмэгдэнэ. Ийм үед үнэнч шударга зүтгэлтнүүд өөрийн ажил үүргээс холдоно. Үнэнч шударга хүмүүс амьдрал, амь насаа хоохойлон хувиа бодон чимээгүй суух болно. Харин зусардан бялдуучлагчид дэвшин, чухал байр суурь эзлэн, албан тушаалаа ашиглан, баяжиж ахиж байдаг. Ард олон улам улам ядууран хоосроно.

Иймэрхүү үед хааны зарлигийг хүмүүс хэрэгсэхгүй болж, засаг төр нь хазайж ирнэ. Иймэрхүү хортой муу



хүмүүс ард түмнийг буянт үйл, аз жаргалаас нь холдуулж, төр засгийн хорт заналт дайсан болдог. Тийм хүмүүс дээрээ байгаа хүмүүсийг хуурч, доороо байгааг хутган үймүүлж, улс орны ядуурал, доройтлын үндэс болно. Ийм хорт хүмүүсийг хаан хамгийн хатуугаар цээрлүүлбэл зохино.

Хэрэв хаан хүн нандин сургаалын дагуу шударга хуулиар хаанчилж байхад эцэг эхээ хүндэлдэггүй, зөвхөн өөрийн гэр бүлийн төлөө санаа тавьдаг, эцэг эхдээ байгааг хамж авдаг, эцэг эхийнхээ үгэнд ордоггүй, тийм хүмүүс байх аваас хамгийн хортой гэмтний тоонд оруулбал зохино. Яагаад гэвэл эцэг эхийн өмнө хүлээх өр юугаар ч төлөх аргагүй их юм. Өөрийн эзэндээ үнэнч биш, эцэг эхээ хүндэлдэггүй тийм гэмт хэрэгтнийг хамгийн хатуугаар цээрлүүлэх хэрэгтэй.

Бурханы ариун сургаалын дагуу шударга хуулиар хаан нь засаглаж байгаа оронд Бурхан гурван эрдэнэд үл итгэж сүм суварга нурааж шатаадаг, лам нарыг барьж авч залхаадаг, ном судрыг устгадаг, бурханы сургаал номлолыг зүйл бүрээр зөрчиж, аашлагч этгээд буй аваас тэдгээрийг хамгийн бузар, нүгэлт ялтанд тооцож төрийн дээд ял цаазаар засаглах ёстой.

Учир нь: Ийм гэмт үйл нь бүх буяны үндэс болсон ард түмний итгэлийг хугалж, хөсөрдүүлдэг юм. Тэдгээр нь бүхий л буянт үйл санааг бузарлаж, өөрсөддөө авсныхаа нүхийг ухдаг юм. Энэ гурван гэмт хэрэг бол хамгийн хүнд ял бөгөөд хамгийн хатуугаар цээрлүүлбэл зохилтой. Бусад бүх гэмт хэрэг бол дээрх гуравтай харьцуулбал харьцангуй хөнгөн ял юм.

8. Хэрвээ нандин сургаалын дагуу улс орноо жолоодож байгаа хааны эсрэг хуйвалдаан зохион байгуулах юм уу, түүн рүү гадны дайсан халдах юм бол дараах гурван үзлийг баримтлах хэрэгтэй.

- 1) Хэрэв хуйвалдагч юм уу гадны дайсан нь зөвхөн хүмүүсийг алж ард олныг боолчлохыг хүсэж буй бол хаан зэвсэг хөдөлгөж түмэн албатаа аврах үүрэгтэй.
- 2) Хэрэв боломж байвал хүч хэрэглэхгүйгээр дарж авах юм уу, эсвэл бут цохих хэрэгтэй.
- 3) Дайсныг аль болохоор алалгүйгээр бүслэн авч зэвсэгийг хурааж авах хэрэгтэй.

Энэ гурван бат үзэлд тулгуурлан хаан хүн бол өөрийн цэргүүдээ тулалдаанд бэлтгэж, байлдааны бэлэн байдалд байлгаж, зохих тушаалыг өгөх үүрэгтэй. Ийм үед цэргүүд хааныхаа буянт үйлсийг биширч, түүний агуу их чин зоригт биширч, хүндэлж байдаг. Цэргүүд өөрийн хааны төлөө ямархуу тулалдаанд орж байгаагаа ойлгож, зүтгэдэг. Хааныхаа энэрэн нигүүлсэхүй өршөөл хайрлах сэтгэлд итгэсэн цэргүүд нь амь бие хайрлахгүй тулалдах учраас хаанд ялалт ирэх нь дамжиггүй. Ялалт нь ч бас тухайн оронд шударга буянт үйл авчрах болой.



БУРХАНЫ ОРОН ЦОГЦЛОХУЙ ГУРАВДУГААР БҮЛЭГ



1. АХАН ДҮҮСИЙН БАРИЛДЛАГА

1. Таг харанхуй шөнийн оронд үй түмэн амьтан бүдчин шавааралдаж бухимдаж байжээ. Таг харанхуйгаас болж бие биеэ харахгүй, хорхой шиг атиралдан туйлын өрөвдөлтэй байлаа. Их бамбар барьсан агуу их хүн гэнэт гарч ирэхэд түнэр харанхуй агшин зуур нэлсхийн гэрэлтлээ. Харанхуйд мөлхөн зүдэрч байсан амьтад жаргалтай сайхан болж, бие биесээ таньж, эвсгээр нөхөрлөн амьдрах боллоо.

Энд цөлийн орон гэсэн маань мунхагийн харанхуйд тарчлах хүний ертөнц юм. Мэргэн ухааны гэрэл үгүй хүмүүс, айдас ганцаарчиллын мананд тэнүүчлэнэ. Тэд ганцаар төрж ганцаар үхнэ. Тэдэнд ухааны гэрэл үгүйн учир хамт олонтойгоо хэрхэн эв найртай амьдрах ухаанаа олохгүй, сэтгэл гутранги, хулчгар байна.

Бамбар барьж гарч ирсэн агуу их хүн гэдэг нь хүний дүрд хувилсан Бурхан багшийг хэлж байгаа бөгөөд түүний гэрлээр гийгүүлэгдсэн хүмүүс анх удаа өөрсдийгөө болон бие биенээ таньж мэдэж байна.

Мэргэн ухаан нигүүлсэнгүйн сэтгэлээр ертөнцийг гийгүүлэн гэрэлтүүлж байна. Тэр Гэгээрэлд хүмүүс өөрсдийгөө болон бусдыг олж мэдэрч, тэдний хооронд эвтэй найртай харилцаа үүсч, сая живаа хүмүүс бие биенээ ойлгосноор, нийгэм оршин тогтнох хэвээ олно.

Жинхэнэ нийгэм гэдэг бол шударга ёс, эрүүл саруул ухаанаар асуудлыг шийдэн, хүмүүс бие биенээ хүндэлж мэддэг, нэг нь нөгөөдөө итгэдэг нийгмийн эв нэгдэл цогцолсон байх ёстой.

Энх тайван, эв найрамдал гэдэг нь нийгэм, хамт олны амьдрал жинхэнэ утга учир нь юм. Хамт олон гэдэг бол гурван янз байна.

- 1) Удирдагчийн эрх мэдэл, хөрөнгө, эрх мэдэлтэй учир тогтож байдаг.
- 2) Хүмүүс тооцоо, ашгийн үндсэн дээр бүлгэмдэж ашиг өгсөөр л байвал цаашид хамтарч байдаг
- 3) Зөв ариун сургаалд татагдсан гишүүдийнх нь амьдралын зорилго нь эв зохицол, зөвшилцөл болж чадсан тийм цогц.

Дээрх гурван хамт олноос сүүлийнх нь жинхэнэ хамт олон юм. Яагаад гэвэл тэд нэгэн зорилгоор амьдарч, буян үйлддэг болохоор тэр.

Гэгээрэл гэдэг бол ууланд орсон бороо горхи болж, тэр нь цааш элбэг уст мөрөн болж далайд цутгахтай адил, нандин сургаалын хур, албан тушаал яс үндэс, хүйс, насыг харгалзахгүйгээр бүх хүмүүс дээр орж, энэ хураар тэтгэгдсэн жижиг бүлгүүд болж тэр нь хамт олон, нийгмийг хамарснаар цаашдаа Гэгээрлийн агуу их далайд нийлэн буяны жаргалд



хүрдэг. Хүмүүсийн сэтгэл санаа ус сүүтэй сүлэлдэх адил таарч найралдахад жинхэнэ эвсэг хамт олон төрж гарна.

Зөв сургаал бол эвсэг хамт олны үндсэн хүч болж, бас хүмүүс нэг нь нөгөөгөө ойлгож, бие биенийхээ эвийг олох, сэтгэлд буй төвөгтэй зүйлийг арилган угаах, боломж олгох гэрэл юм. Ингэхээр Бурханы сургаалын үндсэн дээр үүссэн хамт олныг ахан дүүсийн барилдлага хэмээнэ. Тэд сургаалыг ёсчлон биелүүлж, сэтгэлээ сургаалын дагуу номхруулна.

Ингэхлээр Бурханы ахан дүүсийн барилдлага гэдэг бол онолын хувьд хэнийг ч тооцож болох бөгөөд гагцхүү нэгэн адил шашин шүтлэгтэй гишүүд байх ёстой.

3. Нэг шүтлэгтэй хамт олон бол үнэндээ хоёр янзын гишүүдээс бүрэлдэж байна. Нэг хэсэг нь (хуврагууд) Бурханы сургаалыг хүндэтгэн олонд номлож байна. Нөгөө хэсэг нь (сүсэгтнүүд) тэдний амьдралыг тэтгэж, өөрөөр хэлбэл хоол хүнс, хувцасыг зэхэж байна.

Тэдний аль нь ч гэсэн Бурханы үнэн сургаалыг дэмжиж, дэлгэрүүлэх үүрэгтэй. Гишүүд бат бэх, энх тайван, эв нэгдлийн төлөө амьдрах ёстой.

Ахан дүүсийн барилдлагааг төгс бүрэлдүүлэхийн тулд гишүүд төгс эв нэгдэлтэй байх ёстой. Хуврагууд жирийн сүсэгтнүүдийг сургаж сүсэгтнүүд ч сургаалд итгэснээр, тэдний хооронд ч жинхэнэ эв нэгдэл, амгалан байдал тогтоно.

Тэд сэтгэл санаагаа дээд зэргээр ойлгосон, эвтэй жаргалтай нэгэн сэтгэлээр ямар ч зөрчил маргаангүй амьдрахад бүхий л хүчээ зориулах ёстой.

4. Энх амгалан, эв нэгдэлд хүрэхэд зургаан дүрэм байна,

- ① Үг яриа үнэнч
- ② Үйл явдал үнэнч, зөв байх
- ③ Сэтгэл санаа үнэнч байх
- ④ Ариун сахилыг адилхан мөрдөх
- ⑤ Бүгд зөв байх

Эдгээрээс шижир мэт гялалзах дээдийн дээд эрдэнэ нь зөв үзэл юм.

Гишүүд тус бүр анхааран мөрдөх долоон зүйл байдаг.

- ① Сургаалыг хэлэлцэж сонсохын тулд бүгд цугларах
- ② Хөгшин, залуу ялгаагүй адилхан эвтэй найртай амьдарч бие биенээ хүндлэх
- ③ Сургаал номыг мөрдөж түүнээсээ урвахгүй байх
- ④ Ахмад нь залуустайгаа харилцахдаа ёс зүйн дүрмийг мөрдөх
- ⑤ Үнэнч шударга, гүн хүндэтгэл нь бүгдийн биеэ авч явах хэм хэмжээ нь байх ёстой
- ⑥ Нам сэлүүн газар сэтгэлээ ариутгахдаа бусдыгаа өмнөө оруулж, өөрөө дараа нь орох хэрэгтэй
- ⑦ Бүх хүмүүсийг хайрлаж, зочдыг халуун сэтгэлээр угтаж, өвчтэй зовлонтой хүнийг энэрэн асарна.

Эдгээр долоон мөрдлөгийг биелүүлэх аваас хамтын сэтгэл задрахгүй. Хувь хүн тус бүрдээ мөрдөх долоон зарчим байна.

- ① Цэвэр ариун сэтгэлийг барьж, хувьдаа их зүйл шаардахгүй байх
- ② Шударга ёсыг сахиж, бүх л шуналаа орхих
- ③ Маргаж хэрэлдэхгүй, тэвчээртэй байх
- ④ Сул дэмий чалчихгүй, дуугүй байх



- ❶ Сургаалыг баримталж, даруу төлөв байх
- ❷ Нэг л сургаалыг дагаж, бусад сургаалд автахгүй байх
- ❸ Өдөр тутмын амьдралдаа хямгатай энгийн байж, хоол хувцас голохгүй байх.

Хэрэв энэ долоон зүйлийг биелүүлэх аваас үнэний замаас хазайхгүй зорилгодоо хүрэх болно.

5. Дээр дурдсанчилан ахан дүүсийн амьдрал бол гол нь энх тайван, эв нэгдэл юм. Тэгэхээр эв нэгдэлгүй бол ахан дүүсийн барилдлага тогтохгүй. Гишүүн бүр маргаан гаргахгүй байхын төлөө чармайна.

Хэрэв зөрөлдөөн гарч ирвэл түүнийг аль болох эрт зогсоох хэрэгтэй. Зөрчил маргаан гэдэг бол ямар ч хамт олныг тараах бутаргах шалтаг болдог.

Цусны толбыг цусаар угаадаггүй. Хорсол гомдлыг бас хорсолоор тайлдаггүй. Өшөө хорслыг мартаж тайлахаас өөр сайн арга байхгүй.

6. Эрт цагт Каламита хэмээх хаан байжээ. Тэрээр түүний хөрш Брахмадаттай тэрсэлддэг байжээ. Каламита хаан хатан, хүүгийн хамт нуугдсан боловч баривчлагдан Брахмадаттагийн гарт оржээ.

Азаар хаан хүү зугатжээ. Хаан хүү эцгээ аврах арга хичнээн сүвэгчлэвч нэмэргүй байлаа.

Эцгээ цаазлагдах өдөр хаан хүү танигдахааргүй хувцас олж өмсөөд хөөрхий зовлонд учирсан эцэгтээ чухам юугаар ч туслаж чадахгүй авч хайртай эцгээ сүүлчийн удаа харахаар иржээ. Эцэг нь хүүгээ олны дунд байгааг мэдээд өөртөө хэлж буй мэтээр:

– “Удаан бүү эр!, догшин ширүүнийг бүү үйлд, өшөө хорслыг мартсанаар л арилгаж болно” гэжээ.

Түүнээс хойш хаан хүү эцгийнхээ өшөөг авах аргыг удаан хайжээ. Тэгээд Брахмадатта хааны албанд ажиллах болж улмаар түүний итгэлийг олж чадсан байна.

Нэгэн удаа хаан авд мордохоор болжээ. Хаан хүү энэ боломжийг ашиглан эцгийн өшөөг авахаар шийджээ. Тэр хааныг цэргүүдээс нь сэмхэн холдуулж, хоёулхнаа уул хадаар ангуучилж явлаа.

Удалгүй хаан туйлын ихээр ядарч, алжаал тайлан хүүгийн өвдгийг дэрлэн хурхирч эхлэв. Одоо л өшөө авах цаг ирлээ хэмээн хаан хүү шийдэж илдээ хуйнаас нь сугалан хааны хоолой дээр тавих мөчид эцгийнх нь хэлсэн сүүлчийг үг гэнэт санаанд нь буув. Тэрээр тээнэгэлзэн байтал хаан ч сэржээ. Хаан:

– “Талийгаач Каламита хааны хүү миний хоолойг огтлох гэж байна гэж хачин зүүд зүүдлэв” гэжээ. Тэрээр хааныг барин авч өөрийн эцгийн өшөөг авах цагийг удаан хүлээснээ хэлж илдээ далайснаа больж хөсөр чулуудаж хааны өмнө сөхрөн унасан.

Каламита хааны сүүлчийн үг Брахмадатта хааны сэтгэлийг ихэд хөдөлгөн уяраасан тул хаан хүүг өршөөв. Тэд эв найрамдалтай болж, Брахмадатта хаан эцгийнх нь улс гүрнийг хаан хүүд нь эргүүлэн өгөв.

Каламита хааны хэлсэн сүүлчийн үг нь нөхөрлөл, зэрлэг догшин авираар эвдрэх ёсгүй гэсэн утгатай байжээ. Өшөө хорслыг өшөө хорслоор тайлж болохгүй, түүнийг зөвхөн мартсанаар арилгана хэмээжээ.

Амар амгалан эв нэгдэл ноёлон байдаг Бурханы ахан дүүсийн барилдлагааны ёсонд энэхүү ёгт үлгэрийг үргэлж санууштай. Ахан дүүсийн барилдлагын ёсонд төдийгүй жирийн хүний өдөр тутмын амьдралд ч сургамжтай юмаа.



2. БҮРХАНЫ ОРОН

1. Дээр дурдсанчилан ахан дүүс эв зохистойгоор амьдран Бурханы сургаалыг дэлгэрүүлэн үүргээ мартахгүй гүйцэтгэвээс сургаал нь улам өргөжин дэлгэрэх болно. Бурханы сургаал дэлгэрэх гэдэг бол Гэгээрлийг эрж буй хүмүүс олширч байна гэсэн үг.

Энэ нь бас одоог хүртэлх энэ ертөнцөд ноёлж ирсэн мунхагийн шулмаар хөтлөгдсөн уур хилэн, шунал тачаалын хор багасна гэсэн үг. Чөтгөр шулам ихэссэн газарт шунал хүсэл, хэрүүл тэмцэл, дайн дажин, зэвсэг хангинах дуу, мунхаг тэнэг, алив хогийн ургамлаар дүүрсэн байдаг. Түүнчлэн атаа хорсол, үзэн ядах, заль мэр, луйвар, хуурмаг бусармаг, хараал доромжлол, хамаг муу сэтгэл бялхаж дэвэрч байдаг.

Харин энэ чөтгөр шуламын муу муухай болгон үүрэлсэн газарт мэргэн ухааны гэрэл цацарч, энэрэн нигүүлсэхүйн

бороо түүн дээр хурлан орж, шударга ёс дэлгэрэн, энх амгалан, баяр цэнгэлийн цэцэг дэлбээлэхэд энэ шуламын орон агшин зуурын дотор Бурханы орон болж хувирах юм. Зөөлөн сэвшээ салхи, мөчир дээр найгасан турьхан цэцэгс, хавар айсуйг хэлдэг шиг хүний Гэгээрэл бол өвс ургамал, гол мөрөн, уул ус, орчлонг тэр аяар нь Бурханы орон болгож хувиргах чадвартай. Ийнхүү хүний сэтгэл ариусах юм бол түүний орчинг сэтгэл булаах гэрлээр гийгүүлэх болно.

2. Үнэн сургаалыг хүндэлж байгаа оронд хүний сэтгэл бас тайван ариун байна. Хүмүүсийг хайрлах Бурханы агуу их энэрэн нигүүлсэнгүйн сэтгэлээс хүнийг хамгаалах гэгээ гэрэл цацарч байдгаас бузартсан сэтгэл ариусч байдаг. Амгаланд умбасан цэвэр ариун сэтгэл нь зөв замаар замнах гүн ухаан болж, өглөг өргөн туслахын сэтгэл, тэвчээр хатуужилын ухаан, сахилга журмыг дагах ухаан, энэрэн нигүүлсэх өгөөмөр сэтгэлээр хүмүүсийг жолоодож Гэгээрэх замд оруулж, Бурханы орон цогцлон бүтнэ. Ер нь зөв мэргэн ухаан, ариун нандин сэтгэлээр л Гэгээрэх замд хүрч Бурханы орон үүсэх юм. Гэр дүүрэн элэг бүтэн амьдарч байгаа гэр чинь Бурхан заларсан айл өрх болж хувирна.

Нийгмийн ялгаанаас ч үл тохирох улс орон ч Бурханы ухаанаар залагдаж, ахан дүүгийн эв барилдалгаат орон болж цэнгэл жаргалыг эдлэж болно. Шунал хүсэл дүүрсэн, цус урссан алтан ордонд Бурхан орших боломжгүй. Харин овоохой саравч шиг давчуу ч дээврээр нь сарны гэрэл тусахад эзэн нь цэвэр ариун сэтгэлтэй аваас Бурхан орших орон болно. Нэг хүний сэтгэлд Бурханы сэтгэл шингэсэн байхад тэрээр сэтгэл нэгт олон хүнийг өөртөө татаж ахан дүүсийн барилдлагааг үүсгэн бүтээнэ. Нэг хүн Бурханд итгэвэл тэр итгэл нь эхлээд түүний гэр бүлд, гэр бүлээсээ тосгон, тосгоноосоо том жижиг хот, тэгээд улс гүрэн,



эцэстээ бүх дэлхийд түгэн дэлгэрэх болно.

Бурханд итгэх итгэл дэлгэрнэ гэдэг бол үнэндээ Бурханы орны хязгаар тэлж байна гэсэн үг.

3. Энэ ертөнцийн нэг булангаас нь харвал цус урссан тулалдааны талбар, шунал хүслийн далай, шуналын эзэмшил газар шиг харагдана. Харин Бурханд итгэдэг хүн олшроход ертөнцийг бузарлаж буй цусыг сүү, шуналыг энэрэнгүй сэтгэл болгон хувиргадаг. Энэ ертөнцийг шуламын гараас авч Бурханы орон болгоно. Их далайг шанагаар хутгаж болдоггүйн адил санагдах авч энэ үйлсэд зүтгэсэн, үй олон төрөл арилжсанч дээрх агуу хүслийг гүйцээх чин зорилготой аваас Бурханы Гэгээрлийг олох нь дамжиггүй. Бурханы голын нөгөө эрэг дээр Гэгээрлийн ертөнцөд шунал, уур хилэн, мунхаг тэнэг, үзэн ядах, зовлон шаналгаа, огт байхгүй тийм газар хүлээж байна. Тэнд зөвхөн энэрэн нигүүлсэхүйн хур орж, мэргэн ухаан л цацарна.

Энэ бол энх амгалангийн орон, зовж шаналсан уй гашуут амь тэмцсэн нэгний хорогдох газар номын сургаалыг дэлгэрүүлэх хүмүүсийн амсхийх газар. Энэхүү ариун дагшин газар хязгааргүй гэрэл, мөнхийн үргэлжлэх амьдрал буй.

Энэ оронд ирсэн хүн эндүүрэл төөрөгдлийн оронд дахин хэзээ ч очихгүй. Үнэхээр энэ ариун газар цэцэгс нь агаарыг, мэргэн ухааныг амилуулж, шувууд нь Бурханы номын дууг айлдана. Бүх хүн төрөлхтөний эцсийн зорилго хүсэл энэ юм.

Энэ цэвэр ариун орон бол амрах сэргэх газар болохоос бус хуурах хойргоших газар биш ээ.

Анхилам цэцгийн энэ орон залхууран цэнгэх бус, амарч оюун ухаан нь шинэчлэгдэж, эрч хүч, энэрэнгүй сэтгэлийг

авч Гэгээрэх Бурханы сургаалыг үргэлжлүүлэх газар болой.

Хүн төрж, амьдарч байгаа цагт Бурханы зорилго мөнх үргэлжилнэ. Өөрийн орчин тухайн ертөнцийг буй болгож хар амиа хичээх мэт хирт сэтгэл байгаа цагт Бурханы сургаал төгсгөлгүй үргэлжлэнэ.

Бурханы ачаар ариун ертөнцөд хүрсэн Бурханы шавь нар буцаж урьдын ертөнцдөө ирж Бурхантай үйлс нэгддэг юм Ганц цучилаас төгсгөлгүй их галыг үүсгэж болдогийн адил Бурханы сэтгэлд үүссэн гал нь хүмүүсийн сэтгэлд дөл авалцаж, мөнх үргэлжлэх юм. Бурханы шавь нар нигүүлсэнгүй сэтгэлийг нь авч ариусах болон Гэгээрэх зорилгыг нь авч Бурханы орныг үүрд мөнх алдаржуулахын тулд хүмүүсийн сэтгэлд энэхүү галыг асааж байна.





3. БУРХАНЫ ОРОНД АЛДРЫГ ХҮРТЭГСЭД

1. Удаяна хааны их хатан Сямавата Бурхан багшийн сургаалд гүн итгэсэн, түүнд бие сэтгэлээ бүрэн зориулсан нэгэн байлаа. Тэрээр ордноосоо гадагш гардаггүй ч өөрийн итгэлт зарц, гайхмаар сайн ой ухаантай, нэгэн охиныг илгээж Ялж Төгс нөхцөний сургаалыг нэг бүрчлэн сонсож чаддаг байв.

Харин хааны бага хатан их хатанд атаархаж түүнийг хороох арга замыг эрэлхийлэн, хаанд худал хов мэдээлж, итгүүлж чаджээ. Хаан их хатан Сямаватаг цаазлахаар ял тулган цаазын тавцнаа авчирахад их хатан түүнээс өршөөл гуйсан ч үгүй, гуньж гутсан ч үгүй маш тайван зогсов. Энэ байдлыг харсан хаан их хатнаа хороох сэтгэл төрүүлсэндээ харамсан түүнээс өршөөл гуйн зарлигаа няцаав. Хааны энэ байдалд улам хорссон бага хатан хааны эзгүй хойгуур их

хатны ордныг галдан шатаахаар нэгэн муу хүнийг илгээв. Хатны ордонд гал түймэр авалцахад айж мэгдсэн зарц шивэгчингүүдээ их хатан тайвшруулж, ямар ч айх сандрах явдалгүйгээр үхлийг тайван хүлээн авч, итгэлтэй зарц охины хамт галд шатав.

Бурхан багшийн сургаалы дагагч эмэгтэй шавь нарын дундаас их хатан Сямавата энэрэн нигүүлсэгч, түүний зарц эмэгтэй дуулгавартай сонсогч алдрыг хүртжээ.

2. Бурхан багшийн үеэл дүү Шагж овгийн хунтайж Маханама Бурхан багшийн сургаалд итгэдэг, Бурханы үнэнч шавь нарын нэгэн байв. Энэ үед Касалы Вирудака хэмээх нэгэн догшин хаан Шагжийн омгийнхнийг эзлэн түрэмгийлэв. Маханама хунтайж Вирудака хаанаас өөрийн шилтгээнд буй хүмүүсийн амь насыг аврахыг гуйсан боловч зөвшөөрсөнгүйгээр үл барам шилтгээнээс гарахыг хориглов.

Маханама шилтгээний хаалгыг онгойлгож тэнд байгаа олон хүний амь насыг аврах нэгэн арга олж, ойролцоо байгаа цөөрмийн усан доор өөрийгөө байх хооронд шилтгээний хаалгыг онгойлгох зөвшөөрөл гуйсанд Вирудака хаан усан доор амьд хүн хэдий л удаан байж тэсэх вэ? хэмээн бодож зөвшөөрөв.

Маханамаг цөөрмийн усан доор ормогц шилтгээний хаалгаар аюулд тулгарч сандарсан хүмүүс зугатан гарцгааж байв.

Гэвч Маханама усан доороос гарахгүй л байлаа. Түүнийг яаж тэвчиж байгааг машид гайхан очтол өөрийн үсийг уд модны үндэснээс уяж бэхлэн, олон хүмүүсийн төлөө амиа золиослосон байлаа.



3. Гэлэнмаа нарын дундаас Утпалаварна бол Бурхан багшийн агуу шавь Маудгальяанатай эн зэрэгцэхүйц мэргэн ухаантай, бусад хүмүүсийг Бурханы сургаалд итгүүлэн дагуулагч нэгэн байв.

Девадатта хэмээх харгис хэрцгий зантай, муухай санаатай нэгэн хүн Ажатаватру хааныг Бурханы сургаалын эсрэг ятган, ухаан бодлыг нь самууруулан, зорилгоос нь няцаахыг хичээдэг байлаа. Гэвч Ажатаватру хаан буруугаа ухааран хаанд бараалхахыг хүссэн Девадаттаг оруулсангүй.

Тэрээр хорсон уурсаж хэрмийн гадаа байж байтал хэрэмнээс Утпалаварна гарч ирэв. Түүнийг хараад Девадатта бүүрч уурсан хилэгнэж Утпалаварнаг зодож шархдуулав. Утпалаварна сүмдээ арай ядан эргэж ирээд бусад гэлэнмаа нартаа

- “Эгч дүү нар минь. Хүний амьдрал гэдэг урьдаас мэдэхийн аргагүй, юм бүхэн хувирамтгай, мөнхийн чанар гэж үгүй. Гагцхүү Гэгээрлийн ертөнц л мөнх амгалан.

Та бүхэн Бурханы сургаалыг үнэнчээр дагаж, сахил санваараа эрхэмлэн, сэтгэлээ Гэгээрлийн замд зориулагтун” хэмээгээд нас нөгцжээ.

4. Ангулималя хэмээх олон хүний амь насыг хөнөөсөн аймшигт дээрэмчин Ялж Төгс нөгцсөний нигүүлсэнгүйн сэтгэлээр аврагдан түүний шавь болжээ.


Тэрээр нэгэн удаа хотруу нүглээ наманчилахаар яваад урьд үйлдсэн нүглийнхээ хариуд хатуу цээрлэл, зодуурыг амсан маш хүнд шархдан шаналж, цусаа гоожуулсаар амь голтой л үлдэн Бурхан багшид эргэж иржээ.

Тэрээр Бурхан багшийн өлмийд ойчин хэлсэн нь:

- Урьд үйлдсэн харгис догшин нүглийнхээ төлөө ингэж залхаалт амсах боломж олгосонд би талархаж байна. Бурхан минь би үл хорлох хэмээсэн утгатай нэртэй боловч арчаагүй мунхагаасаа болж олон сайхан амьтны алтан амийг хөнөөж хурууг нь цуглуулсаар “Хуруу цуглуулагч” гэдэг хочтой болсон билээ. Тэгээд таны нигүүлсэнгүйн ачаар мэргэн ухааныг сурч, гурван эрдэнэд биеэ зориулж явна.

Хүн адуу малыг жолоо цулбуурын аль нэгээр хөтөлдөг. Ялж Төгс нөгцсөн та бол миний сэтгэлийг ямар нэг жолоо цулбуур, дэгээ зэргийн аль нэгийг үл хэрэглэн ариусган заллаа. Өнөөдөр би эдэлбэл зохих ёстой ялаа эдлэв. Одоо би амьдралаа ч гуйхгүй, түргэн үхэхийг ч хүсэхгүй зөвхөн цагаа хүлээнэ” гэжээ.

5. Маудгальяна, Шарибудра хоёр Бурхан багшийн агуу их хоёр шавь байлаа. Бурханы ариун сургаалийг дагагсад рашаан усыг хүртэхийг хүмүүс хүсдэгийн адил Бурханы сургаалыг хүлээн авч түгээн дэлгэрүүлж байлаа. Үүнийг хараад хорссон хэсэг бүлэг хүмүүс тэдэнд саад бэрхшээл учруулахыг оролдож Маудгальяны амийг хороохоор завдсан гэдэг. Эхний 2 удаа Маудгальяна зугтаж амжсан боловч 3 дахь удаад тэдний гарт орсон. Гэвч Гэгээрлийг хүртсэн тэрбээр махыг нь тасчин, ясыг үйрүүлсэн тамлалд огтхон ч айлгүйгээр амгалан байж тэнгэрт халив.





САНСКРИТ ҮГИЙН ТАЙЛБАР

Анатман (Төвдөөр Дагмэд)

- Бурхан шашны чухам “Би” хэмээх үгүй гэсэн үндсэн үзлийнх нь нэг. Энэ ертөнц дээрх бүх юмс үзэгдэл бодит бус, ер нь мөнх юм гэж юу ч байхгүй, хувирамтгайн учир Бурхан шашны ойлголтоор бол аливаа юманд мөнхийн мөн чанар гэж байхгүй.

Анатья (Төвдөөр мирдаг)

- Хувирамтгай чанар. Бурханы сургаалын бас нэг үндсэн үзэл. Энэ ертөнц дээр бүх юмс үзэгдэл үргэлж өөрчлөгдөж байдаг. Ганцхан мөч ч хувирахгүй тогтонги байна гэж үгүй. Ямар ч амьд юм мөхөж, амьгүй юм хувирна. Ийм ирээдүй зовлонгийн шалтаг болдог. Тэгэхдээ энэ онолыг зөвхөн гутрангуйн үзлээр тайлбарлаж үл болно. Яагаад гэвэл хувьсал хөгжил, нөхөн сэргэлт гэдэг бол дээрх тогтмол хувиралтын үр дүн нь болж байдаг.

Бодьсадва (Төвдөөр Жанчүб Сэмба)

- Гэгээрэлд тэмүүлэгч. Анх нь Бурхан Гаутама Сиддартагийн нэрийдэж байв. Бурхан их хөлгөний сургаалыг гарч ирсэний дараа Гэгээрэлд хүрэхийг хүсэгч хэн бүхнийг ингэж нэрлэх болжээ. Эцэст нь амьд юм бүхэнд асар их энэрэн хайрлах сэтгэлээр хандаж байгаа. Гэгээрэх замд хөтлөхийг хүсч байгаа хүн бүхнийг тэгж нэрлэх болжээ. Хамгийн алдарт Бодьсад нар бол Жанрайсиг (Кваннон), Очирваань (Жизоо), Манзушири (Монжу) нар болой.

Будда (Төвдөөр Санжай)

- Гэгээрсэн. Бурхан шашны үндэслэгч. Анх Гаутама Сиддартаг ингэж нэрлэж байв. Тэрээр 2500 жилийн өмнө Энэтхэг орноо 35 насандаа Гэгээрсэн билээ. Бүх Бурхан шашинтны эцсийн зорилго бол сургууль номлолоосоо хамаарахгүйгээр Бурхан болоход оршино. Бурхан болох арга замаараа Бурханы шашин нь хэд хэдэн чиглэл урсгалд хуваагдана. Их хөлгөн сударт түүхэн хүн болох Бурханаас гадна бэлэгдлийн олон Бурхад байна. Амиабха (Амида), Махавайрачо (Дайничи), Вайсажиагүүрү Манал Бурхан (Якүчин). Япончуудын баримталдаг ариун орны онолоор бол тэр дагшин оронд төрсөн болгоныг Бурхан гэх, мөн нас нөгцсөн болгоныгоо японоор Хотокэ буюу Бурхан гэж нэрлэдэг.

Дарма (Төвдөөр Чой)

- Үнэний ном сургаал. Энэ бол Бурханы (Төгс Гэгээрсний) сургаал юм. Бурханы сургаалд Судар (Бурхан айлдвар сургаал, хууч) Виная, (Бурханы номлосон сахил баримтлах сургаал), Авидарма (Сүүлийн үеийн эрдэмтэд Винай ба судрын ёсны тайлбар сэлтүүд гэж үзэж буй) зэрэг гурван бүлэгтэй байна. Энэ гурвыг Трипитака буюу Гурван аймаг савын ном гэж нэрлэнэ. Дарма бол



Бурхантны дээдэлдэг гурван эрдэнийн нэг болно.

Карма (Төвдөөр Лай)

- Үйлийн үр. Эхлээд энэ үг зөвхөн үйл гэдгийг тэмдэглэж байсан бөгөөд үйлийн үрийн онол гарч ирсэнтэй холбоотойгоор урд төрөлдөө ямар нэг үйл хийсний үр дүнд үргэлжлэх потенциал хүч гэсэн утгатай болжээ. Хүний үйлдэл бүхэн сайн муу үйлээс шалтгаалж ирээдүйд ямар нэгэн үр дүнд хүргэнэ. Хүний ирээдүй амьдралд нөлөөлөх үйлийн нэгэн хүчийг Карма гэж нэрлэж байна. Сайн үйл хийгээд л байвал буян хуримтлагдаж түүний үр нь ирээдүй хойд төрөлд нь сайн нөлөө үзүүлнэ. Үйлийн үрийн онолоор хүний бүхий л үйлийг бие, хэл, сэтгэлийн гэж гурав хуваана.

Махаяна (Төвдөөр Тэгчин)

- Их хөлгөн. Бурханы шашин дэлгэрсэний түүхэнд Махаяна, Хинаяна гэсэн хоёр том урсгал гарсан бөгөөд Их хөлгөн урсгал нь Төвд, Монгол, Хятад, Солонгос, Япон зэрэг умард зүгийн орнуудад, Бага хөлгөн (Төвдөөр Тэгмэн) нь Бирм, Шри-Ланк, Тайланд зэрэг өмнөдийн орнуудад дэлгэрсэн байна. Их хөлгөн гэдэг нь энэ ертөнцөд үхэж, төрж байгаа бүх амьтны зовлонг болгоож, бүх амьтныг алагчлалгүйгээр Гэгээрлийн замд хөтлөх сургаал юмаа.

Нирваана (Төвдөөр Ня-Ан-дай)

- Төгс амгалан. Үгчилбэл бөхөх гэсэн үг. Энэ нь зөв мэргэн ухаанаар жолоодсон дотоод бясалгалаар ухаан бодлоо төгөлдөржүүлж чадсан тохиолдолд тухайн хүний буртагийн хүлээс, шунал төөрөгдөл нь бүр мөсөн алдрахыг хэлж байна. Энэ чадварыг эзэмшсэн хүнийг Гэгээрсэн Бурхан гэж нэрлэх бөгөөд Гаутама Сиддарта энэ чанарыг эзэмшиж 35 насандаа Бурхан болсон. Гэхдээ одоо цагт хүний бие махбод амьд байх үед нь ариун бус

хэвээр байх тул нас нөгцсөний нь дараа л төгс амгаланг бүрэн олох боломжтой гэж үзэж байна.

Пали – Бурхан багш амьдарч байх үеийн, эртний Энэтхэгийн нэг хэл.

- Бурханы сургаалын бага хөлгөнийхөн хэрэглэж байна. Бурханы сургаалын хамгийн эртний номлолууд нь энэ хэлээр бичигдсэн гэж үздэг. Энэ нь эртний Самгарди (Санскрит) хэлний нэг аман аялгуу бөгөөд Самгарди ба Пали хэлний ялгаа тийм ч их биш. Жишээ болгоход: самгардаар Дхарма палигаар Дамма, самгардаар Нирваана, палигаар Ниббана гэх мэт.

Парамита – (Төвдөөр Пааролдү Чимба, монголоор Чинад хязгаарт хүрэх)

- Үгчилбэл нөгөө талын эрэгт хүрнэ гэсэн үг. Голын нөгөө эрэгт хүрнэ гэдэг нь Бурханы шашины ойлголтоор Бурханы ертөнцийг олох гэсэн утгатай. Үхэх төрөхийн энэ ертөнцөөс Гэгээрлийн ертөнцөд хүнийг аваачих зургаан бараамид байна гэж үздэг бөгөөд энэ нь өглөг, шагшаабад, хичээнгүй, тэвчээр, бясалгал, бэлэг билгийн ухаан юм. (Төвдөөр жинба, чүлтэм, зундуй, содба, самдан, шэйраб эдгээр болой).

Пражня (Төвдөөр Шэйрав)

- Билгийн ухаан. Зургаан билэг бираамидын нэг болно. Энэ бол үнэн худлыг ялгаж салгах, амьдралд зөв хандах оюун ухааны онцгой чадвар юм. Энэ чадварыг төгс эзэмшсэн хүнийг төгс Гэгээрсэн Бурхан гэнэ. Учир нь энэ бол ерийн хүний ухаанаас ялгаатай. Хамгийн цэвэр ариун Гэгээрсэн ухаан болно.



Сангха (Төвдөөр Гэндүн)

- Бурсан хуврага. Бурханы шавь нарын ахан дүүсэг барилдлага. Лам хуврага, гэлэнмаа, хар хүн ч орно.

Эрт цагт гэрээ орхисон гэлэн, гэлэнмаа нар орж байв. Сүүлд их хөлгөн сургаал гарч ирэхэд Бодьсадын зэрэгт зорисон хүнийг лам нар ялгахгүйгээр Бурханы ахан дүүсийн барилдлагад хамааруулах болсон. Энэ нь Бурханы гурван эрдэнийн нэг болно.

Санскрит (Самгарди) хэл.

- Энэтхэг-Европын хэлний аймагт багтсан эртний Энэтхэгийн бичгийн сонгодог хэл. Тэр нь Вед хэл, сонгодог Санскрит хэл гэж хоёр янз буй. Их хөлгөний сургаалууд энэ хэлээр бичигдсэнийг зарим судлаачид холимог Санскрит хэл гэж үзэх нь ч буй.

Сансара (Төвдөөр сридвийн хорло).

- Төрөл арилжих хэлхээ. Бид урьд тоолшгүй наснаас одоо ба ирээдүйд там, бирд, адгуус, асар нар, тэнгэр, хүмүүний зургаан төрөлд тасралтгүй төрж үхсээр байна. Хүн Гэгээрлийг олтлоо энэ хүрднээс гарч чадахгүй, мөнхийн эргэлтэнд байна. Энэ хүрднээс гарч чадсан хүнийг Бурхан гэнэ.

Шунъята (Төвдөөр Донбаанид)

- Хоосон чанар. Энэ ертөнцөд бодитой мөнх юм гэж юу ч байдаггүй гэсэн Бурханы сургаалын үндсэн үзлийн нэг. Юм бүхэн шалтгаан үрийн холбооноос хамаардаг тул мөн чанар гэдэг юм огт үгүй. Иймээс юм болгонд мөн чанар байна, юм болгонд мөн чанар байхгүй гэж нотолж баримталж болохгүй. Ертөнцөд байгаа юм болгон харьцангуй. Иймээс ямар нэг тодорхой үзэл суртлыг

үнэмлэхүй гэх нь утгагүй тэнэг хэрэг болой. Энэ нь их хөлгөн судрын гол ойлголт болно.

Судар (Төвдөөр Доо)


- Шүтээн ном. Бурханы бичигдсэн номлол. Эхлээд богино сургаалын түүвэр, судалгаа шинжилгээний зохиол, шастир гэж нэрлэж байв. Гурван аймаг савын нэг бүлэг болно.

Тхеравада (Төвдөөр тэгман)

- Бага хөлгөн. Бурханы сургаалын өмнөд уламжлалыг хэлнэ. Тхера гэдэг нь ахимаг настан гэсэн утгатай. Бурханы аман сургаалыг нарийн чанд мөрдөж байсан хуучин үзэлт өвгөн лам нарын бүлэг юм. Үүний эсрэг үзэлтэй, нилээд чөлөөт сэтгэлгээтэй, өөр лам нарын бүлэг гарч ирсэн. Тэдний үзэл нь их хөлгөний сүүлийн үеийн хөгжилд нөлөөлсөн хойд хэсгийн уламжлал байв. Иймэрхүү зөрөөтэй сургаал урсгал Бурханыг таалал төгссөний дараа хэдэн зууны турш Бурханы шашны эхний үе шатанд байлаа. Тэр үеийн дэвшилтэй эрдэмтэн Махадева Бурханы сургаалыг таван ангилалд нилээд чөлөөтэй дэлгэрүүлж хэлсэн. Энэ нь эцэстээ Бурханы шашныг Тхеравада Махасангика гэсэн хоёр сургаал урсгалд хуваагдахад хүргэсэн билээ. Махасангика нар нь сүүлдээ Махаяна буюу их хөлгөний номлолыг боловсруулсан.

Трипитака (Төвдөөр Дэнодсүм)

- Гурван сав. Судар (сургаал номлолын бүлэг), Виная (номхотголын буюу хуврагуудын баримтлах журмын бүлэг), Абхидарма (Учир шалтгааны ухааны бүлэг) гурваас бүрдэнэ. Сүүл хэрд Хятад Японы мэргэд лам нарын бүтээлүүд Бурханы сургаалын эмхэтгэлд орсон байна.



**ЕРТӨНЦИЙН АМГАЛАН
ХУТГИЙГ ОЛОХ
ХҮМҮҮНИЙ ЭРЭЛ**





ӨМНӨХ ҮГ

1990-ээд онд Дээрхийн гэгээн 14-р Далай ламын айлдсан нэгэн бэсрэг номыг, гэгээнтнийг морилон саатахуй үес хэлмэрч хийж байсан Төвд эмч Ч.Норовцэрэн надад өгүүлснээр би түүнийг орчуулж олны хүртээл болгох юмсан хэмээх бодол төрж билээ. Ямар хүн зоригтой гэдэг билээ түүний үлгэрээр орчуулгыг даруй эхэлж, мөн дороо дууссан юм. Түүнийг миний нутгийн анд Шашны Дээд Сургууль төгсөөд ШУА-д ажиллаж байсан Т.Цэндсүрэн ариутган шүүхээр тохиров.

Номыг тэр үеийн бурханы шашин, гүн ухаан судалдаг багш нар, эрдэмтдээр хянуулж байсан юм. Хожим нь намайг ШУА-ийн академич Д.Цэрэнсодном гуай доктор профессор Л.Хүрэлбаатартай танилцуулахад тэрээр “Би таны орчуулсан номыг уншсан зүгээр

санагдсан” хэмээсэн нь их л урам хайрласан билээ. Нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн тэр үед энэ ном 30.000 орчим хувь хэвлэгдэж хот хөдөөгийн сүсэгтэн олны хүртээл болж зарим айлуудын бурханы гүнгэрваа, зургийн жаазанд заларсан нь олонтаа тааралддаг юм. 1994 онд “Нүгэл буян” хэмээх сонин номыг бүхлээр нь хэвлэн тарааж, мөн 2000 онд “25-р суваг” телевизийн нэвтрүүлгээр уншиж танилцуулж байсанд бид сэтгэл тааламжтай байдаг. Номонд: “Амьтан бүхэн тэргүүлшгүй цагаас тоо томшгүй төрөл арилжихдаа хэзээ нэгэн цагт нэг нэгэндээ эх нь болон төрж агсан болой. Иймээс энэ ертөнцийн бүх амьтан нэгэн айлын ураг төрлийн хүмүүс мэт холбогдсон амой” хэмээсэн Бурханы шашны нэн гүн утгатай энэрэн нигүүлсэхүйн сургаалийн үндсийг энгийн ойлгомжтой үгээр айлджээ.

2002 онд нэрт сэтгүүлч Ш.Цэрэнпил, Т.Адьяа нарын бүтээл Лондон дахь Төвдийн сангийн тэтгэлээр хэвлэгдсэн “Дээрхийн гэгээнтэн” номын 23-р хуудсанд (1990-ээд оны үед Далай багшийн “Ертөнцийн амгалан хутгийг олох хүмүүний эрэл” хэмээх номыг М.Шагдарсүрэн, Ч.Норовцэрэн нар нь монгол хэлнээ яруу сайхан буулгажээ. Тэнд өгүүлснээр бол...) хэмээгээд ишлэл татсан нь бий.

Номын цагаан буян хурах болтугай!

М.Шагдарсүрэн



Арвандөрөвдүгээр ДАЛАЙ ЛАМ ДАНЗАНЖАМЦ

Арвандөрөвдүгээр Далай дам Данзанжамц Цаст Төвд орны зүүн хойд хэсэгт оршдог Амдо Гүмбүмийн Тагцэр хэмээх газар 1935 онд мэндэлжээ.

Төвдийн уламжлалт сургууль дэгийн ёсоор Бурханы шашин - гүн ухааны дээд хөлөгний боловсролыг төгс эзэмшсэн Далай лам Данзанжамц аваас эх болсон зургаан зүйл хамаг амьтныг мэлмийгээрээ болгоогч, Жанрайсэг бурханы хувилгаан хэмээмөй.

Энэрэн нигүүлсэх ариун ёс суртахууныг дэлгэрүүлэх үйлсэд Далай лам Данзанжамцын оруулсан зүтгэлийг хүн төрөлхтөн гүнээ хүндэтгэдэг бөгөөд энэхүү ариун гэгээн эрхэм хүмүүнд 1989 онд Нобелийн шагнал хүртээжээ.

Далай ламын туурвисан “Миний эх орон, миний ард түмэн”, “Төвд дэх бурханы шашин”, “Билгийн нүдийг нээхүй” зэрэг бүтээл дэлхий дахинаа ихэд алдаршжээ. Далай лам Данзанжамцын “Ертөнцийн амгалан хутгийг олох хүмүүний эрэл” хэмээх бүтээлийг Таны мэлмийд толилуулж байна.

Ертөнцийн амгалан хутгийг олохын тулд хүн төрөлхтний өмнө хүлээсэн хамтын хариуцлагаа улс гүрнүүд гүнзгий ухамсарлаж, сайн санаа, ариун сэтгэл гаргах ёстой. Бусдыг хайрлах энэрэн нигүүлсэх сэтгэлийг хүн бүхэн эзэмших ёстой хэмээн энэ бүтээлд өгүүлдэг.



УДИРТГАЛ

Өглөө босоод радио сонсож, сонин унших бүрд хүчирхийлэл, аймшиг, түгшүүр, дайн дажин, байгалийн гамшиг мэтийн ямар нэгэн эмгэнэлт мэдээ үргэлж чих дэлсэж, сэтгэл донсолгох юм. Энэ мэт золгүй мэдээг сонсолгүй өнгөрөөсөн ганц ч өдөр санаанд эс буунам. Эдүгээ бид бүхний амь нас, тансаг амьдралд цөв учрахгүй гэсэн баталгаа алга. Ийм өлзий бус мэдээг өмнөх үеийнхэн маань дуулж байгаагүй биз ээ. Аймшиг, түгшүүртэй байдлыг байнга мэдрэгч энэрэнгүй уян сэтгэлт хэн боловч ертөнцийн өнөөгийн хөгжил дэвшилд ихээхэн эргэлзэхэд хүрч байна. Үйлдвэр түлхүү хөгжсөн улс оронд бүр ч ноцтой асуудал дэгдэж байгаа нь тодорхой харагдана гэмээн төсөөлмөөр юм шиг.

Шинжлэх ухаан, техник маш олон салбарт гайхамшгийг бүтээлээ. Гэвч хүн төрөлхтөнд тулгарсан амин чухал асуудлууд хэвээрээ л байна. Өнөө үед хэзээ хэзээнээс илүү мэдлэг боловсрол хуримтлагдсан боловч тэр нь сайн сайхнаа бидэнд хайрлахын оронд сэтгэл хямруулж, түгшүүр төрүүлэх боллоо.

Бидний эд өлөг хийгээд техникийн дэвшил үлэмж арвижсан нь эргэлзээгүй ч зовлонгоос хэлтрүүлэн амгаланг авчрахад хүрэлцэхгүй нь мэдээж бөгөөд өнөөгийн хөгжил дэвшлээс ямар нэгэн ноцтой согог үүдэн гарч байгаа юм биш үү хэмээн бодоход хүргэнэ. Энэ бүхнийг тухай бүр шүүн тунгаахгүй аваас хүн төрөлхтний ирээдүйд шил шилээ дарсан аюул учирч болзошгүй. Хүн төрөлхтний аж төрөл хийгээд эд баялаг бүтээх, түүнчлэн оршин амьдарч буй орчлон ертөнцөө төгс танин мэдэх тэргүүтэнд үлэмж хувь нэмэр оруулсан шинжлэх ухаан, техникийн дэвшлийг миний бие ор тас үгүйсгээгүй. Гэвч шинжлэх ухаан, техникийн дэвшлийг бид хэт дөвийлгөн үнэлбээс нэр төр, бодь сэтгэлийн зүг тэмүүлэх хүний мэдлэгийн эрхэм нандин чанар алдагдахад хүрнэ.

Шинжлэх ухаан, техникийн дэвшил эд агуурсын хэмжээлшгүй баялгийг бүтээх чадвартай ч нийт улс үндэстний хэлбэрээр хөгжиж ирсэн дэлхийн соёл иргэншилд үлэмж нөлөөлөх ч улирах цагаар шалгарсан хүмүүнлэг энэрэнгүй ёс суртахууныг орлож чадахгүй нь өдгөө бидэнд тодорхой болов. Бидэнд, шинжлэх ухаан, техникийн хүчээр бүтсэн эд өлгийн ач тус урьд өмнөхөөс үлэмж их нь маргаангүй ч, зовлон зүдгүүр,

аймшиг түгшүүр зэрэг хүн төрлөхтөнд тулгарч буй үндсэн асуудлууд шийдэгдээгүй хэвээр байгаа билээ.

Ингэхлээр нэгэнтэйгүүр эд баялгийг арвижуулах, нөгөөтэйгүүр оюун санаа, ёс суртахууныг төлөвшүүлэх хоёрыг хэм тэгш хөгжүүлэх нь утга төгөлдөр болох буйзаа. Энэхүү аугаа их үйлсийн төлөө хүмүүнлэг ёс суртахуунаа цоо шинээр сэргээн мандуулахад хэргийн учир оршмой.

Эдүгээ дэлхий дахин ёс суртахууны гүн хямралд орлоо хэмээн сэтгэл зовж байдагтай минь олон хүн санал нийлэх болов уу? Нийгмээ улам энэрэнгүй, шударга, эрх тэгш болгоход санаа тавин нэмэр хандив оруулж буй энэрэнгүй үзэлтэн, сүсэгтэн хүн бүхэн дээрх санааг хуваалцана гэдэгт би итгэнэм.

Бурханы шашинтан төвд хүний хувьд ч, бас улс төрийн зүтгэлтний хувьд ч би үүнийг хэлээгүй. Энэрэнгүй нигүүлсэх ёс суртахуун бол Бурхан багшийн их хөлгөний сургаалийн төдийгүй, дэлхийн бусад шашны сургаалийн үндэс гэдгийг номлож, хүмүүнлэг ёс суртахууныг эрхэмлэгчийн нэгэн нь билээ. Би энэ үзлийнхээ үүднээс дараахи бодлоо та бүхэнтэй хуваалцъя. Энэ нь:

1. Дэлхий нийтийн ээдрээтэй асуудлыг шийдэхэд хүмүүнлэг энэрэнгүй үзлийг ноён нуруу болгох.
2. Энэрэн нигүүлсэх үзлийг даян дэлхийн энх амгалангийн тулгуур болгох.
3. Аль ч үзэл сурталтанд хүнлэг энэрэнгүй үзэл адил байдаг шиг дэлхийн бүх шашин энхийн төлөө байх.
4. Хүн төрөлхтний эрх ашигт үйлчлэн нөлөөлөх нийтийн хариуцлага хүн бүрт байх зэрэг болмой.




1940 он

“... Лхаст өнгөрүүлсэн миний балчир нас амьдралын минь хамгийн сайхан үе байжээ.”



“... Миний ээж ядуу хүнийг гар хоосон гаргадаггүй нэгэн байлаа. Гэр бүлдээ зайлиггүй хэрэгтэй хоол хүнсийг ч гэсэн хэрвээ шаардлагатай бол хэн нэгэнд өгчихдөг байсан...”

... Ээж минь миний мэддэг хүмүүцээс хамгийн сайхан сэтгэлтэй хүн байсан. Түүнийг таньдаг мэддэг болгон түүнд хайртай байсан гэдгийг би итгэлтэйгээр хэлж чадна.



*Лхас дахь Потала ордон.
Потала ордон нь Лхасын хамгийн сүрлэг ордон юм.*

ҮЗЭЛ БОДЛОО ӨӨРЧЛӨН ХҮН ТӨРӨЛХТНИЙ АМИН ЧУХАЛ АСУУДЛЫГ ШИЙДЭЦГЭЭ

Эдүгээ бидэнд нүүрлэж буй олон бэрхшээлээс байгалийн гамшгийг хүлцэн тэвчихээс өөр аргагүй. Харин биеэ биеэ ойлгоогүйгээс үүдсэн алив бэрхшээлийг засч болмой. Ийм бэрхшээл нь улс төр, үзэл суртал, шашин шүтлэгийн ялгаанаас болон үл ялиг зүйл, үг хэлээ үл ололцон маргаснаас болдог. Чингэж сөргөлдөн тэмцэлдэх нь хүмүүн төрөлхтнийг нэгэн ам бүлд багтааж байдаг хүн ёсны үндсэн үзлээ гээхэд хүргэдэг. Дэлхийн шашин, үзэл суртал, улс төрийн тогтолцоо олон янз боловч хүн төрөлхтөн амар амгалан, аз жаргалтай байх ёстойг бид эрхгүй санах учиртай. Элдэв хагарал, эд баялгийн болон үзэл сурталын үйлийг хүмүүнлэг сэтгэл, ёс суртахуунаас

дээгүүр тавьж болохгүй. Хамгийн аюултай цөмийн сүйрэл гэхэд л зөвхөн хүн төрлөхтөнийг төдийгүй энэ орчлонгийн бүхий л энх амгаланг бусниулах билээ. Энэ аюулын тухай дэлгэрэнгүй өгүүлэх шаардлагагүй бизээ.

Сайн санаа өвөрлөн цөмийн бүх зэвсгээ даруй устгаж эхлээч гэж дэлхий нийтийн хувь заяаг гартаа барьж байгаа цөмийн зэвсэг бүхий улс гүрнүүдийн удирдагчдад, үй олноор хөнөөх аймшигт зэвсгийг бүтээж буй эрдэмтэд, техникийн ажилтнуудад, мөн удирдагч нартаа нөлөөлж чадах бүх хүмүүст хүснэм.

Цөмийн дайнд ялагч байхгүй, хэн ч амьд үлдэхгүй гэдгийг бид бүгдээрээ ухаарч байна. Хүмүүнлэг бус, санаанд багтамгүй ийм сүйрлийг төсөөлөхөд юутай аймшиг билээ? Гэтлэх арга зам, цаг хугацаа байгаа болохоор дээрх аюулыг зайлуулах нь буянтай үйлс болохгүй гэж үү?

Ер нь бид тулгарсан бэрхшээлээс ихэнхдээ гарч чаддаггүйн учир нь түүний шалтгааныг мэддэггүйд, мэдсэн ч шийдэх аргыг олж чаддаггүйд оршино. Энэ бол гагцхүү цөмийн аюул лугаа холбоотой зүйл ч биш юм.

Дээд төрлийг олсон хүн төдийгүй адгуус мэт эгэл төрөлтөн алин боловч бүгдээрээ энх амгалан, таатай нөхцөл, аюулгүй байдлыг тэмцэн эрэлхийлдэг. Зон олонд амьдрал хичнээн эрхэм байдгийн нэгэн адил адгуус амьтанд ч мөн л нандин билээ.

Хамгийн өчүүхэн хорхой шавьж атугай ч амь насандаа учрах аюулыг сөрөн тэмцдэг бус уу? Бидний хэн маань ч амьдрахыг хүсэхээс бус үхэхийг эс бодох бус уу? Ертөнцийн хамаг амьтан ямар нэгэн арга сүвэгчлэн, хүч чадлаа шавхан амьдрахын төлөө л зүтгэдэг.

Ерөөс зовлон жаргал болвоос бие, сэтгэлийн гэсэн хоёр талтай болой. Үүнээс сэтгэлийн зовлон жаргалыг онцгой анхаарах хэрэгтэй гэж бодогдном. Зовлонг гэсвэрлэх сэтгэлийн тэнхээтэй байваас ашид мөнхийн энх амгаланд хүрнэ гэдгийг би онцлон хэлмээр байна.

Аз жаргал буюу хүний амгалан сэтгэлийг эдийн засгийн хөгжилтэй, юуны өмнө дэлхий ертөнцийн энх амгалантай холбон сэтгэхийг би хичээдэг. Энэ зорилгод хүрэхийн тулд үндэс угсаа, нас хүйс, арьс өнгө, шашин шүтлэгийн алийг ч үл харгалзан хамтын хариуцлагын ухамсрыг ариусган хөгжүүлэх нь чухал хэмээн би үздэг. Хамтын хариуцлага хэмээх санааны гол утгыг товчилбоос бусад хүн ч надтай хүсэл нэг гэсэн үг ээ.

Аливаа амьтан амгаланг хүсэхээс бус зовлонг үл хүснэ. Ухамсартай хүмүүн бид энэхүү үнэнийг эс зөвшөөрвөөс ертөнцийн зовлон улам зузаарах буй за. Хэрэв бид өөрийн тусад бусдынхыг захируулж ашиглаваас үйлс маань түр зуур бүтэх мэт боловч алд биеийн жаргал, амар амгаланг олж эс чадахаар үл барам ертөнцийн энх амгалангийн тухай ярихын ч хэрэггүй болой. Жаргал эдлэхийн тулд хүмүүс янз бүрийн арга сүвэгчилж ирсний ихэнх нь хэрцгий балмадаараа бусдын жигшил зэвүүцэл төрүүлж байв. Зөвхөн өөрийн тусад нийцсэн, хүний ой тойнд багтамгүй хэрцгий арга мэх хэрэглэх нь бусад хүн амьтныг зовлонд унагана. Ийм харалган үйл эцэстээ өрөөл бусдад төдийгүй эргээд өөрт нь зовлон тарина.

Эрдэнэт хүний биеийг олж төрнө гэдэг ховорхон заяах учрал мөний тул туйлын бодолтой, ач тустай амьдрах нь хэрсүү ухааных болой. Бид орчлон ертөнцийг зөвөөр ойлгож, аз жаргалыг олохдоо бодгаль хийгээд хэсэг бусаг хүний нэр алдрын тусын тулд бусдын хөлс



хүчийг шавхах нь тэвчишгүй хэрэг. Иймээс дэлхий нийтийн асуудалд шинээр хандах шаардлага гарч байна. Улс түмний харилцаа, худалдааны өргөжилт, техникийн үсрэнгүй хөгжлийг дагалдан улс гүрнүүд улам бүр ойртож, бие биеэс үлэмж хамаарах боллоо. Урьд аливаа хэрэг явдал ихэвчлэн гэр бүлийн шинжтэй байсан тул тэндээ л шийдвэрлэгддэг байжээ.

Өдгөө бид нэгэн их айлын халуун ам бүл гэсэн итгэл ухааралгүй, хамтын хариуцлагын ухамсаргүй, ахан дүүсэг сэтгэлгүй байваас бидний оршин буй ертөнцөд учрах аюулыг гэтлэн туулах найдваргүй агаад гагцхүү өөдрөг бодол л бидэнд аз жаргал, амар амгаланг авчирч чадмой.

Энэ нь бид бие биеэсээ маш их хамаардаг, туйлын нягт холбоотой болсны гэрч бус уу? Нэжгээд улс гүрэн хэрэг явдлаа дангаар шийдэхэд ихээхэн бэрхшээлтэй болсон төдийгүй бусад улс үндэстний хамтын ажиллагаа, сонирхол, хандлага зэргээс үлэмжхэн шалтгаалах болжээ.

Бидний энэрэн нигүүлсэх үзэл дэлхий нийтийн асуудлыг шийдэхэд туйлбартай энх амгалангийн үндэс болж байна. Үүний утга нь дээр дурьдсанчлан амьтан бүхэн зовлонгоос ангижирч, амар амгаланг эгээрэх хүсэл болой. Бусдын хүсэл эрмэлзлэл, тэмүүллийг үл ойшоон, зөвхөн хувийн жаргалыг горилвоос хүнлэг ёс суртахуунд үл нийцсэн ухаалаг бус хандлага болно. Өөрийн жаргалыг эрэхийн зэрэгцээ бусдын жаргалыг бодолцох нь гагц мэргэн ухаан мөн. Үүнийг би “өөртөө санаа тавих мэргэн арга” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь улмаар “өөр бусдын хүсэл сонирхол хосолсон арга” болон хувирах бөгөөд түүнийг “харилцан ашигтай хүсэл

сонирхол” гэж нэрлэвэл илүү тохиромжтой мэт.

Улс хоорондын харилцан анхаарал гүнзгийрч, улам нийцтэй хамтын ажиллагаа хөгжинө хэмээн хүмүүс найдаж буй боловч хүмүүс бусдынхаа аз жаргал, хүсэл тэмүүлийг үл ойшоон, эс хэрэгсэх аваас жинхэнэ хамтын ажиллагаанд хүрэхэд хэцүү амой.

Голдуу шунал, атаа жетөөний уршгаар хамтдаа эвтэй найрсаг амьдрах нөхцөл бүрэлдэхгүй байна. Явцуу эрх ашгийг хамгаалсан улс төрийн хэрэг явдлыг шашны нөлөөгөөр шийдэж болохгүй авч бидэнд тулгарсан бэрхшээлийн үндсийг цаашдаа тасалж болох талтай. Нөгөөтэйгүүр хүн төрөлхтөн ээдрээтэй асуудлаа хөнгөн хуумгай яаран шийдвэл хойч үе маань ихээхэн бэрхшээлтэй тулгарна.

Дэлхийн хүн ам нэмэгдсээр нөөц баялаг нь шавхагдсаар байна. Ой модоо харъя л даа. Ойн модыг маш их хэмжээгээр огтлох нь цаг уур, хөрс шороо, байгаль орчны тэнцвэр тэргүүтэнд ямар их сөрөг нөлөө үзүүлж байгааг хэн ч тоймлохгүй. Хүн төрөлхтний гэр болсон эх дэлхийнхээ талаар хүмүүс санаа тавихгүй, аминч ахархан бодол сонирхолдоо хөтлөгдөн хэт бөөгнөрснөөс бидэнд хэцүүхэн асуудлууд тулгарлаа.

Дэлхий нийтийн амьдралд урт удаан хугацаанд хэрхэн нөлөөлөх тухайд хүмүүс санаа тавихгүй байна. Өнөө үеийн бид үүнийг одооноос сайтар анхаарахгүй аваас тулгарсан бэрхшээлийг даван туулахад залгамж үед маань ихээхэн төвөг учирна.



ЭНЭРЭН НИГҮҮЛСЭХҮЙН ҮЗЭЛ ДАЯН ДЭЛХИЙН ЭНХ АМГАЛАНГИЙН ТУЛГУУР

Шунал, хүсэл, урин тачаангуй болон юмсыг мөнх мэтээр андууран мунхагладгаас ихэнх зовлон төрдөг хэмээн Бурхан багш сургадаг. Хүсэл, зорилгод хүрэх шилдэг арга бол хүчирхийлэл, түрэмгийлэл хэмээн бид эндүүрэх юм. Ийм үзэл бодол маш хялбархан үйлдэл болон хувирдаг бөгөөд түүний үр дагавар нь зэвсэгт мөргөлдөөн, дайн дажин болой.

Иймэрхүү үйлдэл улирах цагаас хүний оюун санаанд байнга оршсоор иржээ. Нэн ялангуяа орчин үед энэ нь бүр ч хялбархан гүйцэлдэж байна. Бид алив хүсэл шунал, хүчирхийлэл гэх мэт атгаг муу сэтгэлийг яаж хянан зохицуулах вэ? Эл атгаг хорон санаа хорвоо

ертөнцийн аливаа зовлонгийн шалтгаан болдог ажээ. Бурхан шашны их хөлөгний боловсрол олсон миний хувьд ертөнцийн энх амгалантай золгуулах гол үзэл бол энэрэн нигүүлсэх сэтгэл мөн. Энэрэн нигүүлсэх үзэл гэж чухам юуг хэлж буйг тодруулсу.

Та гуйлгачин хүн хараад энэрэн өрөвдөх нь түүний ядуугийн зовлонг мэдэрч, энэрэн нигүүлсч буй хэрэг. Энэ нь аминч бус, бусдыг гэсэн сэтгэл мөн. Үлгэрлэвээс эхнэр нөхөр, үр хүүхэд, өмөг саднаа энэрэн хайрлах сэтгэл тань нигүүлсэх сэтгэл бус, харин ачийг ачаар гэсэн алагч сэтгэл болой. Хэрэв ач тус хүргэхээ боливол таны энэрэх сэтгэл хувьсаж үгүй болж ч мэднэ. Иймээс энэ бол жинхэнэ энэрэн нигүүлсэх сэтгэл бус нь тодорхой. Жинхэнэ энэрэн нигүүлсэх сэтгэл гэдэг болбоос ач тусын хариуг үл бодон бусдын тусыг л урьд л болгохыг хэлнэ. Чингэвээс бусдыг энэрэн нигүүлсэх таны сэтгэл орчлонгийн зовлонг хоосортол орших болно.

Энэрэн нигүүлсэх сэтгэл хязгаар үгүй бөгөөд түүнийг эзэмшихийн тулд цаг ямагт хичээвэл зохино. Гэр бүл, өмөг садандаа бидний хүртээж байгаа хүсэл шунал, ач тусын хариу хольцолдсон мунхаг сэтгэлээс хамаг амьтныг чин санаанаасаа энэрэн нигүүлсэх хязгааргүй сэтгэл үлэмж ялгаатай нь тодорхой. Өгүүлэн буй энэрэн нигүүлсэх сэтгэлийн утга маш өргөн агаад өөрт нь хөнөөл учруулсан дайснаа ч энэрэн нигүүлсэж чадах сэтгэлийн тэнхээг хэлнэ.

Бидний хэн маань ч зовлонгоос ангижирч, амгаланг хүсч байдагт нигүүлсэх сэтгэлийн зохистой тал оршино. Энэ нь аз жаргалыг олох бүх нийтийн хүслийг хязгаарлагч “Би” хэмээх хүчит мэдрэмж дээр тулгуурлана. Үнэндээ амьтан бүхний хүсэл адилхан бөгөөд хүслээ хангах



бүгдийн эрх ч бас адил билээ. Хэрэв бусадтай жишвэл би ганц хүмүүн тул бусад хүмүүсийн ашиг сонирхол илүүтэй чухал.

Бурхан багшийн сургаал ёсоор төрүүлсэн эх шигээ амьтан бүхнийг адилтан санаж, эхээ хайрлаж хүндэтгэх сэтгэлээр бусдыг ачлах учиртай. Бурхан шашны ёсоор, амьтан бүхэн тэргүүлшгүй цагаас тоо томшгүй удаа төрөл арилжихдаа хэзээ нэгэн цагт бидний эх болон төрж агсан болой. Тиймээс энэ ертөнцийн бүх амьтан нэгэн айлын ураг төрлийн хүмүүс мэт холбогдсон амой. Шашинд итгэдэг ч бай, үгүй ч бай ямар боловч энэрэн нигүүлэх сэтгэлийг эс хүндэтгэдэг хүн байх ёсгүй. Бид мэндэлсэн цагаасаа л эцэг эхийнхээ хайр халамжийг амсдаг шигээ өтлөх, өвдөх, зовохын цагт бусдын халамж хишгийг аргагүй хүртдэг. Хүмүүс бид амьдралын эхэн болоод эцэст бусдын хайр халамжийг хүртдэг атлаа идэр насандаа бусдын тусыг бодохгүй байж болно гэж үү?

Бусдыг энэрэн хайрлах уужим сэтгэлийг эзэмших нь зөвхөн сүсэгтэн хүний хэрэг биш боловч түүнийг шашны үйл ажиллагаатай нь холбон үзэж заншжээ. Энэрэн нигүүлсэх сэтгэл зөвхөн сүсэгтэй хүмүүст хэрэгтэй төдийгүй улс төр, үзэл суртал, шашин шүтлэг, арьс өнгө ялгалгүй, хэн бүхэнд чухал. Энэрэн нигүүлсэх сэтгэл нь өөрийгөө хүн төрөлхтний нэгэн тасархай хэмээн эн тэргүүнээ үзэх үүднээс өргөн цараар сэтгэдэг аливаа хүнд байдаг амой. Энэ ачлалт сэтгэлийг, ялангуяа өсөх зандан насандаа эзэмшиж баримтлахыг үл ойшоож, аюул бэрхшээл тулгарахгүй мэт бодох нь идэр залуугийн атгаг сэтгэл мөн буй за.

Хамаг амьтан зовлонгоос ангижран амар амгаланг горилдог нь үнэн болохоор бид алс ирээдүйг бодохдоо

үй олон амьтнаас өөрийн элгэн саданг илүүд үзэж алагч-лалгүй, нийтийн тусыг эрхэмлэх нь өглөгч нинжин сэтгэл болой. Үзэл бодлын ийм сэтгэлтэй болж чадваас жинхэнэ нинжин сэтгэлээр бусдыг хайрлан энэрч, хүндлэн дээдлэхийн үнэн мэдрэмж төрөх нь дамжиггүй. Алив хүнд хувиа хичээх ухамсар хар аяндаа тогтдог. Тэгвэл бусдын тусыг дээдэлсэн энэрэх буянт сэтгэлийг хүчлэн гаргахгүй аваас хувийн жаргал, амар амгаланд хүрэх нь хол бизээ.

Оюун санааны хөгжлийн онцгой сайн нэгээхэн үр болвоос сэтгэлийн догширлыг номхотгож, тайван ухаалаг байхад оршино. Энэ бол бидний өдөр тутмын амьдралд хамгийн ашигтай зүйл мөн. Бидний амьдралд мөнхийн хувьсал хөдөлгөөнд орших тул өдий төдий бэрхшээлтэй тулгардаг.

Сэтгэлээ номхотгон тогтоож, уужим саруул ухаан гаргаваас тэдгээр бэрхшээлийг төвөггүй гэтэлж чадна. Харин өшөө хонзон, атаа жөтөө, урин тачаангуй тэргүүтэнд эзлэгдэж, сэтгэлийн догшролыг үл номхотговоос өөрийгөө хянаж чадахгүйд хүрнэ. Чингэвээс бидний билгийн нүд сохорч, сэтгэлийн жолоо алдарна.

Энэ аймшигт агшинд элдэв самуун дайн мэт асар мунхаг явдал үүснэ. Учир иймд бусдыг энэрэх нинжин сэтгэл, билгийн тайван ухаан хэн бүхэнд, нэн ялангуяа ертөнцийн энх амгаланг цогцлуулах боломж хүчинд нөлөөлөгч төрийн зүтгэлтэн, улс гүрний ажил үйлсийг хөтөлдөг хүмүүст онц хэрэгтэй болой.



*Дээрхийн гэгээнтэн Арвандөрөвдүгээр Далай лам Данзанжамц
1950-иад оны үед
(Эмч, эрдэмтэн орчуулагч М.Шагдарсүрэнгийн хувийн архиваас)*



*Дээрхийн гэгээнтэн Арвандөрөвдүгээр Далай лам
Данзанжамц, Ванчин-Эрдэнэ богдын хамт.
1950-иад оны сүүлээр
(Эмч, эрдэмтэн орчуулагч М.Шагдарсүрэнгийн хувийн
архиваас)*




*1940 оны хоёрдугаар
сарын 22.*

*Бурханы шашны
тэргүүн Далай ламын
Арвандөрөвдүгээр дүрээр
тодруулан, тэргүүнээр
залах ёслолын цеэр*

*“... Би хэдийгээр Далай лам, төвдийн тэргүүн болсон
ч миний эцэг эх маань юу хүсч, юу мэдэж буйгаа
нуулгүйгээр надад хэлдэг байсан.*

*Тийм учраас би ард түмнийхээ ахуй амьдралыг тийм
ч сайн сайхан бичи байна даа гэдгийг үргэлж мэдэрч
байсан.”*



Хойд Энэтхэгт ном айлдаж буй нь



ДЭЛХИЙН ШАШНУУД ЭНХ АМГАЛАНГИЙН ҮЙЛСЭД

Дээр дурдсан зарчмууд бол дэлхийн бүх шашны ёс суртахууны үндсэн сургаал мөн. Бурханы шашин, Христос, Кунз, Хиндиүзм, Лал, Жайны, Жудаизм, Сикийзм, Даосизм, Зароастринзм зэрэг томоохон шашнууд сүсэгтнээ эрхэм дээд хүмүүжилтэй болгох, үйл ажлаараа нийт хүн төрөлхтний сайн сайхан аж төрөл, энэрэхүйн туйлын санааны төлөө нэгэн зорилготой учраас миний бие тэдгээрийг ялгалгүй дэмжин хүндэтгэдэг. Аливаа шашин хүний бие, хэл сэтгэлийн үйлийг боловсруулж, ёс суртахууны хэм хэмжээг тогтоож, худал хэлэх, хулгай хийх, амьтны амь хороохыг цээрлэдэг билээ.

Замбуулингийн сартваахи нарын сургасанчлан ёс суртахууны бүхий л хэм хэмжээний нийтлэг үндсэн зорилго нь өөрийнхөө бус, харин бусдын тусыг бодох сэтгэл юм. Мунхагийн харгайгаар буруу замд орсон сүсэгтнүүдийг зөв замаар хөтлөхийг тэдгээр гэгээн багш нар зорьжээ. Хувиа хичээх мэт элдэв зовлонгийн уг үндсийг таригч мунхаг сэтгэлийг тэвчих нь чухал хэмээн шашин бүхэн сургадаг болой. Мэргэн ухаан, ёс суртахууны зөв хүмүүжил, сэтгэлгээ тогтоож энх амгалангийн замыг гэрэлтүүлж өгдөг учраас аливаа шашны сургаал мөр нэг гэдэгт би хатуу итгэдэг.

Аливаа номлолын ялгаа нь тухайн цаг хугацаа, нөхцөл байдал, соёлоор тохиосон байдаг авч шашинд дан ганц метафизик талаас хандвал хоосон цэцэрхсэн, эцэс төгсгөлгүй маргаан болно. Гэхдээ янз бүрийн шашны сургаалийн жижиг сажиг ялгааны тухай маргалдаж байснаас бусдыг энэрэн нигүүлсэх талаар аливаа шашны бүтээж буй болгосон эрхэм сургаалийг л өдөр тутмын амьдрал ахуйдаа ашиглах нь илүү ач тустай бус уу.

Өвчин тус бүрийг анагаах олон янзын арга байдагтай нэгэн адил шашин болгон амар амгалан, таатай нөхцөлийг хүн төрөлхтөнд авчрах нэгэн зорилготой. Аль нэг шашин үнэнийг илүү тодорхой тайлбарласан тохиолдлыг мэдэрч болох авч зовлонгоос ангижирч, энх амгаланг олох замыг шашин бүхэн өөрийн сургаалдаа заасан байдаг. Хүн бүхэн сэтгэлээрээ нэгдсэн цагт л ер бусын хүчтэй. Зовлонг нимгэлэхийн тулд шашин болгон өөрийн гэсэн арга хэрэглэж, дэлхийн соёл иргэншилд хувь нэмрээ оруулж иржээ. Тиймээс нэг шашнаас нөгөө шашинд орно гэх нь гол бус. Үлгэрлэвээс өөр шүтлэгтэн Буддын шашинд орох нь зөв гэх буюу Буддын шашин бусад

шашнаас илүү дэлгэрч байх ёстой хэмээж үл болно. Чухам энэ үүднээс, Бурханы шашинтны хувьд алив хүний аз жаргалд хувь нэмрээ оруулахыг би хичээдэг.

Дэлхийн бүх шашин ерөнхийдөө адил тул аль нэг шашныг онцгойлон бусад шашны дээр тавьж үл болох агаад “Дэлхийн шашныг” шинээр эрэлхийлэх ч шаардлагагүй. Дэлхийн соёл иргэншилд болон хүн төрөлхтний амьдралыг баян тансаг, утга төгөлдөр болгоход янз бүрийн шашин шаардлагатай нь зүйн хэрэг. Байгалиас заяасан сэтгэн бодох чадвар хүн бүрт харилцан адилгүй учраас энх амгалан, аз жаргалыг олоход элдэв арга хэрэгтэй. Энэ нь яг л хоол унд шиг л чухал байдаг. Зарим хүнд Христосын шашин таалагддаг байхад зарим нь Буддын сургаалийг илүүтэй шүтэж бишрэх жишээтэй. Ертөнцийг бүтээгч гэж байхгүй, бүх юм хүмүүн бидний үйлээс хамаардаг гэж Бурханы шашин сургасан буй. Иймэрхүү маргаантай зүйлийг бусад шашны хувьд ч хэлж болно. Ийнхүү уг асуудал тодорхой байна. Учир юу гэвэл үндэсний хэв заншлын шаардлага, оюун санааны элдэв хэрэгцээг хангах, амьдрах аргаа олоход нь бодгаль хүмүүнд аль ч шашин тодорхой үүрэг гүйцэтгэдэг болохоор бүх шашин дэлгэрч байх ёстой.

Дэлхийн өнцөг булан бүр дэх аливаа шашин, сүсэгтнүүд бие биенээ ойлгох ач тусын үүднээс ихээхэн чармайлт гаргаасай гэж би хүсч байна. Ийм чармайлт, ялангуяа өнөө үед хойшлуулшгүй амин чухал зүйл боллоо.

Хүн төрөлхтний сайн сайхныг бүх шашин эрхэмлэж чадвал ертөнцийн энх амгалангийн төлөөх үйлсэд

найрсгаар хамтран ажиллахад дөхөм болно. Харилцан ойлголцож, нэг чиг хандлагатай байвал бүх шашин хамтран ажиллах ач тустай нэгдэл буй болно. Гэхдээ энэ нь хэдий чухал алхам боловч хялбархан шийдвэрлэгдэхгүйг санавал зохино.

Шашин бүр номлол сургаалийн хувьд ялгаатай нь нууц биш, бас оршин буй шашнуудыг нийтэд таашаагдах шинэ шашнаар сольж чадахгүй нь ойлгомжтой. Амьдралаа ойлгоход нь шашин бүр өөрийн гэсэн аргаараа хүмүүст нөлөөлж тусалдаг. Иймээс бүх шашин цөмөөрөө л байх учиртай. Энх амгаланг эрхэмлэгч сүсэгтнүүдэд хоёр чухал асуудал тулгардаг.


Нэгд. Бүх шашин хамтран ажиллаж болохуйц нийтлэг талбар буй болгохын тулд харилцан бие биеэ ойлголцох замыг улам эрчимтэй хайх хэрэгтэй. Үүний тулд шашин шүтлэгээ харилцан хүндэтгэх, хүн төрөлхтний сайн сайхны төлөөх үйлсэд санаа зоригоо нэгтгэхийг чухалчлах нь зохистой.

Хоёрт. Хүн бүрийн зүрх сэтгэлийг булааж чадах шашны ёс суртахууныг үндэс болгож, нийтийн аз жаргалыг санаа нийлэн бүтээх ёстой. Хүмүүнлэг энэрэнгүй үзэл л дэлхийн бүх шашны хамгийн гол үндэс мөн билээ. Энэ хоёр чиглэл даян дэлхийн энх амгалангийн төлөө шашин тус бүрт ч, бүгд хамтран ажиллахад ч зайлшгүй чухал оюун санааны нөхцөлийг бүрдүүлж байна.

Аливаа шашин бусдыг хүндлэн хайрлах нийтэч үнэн мэдрэмжийг хөгжүүлэх гол хэрэглүүр гэж үзсэн цагт л дэлхийн энх амгалангийн төлөөх үйлсэд сүсэгтнүүд хамтран ажиллах болно. Метафизикийн нарийн ялгааны



асуудал шашин бүрийн дотоодын хэрэг тул түүгээр хөөцөлдөхгүйгээр энх амгалангийн нийтлэг үйлсэд дэлхийн томоохон шашнууд хувь нэмрээ оруулж, хамтран ажиллавал хүн төрөлхтөнд үр ашгаа өгнө гэдэгт би бат итгэнэм. Шашныг эсэргүүцсэн янз бүрийн үзэл суртал манай гарагийн энд тэнд дэлгэрч, шашны ёс суртахууныг бусниулж буй боловч хүн төрөлхтний үлэмж хэсэг шашинд итгэсээр байгаа билээ. Шашингүй улс төрийн тогтолцоо бүхий газарт ч ард олны шашинд сүсэглэсээр байгаа нь шашны хүч сулраагүйг гэрчилж байна. Орчлон ертөнцөд энх амгаланг тогтоох оюун санааны таатай нөхцөлийг шашны энэхүү хүч бүрдүүлж чадна. Тиймээс шашны удирдагч болон энэрэнгүй үзэлтнүүд энэ талаар маш чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Бид даян дэлхийн энх амгаланд хүрч чадах ч бай, үгүй ч бай энхийг зорихоос өөр чиг зам байхгүй. Хэрэв бид омог бардам хүчирхийлэх сэтгэлд автагдвал зөв бурууг ялгах билэг оюунаа гээж, хүний оюунаа гээж, хүний оюун ухааны хамаг нандин чанараа алдахад хүрнэ. Омог бардам сэтгэл, хүчирхийлэл бол хүн төрөлхтөнд тулгарч байгаа ноцтой олон асуудлын нэг мөн.



ОХУ-ын Буриадад
1992 он.

Лондон хотноо хэвлэлийн
бага хурлын цеэр. 1988
оны дөрөвдүгээр сарын
14-нд



Потала ордонд буй
V Далай ламын дүр

“... Хүмүүст бид өөрсдийгөө
газар дэлхийг сөнөөх
чадвартай гэдгийг мэдэж
байна. Ингэж сөнөөх
чадвартай гэдгийг мэдэж
байна. Ингэж сөнөөх эрх
мэдэл ба чадал ямар ч хорхой
шавьж, шувуунд байхгүй.
Хэрвээ хүмүүс бид газар
дэлхийг сөнөөх чадвартай
бол түүнийг хамгаалах,
сэргээх чадвар бидэнд байх
ёстой. Эх дэлхий маань эрх
ганц хүчхдийнхээ ямар ч
ааш аягийг тэвчдэг эх хүн
шиг хүмүүс бидний хорлол,
сүйтгэлийг тэвчсээр өнөөг
хүрэв...”

эс хүссэн сөрөг нөхцөлийг үүсгэдгээрээ байнга зовлон тарина.

Ийм учраас янз бүрийн улс үндэстний тэргүүн нар хүн төрөлхтний амар амгалан аж төрөх нийтлэг шаардлагыг ойлгож, бие биеийг хүндэтгэх цаг нэгэнт болжээ. Ингэх нь хувь хүн, нийгэм, улс үндэстэн цаашилбал дэлхий нийтийн ашиг тусад нийцнэ.

Дэлхий дахины түгшүүртэй байдлын үлэмжхэн хэсэг нь дэлхийн хоёрдугаар дайнаас хойш үргэлжилсэн “Өрнийн хориг”, “Дорнын хориг” гэгчийн хоорондын зөрчлөөс үүдэж байгаа юм. Энэ хоёр хориг хэзээ ч харилцан үл тохиролцох мэтээр санаж, бие биеийн эсрэг сөрөн зогсчээ. Энэхүү утгагүй атлаа үргэлжилсээр буй тэмцэл нь бие биеэ хүн ёсоор үзээгүй, зүйлд нийцүүлэн хүндлээгүйгээс үүдэн гарчээ. Өрнө, Дорнын хориг харилцан бие биеэ үзэн яддаг, дайсагналцдагаа зогсоовол зохино. Тэнд аль алинд нь хүн л байгаа шүү дээ.

Дайсагналцах үзлээ багасгахад хоёр хоригийн удирдагчид чухал үүрэг гүйцэтгэж чадах нь дамжиггүй. Тэдгээр удирдагчид юуны урьд хоёр талын хүмүүсийг адилхан л хүн гэж үзэх ёстой. Энэ үндсэн санааг эс тоомсорловол дайсагналцах үзлийг намжаахад олигтой үр дүн гарахгүй.

Үлгэрлэвээс АНУ, ЗХУ-ын удирдагчид эзгүй газар санамсаргүй тааралджээ гэж бодвол тэд бие биеэ хүмүүнлэг ёсоор хүндлэн золгоно гэж би бодном. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, АНУ-ын Ерөнхийлөгч хоёрыг хардлага сэрдлэг, үл ойлгохын хана тусгаарлаад байна.

Албан ёсын бус байдлаар, тусгай төлөвлөсөн зүйлгүйгээр тэд уулзвал хүмүүсийн хэлхээ холбоо, харилцан ойлголцох явдал сайжирч, бие биедээ хүмүүнлэг ёсоор хандах харилцаа тогтож, чинагш олон улсын асуудлыг нааштай шийдэх боломж бий болно. Харилцан үл итгэх, үзэн ядах уур амьсгал оршин буй цагт эсрэг тэсрэг үзэлтэй хоёр талын хүмүүст үр дүнтэй хэлэлцээр хийж чадахгүй.

Миний бодлоор бол дэлхийн улс гүрний удирдагчид жилд нэг удаа ч болов үзэмж төгөлдөр нутагт алба ажил ярилгүйгээр, бие биетэйгээ найрсаг уулзаж байвал тун ч зүгээрсэн.

Хүн хүнтэйгээ харилцах харилцааг сайжруулахын тулд олон улсын жуучлалыг үлэмж хөгжүүлэх хэрэгтэй гэж би санадаг. Ялангуяа хүн төрөлхтөн эцсийн эцэст нэг нэгдмэл гэдгийг ардчилсан нийгмүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сайтар сурталчилбал даян дэлхийн энх амгалангийн үйлсэд маш их хувь нэмэр болохсон билээ.

Дэлхийн тавцанд хэд хэдэн томоохон гүрэн гарсантай холбогдон олон улсын байгууллагуудын хүнлэг энэрэнгүй ёсны үүргийг басамжилж үл ойшоох байдал гарч байна. Ийм буруу хандлагыг засаж болно гэдэгт би итгэдэг. Олон нийтийн байгууллагууд, ялангуяа НҮБ улс түмний харилцан ойлголцлыг сайжруулах, хүн төрөлхтөнд таатай нөлөө үзүүлэхүйц нөхцөл бүрдүүлэх талаар үлэмж үр өгөөжтэй, идэвхтэй ажиллаж чадна гэж би үзэж байна. Хүчтэй том гүрнүүд НҮБ мэтийн олон улсын нэр хүнд бүхий байгууллагыг өөрийн эрх ашигт нийцүүлэн хортойгоор ашиглавал ноцтой аюулд хүргэнэ.



НҮБ дэлхийг энх амгалан байлгах гол байгууллага болох ёстой. НҮБ бол дарлагдсан буурай ард түмнийг төдийгүй манай гаригийг амгалан тайван байлгах гол найдвар учраас энэ байгууллагаа бид хүндэтгэх учиртай. Улс үндэстнүүд бие биенээсээ эдийн засгийн хувьд урьд үзэгдээгүйгээр хамаарах болсон тул хүмүүсийн харилцан ойлголцол нэг улсын хүрээнээс хальж, түүнийг олон улсын хэмжээнд авч үзэх хэрэгтэй болов.

Үнэндээ жинхэнэ хамтын ажиллагааны уур амьсгалыг бид чин сэтгэлийн харилцан ойлголцлоор бус, харин хүч хэрэглэх, сүрдүүлэх замаар бий болговол дэлхий нийтийн ээдрээтэй асуудлууд улам ч олширно.

Хэрэв бид бага буурай орнуудын ард түмний хүсэл, бодол, хувь нэмэр, аз жаргалыг үгүйсгэвэл тэд хямарч, том гүрнүүдэд сөрөг нөлөө үзүүлэх болно. Эс таашаасан нийгэм, улс төр, соёлын хэлбэрүүдийг тухайн ард түмэнд хүчээр тулгах явдал үргэлжилбэл даян дэлхийд амгаланг тогтооно гэдэг эргэлзээтэй.

Хэрэв хүмүүсийг чин сэтгэлийн тааламжтай байдалд оруулж чадвал бид энх амгаланд зайлшгүй хүрнэ. Нэгэн улсын дотор аз жаргалтай амьдрах эрхийг хүмүүст олгох, олон улсын хэмжээнд бол бүр хамгийн жижиг үндэстний сайн сайхны төлөөх бодлогыг нэгэн зиндаанд явуулбал зохилтой. Нэг тогтолцоо нь нөгөөгөөсөө илүү сайн гэж би хэлэхгүй. Үүнийг бүх нийтээр хүлээн зөвшөөрөх учиртай. Нөгөө талаас авч үзвэл, улс төрийн янз бүрийн тогтолцоо, үзэл суртлууд байх нь зүйн хэрэг. Яагаад гэвэл хүний нийгэмд зуршмал зан заншил байдаг юм.

Аз жаргалын төлөөх зогсолтгүй эрлийг эрчимтэй болдогт түүний ялгаа оршино. Ингэхлээр тухайн нийгэм

бүр өөрийн онцлогийг харгалзах зарчмыг удирдлага болгон улс төр, нийгэм, эдийн засгийн өвөрмөц тогтолцоогоо чөлөөтэй хөгжүүлэх ёстой. Шударга ёс, найрсаг харилцаа, энх амгаланг тогтоох нь олон тооны хүчин зүйлээс шалтгаална. Бид эдгээрийн тухайд ахар богино хугацаанд бус, харин удтал үргэлжилж хүн төрөлхтөнд үр шимээ өгөх талаас нь бодох ёстой.

Бидэнд хийвэл зохих асар их ажил тулгарч байгааг би ойлгож байна. Гэвч нийт хүн төрөлхтний тусыг урьтал болгох тухай миний дээр дурдсан санаанаас өөр замгүй мэт. Хүнлэг ёсыг эрхэмлэсэн улс үндэстэн бүр бусдын сайн сайхны төлөө санаа тавих хэрэгтэй.

Энэ нь харилцан ойлголцол, нийтийг хамарсан удаан хугацааны сонирхол, хэрэгцээнээс үүдэн гарч байгаа юм. Европын эдийн засгийн Нийгэмлэг, Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн эдийн засгийн холбоо гэх мэт бүс нутгийн хийгээд тивийн эдийн засгийн байгууллагууд гарч ирсэн нь үүний нотолгоо мөн.

Иймэрхүү олон улсын байгууллагууд ялангуяа эдийн засгийн хөгжил, улс төрийн тэнцвэр муутай бүс нутагт улам олширно гэдэгт найдаж байна.

Орчин үеийн нөхцөлд хамтын хариуцлага, “хүн хүнээ ойлгох” явдлыг ухаарах нь илтэд нэмэгдэж байна. Үүнд хүрэхийн тулд бид сайн санаа, ариун сэтгэл гаргах ёстой. Чингэхгүйгээр ертөнцийн энх амгалан, аз жаргалд хүрч чадахгүй. Бүх нийтийн хариуцлага, ахан дүүсэг найрамдлын тухай ярьж байгаа өнөө үед манай гарагт дээрх хүний нийгэм чухамдаа тус тусын үндэсний хэлбэртэй бүрэлдэн тогтжээ. Тийм учраас энх амгалангийн төлөөх тэмцэлд эдгээр нийгэм тус бүр чухал

үүрэг гүйцэтгэх учиртай гэж үзэж байна. Нийгмүүдийг улам эрх тэгш, шударга болгох гэсэн оролдлого өнгөрсөн хугацаанд гарсаар ирсэн билээ. Нийгмийн эсрэг хүчнүүдтэй тэмцэх шулуун шударга дүрэм баримталсан олон байгууллага бий болжээ. Эдгээр санааг хувиа хичээх, аминч үзэл халхалсаар байгаа нь тоогүй хэрэг.

Ёс суртахуун, шударга зарчмууд урьд өмнө үзэгдээгүй хэмжээгээр хувийн сонирхолын сүүдэрт бүдгэрч буйг ялангуяа улс төрийн хүрэннээс харж болно. Өнөө үед улс төр, ёс суртахууны нандин чанараа алдсан учраас улс төрөөс зайлсхийсэн шинэ үзэл гарч, улс төрөөс бүрмөсөн ангижрахыг бидэнд сануулж байна.

Хүний нийгмийг ёс суртахуунгүй улс төр хэзээ ч сайн сайхан болгож чадахгүй. Тэгвэл хүний амьдрал ёс суртахуунгүй, адгуус амьтны төвшинд очно. Гэвч улс төрийн бодлого бүхэн заавал бурангуй байх албатай биш ээ.

Хүнийг сайн сайхан ирээдүйд хүргэх явдал, шударга ёс, туйлыг үнэн санааг манай улс төр, соёлын байгууллага үгүйсгэн мушгин гуйвуулж байна. Шашны удирдагчид маань “бузартсан” улс төрд орооцолдож, шашны цэвэр тунгалаг чанарыг алдах вий хэмээн сүсэгтнүүд санаа зовж байгаа нь ч түмэн зөв. Шашин, ёс суртахуун хоёр улс төрд ямар ч байр эзлэхгүй гэх, эсвэл сүсэгтэн хүмүүс өөрсдийгөө даяанчлан улс төрөөс бүр мөсөн тусгаар байх гэсэн санаа зөв эсэхэд би эргэлзэж байна. Ийм бодлого дэндүү өрөөсгөл бөгөөд бидний амьдралд шашны гүйцэтгэх үүрэг, хувь хүнээс нийгэмтэй харьцах жинхэнэ харьцааны утгыг алдруулах юм.

Ёс суртахуун нь сүсэгтэн хүнд хичнээн чухал байдгийн нэгэн адил улс төрийн зүтгэлтэнд ч чухал байх ёстой. Хэрэв улс төрийн удирдагч нар ёс суртахууны зарчмаа умартваас тэдэнд дараа дараалсан бэрхшээл нүүрлэх болно. Бид Бурхан, үйлийн үрт итгэдэг ч бай, үгүй ч бай ёс суртахуун бол ямар ч шашны үндэс мөн гэж хүлээх ёстой.

Энэрэнгүй сэтгэл, зөв ёс суртахуун, төлөв төвшин зан ааш, мэргэн ухаан зэрэг хүний нандин чанар бүхий л соёл иргэншлийн үндэс болсоор ирсэн, болж ч байна. Ийм ёс суртахууныг тухайн нийгмийн орчинд эрэмбэ дараатай боловсролоор тасралтгүй буй болговол илүү энэрэнгүй, хүмүүнлэг ертөнц мэндэлж болох юм. Ийм ертөнц сүндэрлүүлэхийн тулд дээрх санааг хүмүүст бүр эхнээс нь балчир ахуй цагаас нь эзэмшүүлбэл зохино.

Бид энэ өөрчлөлтийг хойч үедээ зүгээр даатган орхиж болохгүй. Өнөө үед ёс суртахууны нандин чанаруудыг сэргээх оролдлогыг зайлшгүй хийх шаардлагатай болжэ. Бид одоогийн боловсролын тогтолцоонд өргөн хүрээтэй, үлэмж гүнзгий өөрчлөлт хийхгүй аваас хойч үе маань хийнэ гэж найдах аргагүй. Бүх нийтийн энэрэн нигүүлсэх үйл ажиллагаанд бид үлэмж өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Ёс суртахуун устлаа гэж сүржин шуугиан тарих хэрэггүй. Гэхдээ зарим нэг зүйлийг хийх л хэрэгтэй. Энэрэнгүй үзэл зэрэг шашны үүргүүдийг өнөөгийн олон орны засгийн газар гартаа аваагүй, ажил хэрэг болгохгүй байгаа учраас олон нийтийн, иргэний соёл боловсролын талыг эрхэлсэн шашны байгууллагууд хүмүүнлэг чанар, ёс суртахууныг сэргээхэд хүч гаргах ёстой. Зорилгодоо



хүрэхийн тулд шинэ байгууллагуудыг буй болгож болно. Ингэснээр даян дэлхийн энх амгалангийн илүү тогтвортой суурь тавигдана гэж би найдаж байна.

Нийгэмд амьдарч байгаа болохоор бид бусад хүмүүсийн зовлонг хуваалцаж, нигүүлсэх сэтгэл, тэвчээрийг өөрсдийн өмөг садандаа төдийгүй дайсандаа ч гаргах хэрэгтэй. Энэ нь бидний ёс суртахууны шалгуур мөн.

Шашны ёс суртахууныг хоосон яриагаар бусдад итгүүлж чадахгүй, харин үйл ажилаараа үлгэрлэх учиртай. Бусдын тусад үйлчилдэг, өндөр хөгжилтэй, нэгдмэл нийгэмд хүмүүс амьдрах ёстой. Бүх шашны туйлын зорилго нь хүний сайн сайхан амьдрал мөн. Шашин бүр хамаг амьтны энх амгалан, сайн сайхны тусын тулд хүчин зүтгэдэг болохоор нэг шашнаас нөгөө шашинд орохыг эрмэлзэх нь гол бус.

Шашинд үндэсний хил хязгаар гэж байхгүй. Шашныг хувь хүн, ард түмэн ашиг тустай л гэж үзвэл хэн боловч түүнийг шүтэх бишрэх эрхтэй. Өөртөө хамгийн тохиромжтой шашнаа хүн бүр сонгон авах нь чухал. Гэхдээ нэг шашинд орохдоо бусад шашныг юм уу, нийгмээ хүндлэхгүй байж хэрхэвч таарахгүй.

Чухамдаа ямар ч шашныг дагалаа гэсэн нийгмээс хөндийрөн тасрахгүй. Нийгмийн дотор найрсаг эвтэй амьдрах хэрэгтэй. Бусдын тусыг эгээрэх нь шашны үндсэн зорилго тул нийгмээс тасарсан хүн бусдын тусыг бүтээж чадахгүйд хүрнэ.

Алив хүн өөрийгөө шалгах, өөрийгөө засах хоёр чухал зүйлийг сэтгэлдээ чамбай тунгаавал зохилтой.

Үнэндээ бид бусдад хандах хандлагаа байнга шалгаж, биеэ сайтар шинжиж, буруу зөрүүг даруй засаж байх нь зүйтэй.

Эцэст нь эд өлгийн дэвшлийн талаар хэдэн үг хэлье. Эд баялгийн дэвшлийг зэмлэсэн үг өрнөдийнхөөс бишгүйдээ гардаг. Гэтэл өрнөдийнхөн түүгээрээ маш их бахархдаг нь хачирхалтай. Хүмүүс нэгэнтээ эд өлгийг чухалчилж байгаа бол эд баялгийн хөгжил дэвшилд буруу гэх юм алга. Хүний амин чухал асуудлыг иж бүрэн шийдэхийн тулд эдийн засгийн хөгжил, хүний ёс суртахууны төлөвшлийг хамтад нь хослон хөгжүүлэх ёстой гэдэгт би баттай итгэдэг. Гэхдээ бид түүний хэмжээ хязгаарыг сайтар мэдэх хэрэгтэй.

Шинжлэх ухаан, техникээс үүссэн материалист мэдлэг хүний сайн сайхны үйлсэд асар их хувь нэмэр оруулсан боловч өнө удтал үргэлжлэх амар амгаланг бүтээхэд хүч хүрэхгүй байна.

Жишээлэхэд, Америкийн техникийн дэвшил аль орноос түлхүү хөгжсөн боловч тэнд сэтгэлийн зовлон асар их. Материалист мэдлэг зөвхөн хүний бие цогцсын чиглэлээр таашаал олгодог болохыг энэ нь харуулж байна. Гэхдээ тэр нь гадны хүчин зүйлээс үл хамаарах дотоод сэтгэлийн аз жаргалыг авчирч чадахгүй.

Хүмүүнлэг ёс суртахууныг сэргээж, өнө удаан үргэлжлэх аз жаргалыг олохын тулд бид улс үндэстэнүүдийн энэрэн нигүүлсэх нийтлэг ёсны өв уламжлалыг эрэлхийлэх шаардлагатай. Энэ ертөнцөд бид бүхнийг нэгэн ам бүл мэт нэгтгэгч хүмүүнлэг зөв ёс суртахууныг гэж умартуулахгүй байлгахад энэхүү бэсрэг өгүүлэл сануулга болох болтугай.




Санаандаа тээж явдаг бодлоо нээн хэлэхийн тулд би энэхүү өгүүллээ бичлээ. Хаана ч, гадаадын хэнтэй ч уулзахад “хүн төрөлхтөн” хэмээн нэгэн бүлийн гишүүнтэй учирч байна даа гэсэн цорын ганц бодол надад байнга төрдөг. Энэ бол хамаг амьтныг хайрлаж хүндлэх үзэл санааг минь улам лавшруулдаг.

Миний энэхүү чин хүсэл орчлон ертөнцийг энх амгалан болгоход өчүүхэн ч атугай хувь нэмэр болоосой.

Энэ дэлхийн хүн төрөлхтөн бие биеэ гүнээ ойлгож, харилцан сайн санаа гаргаж, улам эвтэй найртай амьдраасай гэж залбирнам.

Амьтан бүхэн зовлонгоос хэлтрэн, үүрд орших амгаланг олох болтугай.

Энэ бүхэн бол миний зүрх сэтгэлийн уриалга юм шүү.



“... Зарим нь намайг амьд Будда гэж үздэг. Энэ бол тэнэг явдал. Энэ бол буруу. Зарим нь болохоор Буддын санваартан гэдэг. Энэ бол Окей. Гэвч эндээс хавьгүй олон хүн намайг зүгээр л хүндэтгэдэг.

Хэрэв ихэнх хүн намайг магтаад, дуулаад байвал инээмсэглэх, биеэ тоох явдлыг өөгшүүлэх аюултай. Хэрвээ надаас “Та Далай ламын хойт дүр мөн үү” гэж асуувал би эргэлзэх юмгүйгээр “Тийм” гэж хариулна”. Харин “XIII Далай ламтай ижил оршихуйтай юу” гэж асуувал “Мэдэхгүй” гэж хариулна. Үүнийг хариулахад их хэцүү...”



М.Шагдарсүрэн. Энэтхэг улсын Дарамсалад.




*Профессор М.Шагдарсүрэн эмч Энэтхэг улсын
Дарамсалад Далай ламын ордонд...*

“... Хүмүүцст бид өөрсдийгөө газар дэлхийг сөнөөх чадвартай гэдгийг мэдэж байна. Ингэж сөнөөх чадвартай гэдгийг мэдэж байна. Ингэж сөнөөх эрх мэдэл ба чадал ямар ч хорхой шавьж, шувуунд байхгүй. Хэрвээ хүмүүс бид газар дэлхийг сөнөөх чадвартай бол түүнийг хамгаалах, сэргээх чадвар бидэнд бас байх ёстой. Эх дэлхий маань эрх ганц хүчхдийнхээ ямар ч ааш аягийг тэвчдэг эх хүн шиг хүмүүс бидний хорлол, сүйтгэлийг тэвчсээр өнөөг хүрэв...”




Профессор М.Шагдарсүрэн, эхнэр Д.Тунгалагийн хамт
XIV далай ламд бараалхав.



Миний хөвгүүн
Шагдарсүрэнгийн
Түвшинтөгс Дээрхийн
гэгээний гүн ухааны
коллежид суралцав.
1991-1997

“... Шашны эрдэм номд шамдан хичээсээр сэтгэл санааны онцгой тайван амгаланд хүрнэ. Шашин номыг байнга судлан, бясалгал давлагад ордог хүмүүс хатуужил, тэсвэр тэвчээрээр баттай болдог.

Шашны мөн чанарыг зөв ухааран ойлгохоос л хамаг амьтныг энэрэн хайрлах үнэн сэтгэлийн үндэс тавигддаг. Алив шашны амин сүнс нь сэтгэлийн амар амгаланг сая байгуулж чадна. Хүн өөрөө өөртөө энх амгаланг байгуулаагүй цагт бусдад энх амгаланг хайрлана гэж үгүй...”





ГАРЧИГ

БУРХАН БАГШИЙН СУРГААЛ

Номын оронд өргөх тахил	i
Ерөнхий редактораас өгүүлэхийн учир	vii
Өмнөтгөл	xix
Уншигч танаа өргөн барихуй	xxii

БУДДА

ШАГЖАМУНИ БУРХАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	2
1. Буддагийн намтар	2
2. Бурхан багшийн сүүлчийн сургаал	9
МӨНХИЙН БУДДА ХОЁРДУГААР БҮЛЭГ	13
1. Бурханы нигүүлсэл ба сахил	13
2. Бурханы тус, аврал	17
3. Мөнхийн Будда	20
БУРХАНЫ ДҮР БОЛООД БУЯН ГУРАВДУГААР БҮЛЭГ	22
1. Бурханы дүрийн гурван тал	22
2. Бурхан үзэгдэх	25
3. Бурханы буян	28

ДАРМА

ШАЛТГААН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	33
1. Дөрвөн үнэн	33
2. Шалтгаан	36
3. Харилцан холбоо	38
СЭТГЭЛИЙН ОНОЛ, ЮМСЫН МӨН ЧАНАР ХОЁРДУГААР БҮЛЭГ	41
1. Хувирах юмсад бодит бие үгүй	41
2. Сэтгэлийн онол	44

3. Юмсын үнэн байдал	47
4. Дундач үзэл	51
БУРХАНЫ ЧАНАР ГУРАВДУГААР БҮЛЭГ	56
1. Ариун сэтгэл	56
2. Бурханы чанар	61
3. Бурханы чанар, шуналаас зайлах	65
ЕРТӨНЦИЙН ХҮСЭЛ ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	69
1. Хүний чанар	69
2. Хүний зан араншин	75
3. Хүний амьдрал	77
4. Хүний бодит амьдрал	82
БУРХАНЫ АВРАЛ ТАВДУГААР БҮЛЭГ	87
1. Бурханы сахил	87
2. Авид бурханы ариун диваажин	93
ГЭГЭЭРЭЛ	
ГЭГЭЭРЭХ ЗАМ ӨӨД НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	97
1. Сэтгэлийг ариусгах	97
2. Зөв явах	103
3. Эртний ёгт үлгэр дэх Бурханы сургаал	112
ЖИНХЭНЭ МЭДЛЭГИЙН ЗАМ ХОЁРДУГААР БҮЛЭГ	123
1. Үнэний эрэлд	123
2. Гэгээрэлд хүрэх арга замууд	133
3. Итгэлийн зам	142
4. Ариун сургаал	147
АХАН ДҮҮС	
АХАН ДҮҮСИЙН ҮҮРЭГ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	154
1. Хуврагийн амьдрал	154
2. Сүсэгтний зам	159



**АМЬДРАХ ҮНЭН ЗАМЫН БОДИТ ЧИГ
ХОЁРДУГААР БҮЛЭГ** 166

1. Гэр бүлийн амьдрал 166
2. Бүсгүй хүний амьдрал 174
3. Удирдан жолоодох 181

**БУРХАНЫ ОРОН ЦОГЦЛОХУЙ
ГУРАВДУГААР БҮЛЭГ** 189

1. Ахан дүүсийн барилдлага 189
 2. Бурханы орон 195
 3. Бурханы оронд алдрыг хүртэгсэд 199
- Санкрит үгийн тайлбар 203

**ЕРТӨНЦИЙН АМГАЛАН ХУТГИЙГ ОЛОХ
ХҮМҮҮНИЙ ЭРЭЛ**

Өмнөх үг	211
Арвандөрөвдүгээр Далай лам Данзанжамц	213
Удиртгал	215
Үзэл бодлоо өөрчлөн хүн төрөлхтний амин чухал асуудлыг шийдэцгээе	220
Энэрэн нигүүлсэхүйн үзэл даян дэлхийн энх амгалангийн тулгуур	225
Дэлхийн шашнууд энх амгалангийн үйлсэд	233
Хувь хүний нийгмийн үүрэг	240

“Бурхан Буддагийн айлтгал” хэмээх энэхүү ботиос та амарлингуй гэгээн сэхээрэл, оюун санаанд хөвөрдөн буух эрхэмсэг үгийн торгомсог өнгө, таашгүй амт шимтийг мэдрэх болно. Чинхүү гайхамшигтай айлдвар дор таацан сөхөрч амьдралын эрт болоод эдүгээг эргэцүүлэн би хэн бэ? гэдгээ өөрөө өөрөөсөө асуух тийм л гэгээрэл ухаарал хуран оршжээ. Үүнд л жинхэнэ дуун хөрвүүлэгчийн авьяас чадвар бас судар номын ухаанд шүтсэн гэгээрсэн сэтгэл, сайн сайхан бүхний эрчим хүч лугшин оршиж байна. Бурхны сургаалын 5000 гаруй боть судраас үе үеийн мэргэн Гүүш, Бандида нарыг сорчлон дуун хөрвүүлж бүтээсэн “Бурхан Буддагийн айлтгал” хэмээх энэхүү ном доктор М.Шагдарсүрэнгийн орчуулгаар долоо дахь удаагаа хэвлэгдэж, уншигч таны оюуны мэлмийг нээж, сэтгэлийг ариусгаж байгаад “Сэлэнгэпресс” хэвлэлийн газар гүнээ талархаж байна.



Маналжавын ШАГДАРСҮРЭН

Монгол Улсын хүний гавьяат эмч, доктор профессор дуун хөрвүүлэгч, орчуулагч, анагаах ухаан, боловсрол соёлын нэрт зүтгэлтэн эрдэмтэн юм. Олон мянган хүнийг аюулт өвчнөөс аварч, элэгний хорт хавдрыг судсаар эмчлэх өвөрмөц аргыг Монголын анагаах ухаанд анх нэвтрүүлжээ. АУИС, МУИС, Япон Улсын Цукүбагийн их сургууль, Токио хотын Икашика их сургууль, АНУ-ын Калифорни, БНСУ-ын Сөүл хотын их сургуулиудад суралцан Анагаах ухаан Буддын гүн ухаан, Энэтхэг, Хятад, Төвдийн гүн ухаан, дэлхийн сонгодог яруу найргаас эх хэлнээ яруу тансаг орчуулж, англи, орос, япон, төвд, латин зэрэг хэд хэдэн хэлний шинжлэх ухаан, нарийн мэргэжлийн томоохон овор хэмжээний толь бичгүүдийг зохион бүтээсэн шинэ Монголын нэртэй соён гэгээрүүлэгч эрдэмтэн юм.

“Wherever the Buddha’s teachings have flourished,
either in cities or countrysides,
people would gain inconceivable benefits.
The land and people would be enveloped in peace.
The sun and moon will shine clear and bright.
Wind and rain would appear accordingly,
and there will be no disasters.
Nations would be prosperous
and there would be no use for soldiers or weapons.
People would abide by morality and accord with laws.
They would be courteous and humble,
and everyone would be content without injustices.
There would be no thefts or violence.
The strong would not dominate the weak
and everyone would get their fair share.”

※ THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL ※

**With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.**

**The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of
Limitless Light!**

~The Vows of Samantabhadra~

**I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.**

**When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.**

**~The Vows of Samantabhadra
Avatamsaka Sutra~**

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.

May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

【外蒙文：佛陀的教法】

財團法人佛陀教育基金會 印贈
台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by
The Corporate Body of the Buddha Educational Foundation
11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.
Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415
Email: overseas@budaedu.org
Website: <http://www.budaedu.org>

This book is strictly for free distribution, it is not for sale.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan
10,000 copies; November 2013
MO019-11785



